



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр, Пүрэв гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1-2
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	3-12
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	13-223
<hr/>	
<b>1.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх</b>	15-16
<b>2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	16-70
<b>3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	70-115
<b>4.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	115-135
<b>5.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	135-156
<b>6.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүн 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	156-160
<b>7.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</b>	160-182
<b>8.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	182-188
<b>9.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн</b>	188-215

---

**тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

**10.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

216-223

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
05 дугаар сарын 21-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Батнайрамдал, Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, Ц.Туваан, Б.Тулга, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ж.Батсуурь, Ж.Золжаргал, М.Мандхай, Ч.Номин, Н.Учрал, Л.Энхнасан;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, Д.Батлут, Д.Ганбат, Э.Одбаяр;

Тасалсан: А.Ганбаатар;

Хоцорсон: О.Алтангэрэл-1 цаг 23 минут, Н.Алтанхуяг-05 минут, Д.Амарбаясгалан-20 минут, С.Амарсайхан-3 цаг 31 минут, Т.Аубакир-2 цаг 43 минут, Х.Баасанжаргал-05 минут, Ц.Баатархүү-12 минут, Д.Батбаяр-40 минут, Х.Баттулга-1 цаг 27 минут, Б.Батцэцэг-29 минут, Ж.Баярмаа-17 минут, Х.Болормаа-01 минут, Х.Булгантуяа-02 минут, Г.Ганбаатар-16 минут, С.Ганбаатар-16 минут, П.Ганзориг-04 минут, Л.Гантөмөр-40 минут, Х.Ганхуяг-02 минут, Т.Доржханд-28 минут, Б.Дэлгэрсайхан-01 минут, Б.Жавхлан-2 цаг 07 минут, Х.Жангабыл-09 минут, Б.Жаргалан-25 минут, Д.Жаргалсайхан-2 цаг 14 минут, З.Мэндсайхан-10 минут, П.Наранбаяр-2 цаг 50 минут, О.Номинчимэг-34 минут, Н.Номтойбаяр-02 минут, С.Одонтуяа-09 минут, Ц.Сандаг-Очир-12 минут, О.Саранчулуун-2 цаг 33 минут, Г.Тэмүүлэн-04 минут, Ч.Ундррам-08 минут, Б.Хэрлэн-02 минут, Д.Цогтбаатар-23 минут, Ж.Чинбүрэн-04 минут, Б.Чойжилсүрэн-01 минут, Ж.Энхбаяр-04 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 05 сарын 18-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, 05 сарын 19-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай/-ийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатараас 2026 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг *Төрийн байгуулалтын байнгын хороонд* тус тус хуваарилсныг танилцуулав.

***Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу *Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай/-ийг Засгийн газар 2026.05.15-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.*

**С.Бямбацогт:** *Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай/-ийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.*

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 23  
Бүгд: 82  
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, С.Одонтуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргав.

Нийт 82 гишүүнээс 61 гишүүн дэмжиж, 74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг *Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт*

өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай/-ийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундррам нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Пүрэвдорж, Д.Рэгдэл, Р.Эрдэнэбүрэн, Г.Очирбат, Ц.Даваасүрэн, Э.Болормаа, С.Зулпхар, Х.Тэмүүжин, Л.Мөнхбаатар, Б.Батбаатар, Ж.Баярмаа, О.Номинчимэг, Л.Гантөмөр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Ч.Лодойсамбуу, Ц.Сандаг-Очир нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 11 цаг 12 минутаас 18 цаг 13 минутад хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Р.Эрдэнэбүрэн нар үг хэлэв.

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 07 минут үргэлжилж, 13 цаг 07 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.*

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:01/

**Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал

эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Д.Рэгдэл, Р.Эрдэнэбүрэн, Л.Соронзонболд, Ц.Мөнхтуяа, Э.Болормаа, С.Зулпхар, Л.Мөнхбаатар, Б.Батбаатар, Ж.Баярмаа, О.Номинчимэг, П.Наранбаяр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Бямбацогт, Ч.Лодойсамбуу нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Хэрлэн нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:25/*

***Дөрөв.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Уянга, М.Ганхүлэг, Л.Соронзонболд, Ж.Галбадрах, Б.Батбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:29/*

**Тав.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх нар байлцав.

**Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан танилцуулав.**

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, А.Ариунзаяа, Р.Эрдэнэбүрэн, Г.Очирбат, Б.Түвшин, С.Зулпхар, Б.Батбаатар, Г.Тэмүүлэн, Ц.Баатархүү нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 18 цаг 13 минутаас 19 цаг 46 минутад хуралдааныг даргалав.*

*Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт товлосон асуудлыг хэлэлцэж дуустал хуралдааны цагийг сунгав./18:19/*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./18:36/*

**Зургаа.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүн 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Улсын

бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газрын дарга С.Чинбат, мөн газрын Иргэний бүртгэлийн газрын дарга Н.Наранцэцэг, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Биндэрьяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ажлын 5 өдрийн завсарлага өгөв./18:46/

***Долоо.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Да.Цогтбаатар, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаясгалан, Г.Ганбаатар, П.Наранбаяр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 19 цаг 46 минутаас 22 цаг 17 минутад хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт*

*явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./19:59/*

***Найм.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Ц.Долгормаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./20:20/*

***Ес.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Төсвийн

тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, П.Батчимэг, Л.Соронзонболд, П.Мөнхтулга, Д.Ганмаа, О.Саранчулуун, Да.Цогтбаатар, Ө.Шижир, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./21:52/*

***Арав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Р.Ринчинбазар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх

Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./22:17/*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Монгол Улсын Их сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургуулийн 9<sup>в</sup> ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын 21 дүгээр сургуулийн 12<sup>в</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны ахмадууд, нийслэлийн ерөнхий боловсролын “Төгсдэлгэрэх” сургуулийн 9<sup>в</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1998 оны төгсөгчид, Хөгжлийн банкны ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 60 дугаар сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн нарын урилгаар Архангай аймгийн Цахир, Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Жаргалант сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 57 дугаар сургуулийн 12<sup>в</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын урилгаар Улаанбаатар хотын их, дээд сургуулиудад суралцаж буй “150x150” тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан Баян-Өлгий аймгийн оюутнууд, Улаанбаатар хотын их, дээд сургуулиудад суралцаж буй Баян-Өлгий аймгийн оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 21 дүгээр сургуулийн 12<sup>в</sup> ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Сэлбэ”

сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 11 цаг 24 минут үргэлжилж, 126 гишүүнээс 104 гишүүн хүрэлцэн ирж, 82.5 хувийн ирцтэйгээр 22 цаг 17 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 00 минут

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

Чуулганы хуралдааны ирц 126 гишүүн ирвэл зохихоос 66 гишүүн буюу 52.4 хувийн ирцтэй байна. Ирц хүрсэн учраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн /Пүрэв/ гаргийн нэгдсэн чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн Энхбаясгалан багштай 12<sup>а</sup> ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй сургуулиа төгсөөд хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа орж, эх орондоо ихийг хийж бүтээх бүтээлч хариуцлагатай иргэн болохыг хүсэн ерөөе.

Өнөөдөр, энэ өдрүүдэд бас төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүдийн мэндчилгээг дэвшүүлье. 05 сарын 18-нд Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах, 05 сарын 19-нд Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар нар төрсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах, Энхбаярын Батшугар нарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Эртэч гишүүд маань өглөө 9 цагт Чулуунбилэгийн Лодойсамбуу, Саруулсайханы Цэнгүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Буланы Бейсен, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд өглөө 9 цагт 00 минутад ажилдаа иржээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 10 асуудал хэлэлцэнэ. Нэлээн ачаалалтай хуралдана өнөөдөр.

1 дүгээрт нь Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулахдаа протоколыг соёрхон батлуулах тухай

хуулийн төслийг Засгийн газар 05 сарын 15-ны өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 05 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн.

4 дүгээрт нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 05 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн.

5 дугаарт нь Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газар 2026 оны 05 сарын 14-ний өргөн мэдүүлсэн.

6-д нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир нарын 4 гишүүн 05 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн.

7-д нь Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг хийнэ.

8 дугаарт нь, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

9 дүгээрт нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 онд төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

10 дугаарт нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Ийм 10 асуудлыг хэлэлцэхээр болсон байна.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачилсан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэх бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн**

**төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.**

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

1.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 05 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газар 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Санал хураалт явуулна. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Одоо Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд сууж байгаа гишүүд орж ирсэн үү? Сэддорж дарга, Заяабал дарга шинээр томилогдож байгаа байх тийм ээ?

Хэлэлцээр соёрхон батлах, Эдийн засгийн байнгын хороонд сууж байгаа гишүүдийг түр санал хураалтад орж ирэхийг хүсэж байна. Мөн бас хүрэлцэн ирээгүй гишүүдийг бас танхимд орж ирж санал хураалтад орохыг хүсэж байна.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Одонтуяа гишүүн, Батбаатар гишүүн суудлаа эзэлчихье санал хураалт явах гэж байна. Нөгөө. Агаарын хөлгийн түлш хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн

төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 82 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 72 хувийн саналаар энэ санал хураалт дэмжигдлээ.

Төслийг Их Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Одонтуяа гишүүн дэмжсэнээр, Батчимэг гишүүн дэмжсэнээр тооцёе.

10.10 цаг

Зочин танилцуулъя. Монгол улсын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургуулийн Алтанцэцэг багштай 9<sup>в</sup> ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо шамдан суралцаж, удахгүй болох анги дэвшилтийн шалгалтаа амжилттай өгөөрэй. Дараагийн асуудалдаа оръё.

**Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал, Их Хурал хадгална гэж, 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал үйл ажиллагааны зохих салбар, чиглэлээр Байнгын хороотой байна гэж, Мөн зүйлийн 2 дахь хэсэгт Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж тус тус заасан байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу сонгуулийн холимог тогтолцоогоор сонгогдож байгуулагдсан 126 гишүүний бүрэлдэхүүнтэй Улсын Их Хурлын бүрэн эрх 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Анхдугаар чуулганаа хийж тангараг өргөснөөр хэрэгжиж эхэлсэн билээ.

Энэ удаагийн парламентын бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш 4 ээлжит чуулган хуралдаж байгаа бөгөөд ээлжит бус 1 чуулганыг хуралдуулсан байна.

9 дэх парламентын бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш 2 жилийн хугацаанд төсөл өргөн мэдүүлсэн өдөр хүртэл нийт 131 хууль, Улсын Их Хурлын 169 тогтоол баталсан нь өмнөх бүрэн эрхийн хүрээнд баталсан хуулийн 8.9 хувьтай нь дүйцэхээр байна.

Түүнчлэн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс Улсын Их Хурлын үйл ажиллагааг 8 Байнгын хороо, 15 дэд хороотой байхаар зохион байгуулсан. Энэхүү хуулийн хүрээнд нийт Байнгын хороог 11 Байнгын хороотой байхаар 7 дэд хороотой байхаар бол зохион байгуулж оруулж ирж байна.

Улсын Их Хурлын зохион байгуулалтын оновчтой үйл ажиллагааг боловсронгуй болгох, гишүүдийн ирц, оролцоо, хариуцлагыг сайжруулах, Улсын Их Хурлын үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээмжтэй ажиллаж буй гишүүдийг дэмжих, хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийг чанаржуулах, мэргэшсэн Байнгын хороодод түшиглэж парламентыг бэхжүүлэх зорилгоор миний бие болон Улсын Их Хурлын С.Бямбацогт, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл, Ж.Батжаргал, Б.Бейсен, Л.Лодойсамбуу, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, С.Сандаг-Очир, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн нарын 12 гишүүний хамтаар энэхүү хуулийг боловсруулан өргөн барьж байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтыг оновчлох хүрээнд Улсын Их Хурлын зохион байгуулалтыг Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Өргөдлийн, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Хүний эрхийн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, Цахим хөгжил, хууль, оюуны бодлогын, Эдийн засгийн, Эрүүл мэнд, нийгмийн бодлогын гэсэн 11 хороотойгоор хуульд тусгаж оруулж ирж байна.

Байнгын хороог 11 болгосонтой холбогдуулан Байнгын хорооны бүрэлдэхүүнийг хуульд нийцүүлэн нийт Байнгын хороо 21 хүртэл гишүүнтэй байхаар бол хуульд заалаа.

Мөн Байнгын хорооны харьяанд ажиллах дэд хороодын эрхлэх асуудлын ялгаа, заагийг зааж, Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Тусгай хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Ёс зүй, Төсвийн зарлагын хяналтын, Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын, Хүний эрхийн, тогтвортой хөгжлийн зорилгын гэсэн нийт 7 дэд хороотой байхаар төсөлд тусгаж оруулж ирж байна.

Улсын Их Хурлын эргэх холбоо, хүртээмж, ил тод байдлыг сайжруулах, сонсогчдод мэдээллийг тогтмол хүргэх, тогтолцоо бүрдүүлэх хүрээнд Улсын Их Хурлын даргыг сонгох хуралдааныг хэлэлцүүлэгтээ явуулахаар болгож байна.

Мөн Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь энэ тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, хуульд заасан тохиолдолд оролцох боломжийг хангахуйц хүртээмжтэй байх, Улсын Их Хурлын мэдээ, мэдээллийг нийтэд дамжуулахдаа дохионы хэл, товч, бүрэн, товч бичгийн тайлбар зэргийг оруулж тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, оролцох хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд хуулийг бол боловсруулж оруулж ирлээ.

Иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан шийдвэрлэсэн байдал түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн сар бүр тогтмол мэдээлэл хийдэг байхаар бол хуульд өөрчлөлт орууллаа.

Шаардлагатай гэж үзвэл хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын цахим хуудас, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, харилцаа холбооны хэрэгслээр иргэдээс санал авах боломжийг нэмэгдүүлэхээр мөн тусгаж ирлээ, тусгалаа. Баталсан хууль тогтоомжийн ач холбогдол, үр нөлөөг иргэдэд энгийн ойлгомжтой, богино хэмжээний дүрс бичлэг болон зурган зэрэг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэн иргэдийг тогтмол мэдээллээр хангадаг байхаар зохицуулж оруулж ирлээ.

Мөн өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл хэлэлцүүлгийн үйл явц болон баталсан хууль тогтоомжийн зохицуулалт, ач холбогдлыг хууль санаачлагч гишүүн, ажлын хэсэг, Байнгын хорооны дарга тайлбарлан таниулж тогтмол мэдээлдэг байх нөхцөлийг, заалтыг бол оруулж ирсэн.

Улсын Их Хурлын хэлэлцэж буй асуудлаар улс төрийн зөвшилцлийг хангах, парламентыг үл хүндэтгэх нөхцөлд хариуцлага тооцдог байх механизмыг бол бас бүрдүүлж байна.

Хэлэлцэж байгаа аливаа асуудлаар Улсын Их Хурал дахь улс төрийн хил, зөвшилцлийг хангах арга хэмжээ авахыг Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дарга нарт үүрэг болгохоор. Мөн хурал хуралдаан даргалагч чуулганы хуралдааны явцад парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гаргасан этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэхээр томилох эрх бүхий этгээдэд албан бичиг илгээж, томилох эрх бүхий этгээд нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх хариуг хуралдаан даргалагч албан ёсоор ирүүлнэ.

Ийнхүү ирүүлсэн албан бичгийг хуралдаан даргалагч холбогдох хуралдаанд уншиж танилцуулахаар энэхүү хуульд бол заалаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат Бат-Эрдэнэ нарын 12 гишүүнээс 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Улсын Их Хурлын зохион байгуулалтыг оновчлох, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гишүүдийн ирц, оролцоо, хариуцлагыг сайжруулах, Улсын Их Хурлын үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээмжтэй ажиллаж буй гишүүдийг дэмжих, хууль тогтоомжийн төслийн

хэлэлцүүлгийг чанаржуулах, мэргэшсэн Байнгын хороодод түшиглэсэн парламентыг бэхжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам хуулийн төслийг дэмжиж буйгаа илэрхийлээд төсөлд ээлжит чуулганы хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо, дотоод, гадаад албан томилолт, хууль тогтоомжийн төсөл санаачилсан, хамтран санаачилсан, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шаалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн эсэх талаарх мэдээллийг бодит цагийн горимоор олон нийтэд ил тод тогтмол мэдээлнэ гэж заасны хүрээнд асуулт асуух, үг хэлэх боломж олдохгүй тохиолдолд хэрхэн зохицуулах, гишүүн ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн тохиолдолд 30 хүртэл хоногоор хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрхийг хасах зохицуулалт нь тухайн гишүүний ард түмнээс авсан мандатад халдаж байгаа эсэх, гишүүнийг ямар тохиолдолд ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс хасах, өнгөрсөн хугацаанд ажилласан Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагааны үр дүнгийн талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлсэнтэй холбоотой ирц, саналаа биечлэн өгсөн байдал, хуулийн төсөл санаачилсан ажлын хэсэгт ажилласан зарчмын зөрүүтэй санал гаргасан зэргийг Байнгын хорооны даргаар сонгоход шалгуур болгох нь зохимжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Байнгын хорооны даргыг сонгоход нэр дэвшигчийн сонгогдон ажилласан хугацаа, туршлага, эсхүл Улсын Их Хурлын үйл ажиллагаанд оролцсон байдлын алийг нь харгалзах талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд орсон асуудлыг төлөвлөгөөний дагуу хэлэлцдэг байх, Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүний ирцийг хэрхэн хянах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Улсын Их Хурлын гишүүний хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаатай холбоотой мэдээллийг хариуцлага болон Байнгын дэд хорооны даргыг дахин болон улиран сонгоход харгалзан үзэх тоо, хөөцөлдсөн нөхцөл байдал үүсэх эсэх, цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын байнгын хорооны эрхлэх асуудалд инновацын асуудлыг тусгасан эсэх, жагсаалтаар сонгогдсон гишүүн биет төлөөлөгч, туслахтай байхаар өөрчилснөөр төсөвт ачаалал ирэх эсэх, хууль санаачлагчаас өргөн мэдүүлж байгаа төслийн зардлын тооцоо хийсэн тайланд үнэлгээ хийх нь хууль санаачлагчийн эрхэд халдах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам гишүүдийн чуулганы хуралдаандаа хариуцлагатай оролцох хөшүүрэг болсон өөрчлөлт оруулах нь зүйтэй ч нэг тал руу туйлшрахгүй байх, Улсын Их Хурлаар баталж байгаа хууль тогтоомжийн чанарыг сайжруулах, Улсын Их Хурлын бүтээмжийн чанарыг нэмэгдүүлэх талаар нь анхаарах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж байгаа Улсын Их Хурлын гишүүн холбогдох Байнгын хорооны бүрэлдэхүүнд ажиллахыг дэмжихийн зэрэгцээ уг гишүүн хүсэлт гаргасан бол 2 Байнгын хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах боломжийг судлах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар гишүүн Улсын Их Хурлын үйл ажиллагаанд оролцож буй

байдлыг нээлттэй мэдээлэх зохицуулалтад асуулт асуусан, үг хэлсэн тоо байх эсэхийг ажлын хэсэг ярилцах, Байнгын хорооны даргыг сонгоход парламентын ажлын туршлагыг харгалздаг байх, инновацийн асуудал салбар дундын асуудал тул хэлэлцүүлгийн явцад анхаарах нь зүйтэй. Төслийг үзэл баримтлал, зарчмын зарчмын хувьд бүрэн дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хамтын удирдлагатай байгууллагын хувьд хуралдааны бэлтгэл ажил хангах, хуралдаан явуулах, шийдвэрийн хэрэгжилт чухал бөгөөд төслийг дэмжихээ илэрхийлж, цаашид төсөв, татвар, нийгмийн даатгал, эрүү, иргэний хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг мэргэшсэн салбарын нэгдсэн бодлогоор Засгийн газар өргөн мэдүүлэх нь зүйтэй. Өргөн мэдүүлж буй төслүүдэд үр дагаврын үнэлгээ хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэр хянах шатад зардлын тооцоо хийсэн тайланд үнэлгээ хийх нь хууль санаачлагчийн эрхэд сөргөөр нөлөөлөх эсэхийг анхаарах шаардлагатай. Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж байгаа Улсын Их Хурлын гишүүн холбогдох Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох, гишүүдийн хариуцлагыг сайжруулах төслийн саналуудыг дэмжиж байгаа бөгөөд Ерөнхий сайдын үүргийг хавсран гүйцэтгэж байгаа Улсын Их Хурлын гишүүн холбогдох Байнгын хорооны хуралдаанд бүрэн суух нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар 126 гишүүнтэй парламент бүрэн эрхээ хэрэгжүүлээд 50 хувьдаа хүрч байгаа нь энэ үед Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад холбогдох өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүссэн. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгааг дурдаад хуулийн төслүүдийг дэмжихээ илэрхийлж үг хэлсэн болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 66.7 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 66.7 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Ундрам гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачилсан илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Д.Энхтүвшин:** Гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Хэдэн асуулт байна. Хуулийн төслийн хууль зүйн техник бичилттэй холбоотой нэг асуулт байна. Энэ 8 дугаар зүйл нь өөрөө гишүүний бүрэн эрх гэдэг заалт байгаа. Тэгээд 8 дугаар зүйл дээр хуулийн төсөл дээр болохоор бүрэн эрхээс гадна гишүүний ёс зүй, ёс зүйн хариуцлага хүлээлгэх, энийг шийдвэрлэх журам гэх мэтчилэнгээр нэлээн олон зүйл ингээд нийлүүлээд чихчихжээ 8.13 хүртэл. 8.3-аас 8.13 хүртэл 10 зүйл, заалт ингээд нэмчихсэн байна.

Тэгэхээр энэ техник талаасаа ингээд уншихад бас ойлгомжгүй иймэрхүү байдал бий болоод байна. Ер нь бол энэ хуулийн төсөл дээр бас нэг асуудал байгаа нь болохоор хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт хууль санаачилсан буюу хамтран санаачилсан төлөөллийг оролцуулахаар ингээд заачихсан байна лээ. Тэгэхээр энэ нь бол одоогийн байгаа хуулийг дордуулсан агуулгатай. Өөрөөр хэлбэл, ажлын хэсэг хэлэлцүүлэгт бэлдэх ажлын хэсэг нь бие даасан шинжтэй. Энэ төслийн хуулийн техник, концепцын өөрчлөлт, зохицуулалтыг нь хардаг ийм зүйл, заалт байсныг одоо санаачлагч нь өөрөө орохоор энэ бол агуулга нь алдагдахаар тэгэхээр дордуулсан ийм шинжтэй харагдаад байна. Тэгэхээр энэ эхний асуулт нь болохоор энэ техник талаасаа 8 бүрэн эрх гэдэг хуульчилсан заалт дотор энэ өөр зүйл, заалтуудыг оруулах нь болж байна уу үгүй юү?

Дараагийн асуулт нь болохоор энэ дээр хуулийн төсөлд гишүүн энэ хуулийн 4.1.2, 4.1.11-д заасан чуулганы хуралдаанд, эсвэл хуралдаанаас гадуур бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэж доромжилсон бол иргэний маргааны журмаар шүүхэд хандаж болно гээд. Тэгэхээр энэ бас өөрөө Үндсэн хуулиар хүн эрх нь зөрчигдсөн бол шүүхэд хандах эрхтэй. Тэгэхээр энэ бол иргэний шүүх байна уу, эрүүгийн шүүх байна уу, захиргааны хэрэг байна уу гээд өөр өөр шүүхэд хандах ийм бололцоотой. Тэгэхээр зөвхөн иргэний маргааны журмаар шүүхэд хандаж болно гэсэн ийм зүйл, заалт байна. Энийг нэг тодруулж өгөөч?

Дараагийн асуудал нь болохоор 3 дахь асуулт нь Улсын Их Хурлын дэргэдэх хүрээлэн байгуулна гээд. Тэгээд энэ хүрээлэн одоо байгаа судалгааны хүрээлэнг хэлж байна уу, эсвэл шинэ ийм хүрээлэн байгуулах гэж байна уу гэдэг 3 дугаар асуулт.

Дөрөвдүгээрт нь болохоор энэ хариуцлагатай холбоотой заалт байгаа. 30 хүртэл хоногоор хуралдаанд ирц ч юм уу, биечлэн, саналаа биечлэн өгөх байдлыг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ ээ гэж байгаа юм. Тэгээд 8.7.2.А дээр 30 хүртэл хоногоор хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрхийг хасна гээд. Тэгэхээр Үндсэн хууль дээр байгаа заалт дээр энэ бол зөрчилдөхөөр л харагдаад байна л даа. “Монгол Улсын засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна”. “Ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэхээр энэ гишүүдийн хэлж байгаа үг чинь бас яг ард иргэдийн сонгогчдын энэ Үндсэн хуулийн эрхийг хэрэгжүүлж байгаа ийм үйл ажиллагаа байтал энийг ингээд 30 хоногоор хязгаарлачихаар ирцдээ ороогүйгээсээ болоод, саналаа биечилж өгөөгүйгээсээ болоод ийм хариуцлага ноогдуулах нь Үндсэн хуулийн энэ эрхийг зөрчиж байгаа юү? Тэгээд энэ ирцтэй холбоотой, биечлэн өгөхдөө асуудлууд дээр бас дагалдуулаад энэ тов дараалал тогтоохдоо жишээлбэл зэрэгцээд олон хурлуудыг зарлачихдаг.

**С.Бямбацогт:** Хууль санаачлагч хариулъя Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сүүлийнх нь асуудлуудаас эхлээд хариулчихъя. 8.7.2.а дээр 30 хүртэл хоногоор хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрхийг хасах гэгчээд байгаа юм. Тэгэхээр ер нь бол яах вэ бид нар хариуцлагыг нэлээн жоохон өндөржүүлье гэсэн шүү дээ. Нэлээн өндөржүүлье гэсэн. Үг хэлдэг байх. Хуралдаандаа идэвхтэй оролцдог байх, тасалдаггүй байх, ирцдээ орчхоод буцаад гараад явдаггүй байх, тэгээд санал өгөх бүрэн ирцээрээ өгч байж үйл ажиллагаандаа өөрөөр хэлбэл гарч байгаа хууль бүрэн дүүрэн батлагддаг байх гэх мэтчилэн зөндөө олон асуудлууд бид нар яригдаад байгаа. Энэ бол олон түмэн ч ярьж байгаа, бидний хүрээнд ч өөрсдөө ч бас хэдүүлээ үйл ажиллагаагаа чанаржуулж сайжруулъя гэж ярьж байгаа.

Тэгээд эндээс улбаалаад ёс зүйн асуудалтай холбоотой Ёс зүйн дэд хороон дээрээ нэлээн ач холбогдол өгье гэсэн юм. Өнөөдрийн хүрээнд бол Ёс зүйн хороо маань ажиллахын хүрээнд бол ажиллаж байгаа. Гэсэн хэдий ч тодорхой хэмжээний шийдлүүд бас гаргаж нэлээн тийм хүчтэй байх шаардлага бол зайлшгүй болчхоод байгаа юм. Тийм болохоор ямар ч л байсан Ёс зүйн хороон дээрээ хэд хэдэн асуудлуудыг оруулаад өгчихье гэж байгаа юм. Энэ бол гишүүдээс ирсэн санал. Нийт бол 2000-аад санал орж ирсэн. 40-өөд гишүүн санал өгсөн. Дээрээс нь Байнгын хороод болон Тамгын газраас яг ажиллаж байгаа хүрээнд нь бас тодорхой хэмжээнд саналуудыг бид нар аваад суулгаад ингэсэн суулгасан ийм хуулийн санал орж ирж байгаа юм шүү. Тийм болохоор энэ дээр 30 хүртэл хоногоор хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрхийг хасъя гэсэн нэг ийм санал орж ирж байгаа. Энийг мэдээж гишүүдийн хүрээнд бол ярих ёстой. Аливаа асуудал 2 талтай.

Нөгөө талаасаа бол мэдээж олон түмнийг бол төлөөлж байгаа, Монголын ард түмнийг төлөөлж байгаа, тойргоо төлөөлж байгаа гишүүний хувьд бол хэлэх, ярих, асуух энэ бүрэн эрхийг нь бол бид нар бас хааж боох ийм боломж бас тэр бүр бол бас хэцүү. Гэхдээ ямар ч л байсан оруулж ирье. Хэдүүлээ ярилцъя, ажлын хэсэг гарна. Өнөөдөр чинь нийт парламентад байгаа намын бүрэлдэхүүний хэмжээнд том ажлын хэсэг байгуулагдаад ингээд ажиллана л гэж байгаа юм шүү.

2 дугаарт, Хүрээлэнгийн асуудал орж ирж байгаа. Хүрээлэнгийн асуудал хуучин Тамгын газрын дэргэд байсан юм байгаа юм. Тэгэхээр энийгээ нэг мөр Улсын Их Хурлынхаа дэргэд гарч байгаад ажиллах ийм боломж бололцоог нь бол бүрэн дүүрэн хангаж өгье гэсэн ийм байдлаар бол оруулж ирж байгаа шүү.

3 дугаарт, иргэний маргааны асуудал байгаа. Иргэний маргааны асуудал ер нь бол эд нар аливаа асуудал иргэнийхээ хуулиар бол шийдэгдээд явдаг шүү дээ. Тэгэхээр Ёс зүйн хороо ёс зүй талаасаа бол бид нар Ёс зүйн дэд хороогоороо бол тодорхой асуудлуудыг шийдье. Тэрнээс дээшээ гарсан асуудлуудыг бол тодорхой хэмжээнд иргэнийхээ.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 21 дүгээр сургуулийн Хишигдэлгэр багштай 12<sup>B</sup> ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа хүүхдүүддээ бас энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Нэмж хариулъя. Лодойсамбуу гишүүн нэмж хариулъя хууль санаачлагч.

**Ч.Лодойсамбуу:** Энхтүвшин гишүүний асуулт тэр нөгөө хариуцлага, үг хэлэх эрхийг нь хасах тухай хариуцлага, Үндсэн хуулийн зөрчил буюу гишүүний бүрэн эрхийг хязгаарлаж байгаа хэрэг биш үү гэж. Үндсэн хуулийн 3 дугаар зүйл дээр тодорхой заалттай байгаа нь иргэн, төрийн эрх мэдэл бүх ард түмний мэдэлд байна. Энэ ард түмнээ төрөө барих эрхээ төлөөллөөрөө дамжуулж эдэлнэ ээ гэж байгаа юм. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн өөрөө чуулганы хуралдаандаа оролцохгүй байх, саналаа хэлэхгүй байх, саналаа өгөхгүй байх нь өөрөө тэр Үндсэн хуулийн иргэний эрхийг нь өөрөө хаагаад байгаа үйлдэл болоод байгаа юм. Тэгэхээрээ Их Хурал өөрөө иргэний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хаагаад байгаа энэ үйлийг зогсоох үүднээс гишүүнийг хариуцлагажуулах ийм заалтыг оруулсан гэдэг талаас нь бид нар бодвол их зөв болж байгаа юм. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтүвшин:** Тэгээд энэ ирцтэй холбоотой асуудал дээр жишээлбэл энэ буцаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй энэ 126 гишүүний чинь 20 гаран нь ингээд Засгийн газрын гишүүд болчихсон тэгээд энэ ирцтэй холбоотой асуудал дээр биечлэн энэ санал өгөх, үг хэлэх асуудлууд дээр жишээлбэл Засгийн газрын бодлогоо танхимын зарчмаар гээд жишээлбэл эсрэг байр суурь илэрхийлэхгүй, үг хэлэхгүй иймэрхүү байдалтай байдаг. Тэгэхээр ийм энэ үг хэлсэн, асуулт асуусан гэдэг ийм чанарын биш ийм тооны асуудлаас хэт хөөцөлдөөд үндсэн Улсын Их Хурлын гишүүдийн ард түмний энэ эрхийг бас хөндөж байгаа иймэрхүү л зүйл, заалт болоод байна л даа. Тэгээд эрэмбээ хараад үзвэл тэр үг хэлнэ гэхээс тэр тоо гэхээс илүү байр сууриа илэрхийлнэ, саналаа өгнө гэдэг чинь бол илүү чухал зүйл, заалтууд байгаа.

Тэгэхээр энэний эрэмбэ зөрчилдөөд байгаа юм шиг санагдаж байна. Яах вэ хэлэлцүүлгийн явцад ярилцаад зарчмын зөрүүтэй санал гаргаад өөрчлөх бололцоо боломж.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ Их Хурлын тухай хууль болон Дэгийн тухай хууль дээр хэд хэдэн асуудал байна л даа. Яг Улсын Их Хурлын гишүүн бол хуулийн төслийг өргөн барих бүрэн эрхтэй. Тэр эрхийнхээ дагуу бас тодорхой судалгаа хийгээд тэрийгээ өргөн барьдаг. Гэвч зарим нэгэн хууль, тогтоол, хуулийн төсөл болон тогтоол, тогтоолын төсөл дээр Байнгын хорооныхон санал гаргуулах, дүгнэлт гаргуулах талаар нэг ийм заалт урьд нь байсан л даа. Тэгэхээр энэ урьд нь байсан энэ заалтаараа бүүр Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хууль зөрчсөнд зөрчиж байгаа тул гэж дүгнэлт гаргаж байсан юм. Тэгэхээр энэ чинь Үндсэн хуулийн цэцийн үүргийг аваад ингээд явчих өөр тусдаа институцийн ажлыг урдуур нь орж хийдэг ийм юм болчихоод байгаа юм. Тэгээд энийгээ бас нэг жоохон засаад нэг хүрээг нь зассан юм шиг байгаа юм. Тэгээд энэ талаар бас тодорхой мэдээллүүдийг өгчхөөрэй.

Хоёрдугаарх нь санал өгөхдөө түдгэлзэх саналыг яах юм бэ? Энийг ямар байдлаар зохицуулж байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл энэ чинь Их Хурлын гишүүн бол жишээ нь татгалзана, дэмжинэ гэсэн хоёрхон зүйлтэй. Гэтэл энэ асуудал дээр оролцохгүй байх, түдгэлзэх ийм асуудлууд байж байгаа. Энэ дээрээ тэгээд ямар энэ кнопоороо яаж шийдэх юм бэ гэдгийг бас асуумаар байна.

Гуравдугаарх нь бол яг Лодойсамбуу гишүүн яриад байна. Өөрөөр хэлбэл энэ үг хэлэх, ард иргэдийнхээ санаа бодлыг энэ төрд хүргэх тэр ажлуудыг бид нар асуултаар үг хэлж бас хүргэдэг. Гэтэл энэ минут тавьчаад тэгээд бид нарын нөгөө үг хэлэх эрхэд чинь шууд халдаад байгаа байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл энэ жишээ нь энэ түрүүлж орсон хүмүүс нь үгээ хэлчихдэг. Тэгэнгүүт бусад аймаг, сумдын иргэдийг төлөөлж байгаа тэр хүмүүс яагаад үгээ хэлж болохгүй байгаа юм бэ? Энэ дээр чинь гол асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ чинь иргэдийнхээ саналыг л энэ төрдөө хүргэх, тэр гүүр болох тэр үндсэн үүргээ бид нар яг энэ минутын хязгаарлалтаас болоод ерөөсөө хэрэгжүүлж чадахгүй байна.

Гуравдугаарх нь, дөрөвдүгээрх нь тэгээд энэ Дэгийн тухай хууль гарах болгондоо л тэгээд л миний эсрэг юм гаргадаг. Өнгөрсөн хугацаанд энэ дэгийн хууль өөрчлөгдөх болгондоо хэд хэдэн асуудлаар эсрэг юм шийдээд л явдаг миний хийж байгаа бүх зүйлийг бүгдийг нь хаах ийм л зорилгоор хэд хэдэн дэгийн хууль байсан. Одоо энэ залуу гишүүд гараад ирчихсэн Ардчилсан нам сөрөг хүчнийхээ үүргийг биелүүлээд ирэнгүүт бүүр их хааж эхэлж байх шиг байна.

Тэгээд зэрэг үг хэлж болохгүй, хашхирч болохгүй, аль эсвэл бусдын нэр хүндэд халдах юм бол шууд хориглоно гээд заачихсан. Тэгээд бусдын нэр хүнд гүтгэх гэд гэдэг заалтууд чинь тун удахгүй энэ Тэмүүжин гишүүний ажлын хэсэг Засгийн газар руу тодорхой хүсэлт явуулаад энэ гүтгэх асуудлаар санал оруулж ирэхийг даалгаж байгаа юм байна лээ. Тэгээд гүтгэх нь ороод ирнэ л дээ. Тэгээд Их Хурлын гишүүн гүтгэлээ гэхэд тэр шүүхээр аваачаад жижиг юу байдаг юм торгуулийн ял өгөнгүүтээ нөгөө шүүхээр шийдэгдсэн гээд нөгөөдөх гишүүнийг чинь буцаагаад татах ийм нөхцөл байдал руу бүгдээрээ орчихлоо шүү дээ. Ингэж хориглож болохгүй байхгүй юу даа. Энэ чинь мэдээж тодорхой үндэстэй үгийг хэлэх ёстой.

Уг нь тодорхой баталгаатай байх ёстой. Гэтэл энийг зүгээр ингээд л дураараа нэг хэн нэгэн албан тушаалтан, шүүхийг нь хуулийн хяналт, хуулийнханд хяналт тавьж байгаа тэр нөхөр нь нөгөө Их Хурлын гишүүнээ торгоод л тэгээд Их Хурлын гишүүнээс нь түдгэлзүүлэх ийм юм руу орчих ийм заалтыг оруулчихсан байна. Тийм учраас энэ дээр ямар асуудал.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Хууль санаачлагч хариулья Бат-Эрдэнэ гишүүн. Жадамбын Бат-Эрдэнэ. Нэмээд бас манай хууль санаачлагч гишүүд хариулж болно. Ариунзаяа гишүүн, Лодойсамбуу гишүүн, бусад гишүүд байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Бусдын нэр хүндэд халдах, гүтгэх доромжлох гэсэн асуудлууд бас нэлээн энэ чуулганы танхимд бол гардаг. Манай Пүрэвдорж гишүүн бол бас өөрөө нэлээн хатуухан үгтэй. Энэ дээр бас нэлээн жоохон эмзэг байх шиг байгаа юм. Тэгэхээр ер нь бол Ёс зүйн дэд хороогоороо хэдүүлээ асуудлуудаа

шийдье гэж байгаа юм. Тэн дээр байгаа асуудлууд хэрхэн шийдэх, хэрхэн хариуцлага тооцох гэдэг дээр хэдүүлээ ажлын хэсэг дээрээ бас ярьж болно. Нэг.

Тэрнээс цаашаа гарсан, хатуудсан, доромжилсон, гүтгэсэн үндэслэлгүй гэдэг ийм зүйл байвал мэдээж бид нар чинь Монгол Улсын иргэнийхээ хувьд бол иргэнийхээ хуулиар шийднэ шүү дээ. Тэрнээс наана дотор байгаа тэрнээс наана байгаа асуудлуудаа хэдүүлээ танхим дотроо аливаа хуралдаан чуулган, Байнгын хороо, дэд хороон дээрээ бол аливаа асуудал дээр хүлээцтэй хандах. Тэгээд болохгүй бол Ёс зүйн дэд хороогоороо бол шийдүүлье гэж байгаа.

Ёс зүйн дэд хороотой холбоотой 3, 4 заалт орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл санкцад тодорхой хэмжээний арга хэмжээ авах, уучлалт гуйх гэж байна жишээ нь бол. Цалингийн хэмжээг 20 хувиар бууруулах гэж байна гэх мэтчилэн ийм зүйлүүдийг оруулж ирж байгаа.

Үг хэлэх, аливаа хуулийг бол Улсын Их Хурлын гишүүн хуульд боловсруулж байгаа, санаачилж байгаа. Тэр дээр нь бол мэдээж судалгаа хийгээд оруулж ирж байгаа шүү дээ. Зарим нэгэн тийм поп шинж чанартай хуулиуд бол орж ирдэг ээ үнэн. Энэ бол төсөвтэй холбоотой асуудлуудыг төсвийг эвдсэн, тодорхой хэмжээний эдийн засагтаа хохирол учруулсан ч байдаг юм уу, тодорхой хэмжээний эдийн засгийн бас нэлээн зөрчилтэй, төсөв мөнгөний асуудалтай зөрчилтэй ч гэдэг юм уу ийм хуулиуд орж ирэх асуудлууд байдаг. Тэгээд энэ тохиолдолд бол таны саяын асуусан аливаа дүгнэлтийг бол Тамгын газар дээр гаргуулья гэж байгаа. Тамгын газар дээр, шинжээч дээр нь бол гаргуулья гэж байгаа.

Үг хэлэхтэй холбоотой асуудал бол мэдээж Үндсэн хуульд заасан асуудлууд байж байгаа. Сая Лодойсамбуу гишүүн ч бас тайлбар хийлээ. Ер нь бол мэдээж Монгол Улсынхаа иргэдийг төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүний хувьд бол үг хэлэх эрхийг бол бид нар бол хааж, хязгаарлаж бол тэр болгон болохгүй.

Гэхдээ энд 30 хоногоор гэж байгаа юм. 30 хоног байх уу, эсвэл магадгүй зүгээр тухайн чуулган дээр ч байж болно шүү дээ. Хэрвээ энэ чуулган дээр үймүүлээд байвал энэ чуулган дээр үг хэлэх эрхийг нь хасаж болно шүү дээ. Энэ дээр бол өөрчлөлтүүд хийгээд явахад бол бүрэн дүүрэн бололцоотой л гэж харж байгаа. Өөр юу байлаа?

**С.Бямбацогт:** Ариунзаяа гишүүн нэмээд хариулчихъя хууль санаачлагч.

**А.Ариунзаяа:** Пүрэвдорж гишүүний асуултад нэмэлтээр хариулья. Санал хураалт бол одоогийн явж байгаа зарчмаараа зөвшөөрсөн, татгалзсан гэсэн 2 хувилбараар бол байгаа. Түдгэлзсэн асуудал гэж байхгүй. Үндсэн хууль зөрчсөн гэж өөрөө үзэж байгаа бол санал хураалтад оролцохгүй ирцээс хасагдах энэ хувилбар бол хэвээрээ байгаа. Яг иргэний журмаар бас энэ гүтгэхтэй холбоотой асуултыг та асуулаа. Улсын Их Хурлын тухай хуулиар, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар 41.2 дээр гишүүний халдашгүй байдал бүрэн эрхийн баталгаа, төсөвтэй холбоотой, энэ үйл ажиллагаатай холбоотой гишүүний бүрэн эрхийн баталгаа дээр гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад үед хуулийн хариуцлага хүлээхгүй.

Мөн түүнчлэн гишүүнд хориглосон асуудал 44 дүгээр зүйл дээр 44.1.11 дээр бусдыг гүтгэж, доромжилж болохгүй ээ гээд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар байгаа.

Тэгэхээр хориглочихсон байгаа үйлдлийг үл тоогоод гүтгээд байвал яах вэ гэдгийг тодруулж өгч, иргэний шүүхээр шийдвэрлэгдэнэ шүү гэсэн л ийм тодруулга оруул.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Тодруулах уу? Пүрэвдорж гишүүн тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Намайг энэ хуулийн төсөл дээр санаачлагчаар нь гарын үсэг зураач ээ дарга нарын нэг учраас гэх дээр би зураагүй юм. Яагаад гэвэл энэ чинь дандаа сөрөг хүчнийхнээ боомилдог ийм л хууль. Дээрээс нь эрх баригч нам дотроо бас нэг үг хэлээд байдаг энэ Ганбаатар мэтийн хүмүүсийг хориглодог байхгүй юу, хорьдог байхгүй юу даа. Тийм учраас би санаачлагчаар гарын үсэг зураагүй.

Тэгэхээр жишээ нь Бат-Эрдэнэ гишүүний туслах хүүхэн Булган аймгийн Пүрэв-Очир гэдэг Засаг даргыг гүтгэсэн гээд өргөдөл өгөөд гишүүд өөрсдийгөө туслахаараа ингээд өгүүлчхэж байгаа юм л даа. Тэр нь ажлын албанд ирчихсэн юм шиг байгаа юм. Тэгээд ингээд нэгнийгээ ингээд л хэлсэн үгийнх нь төлөө ингээд л тийм нэг уулаасаа улаан цагаан би бол ерөөсөө ба ямар ч тийм баримтгүй юм ярьдаггүй хүн. Та нар өнөөдөр би өнгөрсөн 8 жилийн турш та нарыг шүүмжиллээ. Та нар тэгээд намайг Ёс зүйн хороонд өгөхгүй яасан юм?

**С.Бямбацогт:** Бат-Эрдэнэ гишүүн хариулъя хууль санаачлагч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ингээд асуудлууд чинь гарч ирж байна Пүрэвдорж гишүүн ээ. Булгантай холбоотой хүн болгон надтай холбоотой байж болохгүй байхгүй юу даа. Бүгдийг нь миний туслах бүгдийг нь миний хамтран ажиллагч эд нар гээд ингээд байж болохгүй л байхгүй юу даа. Тэр нэг бүсгүй гомдол гаргасан л юм байна лээ. Булганых нь Булган. Миний туслах биш. Миний туслах биш, бие төлөөлөгч биш, биш байгаагүй. Тэгэхээр энийг юу гэж ойлгох вэ? Гүтгэлэг гэх үү юу гэж ойлгох вэ? Ингээд л асуудлууд гарч ирж байгаа байхгүй юу.

Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя. Хууль санаачлагч нар бас асуултдаа гүйцэд хариулмаар байна. Жоохон буруу зөрүү мэдээлэл яваад л байх юм. Би бууж байгаад хариулах уу эс үгүй бол? Даргалж байгаад бас хариулах жаахан тийм л байгаад байна л даа. Дүгэрийн Рэгдэл гишүүн.

Уучлаарай зочин танилцуулаадахъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Сэлбэ” сургуулийн Бадам багштай 12<sup>а</sup> ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа нийт сурагчдадаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сурлагын өндөр амжилтыг хүсье. Тэгээд удахгүй 12 дугаар ангиа төгсөн хүссэн сургуульдаа орж, хүссэн мэргэжлээ эзэмшиж, улс эх орондоо хэрэгтэй, бүтээлч, хариуцлагатай иргэн болж болоорой гэж хүсэн ерөөе.

**С.Бямбацогт:** Пүрэвдорж гишүүн тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Мэдээж Их Хурлын гишүүн энэ Их Хурлын чуулганд болон Байнгын хороонд үг хэлэхдээ бол хариуцлагатай байх ёстой. Ямарваа нэгэн баримтгүйгээр хүн амьтан гүтгэж болохгүй. Тэр бол мэдээж. Тийм ч учраас Пүрэв-Очир гэдэг хүнийг хууль бусаар томилогдчихсон гэдгийг нь Бат-Эрдэнэ гэдэг дарга хамгаалаад л байгаа юм л даа. Би тэрийг нь баталгаажуулж байгаа юм. Намайг Ёс зүйн хороонд өгсөн учраас би бүх материалыг нь өгөх гэснээ ерөөсөө энэ нэг Их Хурлын гишүүн нь нөгөөдхийгөө ингээд шалгуулаад явж байдаг ямар юм байдаг юм гэж бодоод өгөөгүй.

Ер нь бол үг хэлснийхээ төлөө энд хариуцлага хүлээх юм бол, хариуцлага хүлээх юм бол та нарыг бүгдийг чинь тэр хориглоно гэдгийг юуны дагуу иргэний шүүхэд өгөөд ч юм уу эрүүгийн, гүтгэхээр бол эрүүгийн заалт жишээ нь Засгийн газар оруулаад тэр нь батлагдлаа гэх тохиолдолд гүтгэхээр бүгдийг чинь та нарыг торгоод тэгээд торгосон учраас шүүхээр ял.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Пүрэвдорж дарга та бас намайг мэднэ дээ. Уг нь бол нэг жоохон жижигхэн юмаар бол шалчиг шалчиг хийгээд байдаг хүн биш шүү дээ. Би хэрвээ ярихаар бол тантай өөртэй чинь очоод тулаад ярьчих байх. Түүнээс биш зүгээр тойруулаад ингээд, тойруулаад ингээд янз янзын юмнууд ингээд ярих юм байхгүй. Тийм болохоор, тийм болохоор аливаа зүйл бол зарчмынхаа дагуу л байх ёстой. Би сая яг үнэнээ хэллээ шүү дээ. Би сая яг үнэнээ хэллээ шүү тийм. Би яг үнэнээ хэллээ шүү. Багахан шиг шалчигнасан нь дээр байх даа.

**С.Бямбацогт:** 2 Улсын Их Хурлын дэд дарга маань тийм хуулиа тайлбарлаж, яг хуулийнхаа зүйл, заалтыг яримаар байна. Хувийн асуудлыг хоорондоо бас энд яримааргүй байна. Ариунзаяа гишүүн тайлбарлаад өгчих.

**А.Ариунзаяа:** Пүрэвдорж гишүүн болон Бат-Эрдэнэ гишүүд нарын 2 дэд даргын яриад байгаа асуудлаар Ёс зүйн дэд хороон дээр гомдол ирээд надад хуваарилагдаад би энэ асуудлыг авч үзээд тэгээд ёс зүйн зөрчил үүсээгүй байна гэж дүгнэсэн шүү Пүрэвдорж гишүүн ээ. Баримтыг ярьсан байна. Одоо шалгагдаж байгаа юм байна гэдэг асуудлыг ярьсан.

Гэхдээ энэ асуудлаар бусдыг гүтгэж доромжилно гэсэн үг биш, зөвшөөрөгдөж байгаа гэсэн асуудал биш. Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжилж, гүтгэхээс бусад тохиолдолд хуулийн хариуцлага хүлээхгүй гэж одоогоор нь байгаа. Тэгэхээр бусдыг үнэхээрийн хүн алаад чандарлачихсан гэж гүтгэж байгаа бол энэ чинь өөрөө иргэний шугамаараа шийдвэрлэгдэх ёстой. Ерөнхийлөгч хүртэл бусдыг гүтгэсэн, доромжилсон хүмүүсийг эргүүлэн татах ёстой. гэдэг хуулийг оруулж ирээд бид нар хүлээгээд авчихсан шүү дээ. Тэгээд одоо яагаад ийм юм ярьцаагаад байгаа юм. Хариуцлагатай байх ёстой.

Тэгэхээр Ёс зүйн дэд хороонд бол тэгээд хариуцлагатай хүмүүс нь ороод өөрсдөө энийгээ ярьж байх ёстой. Тэгэхээр энэ агуулгаар нь харцгаагаарай. Битгий хувийн амбицаар ярьцаагаад бай.

**С.Бямбацогт:** Яах юм бэ 2 удаа тодруулчихсан Пүрэвдорж дарга. Та бас дэгээ барья. 2 боломжгүй шүү дээ. Тэгээд энэ чинь хуучин гүтгэх, гэмт хэрэгт

холбож гүтгэж доромжилж болохгүй гэсэн заалт байж байгаа тэр заалт хэвээрээ л байж байна шүү дээ. Хэвээрээ байж байгаад шинээр оруулчихсан юм шиг тэгээд бас гүтгэж болох юм шиг ярьж болохгүй байх. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя.

**Д.Рэгдэл:** Би ярья. Одоо та нар болиоч ээ боль боль. Баярлалаа Пүрэвдорж ээ.

Энэ нэмэлт, өөрчлөлтийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь дэмжиж байгаа. Асууж тодруулах зүйл бас байна.

1 дүгээрт, энэ Байнгын хороонытой холбоотой тоотой холбоотой асуудал. Ер нь Их Хурлын Байнгын хорооны тогтвортой байлгамаар байгаа юм. Ер нь асуудлын хүрээгээ ингээд бодоод хуваагаад үзэхэд энэ 11 Байнгын хороотой байх явдал бол илүү зохимжтой. Асуудлаа хувааж байршуулж, хувааж шийдэхэд. Тийм учраас ер нь энийг бол нэг мөр шийдээд 11 Байнгын хороотой байхгүй бол бид нар чинь 2 жил болоогүй байж 3 Байнгын хорооны бүрэлдэхүүнтэй л, бүртгэлтэй ажиллаад байна.

Байнгын хорооны хувьд намайг нэг баярлуулж байгаа зүйл байгаа юм. Анх удаа шинжлэх ухаан, технологи, инновацын бодлогын асуудал нэг Байнгын хороо дээр орж ирсэн. Энэ бол маш зөв, маш зөв. Улсууд инновац цахим бодлого руу инновац нь цахим бодлого дээр байна гэсэн байр суурьтай байдаг. Энэ бол маш буруу байр суурь байгаа юм. Энэ бол баярлуулж байна.

2 дугаарт, энэ Байнгын хорооны дотор нэг асуудал ерөөсөө орхигдоод байгаа юм. Энд тэнд тараагдаж тавигдсан, зарим чухал асуудал бол бүүр байхгүй байна. Жишээлбэл энэ үйлдвэржилтийн бодлогын асуудал. Бид нар Хүнс хөнгөн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлогын хороо байгуулчхаад Үйлдвэржилтийн бодлогын хорооны зарим юмыг бол Эдийн засгийн байнгын хороон дээр аваачиж тавьчхаад, зарим нь бол ерөөсөө хаана ч байхгүй. Тэгээд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асуудал бол алга. Өндөр технологи хөгжүүлэх асуудал бол энд үндсэндээ байхгүй байна.

Тийм учраас энэ 22.6.8 дээр байгаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлогын асуудалтай энэ хэсгээ бол ер нь Үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын байнгын хороотой л баймаар байгаа юм. Тэгээд энэ Байнгын хороон доороо үйлдвэрлэлийнхээ асуудлыг төвлөрүүлээд авч явмаар нэг ийм санал байгаа.

2 дугаарт, энэ хуулийн дотор гишүүдийнхээ ирц, санал биечлэн өгөх хөшүүрэг бий болгож, бүтээмжийг нэмэгдүүлэх талаар нэлээн өөрчлөлтүүд оруулж байгаа юм байна. Би дэмжиж байгаа. Тэгэхээр гишүүдийн бүтээмжид нөлөөтэй нэг чухал асуудал бол гишүүний ажлын байрны асуудал байгаа юм. Одоо миний ойлгож байгаагаар бол өөрийн гэсэн ажлын байргүй гишүүн нэлээн олон байгаа. Тэгэхээр би Бямбацогт даргаас энийг асуугаад байгаа юм. Өөрийн гэх ажлын байргүй учраас тэр ажлын байр, унаа машин, гэр оронд нь нэгжлэг, үзлэг явуулах асуудал бол нээлттэй байгаад байгаа. Гишүүн 16м<sup>2</sup> өрөөндөө туслахтайгаа хамт суудаг. Тэгэхээр туслахын өрөө юм уу, гишүүний өрөө юм уу маш тодорхойгүй.

Тийм учраас энэ гишүүнийг дангаараа тэр жижигхэн өрөөндөө сууж ажиллах энэ боломжийг бүрдүүлэх талаар Их Хурал маань ямархуу, Их Хурлын дарга маань бас ямархуу юм ажил төлөвлөж байгаа юм бол гэж ингэж асуумаар байгаад байгаа юм.

Байнгын хорооны хувьд бол Байнгын хороонууд даргатай. Тэгэхээр Байнгын хорооны даргыг эзгүйд ажлын хэсгээс асууж байгаа Байнгын хорооны даргын эзгүйд хэн орлох вэ гэдэг асуудал бол нээлттэй хэвээрээ байгаад байгаа. Дэд хорооны дарга эзгүй байхад Их Хурлын дарга захирамж гаргаад орлуулах хүнийг нь томилчихно гэж заасан энэ хуульд. Тэгэхээр Байнгын хорооны дарга маань эзгүй үедээ хэн нэг гишүүнээсээ амин хувиараа бараг гуйх маягтай л ажлаа орлуулдаг. Тийм учраас энэ Байнгын хороонуудыг дэд даргатай байлгаж өгвөл ямар юм бэ гэсэн нэг ийм ийм л 3 асуулт байна. Эхний удаа. Тэгээд хариулт авч байгаад тодруулах юм байгаа.

**С.Бямбацогт:** Тэр гишүүдийн өрөөтэй холбоотой асуудал үнэхээр Төрийн ордон бол багтдаггүй. Төрийн ордондоо Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Их Хурал, Их Хурлын гишүүд, туслахууд, зөвлөхүүд, Тамгын газрын ажилтнууд, мөн Засгийн газар, Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бүгдээрээ нэг байшин дотор сууж байгаа. Ер нь хэзээний л өрөө тасалгаа хүрэлцдэггүй байсан. 76 гишүүнтэй байхдаа хүрэлцдэггүй байсан. Одоо 126 гишүүнтэй болоод бүүр хүрэлцэхээ больсон. Үнэхээр хүнд болсон байгаа. Төрийн ордныг бас шинэ парламентын ордонтой больё гэдэг асуудал 10, 20-оод жилийн өмнөөс яригдаж эхэлсэн. Хэд хэдэн хувилбар яригдаад төсөв мөнгөнөөсөө болоод мөн бас байршлаасаа болоод ерөөсөө их явдаггүй. Хэрвээ Төрийн ордон, парламентын ордон бас бариад эхэллээ гэх юм бол ард түмэн бас ард иргэдийн амьдрал хэцүү хүнд байх үед өөрсдөө өрөө, тасалгааны асуудлаа бариад эхэллээ гээд бас иргэд шүүмжилнэ гээд бас гишүүд бас болгоомжилдог. Иймэрхүү олон шалтгааны улмаас парламентын ордонтой болох асуудал бол олон жил саатаж ирсэн. Одоо ч гэсэн бол бас үүнийг барихад бас нэлээн хүндрэлтэй байх. Зүгээр хаана барих вэ, яаж барих вэ гэдэг дээр тодорхой ажлын хэсэг гаргаад тодорхой судалгаа тооцоо хийгээд, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг нь боловсруулаад улс орны эдийн засаг сайжирсан үед барих бололцоо, боломж бий болсон үед бас барих барьж эхлүүлэхээр иймэрхүү байдлаар л судалгаа хийлгэхээс өөр аргагүй байгаа. Энийг бас гишүүд маань зөв ойлгоорой.

Одоо ингээд Байнгын хороодын тоо нэмэгдэхээр дахиад л нөгөө Байнгын хороод чинь ядаж нэг давхар өрөөнд суух ёстой. Тэгтэл давхар өрөө хүртэл олдохооргүй ийм хүнд байдалд орж байгаа. Тэгээд ийм л бодитой нөхцөл байдал бол та бол хэлж байна. 15м<sup>2</sup> жижигхэн өрөөнд гишүүд туслах, зөвлөхүүдтэйгээ сууж байгаа. Үнэхээр ийм л нөхцөл байдалд бид ажиллаж байгаа. Нөхцөл байдалдаа дасан зохицоод ажиллахаас өөр боломжгүй байгаа. Тэгээд ямар ч байсан бол ажлын хэсэг гаргаад тэр хаана барьж болох вэ, яаж барьж болох вэ гэдэг дээр тодорхой тооцоо, судалгаа хийлгэх тал дээр анхааръя. Бусдаар бол барих боломж бол нэлээн хүнд хэцүү байгаа шүү. Улсын төсөв хүнд байгаа учраас. Энийг та зөв ойлгоно уу.

Бусад асуултад нь Бат-Эрдэнэ дарга хариулчих уу? Хууль санаачлагч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Рэгдэл гишүүн Үйлдвэржилтийн байнгын хорооны асуудлыг ярьж байх шиг байна. Бид нар чинь бас Үйлдвэржилтийн байнгын хороотой байсан л даа. Би ч дотор нь бас ажиллаад явж байсан. Яг үндсэндээ бол 1 дүгээрт яг Үйлдвэржилтийн байнгын хороон дээр ачаалал бол 1 дүгээрт багатай байсан.

2 дугаарт, үйлдвэржилтийн байнгын хорооны бодлого Эдийн засгийн байнгын хорооны бодлоготойгоо бас уялдаад, давхцаад байсан юм. Тийм болохоор хөнгөн үйлдвэртэй холбоотой асуудал бол Хүнс, хөдөө аж ахуйнхаа байнгын хороон дээр бол харьяалагдаад явчхаж байгаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн байнгын хороо гээд.

Хүнд үйлдвэртэй холбоотой асуудлууд нь Эдийн засгийн байнгын хороон дотор ороод явчхаж байгаа. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд ороод явчхаж байгаа юм.

Дэд хорооны даргыг орлуулах асуудал, хэрвээ дэд хорооны дарга томилолттой эд нар байх тохиолдол бол дэд хороо болон Байнгын хороо бол дотроосоо аль нэг гишүүнээ бол сонгоод тэрийгээ бол захирамжаар, Улсын Их Хурлын даргын захирамжаар Байнгын хороо бол даргаа орлуулаад явчихна. Дэд хорооны хувьд бол тодорхой заалт бол байгаа билүү? Ямар ч л байсан хэрвээ шаардлагатай бол Байнгын хорооноосоо гаргах хувилбар байж болох юм уу? Энэ дээр бол тодорхой заалт байгаа билүү? Өшөө нэмж хэлье. Гишүүд хар даа.

**С.Бямбацогт:** Ариунзаяа хууль санаачлагч гишүүн нэмж хариулъя.

**А.Ариунзаяа:** Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 25.9 дээр Байнгын хорооны дарга 7 ба түүнээс дээш хоногоор эзгүй байвал захирамжаар нэг гишүүнд түр хариуцуулж байгаа. Үүнтэй нэгэн адилаар шинэ өргөн баригдаж байгаа энэ нэмэлт, өөрчлөлт дээр дэд хорооны даргыг мөн түүнчлэн захирамжаар 7 хоногоос дээш хоногоор эзгүй байвал захирамжаар хариуцуулна гэсэн ийм заалт шинээр орж байгаа.

Тэгэхээр Байнгын хорооны даргыг 7-гоос дээш хоног эзгүй байвал захирамжаар өөр гишүүнд хариуцуулах зохицуулалт одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар явж байгаа гэдгийг хэлье ээ. 7-гоос доош хоногтоо байвал тухайн үедээ л аль нэг гишүүнд нь түр хариуцуулаад л явж байгаа.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа нийт ахмадууддаа амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс өргөн дэвшүүлъя.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя. Рэгдэл гишүүн тодруулж асууя.

**Д.Рэгдэл:** Тэр ажлын байрны хувьд бол асуудал хүнд байгааг ойлгож байгаа. Тэгэхдээ 1 зүйлд та бүхэн маань анхаараарай. Хэрвээ ямар нэгэн асуудал гараад Их Хурлын гишүүний туслахын ажлын байранд үзлэг, нэгжлэг хийх бол Их

Хурлын гишүүний ширээ сандал тэр бол хамрагдах нөхцөл байгаад байгаа. Маш эрсдэлтэй нөхцөл байгаа шүү. Тийм учраас энэ талд зай талбайгаа ашиглаад туслахууд нь нэг дор ч болсон нэг ширээ сандал тавьж өгмөөр байгаа юм. Байшин барих асуудал яах вэ дараагийн Их Хурал бариулаад л явна биз гэж бодож байна.

2 дугаарт, энэ Байнгын хорооны, Үйлдвэржилтийн байнгын хороо байсныг би бол би сайн мэднэ, байсан юм. Тэгэхээр энэ дээрээ үйлдвэржилтийн бодлого бол амин сүнс. Эдийн засаг дээр бүгд цуглаж хэлэлцэгдэх ёстой. Тэгэхээр үйлдвэржилтийн байнгын хороо гэж байгуулах хэрэгтэй байгаа юм. Зүгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр гэдэг нь бол бие даагаад бай.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Гүйцээгээд асуучихъя асуултаа дуусгая.

**Д.Рэгдэл:** Тэгээд цаана нь энэ хаягдчихаад байна гэдэг энэ ажлын хэсэг бол бас сайн ойлгоорой. Жишээлбэл сая би хэллээ шүү дээ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асуудал ерөөсөө байхгүй. Өндөр технологийн үйлдвэрлэлийн асуудал байхгүй. Энэ бол Монгол Улсын хөгжилд бас л их чухал салбарууд байгаа. Тийм учраас ажлын хэсэг энэ Үйлдвэржилтийн байнгын хороо гэдгийг бас нэг эргэж сайн хараарай. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Равжихын Эрдэнэбүрэн гишүүн. Хэн хариулах юм? Хариулья.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ байртай холбоотой асуудал дэд даргын хувьд бол миний бие хариуцдаг. Тэгээд Рэгдэл гишүүн бас нэлээн зөв асуудлуудыг хөндлөө. Ер нь бол цааш цаашдаа бид нар бас нэг парламентын гэсэн өөрийн байртай байх ёстой. юм. Одоо яг үнэндээ бол бид нар гишүүд бол маш жижигхэн өрөөнд сууж байгаа шүү дээ. Зарим нь бол бүр туслахуудтайгаа сууж байгаа. Тэгэхээр энэ ажиллах боломж бололцоогүй бол гаднаас харахад бол бол их л том өрөө байранд ажиллаад байдаг байх гэж боддог байх иргэд маань. Яг үндсэндээ бол зарим гишүүд маань бол бүүр их жижигхэн байранд бол сууж байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт, ер нь бол цаашдаа парламент гэдэг бол өөрөө том институц. Энэ бол ард иргэдийг төлөөлж байгаа, ард иргэдийн саналыг төлөөлж, боловсруулж байгаа, хууль боловсруулж байгаа ийм том институц. Энэ өөрийн гэсэн том байртай байх нь, өөрийн гэсэн байртай байх нь зүйтэй байгаа юм. Саяхан 1 асуудал гарсан. Одоо бол бид нар чинь Засгийн газрын байранд байж байгаа. Тэгээд.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя.

**Р.Эрдэнэбүрэн:** Энэ Их Хурлын тухай хууль, дэг энэ тэр чинь хэлэлцүүлэг нь бол тусдаа явж байгаа биз дээ дарга аа? Хяналт шалгалт энэ тэр чинь нэг явж байна уу? Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ юу бол 2 үндсэн хэсэгтэй юм байна гэж ойлгосон. Нэг хэсэг нь бол Байнгын хороог өөрчлөх, нөгөө хэсэг нь тэгээд нөгөө гишүүдийн сахилга батыг сайжруулах гээд энэ би зөв бодож байна уу буруу бодож байна уу?

2 дугаарт, энэ 24 онд 11 Байнгын хороотой, 25 онд дахиж өөрчлөгдөөд 8 Байнгын хороотой, одоо дахиад 11 болгож байгаа ийм юу явж байгаа юм шиг

байна. Тэгээд энэний 24 онд хууль батлахдаа яагаад 11 гэсэн юм? 25 онд яагаад буцаагаад 8 болгосон юм? 20, одоо ингээд дахиад 11 болгож байгаа юм байна. Энэ бүх юунууд дээр тэр өөрчлөлт болгон дээрээ яагаад, ямар үндэслэлээр ийм өөрчлөлтүүд хийсэн юм бэ гэдэг судалгаа байна уу 1 дүгээрт?

Одоо бол ярьж байгаа нь бол ирц хүрэхгүй байна. Тэгээд энэ хууль батлагдах юм бол боловсролын салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, багш нарын чанар сайжрах, 3 ээлжээр хичээллэж байгаа тоо хэмжээг бууруулах, хүүхдийн хүмүүжил төлөвшил, боловсролын чанарын бодол, оновчтой шийдэл гаргах энэ тэр гээд иймэрхүү юмнууд бичсэн байна. Тэгээд энэ чинь энэ яамных нь ажил биш юм уу, Засгийн газрын ажил биш юм уу? Заавал Байнгын хороо өөрчлөгдөхөөр сайжрах гээд байна гээд хэн засаг тэгээд байгаа юм уу? Эхний асуулт нь ийм асуулт асуумаар байна. Тэгээд энэ Байнгын хороог ингэж өөрчлөх гээд байгаа тэр олон болохлоор чинь улам л ирц нь хүрэхээ болино биз дээ?

Хоёрт нь бид нар энэ парламент 2 жил энэ дэгээр явлаа. Энэ парламентын сахилга хариуцлагыг сайжруулах эд нар гээд энэ ирц, оролцоог хэтэрхий ийм механик байдлаар шийдэх гэж их оролдож байна гэж хараад байгаа юм. Хуралдаа суух, заавал өөрөө санал өгөх, үг хэлэхдээ томоотой үг хэлэх энэ тэр гээд. Парламент чинь бол өөрөө мэтгэлцээн хийж байдаг газар. Аливаа асуудлуудыг мэтгэлцээд тэр мэтгэлцэхдээ бол эмоцтой ч байдаг, зарим газар бол бүүр зодолдож байгаа харагддаг. Зодолдоод сүйд болохоо больё гэхэд энэ мэтгэлцээн дундаас чинь хүмүүсийн анхаарлыг татсан энэ мэтгэлцээнүүд дундаас иргэд, сонгогчид юу болоод байгааг харж байдаг, олж авч байдаг. Одоо ингээд бүүр мэтгэлцээн байхгүй болгож байна шүү дээ. Одоо бүүр сүүлийн үед ялангуяа ингээд бие бие рүүгээ тэр над руу муухай харж байх шиг байна гээд л гараад хэвлэлийн хурал хийдэг болсон. Энэ намайг ингэж хэлэх гээд байх шиг байна гээд л хэвлэлийн хурал хийж байдаг болсон. Тэгээд ийм мэтгэлцээн байхгүй парламент гэдэг бол өөрөө үхмэл тийм парламентынхаа үүргийг биелүүлж чадахгүй, гүйцэтгэж чадахгүй болж байна л гэж ингэж харж байгаа.

Тэгээд би дараа нь бас дэгийн юун дээр өөрчлөлтүүд дээр бас асуулт асууж, саналаа хэлэх гэж байгаа дэг дээр. Дэгээс бас их болж байгаа юмнууд их байгаа. Тийм учраас энэ Ёс зүйн хороо эд нар гэдгийгээ ер нь аль болохоор жоохон сулруулахгүй бол ер нь тэгээд л бүгдээрээ л нэг юм Ёс зүйн хороогоор айлгасан, ёс зүй ярьсан л ийм л юу боллоо. Өмнө нь их амьд парламентууд байсан. Тэр үед зарим хүмүүс хоорондоо бие биеэ шанаадаад энэ тэр явж байсан тийм юм гарч л байсан. Одоо нэг их тэгээд зодолдож бариад сүйд болохоо болих гэхэд үгүй ядах нь ээ ингээд чөлөөтэй жоохон ярьчихдаг, эмоцтойдуухан хэлэлцүүлэг хийчихдэг тийм юм руу аваачиж байж байж. Энэ парал.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** 8 Байнгын хороо, 15 дэд хороотой байсан. Энийгээ 11 байнгын хороо болгож байгаа. Энэ яагаад 8 дэд хороогоо 8 болгоод, дэд хороогоо 15 болгоод 8 Байнгын хороотой болсон юм бэ гэхээр ер нь даргын зөвлөл дээр 2024 онд бид орж ирээд даргын зөвлөл дээр бас нэлээн ярьсан юм. Үндсэн хуульд өөрчлөлт хийгээд холимог тогтолцоотой олон намын тогтолцоотой болчихлоо, 5 нам эвсэлтэй болчихлоо. Тэгэхээр даргын зөвлөлөө бол бас нэлээн өргөжүүлье.

Зөвхөн бүлэг бүхий 2 Ардчилсан нам, Ардын нам 2 ингээд хоорондоо хуралдаад байх биш, бусад нам, эвслээ бас оруулъя. Даргын зөвлөл дээр бас орж ирж асуудлуудаа үздэг, ярьдаг, хэлдэг байя.

Дээрээс нь Байнгын хороогоо, дэд хороогоо нэмэгдүүлье гэсэн ийм шийдвэр гарч байсан юм. Дэд хороогоо олон болгоё. Хуучин 76 гишүүнтэй байсан бол одол 126 гишүүнтэй болчихлоо. Маш олон залуучууд орж ирлээ. Маш олон идэвхтэй судлаачид, мэргэжилтэн, салбар салбарын мэргэжилтнүүд орж ирлээ. Тийм болохоор ер нь бол ажлаа бол нэлээн өргөжүүлье. Ингээд өргөжүүлээд дэд хороогоо олон болгоод үзье гэсэн нэг ийм санал гарсан юм. Ийм логигоор бол 15 болгоод тэгээд дэд хороон дээрээ ажиллаг, дэд хороон дээрээ саналуудаа гаргаг, олон залуучууд ажиллах бололцоог нь хангая. Тэгж байгаад буцаад Байнгын хороон дээрээ хумьж орж ирдэг ийм байдлаар нэг үзээдэхье гэж оруулж ирж анхны санал бол ингэж гарч байсан юм байгаа юм. Тэгээд яах вэ зарим дэд хороон дээр бол бас тэр болгон бол хуралдаагүй. Тийм болохоор ер нь буцаагаад бол бас жоохон хумих нь зүйтэй юм гээд ийм санал орж ирж байгаа шүү.

Мэтгэлцээний хувьд бол мэдээж нэгдсэн чуулган болоод бусад Байнгын хорооны хурал бол мэдээж Улсын Их Хурлын гишүүдийн хувьд бол гол мэтгэлцээний талбар байх ёстой. Мэтгэлцээний талбар байх ёстой. Үүнийхээ хүрээнд бид нар бол Дэгийн тухай хуульдаа бас өөрчлөлт оруулж ирж байгаа. Маргаашаас бас энэний дараагаар бас яригдаад явах байх. Шаардлагатай бол чуулганы хуралдаан дээр Их Хурлын дарга юугаа өөрчлөөд, процедураа өөрчлөөд мэтгэлцэх бололцоог нь өгчихье гэж байгаа юм. Нэг цаг, 60 минут хүртэл мэтгэлцчихье тодорхой асуудлуудаар.

Тэгэхгүй бол асуулт хариулт, асуулт хариулт гээд эндээс бол нэг их олон асуултууд гол шийдэл бол гарч өгөхгүй байгаад байгаа. Тийм болохоор мэтгэлцэх боломж, бололцоог харин энэ хуулиар гаргаж ирье гэсэн ийм санал орж ирж байгаа шүү.

**С.Бямбацогт:** Одоо чинь дэгээрээ 4 минутаар асуугаад 3 минутаар хариулаад тодруулж 1, 1 минутаар 2 удаа тодруулж асуух тэгээд 1, 1 минутаар хариулах ийм дэгтэй байгаа. Энэ дэгийн зохицуулалтыг нийт 8 минутдаа багтаагаад 1 минутаар асуугаад 1 минутаар хариулуулаад ингээд 8 удаа асуулт, хариулт авах ийм бас боломжийг нээж өгч байгаа.

Дээрээс нь үнэхээр ингээд асуулт хариулт хангалттай болохгүй. Үнэхээр асуудал маань чухал, ойлголт маш том зөрүүтэй байгаад байх юм бол энэ асуулт, хариултын горимоо зогсоож байгаад тодорхой хугацаанд мэтгэлцэх, талууд хоорондоо мэтгэлцэх ийм чөлөөтэй дэгийн зохицуулалт бас орж байгаа. Иймэрхүү байдлаар таны хэлж байгаа нөгөө парламент дээр хэрэлддэг биш хэлэлцдэг, маргалддаг биш мэтгэлцдэг ийм үнэхээр асуудлуудыг олон түмний мэдэх эрхийг хангах иргэдийн энэ боломжийг бий болгох ийм зохицуулалтуудыг бас нэлээн оруулж өгсөн байгаа гэдгийг бас танд нэмж хариулъя.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн болон Сандаг-Очир гишүүн бас нэмж хариулъя. Тодруулсных нь дараа хариулчихъя. Эрдэнэбүрэн гишүүн .

**Р.Эрдэнэбүрэн:** Мэдээж гишүүд ингээд хууль санаачлаад явах эрхтэй. Тэгэхдээ энэ Их Хурлын бүтцийн асуудал ярьж байна. Сая ингээд харж байхад бол 2 дэд дарга маань ч гэсэн энэ асуудал дээр ойлголцсон зүйл байхгүй байгаа харагдаж байна. Бүлэгтэй, манай намын бүлэгтэй, намын даргатай ярилцсан, хэлэлцсэн ийм зүйл байдаг уу? Энэ чинь Их Хурлын бүтцийн асуудал ярьж байна. Нэлээн хоорондоо зөвшилцөж ярьж байж сайжруулбал уул нь илүү үр дүнтэй юм шиг байгаа юм. Заавал ч үгүй саналын тоогоор ч юм уу ингээд санал хураалтаар шийдээд байхаасаа илүү. Тэгвэл их үр дүнтэй болмоор юм шиг санагдах юм. Тэгээд энэ тал дээр Бат-Эрдэнэ гишүүн ярьсан зүйл байдаг уу манайхантай? Бусад намуудтайгаа ойлголцоод юу яасан юм байдаг уу?

**С.Бямбацогт:** Энэ дээр би хариулчихдаг юм уу. Би одоо доошоо бууя даа. Пүрэвдорж дарга удирдъя. Би асуултад бас хууль санаачлагчийн хувьд хариулаад явъя нэмээд.

Энэ хуулийн төслийг Улсын Их Хурлын дарга Учрал байх үед, Төрийн байгуулалтын дарга байнгын хорооны дарга Сандаг-Очир дарга байх үед хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаад Сандаг-Очир дарга ахлаад нэлээн юмнууд хийчихсэн байсан. Тэгээд тэр үедээ бол даргын зөвлөлд танилцуулаад, бүлгүүд дээр танилцуулаад саналыг нь авчихсан. Дараад нь даргын зөвлөл дээр энэ хуулийн төслүүдийг энэ Их Хурлын тухай хуулиуд, Их Хурлын тухай хууль, Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай энэ 3 хуулийг даргын зөвлөл дээр 2, 3 удаа хэлэлцээд саналуудаа нэгтгээд ингээд энэ ажлууд хуулиуд маань өргөн баригдсан гэдгийг бас нэмж мэдээлэл өгье.

Сандаг-Очир гишүүн хууль санаачлагч хариулья.

**Ц.Сандаг-Очир:** Эрдэнэбүрэн гишүүн түрүүн асуугаад байна лээ яагаад 11 болчихсон юм бэ 8 байж байгаад гээд. Яах вэ бид нар ажлын хэсэг дээрээ яриад Байнгын хороодын тоог бол ер нь бол Засгийн газар болоод Улсын Их Хурлын хоорондын уялдаа холбоог хангах үүднээс энэ Байнгын хороодыг бас Засгийн газрын бүтэцтэйгээ бас ойртуулж, Засгийн газар яамдын бүтцийг харгалзаж байгаад Их Хурлынхаа Байнгын хороодыг бас харьяалуулж байгаа. Тухайлбал, одоо хэрэгжиж байгаа энэ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо гээд асар том Байнгын хороо байгаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, эрүүл мэнд, хөдөлмөр халамж гээд. Тийм учраас ийм том Байнгын хороог 2 хуваагаад Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороог нь тусад нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамных нь харьяанд нь өгөөд, Боловсрол, шинжлэх ухааных нь Байнгын хороог Боловсролынхоо яамандаа өгөөд ингээд явах нь бол зохимжтой юм байна.

**Б.Пүрэвдорж:** Нэмж хариулья.

**Ц.Сандаг-Очир:** Одоогийн. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороог 2 хуваагаад 2 яамных нь бүтцэд нь байх нь илүү зохимжтой юм байна гээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн байнгын хороог манай яаманд харьяалуулаад яг хөдөө аж ахуйн байнгын хороог нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд нь байх нь зохимжтой юм байна гээд яам яамандаа Байнгын хороо Байнгын хорооны эрхлэх асуудлынхаа хүрээнд байх нь цаашдаа Засгийн

газар, Улсын Их Хурлын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаад явах нь илүү зохимжтой юм байна гэдэг үүднээс 8-ыг 11 Байнгын хороо болгож оруулж ирж байгаа шүү.

**Б.Пүрэвдорж:** Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Одоо асуулт асууна. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

**Г.Очирбат:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Тодорхой 3, 4 асуулт байна.

1 дүгээрт энэ Их Хурлын дэгийн чуулганы, Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хуулийг гурвууланг нь багцалж оруулж ирдэг нь ямар учиртай юм бэ? Энийг асуучихъя. Дэс дараатайхан шиг Их Хурлын тухай хуулиа эхэлж явуулаад Дэгийн тухай хуулиа араас нь явуулаад, хяналт шалгалтаа явуулаад ингээд нэг засаг замбараатай явж болохгүй байсан юм уу? Нэг.

Хоёр гэх юм бол энэ ер нь энэ 3 хуулийн төсөл чинь уялдаа холбоотой цаашаа явна гэж үзэх л байх. Тэгэхдээ заавал ийм түргэвчилсэн, яарсан маягтай оруулж ирж байгаа нь ямар учиртай юм? Энэ дээрээс давхар асуулт асуучихъя. Тэгээд Их Хурлын дарга бол дарга болохоосоо өмнө энэ 5 нам байна бүгдийнх нь дуу хоолойг оролцуулна, парламентын зарчмын дагуу мэтгэлцүүлнэ ингээд явсан. Тэгээд Дэгийн тухай хууль болон Хяналт шалгалт, Их Хурлын тухай хууль дээр гишүүдээс санал авсан. Би бас нэг тодорхой саналууд өгсөн. Тэгээд өгсөн саналууд маань ихэнх нь эсрэгээрээ тусчихсан байх юм. Тэгэхээр хэчнээн гишүүн санал өгсөн юм? Энэ Улсын Их Хурлын судалгааны хүрээлэнг оролцуулсан юм уу, тэд нараас санал авсан юм уу, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудаас санал авсан юм уу, хэчнээн санал ирсэн юм, алийг нь тусгаж авсан юм энийг асуучихмаар байна бас.

Сүүлийнх нь бол энэ өнгөрсөн оны 07 сарын 09-нд байх Улсын Их Хурлын тухай хууль болон Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тэгээд энэ Тамгын газрын хяналт шалгалттай холбоотой бүх зүйл, заалтыг уул нь ингээд зөвлөмж болгосон шүү дээ. Зөвлөмж болгосон. Тэгээд одоо буцаагаад энийгээ оруулж ирээд хатууруулаад дүн шинжилгээ хийнэ, хуулийн дүгнэлт хийнэ гээд ийм юмнууд оруулаад ирэх юм. Энэ чинь зарчмын хувьд зөв юм уу буруу юм уу? Үндэсний аудитын газар гээд л нэг хянадаг, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар гээд л нэг хяналт явдаг. Одоо Тамгын газар гээд л дахиад хяналт явдаг. Ингээд 3, 4 хяналтын тогтолцоо чинь ороод ирэхээр ажил цаашаа урагшлах юм уу? Хууль санаачлагч нар маань асуултыг маань бичиж авч байгаа байгаа. Үгүй л юм шиг харагдаад байгаа юм. Эхлээд энэ 3 асуултдаа хариулт авчхаад тэгээд цаашаагаа тодруулж асууя.

**Б.Пүрэвдорж:** Энэ хуулийн, 3 хуулийг санаачлагч нь Их Хурлын дарга, мөн Их Хурлын дэд дарга нар байгаа. Тийм учраас Их Хурлын дарга, Их Хурлын дэд даргын суудал дээр сууж энэ хариултаа хэлэхээр суудал сольсон байгаа. Тэгээд Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Очирбат гишүүний асуултад хариулъя. Энэ 3 хууль Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг яагаад хамтад нь өргөн барьчихав, замбараатай, цэгцтэй цувуулаад өргөн барьж болсонгүй юу гэж Улсын

Их Хурлын үйл ажиллагааг зохицуулсан ерөөсөө 3 ийм л 3 хууль байгаа. Энэ 3 хуулийг ямар ч байгууллагаас санал авахгүй Улсын Их Хурал өөрөө баталдаг.

Тийм болохоор Улсын Их Хурлын хууль маань үндсэндээ органик буюу Үндсэн хуульчилсан хууль. Энэ хуулийгаа хэрэгжүүлэхийн тулд процессыг бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль. Дээрээс нь Хяналт шалгалтын тухай хууль. Ийм учраас нэг нэгнээсээ эшилсэн хоорондоо салшгүй холбоотой зохицуулалтууд байдаг учраас энэ 3 хуулийг салгаж хэлэлцэх ямар ч боломжгүй. Яагаад гэвэл Улсын Их Хурлын тухай хуульд орсон, хөндөгдсөн заалтуудыг түүндээ нийцүүлж Хяналт шалгалтын тухай хуульд, Дэгийн хуульд хийх ёстой. учраас энэ 3 хуулийг заавал хамтад нь хэлэлцэж зохицуулалтуудыг нь хооронд нь уялдуулах, ингэхгүй бол хууль хоорондын хийдэл, хууль хоорондын зөрчил, хууль хоорондын давхардал гарах учраас хамтад нь өргөн мэдүүлсэн юм гэдгийг 1 дүгээрт нь хэлье.

Түргэвчилсэн яарсан асуудал байна уу гэж. Яаралтай горимоор Засгийн газар хууль өргөн мэдүүлэх ёстой. Үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар яаралтай горимоор. Бусад тохиолдолд бол яаралтай горимоор хууль хэлэлцдэггүй. Улсын Их Хурлын тухай хуулиудыг бол бусад Засгийн газраас санал авдаггүй өөрсдөө шийддэг. Ийм учраас бид нар бол санал авахгүйгээр өргөн мэдүүлсэн. Ингэхдээ бол түрүүн хэлсэн Учрал даргын үед Сандаг-Очир Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ахалсан ажлын хэсэг өнгөрсөн 2 сард байгуулагдаад ажиллаж байсан. Үүнийг нь үргэлжлүүлж явсаар байгаад Улсын Их Хурлын даргын зөвлөлийн гишүүдэд Улсын Их Хурлын даргын зөвлөл дээр хэд хэдэн удаа хэлэлцээд, намын бүлгүүд дээр танилцуулж байж бас оруулж ирсэн.

Мөн миний хувьд Улсын Их Хурлын дарга болчихоод Улсын Их Хурлын 126 гишүүн Улсын Их Хурлын 126 гишүүний зөвлөх, туслахууд, Улсын Их Хурлын тамгын газар Улсын Их Хурлын дэргэдэх Парламентын судалгааны хүрээлэнгээс хүн нэг бүрээс нэг бүрчлэн санал авсан. Энэ дээр Улсын Их Хурлын 30-аад гишүүн саналаа бичгээр ирүүлсэн. Улсын Их Хурлын гишүүдийн ажлын албанаас 70-аад гишүүн ирүүлсэн. Улсын Их Хурлын Тамгын газрын 200 гаруй ажилтан саналаа өгсөн. Улсын Их Хурлын дэргэдэх Парламентын судалгааны хүрээлэнгийн бас саналуудаа бүгдийг нь өгсөн. Эндээс орж болох заалтуудыг оруулаад хэрхэн яаж оруулсан талаараа бас гишүүдэд бас ийм материалууд тараасан байгаа. Энэ дээр бас тодорхой гадаад, дотоодын туршлага, олон улсын гишүүдийн орсон саналуудын талаар мэдээллүүд орсон байгаа.

Өөр ч юу юу асуулаа? Гишүүдийн санал, бусад байгууллагуудаас санал авсан. Мэтгэлцүүлэх асуудал. Мэтгэлцүүлэх асуудал дээр үндсэндээ бол маш тодорхой одоо байгаа дэгээс илүү 8 минут 1 минутаар асуулт асуугаад үндсэн 8 удаа асуулт авах, хариулт өгөх бололцоотой. Дээрээс нь чуулганы асуулт, хариултын дэгийг зогсоож байгаад тодорхой хугацаанд хоорондоо чөлөөтэй мэтгэлцэх боломжийг бас нэмж оруулсан байгаа.

**С.Бямбацогт:** Ганбатын Очирбат гишүүн нэмж тодруулъя.

**Г.Очирбат:** Яг л ийм хариулт ирэх байх гээд тодруулгаа авч байгаа юм. Их Хурлын тухай хуулийн 46.5.6-г Их Хурлын гишүүд бүгдээрээ нэг уншчихаарай.

Үүнтэй холбоотой Дэгийн тухай хуулийн 34.1 би уншаад үзүүлчихье. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл болон төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар хэлэлцүүлгийн явцад Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргуулна гэж байгаа юм. Энэ чинь одоо ер нь энэ ард энэ ардчилсан Монгол Улс, парламентын засаглалтай Монгол Улс Их Хурлын гишүүд нь иргэдээ төлөөлөөд үг, үзэл бодлоо энэ чөлөөтэй илэрхийлэх ёстой, дуу хоолой болох ёстой.

Тэгэхэд одоо та хуульчилж оруулж ирж байгаад энд Их Хурлын гишүүдийн амыг барих гэж байна. Их Хурлын дарга анх дарга болохдоо арай ч ийм хуулийн төсөл оруулж ирнэ гэж бодоогүй. Тэгэхээр энэ дээр та тодорхой нэг хариулт өгчих. Яах гэж энэ заалтуудаа оруулж ирсэн юм. Амыг нь барих гэж байна шүү дээ та гишүүдийнхээ. Үг, үзэл бодлыг нь илэрхийлэх бүх юмыг нь.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Хууль санаачлагч, Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт хариулна.

**С.Бямбацогт:** Энэ бол хэлэлцүүлгийн явцад Байнгын хорооны санаачилгаар, Байнгын хорооны гишүүдийн хүсэлтээр энэ асуудлыг хэлэлцэхээр орсон. Бодитой кэйсээр өнгөрсөн жил бид нар төсөв хэлэлцэж байх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа гишүүн боловсролын байгууллагуудын салбарын зардлыг ДНБ-ий хэдэн хувь гэлээ 4 гэлүү, 8 хувь гэж болгоё гэсэн санал оруулж ирээд 7 хувь тийм ээ энэ маань үндсэндээ бол улсын төсвийн маш том зардал эзлээд үүнээсээ болоод Монгол Улсын төсөв батлагдахгүй байх, эргээд төсвийн алдагдал маш их хэмжээгээр нэмэгдэх ийм эрсдэлтэй заалт нөгөө дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор Улсын Их Хурал дээр босох ийм асуудал үүссэн бодитой кэйс. Иймэрхүү саналууд Улс орны үндэсний аюулгүй байдалтай холбоотой, энэ төсөв санхүүтэй холбоотой ийм хуулиудыг гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргаад тэр нь асуудал дагуулахаар байх юм бол Байнгын хорооны саналаар, хүсэлтээр энийг нь тухайн үед нь санал, дүгнэлт үнэхээр эдийн засагт хор хохиролтой байна уу, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, эрсдэл уч.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Гүйцээж хариулъя.

**С.Бямбацогт:** Гэдгүүдийг нь Тамгын газар үздэг, хардаг байя. Ингээд яг энэ бол асуудалтай байна, асуудалгүй байна гэдгийг мэдээлдэг байя. Энэ дээрээс нь Байнгын хорооны гишүүд, Улсын Их Хурлын гишүүд мэдэх эрх нь хангагдаад үндсэн ойлголттой болоод, тэгж байгаад дэмжих, дэмжихгүй байх санал, байр сууриа илэрхийлэхэд нь туслах ийм л зорилготой юм. Бусад бусдаар гишүүдийн амыг яах гэж байгаа зүйл ерөөсөө биш ээ. Гишүүд маань өөрсдөө мэддэггүй. Энэ гаргаж байгаа санал маань үндэсний эрх ашигт нийцэх үү, нийцэхгүй юу, улс орны эдийн засагт аюултай юу, аюулгүй юу гэдгээ бас мэдэхгүй. Зарим тохиолдолд мэдээд попорч бас санал гаргадаг тохиолдол бол байдаг. Тэгээд энийг бид нар Улсын Их Хурлын гишүүд, нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэнэ ээ гэж тангараг өргөдөг. Нийт иргэн, улсынхаа эрх ашгийн эсрэг санал гаргаад байвал энэ нь үнэн байна уу, зөв байна уу, буруу байна уу, зөв байна уу, үнэн байна уу, худлаа байна уу гэдгийг нягталдаг. Ингэж гишүүдийн мэдэх эрхийг нь хангах л ийм зорилготой заалт орж ирсэн юм.

**Б.Пүрэвдорж:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Тэгээд харин Их Хурлын гишүүд салбар салбараа төлөөлж орж ирсэн гишүүд салбарынхаа төлөө дуу хоолой болж болно. Энийг нь харин ардчилал гээд байгаа юм. Парламентын засаглал гээд байгаа юм. Тэгээд болох, болохгүйгээ бид хэд хэдүүлээ ярьж байгаад зарчмаараа, олонхоороо шийдээд л явдаг ийм л тогтолцоо. Энийг та хуульчилж ингэж оруулж ирж болохгүй ээ 1 дүгээрт.

2 дугаарт, дахиад би танд бол бодит кэйс ярья. Хэд хоногийн өмнө танд хуулийн төсөл өргөн барихдаа та бид 2 бас ярилцаж байсан 2027 оны төсвийн хүрээ, 28-аас 29 оны төсвийн төсөөллийг дагуулж нэмүү өртгийн албан татварын 2 тодорхой хууль заалтыг хүчингүй болгосон. Одоо тэгээд энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад иргэддээ нэг НӨАТ-ын буцаан олголтын 100 хувь, 50 хувь олгочихъё гэсэн санаачилга гаргасан Их Хурлын гишүүдийг Их Хурлын гишүүдийг та үг хэлэх эрхгүй, Байнгын хороон дээр оруулж ирсэн зарчмын саналыг чинь Тамгын газар шалгалт хийгээд бүтэхгүй юм байна гээд татах юм байна. Та хууль санаачилж болохгүй ээ, таны хууль чинь асуудалтай байна гээд Тамгын газар татах юм байна, дүгнэлт гаргах юм байна ингэж болох юм уу? Энэ рүү л явж байна шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Энд Улсын Их Хурлын даргын санаачилгаар болон Тамгын газрын санаачлахаар Улсын Их Хурлын гаргаж байгаа гишүүдийн гаргаж байгаа, санаачилж байгаа хууль, дээрээс нь гаргаж байгаа зарчмын зөрүүтэй саналыг хязгаарлах ямар ч зохицуулалт байхгүй. Зөвхөн Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлгийн явцад гишүүд, Байнгын хорооны гишүүд Байнгын хорооны саналаар Тамгын газар шаардлагатай бол зөвлөмж, дүгнэлт гаргаж болно гэж байгаа. Энийг та бас нэг ялгаж харах хэрэгтэй. Ялгаж. Яагаад гэвэл нийт иргэн, улсын эрх ашгийн төлөө л бид нар санал гаргах ёстой. Энэ улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, төсөв, мөнгөтэй холбоотой саналууд дээр бид маш хариуцлагатай хандах ёстой. Гишүүний эрх гэдгээрээ хаа хамаагүй санал гаргаж болох эрхтэй байж бас болохгүй. Энэ дээр нь л зөв байна уу буруу байна уу гэдэг дээр нь л гишүүддээ бусад гишүүддээ мэдэх эрхийг нь хангах ийм боломжийг л.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууя.

**Ц.Даваасүрэн:** Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Би 4 зүйл дээр л асуулт асуух гээд байгаа юм. Тэгэхээр энэ удаагийн Их Хурлын тухай хуулийн өөрчлөлт дээр хуралдаа идэвхгүй оролцдог гишүүдийг үг хэлэх эрхийг хэд хоногоор ингээд хасна гэж байгаа юм. Энэ хэзээ ч байж болохгүй зүйл байхгүй юу. Их Хурлын гишүүн чинь иргэний төлөөлөл байгаа байхгүй юу. Тухайн сахилга батгүй гишүүнийг хувь хүнийх нь хувьд бол хариуцлага тооцож болох л байх л даа. Гэхдээ миний ард байгаа Хөвсгөлийн, Эрдэнэтийн, Булганы иргэдийн энэ төлөөллөө хэрэгжүүлэх эрхийг хасаж болохгүй байхгүй юу. Энэ асар том бүдүүлэг алдаа болно шүү. Иргэн Бат над руу утасдаад энэ үг хэл гэхэд тэрийг хасаж болохгүй байхгүй юу. Тэр хувь хүний гаргасан алдаа хувь хүнээрээ л явах ёстой.

Тэр цалинг нь байна уу яана тэгж. Энийг олон жил ярьсан Бямбацогт гишүүн өөрөө мэдэж байгаа байлгүй дээ. Бид зөндөө яриад л тэгээд л Лүндээ ахалж байсан үе санагдаж байна. Одоо иргэд нь мэдээлэхээс өөр аргагүй юм байна гээд л өнгөрцгөөсөн шүү дээ. Яагаад энийгээ ингээд дахин дахин өөрчлөөд байгаа юм. Тэгээд иргэд нь мэдээлдэг болъё л гэсэн шүү дээ. Тэгээд иргэд нь хариуцлагаа ярьдаг бол гээд.

2 дугаарт, энэ Их Хурлын дарга гэдэг хүн энэ хуулийг хэлэлцэх үү үгүй юу гэдгийг бол шийддэг байж болохгүй. Зөвхөн хурал зохион байгуулагч байхгүй юу. Зөвлөлийн хурал гээд ингээд шийдээд байж болохгүй. Тийм учраас хуучин Байнгын хороо шийддэг байсан юм. Энэ хуулийг хэлэлцэх үү үгүй юу гэдгийг. Тийм учраас энэ агуулгад нь буцааж оруулах хэрэгтэй. Занданшатар энэ өөрчлөлтийг байхгүй болгосон.

Тийм учраас жишээлбэл, Ховдын тойргийн гишүүн Хөвсгөлийн тойргийн гишүүний хуулийг хэлэлцэх үү үгүй юу гэдгийг шийдэж болохгүй шүү дээ. Тийм учраас энэ асуудлыг шийдээч ээ гэж.

Өөр нэг асуудал бол Занданшатарын Засгийн газартай холбоотой асуудал. Дэмжихийг дэмжихийг дэмжихгүй гэж хураах уу үгүй юу гэдэг асуудал. Тухайн үед яасан гээд тэгэхээр Үндсэн хууль дээр байгаа заалтаар хураагаагүй гээд байхгүй юу. Үндсэн хууль дээр байгаа заалтаар хураа гээд Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль дээр байхгүй байгаа байхгүй юу. Үгүй ээ тэгээд Дэгийн тухай хууль дээр байхгүй юмаар хүн яаж санал хураах байсан юм. Тэгээд энэ Үндсэн хуулийн 27.1 дээр чуулганы хэлбэрээр шийднэ ээ гэхчхэн байгаа юм. Чуулганы хэлбэрээр гэдэг чинь бол энэ чинь Үндсэн хуулийн заалт шүү 27.1 дээр чуулганы хэлбэрээр шийднэ ээ гэж. Чуулганы хэлбэрээр гэдэг чинь Байнгын хороо хэлэлцээд нэгдсэн хуралдаанаар шийднэ гэсэн үг байхгүй юу.

Одоо та нар заримдаа ингээд Байнгын хороогоор ярьсан асуудлыг, гаргасан саналыг өөр хэлбэрээр нэгдсэн хуралдаан дээр санал хурааж болох юм шиг яриад байгаа юм. Энэ бол цэвэр Үндсэн хуулийн зөрчил болно шүү. Яагаад гэвэл Үндсэн хуулийн 27.1 дээр чуулганы хэлбэрээр шийд ээ гэхчхэн байгаа. Тэгээд бид нар 30-аад жил ингэж явж ирчхээд бид нар тухайн үед яасан Байнгын хороон дээр яг л тэр нөгөө огцруулах хэсгээр л санал хураасан шүү дээ. Огцруулах нь дэмжээгүй. Огцруулахыг дэмжээгүйг дэмжье гэдэг санал хураалтыг огцруулахаар л хураасан шүү дээ. Огцруулахаар л бүх юм явсан байхгүй юу. Цэц гэж нэг ийм будилаантай юм гарч ирэнгүүтээ төрийн эргэлт хийгээд хаячихсан. Тэгэхээр энэ 30-аад жил явсан энэ юмаа ингээд бид нар яах гэж байна вэ? Дэмжээгүйг дэмжье гэж. Энэ асуудлыг яаж шийдэв гэж? Яагаад гэвэл Үндсэн хуулийн 28.2 дээр Байнгын хорооны эрх, үүргийг хуулиар тогтооно гэсэн Үндсэн хуулийн заалт яриад байна шүү. Би тэгээд Их Хурлын тухай хуулийн 22.3 дээр Байнгын хорооны эрхийг зааж өгсөн. 22.3.7-д Их Хурлаас томилогдсон албан ёсоор огцруулах, чөлөөлөх асуудлыг Байнгын хороо шийднэ ээ гээд, санал, дүгнэлт гаргана гээд заагаад өгчихсөн. Тэгээд Дэгийн хуулийнхаа 101.3 дээр энэ асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ ээ гээд заагаад өгчихсөн. Тэгээд энэ асуудлуудыг яаж цэгцлэх гэж байна вэ гээд .

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт хариулна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүдийн үг хэлэх эрхийг хязгаарлах энэ болохгүй ээ гэж байна. Энэ угаасаа та бас мэдэж байгаа олон жил Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд, Их Хурлын тухай хуульд байдаг ёс зүйн зөрчил гаргасан хуралдааны дэг зөрчсөн бол 3 хүртэл хоногоор үг хэлэх, санал гаргах эрхийг нь хязгаарлана гэсэн заалт одоо байгаа. Одоо байгаа заалтыг илүү хариуцлагажуулж 30 хүртэл хоногоор болгож байгаа. Ёс зүйн дэд хороо үүнийг 30 хоног байх уу 3 хоног байх уу 10 хоног байх уу гэдэг нь Ёс зүйн дэд хороо хуралдаж шийдэхээр оруулж байгаа.

Ерөнхийлөгчийн санаачилсан хуульд чуулганы хуралдааны 30-аас доошгүй хувьд нь суугаагүй бол эгүүлэн татах асуудал хөндөгдсөн. Тэгвэл бид нар Байнгын хорооны хуралдаан, чуулганы хуралдааныхаа 50-аас доошгүй хувьд нь суухгүй бол энэ гишүүдийг яах вэ? Хуралдаандаа ирж ирцдээ орчхоод санал хураалтад оролцохгүй яваад байвал яах вэ. Бусдыг гүтгээд, гутаагаад, доромжлоод байвал яах вэ гэдэг заалтууд дээр Ёс зүйн дэд хороо бас арга хэмжээ авдаг байя. Улсын Их Хурлын гишүүд маань өөрсдөө хариуцлагатай байя. Ард түмнийг төлөөлнө, би ёстой. үнэхээр таныг төлөөлөөд, та бүгдийг төлөөлөөд үнэхээр сайн ажиллана гэж ирчхээд хуралдаа суудаггүй, санал хураалтдаа оролцдоггүй, ажлаа хийдэггүй ийм байгаад байвал төлөөлөх бүрэн эрх нь хангагдахгүй байна. Тэгээд тэр төлөөлөх бүрэн эрхээ хангаач ээ гэж шаардаж хангуулахын тулд энэ заалтуудыг хуучинд байсан заалтыг илүү хариуцлагажуулж байгаа гэдгийг бас хэлье.

Улсын Их Хурлын дарга энэ хэлэлцэх асуудлыг шийддэггүй. Урьд нь бол яах вэ өргөн барих гэж байгаа хууль дээр бол хугацаа байдаггүй ингээд хэдэн сараар жил л жилээр өргөн баригдахгүй байсан асуудал байсан юм байна лээ. Одоо энэ хууль дээр сарын дотор гишүүдийн санаачилсан хуулийг хүлээж авах ёстой. гэж оруулж байгаа. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл л асуудлыг шийдэхээр орж байгаа даргын дэргэдэх зөвлөл. Байнгын хороод нь саналаа оруулж ирээд тэрийг даргын зөвлөл дээр ярьж шийдэхээр ийм орж байгаа.

Засгийн газрыг огцруулах, дэмжих, дэмжихгүй гэдэг дээр дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураахыг болиулж байгаа. Энэ бол гишүүдийг төөрөгдүүлдэг, олон саналууд Байнгын хороон дээр уначхаад чуулган дээр босдог ийм үндсэндээ бол хууль хулгайлдаг ийм зохицуулалтыг больё гэж.

Үндсэн хуульд нийцээгүй бол Үндсэн хуульд нийцсэн саналаар л хураах ёстой. Засгийн газрын Занданшатарын Засгийн газрыг огцруулах асуудал маань Үндсэн хуульд Засгийн газрыг огцруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураах ёстой. шүү гээд биччихсэн байсан. Энэ томъёоллоор ч санал хураагаагүй. Дэмжээгүй саналыг дэмжье гэж төөрөгдүүлсэн саналын томъёоллоор санал хураасан учраас энэ асуудал дээрээ Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурал хууль зөрчсөн байна гэж дүгнэлт гаргасан. Энэ бол бас нэг хоорондоо бас ялгаатай.

Тийм болохоор цаашдаа ийм Үндсэн хуульд бүх хууль нийцэж байх ёстой. Үндсэн хуульд нийцээгүй бол Үндсэн хуульдаа нийцүүлэх ажлыг Улсын Их Хурал хийх ёстой. Энэ дээр бас нэг жоохон тийм хууль хоорондын хуулийг бас цоорхой.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Даваасүрэн:** Тийм учраас харин тэр нөгөө нэг дэмжихүйг дэмжье гэдэг ч юм уу аль эсвэл Үндсэн хуулийн заалтын дагуу хураа гэж дэгийн хуулийн Үндсэн хуулийн тэр заалтаар чинь зохицуулсан юм Дэгийн хууль, Их Хурлын хууль дээр байхгүй байсан байхгүй юу. Өөрөө тэрийг хүлээн зөвшөөрч байгаа нь сайн хэрэг. Энэ тэр даргын дэргэдэх зөвлөл гэхээр чинь л дарга болчихоод байгаа байхгүй юу. Миний хэлээд байгаа юм бол Байнгын хороо нь шийддэг байх ёстой. юм. Ер нь бусад орны парламент тийм байна лээ. Энэ хуулийг хэлэлцэх үү үгүй юү гэдгийг Байнгын хороо Их Хурлын бүтэц нь шийддэг байх ёстой. юм байна лээ. Тэрийг хараач гэж.

Энэ халдашгүй байдлын асуудал байна. Өнөөдөр ингээд Их Хурлын гишүүн халдашгүй гэж байна. Миний 1 минутыг үргэлжлүүлээд явчхаарай. Халдашгүй гэж байна. Гэтэл халдчихаар ямар ч зохицуулалт байхгүй юм байна лээ. Одоо зарим гишүүнд ийм халдсан юмнууд гарсан. Үгүй ээ гэтэл яг ингээд бусад хууль дээр Эрүүгийн хууль дээр ч юм уу юун дээр халдчихаар яаж байна ямар ч заалт байхгүй. Машин эвдсэн тохиолдол гарсан ямар ч заалт байхгүй. Халдашгүй л гээд байна. Тэгэхээр энэ асуудлуудыгаа ер нь нэг мөр ингээд шийдээд явах талаас нь яаж харсан юм бэ? Халдашгүй байдлыг зохицуулах чиглэл дээр нь ер нь яасан юм? Одоо юу ч байхгүй юм байна лээ шүү ямар ч хуульд.

Жишээлбэл, саяхан гээд л тэгэхэд 1 гишүүнд гар хүрчихсэн асуудал гарахад бол зүгээр л нөгөө яг энгийн байдлаар, иргэний байдлаар тэр нь явж байгаа байхгүй юу. Нөгөө төрийн өндөр албан тушаалтанд гар хүрсэн гэдэг юм ерөөсөө байхгүй юм байна лээ. Яагаад гэвэл төрийн өндөр албан тушаалтан бол эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүн. Тэр иргэдийг төлөөлж тэр тэмцлийг хийх ёстой. хүн. Зүгээр яах вэ зарим нэг нь энэ нэг халдашгүй байдлыг авчхаад янз бүрийн юманд холбогдоод байдаг л асуудал байгаа болохоос биш уг нь энэ халдашгүй байдал дор ард түмнийхээ төлөө тэмцэл хийе гэсэн ийм л заалт шүү дээ.

Гэтэл яаж байна вэ чөлөөтэй эрүүгийн хэрэг үүсгэж байна. Эрүүгийн хэрэг үүсгэх асуудал чинь манайд ингээд гүйцэтгэх ажил дээр нотлогдсоны дараа биш зүгээр л мэдээллээр үүсгэдэг, хэн дээр ч үүсгэж болдог. Тийм нэг ийм нөхөр хэвлэл дээр юм биччихвэл тэрүүгээр үүсгэж болох жишээтэй. Тэгэхээр иймэрхүү халдашгүй байдлын асуудлуудыг ер нь яаж үзэж байгаа юм бэ? Яаж зохицуулсан юм бэ?

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Халдашгүй байдлыг та бол ингээд үндсэндээ бол одоо байгаа хууль чинь их сул байна гэдэг. Манай Пүрэвдорж дарга болохоор байгаа хууль чинь хэтэрхий хатуу болчихсон Их Хурлын гишүүн ч гишүүд хэзээ ч бүрэн эрхээ түдгэлзэх боломжгүй болчихсон гэж ярьдаг. Энэ асуудлыг бид нар нэлээн сайн судлах ёстой. юм байна лээ. Энэ үүднээсээ Ерөнхийлөгчийн санаачилсан гишүүдийн бүрэн эрхтэй холбоотой, халдашгүй байдалтай холбоотой хууль. Дээрээс нь Улсын Их Хурлын гишүүн Батбаатар нарын санаачилсан гишүүдийг эргүүлэн татахтай холбоотой, Нарантуяа-Нара нарын гишүүний санаачилсан хуулиуд, эдгээрийг хэлэлцэх эсэхийг нь шийдэж байгаад нэгдсэн байдлаар ажлын хэсэг байгуулаад тэр ажлын хэсэг дээрээ илүү сайн ярьж байж оруулах ёстой. гэж харж байгаа.

Ялангуяа манай Даваасүрэн гишүүн бол Халдашгүй байдлын дэд хорооны дарга. Энэ гишүүдийн бүрэн эрх, халдашгүй байдалтай холбоотой асуудал дээр бид онцгой анхаарах ёстой. онцгой. Тийм болохоор энийг бол нэлээн нухацтай авч үзье гэж бодоод энэ удаагийн хууль дээр бол хөндөөгүй байгаа. Энэ саяын хууль санаачлагчийн санаачилсан хуулиудыг хэлэлцэх эсэхийг нь шийдээд ажлын хэсэг байгуулаад энэ дээрээ бол нэгдсэн журмаар нэлээд.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Төгсдэлгэрэх” сургуулийн Зулцэцэг багштай 9<sup>В</sup> ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сурагчдад сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Энхбатын Болормаа гишүүн асуулт асууна.

**Э.Болормаа:** Өнөөдөр бид Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт асуудлыг хэлэлцэж байна. Тэгээд 126 гишүүнтэй парламент маань өмнөх 76 гишүүнтэй парламентын баталсан хуулийн дагуу өнөөдөр ажиллаж байна. Танхим дотор бол гарын 5 хуруунаас бусад нь бол бүгдээрээ дандаа анх удаагаа сонгогдсон гишүүд л ер нь сууж байна. Тэгээд ажлын хэсгээс өгч байгаа хариултууд бол дандаа өмнө нь баталчихсан хүмүүс маань энэ ийм дутуу байжээ, энэ ийм болоогүй байжээ ийм өөрчлөх ёстой. гээд бид нар засвар хийгээд явж байна л даа. Тэгэхээр бид нар ер нь цаашдаа аливаа асуудалдаа маш нухацтай хандаж байх ёстой. гэдгийг дахин сануулж байгаа үйлдэл болов уу.

Гишүүд хариуцлагатай байх ёстой. гэдэг дээр бол 100 хувь санал нэгдэж байна. Харин олон нийт бид нараас шаардаж байгаа хариуцлага бол энэ хэдэн удаа суусан, хэдэн минут энэ танхимдаа суусан биш олон нийтийн эрх ашгийн төлөө шударга, үнэн зөв, олон нийтийн эрх ашгийг 1-д тавьсан ийм шийдвэрүүд гаргаж чадаж байна уу гэдгийг нэн тэргүүнд харж байгаа байх гэж би бодож байна.

Тэгэхээр энэ удаагийн энэ өөрчлөлт дээр бид нар зөвхөн зөвшөөрөх, татгалзах гэсэн ийм 2 сонголттой байдаг бол түдгэлзэх гэдэг асуудал дээр ямар судалгаанууд хийсэн бэ? Онцлоод бусад улс орны жишээг судлахад ихэнх улс орнууд бол түдгэлзэх гэдэг ийм 3 дахь сонголттой байдаг юм байна. Тэрний үндсэн шалтгаан нь бол ашиг сонирхлын зөрчилтэй бол түүнийгээ илэрхийлж, тухайн санал хураалтаас түдгэлздэг байх.

Жишээлбэл, энд юу гэдэг юм бензиний компанитай байж байж бензин шатахуун тосны асуудал хэлэлцэхэд тэр хүн ашиг сонирхлын зөрчлөө илэрхийлээд түдгэлзэх ёстой. Сургууль эзэмшээд боловсролын, сургуулийн, хувийн сургуультай холбоотой асуудал ярилцаж байвал мөн ашиг сонирхлоо илэрхийлээд түдгэлзэх ёстой. Уул уурхайн компани ажиллуулдаг, магадгүй стратегийн ордны эзэмшигч тэгээд стратегийн ордны асуудал ярихад мөн түдгэлзэх ёстой. гэх мэтчилэн ийм хариуцлагын асуудлыг ийг иргэд нэн тэргүүнд шаардаж байгаа болов уу гэж би хувьдаа бодож байна. Тэгэхээр энэ хариуцлагын асуудлыг хэрхэн тооцсон бэ, энэ дээр ямар судалгаа хийсэн бэ гэдгийг тодруулж асууя.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Ер нь цаг үеийн шаардлагаар нийгмийн хөгжил, дэвшилтэй уялдуулж байнга л хувьсаж өөрчлөгдөж байгаа хүний амьдралын хэв маяг ч тэр, улс орнуудын хөгжил ч тэр. Тийм болохоор байнга үүнд нийцүүлж хууль тогтоомжийг өөрчлөх, засах, сайжруулах шаардлагууд байнга урган гардаг. Энэ хүрээндээ Улсын Их Хурлын энэ тухай хуулиудыг бид нар өнөөдөр засвар хийж байгаа биш гишүүдийн хариуцлага, парламентын ил тод байдал, хүртээмжийг сайжруулах зорилгоор оруулж байгаа. Өөрөөр хэлэх юм бол илүү иргэддээ ээлтэй парламент болъё, илүү нээлттэй парламент болъё, иргэдийн илүү оролцоонд тулгуурласан парламент болъё гэсэн заалтуудыг орсон.

Ялангуяа энэ дээр хуулийг хэлэлцүүлгийн явцад боловсруулахаас нь авхуулаад хэлэлцүүлэх, эцэслэн батлах энэ хүртэл бүх процесст иргэдэд нээлттэй мэдээлэл өгдөг, иргэдийн саналыг авдаг энэ тогтолцоог би бас бий болгох [d.parliament.mn](http://d.parliament.mn), [d.pettition](http://d.pettition) бусад хувилбаруудыг E-Mongolia иргэн болгоноос санал авах энэ боломжуудыг хүртэл нээж өгч байгаа. Хуулиудаа мөн хэлэлцүүлгийн шат бүрийг иргэдэд бас сурталчлах, таниулах, ойлгуулах, хуулийн хэлэлцүүлгийн үе шат бүрд нь ажлын хэсэг хууль санаачилж ажиллах, эцэслэн баталсных нь дараа яг ийм ач холбогдолтой, амьдралд ийм үр өгөөжтэй ийм зорилготой ийм хууль бид нар баталлаа гэдгээ олон нийтэд сурталчлах энэ үүргүүдийг бас улс Улсын Их Хурлын гишүүдэд нээж өгч байгаа. Үүгээрээ үндсэндээ бол энэ парламент юу хийдэг юм бэ гэдгийг иргэд маань илүү мэддэг болно, мэдээлэлтэй болно. Илүү оролцуулснаараа илүү идэвхтэй иргэд маань оролцдог болно. Энэ томоохон бодлого орж ирж байгаа.

Дээрээс нь олон нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих ёстой. зөв. Яг энэ үүднээс энэ асуудлууд орж ирж байгаа. Мөн ашиг сонирхлын зөрчлийг шийдэхтэй холбоотой манай Баасанжаргал нарын гишүүдээс тодорхой саналууд гарсан. Тэр саналуудын томъёоллыг энэ Дэгийн хууль дээр бас тусгаж өгсөн байгаа. Тийм болохоор одоо байгаа Дэгийн хуулийн 10.10 дээр ашиг сонирхлын зөрчилтэй бол санал хураалтад орохгүй байх зохицуулалт байгаа. Үүнийг илүү нарийвчилж зохицуулж оруулахаар тусгасан байгаа. Ийм байдлаар үндсэндээ юу гэдэг юм тодорхой бизнестэй бол, тодорхой ашиг сонирхол хөндөгдсөн бол энд оролцохгүй байх ёстой. шүү гэдгийг илүү нарийвчилж тусгаж өгсөн. Ингэж өгөх ёстой. Энэ хуулиудыг бас хэлэлцүүлэхдээ байнгын ер нь судалгаатай байдаг. Манай та бүхэнд тараасан энэ номууд дээр ямар ямар улс орнуудыг яаж яаж судалсан, аль парламент дээр ямархуу жишиг байдаг энэ бүгдийг нь ингээд судлаад Улсын Их Хурлын гишүүддээ бол тараагаад өгчихсөн байгаа энэ дээр үндсэндээ.

Ер нь гол нь бол манайхан бол угаасаа 92 онд Үндсэн хууль батлах үеэсээ л Германы Үндсэн хууль, Германы Бундестагийн бас дэг сонирхож харж байсан юм байна лээ. Үүнтэй холбоотой бол бас нэлээн суурилж судалдаг зохицуулалт бол бас тэр дээр нэлээн тулгуурладаг. Гэхдээ маш олон улсын парламентын үйл ажиллагааг судалж тэндээс харьцуулж байж тодорхой заалт.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Энхбатын Болормаа гишүүн нэмж тодруулья.

**Э.Болормаа:** Бямбацогт дарга би энэ нөгөө танилцуулга бас судалгаануудыг уншсан юм. Тэгээд яг түдгэлзэхтэй холбоотой асуудал хараагүй учир та дараа нь бас нөгөө ажлын хэсгээс над руу мэдээлэл явуулчихвал бас

болно. Яг түдгэлзэхтэй холбоотой энэ дээр эерэг, сөрөг талыг нь хэрхэн судалсан талаар.

Энэ дээр нэмээд нэг тодруулах асуулт нь болохоор сайд нартай холбоотой асуудал байгаа. Сайд нар бол мэдээж бүгдээрээ Улсын Их Хурлын гишүүд. Жишээлбэл яг одоо танхим д Сандаг-Очир сайдаас өөр сайд алга байна. Тэгэхээр нөгөө бид нар дарга давуу эрхтэй гэдэг шиг энэ танхим дотор бас нэг тийм кастын систем үүсээд байна л даа. Сайд нар давуу эрхтэй, чуулгандаа суудаг, суудаггүй. Тэгэхээр энэ хариуцлагын тогтолцоо мөн сайд нар дээр хэрхэн яригдах юм бэ? Чуулганы ирц, санал хураалттай холбоотойгоор бүүр сайдын асуудал ч гэсэн хариуцлага яригдах юм уу? Энэ дээр ажлын хэсэг бодолцож ярилцана уу гэдгийг тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Сайд нар, Ерөнхий сайд, давуу эрхтэй, гишүүд дутуу эрхтэй байхгүй. Энийг маш тодорхой зохицуулсан байгаа. Улсын Их Хурлын гишүүн л бол гишүүний үүргээ биелүүлнэ. Энэ дээр сайд байна уу, Ерөнхий сайд байна уу хэн байгаа нь хамаа байхгүй гишүүдэд яг тавигдаж байгаа адилхан шаардлага тавигдана. Харин Улсын Их Хурлын гишүүд 2 Байнгын хороонд харьяалагдана. Сайд нар, Ерөнхий сайд 1 Байнгын хороонд харьяалагдана гэж эрхийг нь хязгаарласан. Хариуцлагын хувьд бол яг адилхан хариуцлага. Хурлаа тасалж байгаа бол, санал хураалтад оролцохгүй бол яг адилхан хариуцлагаа хүлээх ийм дэгийн зохицуулалт байгаа.

Мөн чуулганд асуудал хэлэлцэж байх үед бас үг хэлэх, асуулт асуух хүмүүс маань суудаг, бусад гишүүд нь бол байж байгаад санал хураалтыг бол тодорхой цагтай болгоод санал хураалтыг урьдчилж зарлаад явуулдаг тийм байдлаар байлгах дэгтэй болж байгаа. Заавал чуулганы хуралдаанд суух биш өрөөндөө уулзалтаа хийх, өрөөндөө материалаа судлах ийм боломжууд бол Улсын Их Хурлын гишүүн, сайд нартай яг адилхан л бий болж байгаа. Тэр түдгэлзэхтэй холбоотой.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Хариулъя.

**С.Бямбацогт:** Түдгэлзэхтэй холбоотой байгаа одоо хууль дээр ерөөсөө дээр үеэсээ явж ирсэн Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэнээс бусад асуудлаар санал хураалтад оролцох үүрэгтэй гээд биччихсэн байгаа. Үндсэн хууль зөрчсөн байна энэ асуудал тийм учраас санал хураалтад оролцохгүй гэвэл түдгэлзэж болно. Бусад үед Улсын Их Хурлын гишүүнийхээ үүргээ биелүүлж, бүрэн эрхээ эдэлж, санал хураалтад оролцох үүрэгтэй. Яг энэ зохицуулалт бол хэвээрээ байж байгаа. Хөндөгдөөгүй учраас энэ түдгэлзэхтэй холбоотой заалтуудын талаар судалгааг бол хавсаргаагүй байгаа. Улсын Их Хурлаас биш эд нар судалгааныхаа материалыг танд бичгээр хүргүүлчихье.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 10-ын 2-ын ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багшид нь сурган хүмүүжүүлэх ажилд нь өндөр

амжилт хүсье. Сурагчдад нь сургалт, боловсролын үйл ажиллагаанд нь амжилт хүсье.

Сархадын Зулпхар гишүүн асуулт асууна.

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Их чухал хууль орж ирж байна. Нөгөөтээгүүр энэ хуулийн жишээ нь нэмэлт, өөрчлөлт бол бидний өөрсдийн өгсөн санал. Бидний санал бол яаж гарсан гэхлээр зэрэг өнгөрсөн хугацаанд, нэн ялангуяа өнгөрсөн жил гарны хугацаанд манай Их Хурал дээрх үйл ажиллагаатай уялдсан зарим нэг бэрхшээлүүд, сорилтууд, заримдаа бол асуудал гэж хэлэх ёстой. Энийг даван туулахын тулд бидний гаргасан санал. Тэгэхээр бид өөрсдөө 1 дүгээрт энэ саналаа гаргасан.

2 дугаарт бол олон нийтээс бас бидэн рүү чиглэсэн бас ийм хүлээлт, заримдаа бол шаардлага бол байгаа. Их Хурал бол илүү жишээ нь сахилга хариуцлагатай, ёс зүйтэй, үр дүнтэй ажиллах ёстой. бол та бүхэн ажиллаж чадахгүй байна, бодлоо гаргаж чадахгүй байна, хуулиа баталж чадахгүй байна, энэнээс чинь болоод улс орны нийгэм эдийн засгийн амьдралд бол өөрчлөлт гарахгүй байна гэдэг ийм л дүгнэлтийн хариу болгож бид илүү парламент маань сайн ажиллах үүднээс гаргаж байгаа хуулийн нэмэлт, өөрчлөлт учраас энийг бид зүйл, заалт болгоноор нь яриад, хэлэлцээд, өөрсдөө шийдвэр гаргаад явах нь зөв байх гэсэн ийм бодолтой байна. Би хувьдаа бол дэмжиж байна.

Асуулт байна. Мэдээж хэрэг жишээ нь хуулийн төсөл бол мэргэжлийн түвшинд бол янз янзын байдлаар судалгаа хийгдээд бас орж ирж байгаа байх. Гэхдээ зарим зүйлийг бол бас тодруулах зайлшгүй шаардлагатай. Явцад нь бас хэлэлцэх байх гэж бодож байна.

Саналаа биечлэн өгөх ийм зохицуулалт орж иржээ. Энэ их зөв өө. Сая дав та бүхний ярьсанчлан бид биечлэн өгөөгүйгээс болоод энд ямаршуу байдлаар хуулийн шийдвэрүүд гарч байгааг бол бүгдээрээ харлаа шүү дээ тэр. Энийг биечлэн өгөхтэй холбоотойгоор бас зарим нөхцөлүүд бас бий. Сайд нар уулзалттай байж болно, гишүүд бас янз янзын хурал цуглаантай байж болно. Энэ асуудлыг та бүхэн нөхцөлүүдийг нарийвчлан судалсан уу гэж байгаа юм. Тэгэхгүйгээр бүх юмыг механикаар авч үзэж байтал бас ахиад нөгөө нэг гишүүдийн маань өөрсдийнх нь ирцтэй холбоотой, бусад асуудалтай холбоотой маргаан үүсгэх вий гэсэн нэг ийм 1 дүгээр асуудал байна.

2 дахь зүйл , гишүүд их ярьж байна сая бол бас энэ үг хэлэх, асуулт асуух эрхийг түдгэлзүүлэхтэй холбоотой. Энэ ерөөсөө шинэ зүйл биш ээ. Энэ парламентад байдаг угаасаа практик. Филипастер гэдэг практик шүү дээ энэ чинь байж байгаа. Хамгийн гол нь бид аль загвараа авах вэ л гэдэг л байгаа юм. Бид Англи Саксоны загварыг авах юм уу, эс үгүй бол энэ эх газрын загвараараа явж байгаа юм уу гэж. Би бол сая та бүхний өгсөн жишээ нь хариултаас бол бид бол Бонны болон Германы загварыг авдаг учраас эх газрын загвараараа явж байгаа юм байна гэж ойлголоо. Илүү хатуу болгож байгаа юм байна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр зэрэг энэ дээр яг ажлын хэсэг, хууль санаачлагч нар хэрхэн судалж, яаж оруулж ирсэн бэ гэдэг энэ зүйл дээр та бүхэн хэлээч. Учир юу гэхлээр

зэрэг хэрвээ Их Хурлын гишүүн дэг зөрчих юм бол, хамааралгүй их ярих юм бол, бие биеэ жишээ нь доромжлох юм бол тэртээ тэргүй үг хэлэх, асуулт асуух эрхийг нь бол хязгаарладаг ийм зохицуулалт байж байгаа. Энд бид ерөөсөө гайхаад хэрэггүй шүү нөхдүүд ээ. Парламент өөрийн гэсэн соёлтой, парламент өөрийн гэсэн дэгтэй. Тэгж байж энэ бол явдаг. Парламент бол онцгой төлөөлөл шүү дээ. Бид бол ажил хийж чаддаг, ёс зүйтэй байж чаддаг, хариуцлагатайтай байж чаддаг ийм жишээ нь нийгмийн төлөөлөл учраас ийм журам бол өөрөө үйлчилдэг учраас энэтэй холбоотой асуулт бас хариултыг та бүхнээс асууж байна гэж байгаа юм.

З дахь зүйл, энэ Байнгын хороодын даргыг сонгохтой холбоотой зүйл дээр ирцийг бас их чухалчилсан байна, асуулт асуусан байдлыг чухалчилсан байна, санал гаргасан байдлыг чухалчилсан байна. Тэр битгий хэл гадаад, дотоод томилолтыг чухалчилсан байна. Энэ зөв үү? Зарим шалгуур чинь хэтэрхий механик болж байна уу? Гэтэл Байнгын хорооны дарга гэдэг бол өөрийн гэсэн тодорхой шалгууртай, парламентын ажлын туршлагатай юу гэж үздэг, тухайн салбарыг эсвэл харьяалах чиглэлээ хэр мэдэж байна гэдгээр нь бас үздэг, хэлэлцүүлэг удирдах магадгүй нөхцөл байдал намжмал биш байх юм бол тэрийг намжаах үүрэг хүлээх ур чадвар байна уу, парламентын гишүүдийн дунд бол хүлээн зөвшөөрөгдөх чанар байна уу гэдгээр нь хэмжиж энийг тодорхойлдог учраас энэтэй холбоотой зүйл дээр та бүхэн хэрхэн жишээ нь ажилласан юм бэ гэсэн ийм асуулт байна.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Зүлпхар гишүүний асуултад хариулъя. Саналаа биечлэн өгөх зохицуулалт туссан байгаа. Гишүүн саналаа заавал биечлэн өгөх зохицуулалт нэмээд Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд маань идэвхтэй үйлдлээрээ саналаа өгнө. Дэмжиж болно, дэмжихгүй байж болно. Тэр чөлөөтэй. Ганцхан дэмжиж байгаа бол дэмжиж байгаа саналаа биечлэн өгчихье, дэмжихгүй бол дэмжээгүйгээ биечлэн саналаа өгчихье. Дэмжээгүйг дэмжье гээд идэвхгүй үйлдлээр санал өгдгөөсөө болоод Үндсэн хууль зөрчөөд хууль бусаар засгийн газраа огцруулаад энэ асуудал та бүхэн мэдэж байгаа. Ийм алдаануудыг давтмааргүй байна. Тийм болохоор энэ Улсын Их Хурал дээр одоо хэлэлцэж байгаа асуудал дээр заавал дэмжих, дэмжихгүй нь гишүүний бүрэн эрх. Ганцхан биечлэн өгч хариуцлагатай оролцдог байя гэдэг зохицуулалтыг тусгаж нарийвчилж оруулж өгч байгаа.

Тэгээд үүнтэй холбоотойгоор санал хураалтад ерөөсөө биечлэн оролцохгүй бол тодорхой хуулийн хариуцлага, ёс зүйн хариуцлага хүлээхээр ийм зохицуулалтууд бас орж ирж байгаа. Ингэж өгөхгүй бол үндсэндээ Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хэлэлцэж байгаа хуулиуд маань ингээд эс үгүй бол дэмжээгүйг дэмжье гээд батлагддаггүй хууль унаад байдаг, эс үгүй бол унагаахгүйн тулд асуудлаа шийдэж чадахгүй хурал гацаад байдаг ийм юм руу орчих гээд байх юм.

2024 оноос хойш ч манай 9 дэх удаагийн парламент нийтдээ 57 Байнгын хороод хуралдаж чадаагүй байна. Энд ирц хүрэхгүй шалтгаанаар 40 орчим удаа, ирц хүрсэн ч нөгөө саналаа өгөхгүй асуудал нь унаад байсан учраас яах аргагүй хойшлуулах шалтгаанаар хуралдахгүй байх иймэрхүү тохиолдлууд гарч байгаа юм. Тийм болохоор илүү саналаа биечлэн өгдөг байх зохицуулалт орсон.

Улсын Их Хурлын гишүүнд үг хэлэх, хариуцлагатай холбоотой, Байнгын хороодын дарга нарыг сонгох үг хэлэх ирцийн асуудал ярьж байна. Ер нь статистик үзүүлэлтүүдийг одоо ч гэсэн мэдээлдэг. Хуралдаанд оролцсон, оролцоогүй, тасалсан, чөлөөтэй, гадаад томилолттой, дотоод томилолттой, өвчтэй. Дээрээс нь санаачилсан хууль, ажлын хэсэг ахалсан, ажлын хэсэгт орж ажилласан байдал. Энийг илүү чанарын хувьд хууль санаачилж байна гээд хууль санаачлагчийн нэгд хамтад нь гарын үсэг зурчхаад бланк дээр нь тэр гарын үсэг зурсан өөрийнхөө санаачилсан хуулийнхаа эсрэг саналаа өгдөг, эсрэг асуулт асууж эсрэг дэмжихгүй үг хэлдэг иймэрхүү хариуцлагагүй хандлагыг больё. Үнэхээр хууль санаачилсан бол хариуцлагатай байя.

Ажлын хэсэгт орчхоод ажлын хэсгийн хуралдаандаа ирдэггүй. Би орно би орно гээд бүгдээрээ ажлын хэсгийн гишүүн болчихдог. Тэгсэн мөртөө ирдэггүй бол 2-оос дээш удаа ирэхгүй бол ажлын хэсгээс гаргадаг байх.

Мөн анх Байнгын хорооны даргыг сонгохдоо бол туршлагыг харгалзъя гэж байгаа. Цааш цаашдаа бол Байнгын хороод дээр илүү их юу гэдэг юм гишүүдийн идэвх оролцоог бас харгалзаж болох юм гэж оруулж өгч байгаа. Мэдээж үндсэн шалгуур нь бол Байнгын хороог удирдах туршлага байна.

2 дугаарт нь нэмэлт шалгуур нь бол бас идэвх оролцоо байна гэсэн нэмэлт зохицуулалт гишүүдийг идэвхжүүлэх ийм бас зохицуулалтууд нэмж орж байгаа.

**С.Бямбацогт:** Ариунзаяа гишүүн нэмж, хууль санаачлагч Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя, хариулъя.

**А.Ариунзаяа:** Санал хураалтыг биечлэн өгнө гэж зааж өгч байгаа юм чинь санал хураалтыг тодорхой цагийг нь бас тодорхой болгож байнга зарлана. Тэр зарлагдсан цагаасаа өмнө 10 минутын өмнө Улсын Их Хурлын ордон дотор 1 минутын туршид хонх дуугарна. Ингэснээр ямар ч уулзалтад байсан бай гишүүн орж ирж саналаа өгөх үүргийг хүлээх юм. Энийг онцолж нэмж хэлмээр байна.

2 дахь нь болохлоор энэ Байнгын хорооны даргыг сонгохтой холбоотой гишүүд их асуулт асуугаад байна. Энэ болохлоор тодруулж өгсөн энэ заалт нь зөвхөн дахин буюу сунгаж сонгох асуулт дээр нь тухайн Байнгын хорооны даргыг хэрхэн ажлаа хийсэн бэ гэдэг дээр суурилж бас үнэ үнэлгээ болгох юм гэж тодруулж өгч байгаа асуудал. Анх сонгогдож байгаа Байнгын хорооны даргыг бол туршлагаар нь, нөгөө талдаа бол сунгагдах тал дээр нь бол өөрөө үнэхээрийн даргаа сайн хийсэн юм уу, оролцоотой байсан юм уу, бусдад өгчхөөд яваад байсан бол тэр хүнийг сунгах шаардлагагүй шүү дээ. Энийг л оруулж өгч байгаа юм гэдгийг.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Зулпхар гишүүн нэмж тодруулъя.

**С.Зулпхар:** Биечлэн санал өгөхийг бол бүрэн дэмжиж байгаа. Тэгж байж бид бол энэ хууль бол их зөв гарахаар, хуультай холбоотой шийдвэр зөв гарахаар ийм л нөхцөл байдал үүсэж байгаа шүү дээ. Тэгээгүйгээс болоод бид бол буруу механизмтай яваад байсан гэдэг талаас нь.

Миний жишээ нь 3 дахь асуулт байгаа шүү дээ. Тэр Байнгын хорооны дарга бол саяын бидний хэлсэн зарим нэг жишээ нь тоон үзүүлэлтүүд бол нэг их онцгой ач холбогдол байхгүй. Асуулт асуух, үг хэлэхээр бол бид өчигдөр ч гэсэн Байнгын хороон дээр ярьсан шүү дээ. Ариунзаяаг гишүүн бол бараг баттай Байнгын хорооны дарга л гэдэг л ийм л шалгуур гарч ирж байгаа байхгүй юу. Тийм байж болох байх.

Гэхдээ яг практик дээр яагаад гэхлээр зэрэг бүх улсын жишээ нь парламентад юу вэ гэхлээр зэрэг энэ улс төрийн ажлын туршлага гэж чухал юм байгаа юм. 2 удаа сонгогдоод 3 удаа сонгогдоод ирэхээр зэрэг тэртээ тэргүй Байнгын хороог чинь даргалаад явах тийм хэмжээний туршлагатай байгаа шүү дээ. Энийг та бүхэн хэр харгалзсан бэ гэдэг би ийм асуултыг асууж байгаа юм. 5 тусдаа шалгуур байгаа. Би тэр шалгуурыг дараа нь ажлын хэсэг дээр бол ярина гэж бодож байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Ариунзаяа гишүүн нэмж хариулъя.

**А.Ариунзаяа:** Бид саяхан Энхтуяа гишүүний бас нэг асуултыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр асуусныг бас сошиал дээр та хэд маань бас харсан байх. Нэлээд хүмүүсийн анхааралд өртсөн. Тэр нь Байнгын хорооны даргаар сонгогдчихоод хурлаа өөрөө удирдахгүй хэд хэдэн удаагийн чөлөө аваад байна гэж. Тэгэхээр зүгээр дарга байхын төлөө дарга болоод хурлаа бусдаар удирдуулаад, чуулгандаа оролцдоггүй, тухайн салбарын асуудлыг мэддэггүй, асуултад хариулдаггүй ийм хүнийг дахин улираан сонгох шаардлагагүй ээ гэдэг л ийм л үзүүлэлт орж ирж байгаа юм. Тэрнээс биш анх даргаар сонгогдоход энэ асуудлыг бол шалгуур болгохгүй гэдгийг онцлон хэлж байгаа юм.

Ер нь бол Улсын Их Хурлын гишүүд чуулганы хуралдаан үйл ажиллагаандаа идэвхтэй оролцож, асуулт асууж, хариулт өгдөг байх үндсэн үүрэг шүү дээ. Тэгэхээр энийг л онцолж хэлж байгаа юм гэдгийг бас тодруулж хэлье. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Зулпхар гишүүн нэмж тодруулъя.

**С.Зулпхар:** Баярлалаа 1, 3 дугаар асуултын хариулт бол их тодорхой болж байх шиг байна.

2 дахь асуудалтай холбогдуулаад тэр үг хэлэх эрхийг түдгэлзүүлэхтэй холбоотой. Улсын Их Хурлын гишүүн бол Улсын Их Хурлын танхимд хэлсэн үгнийхээ төлөө тухайн үед болон дараа нь бол хариуцлага хүлээдэггүй. Энэ бол халдашгүй байдал нь л даа. Энийг бол бид бол мэдэж байгаа. Гэхдээ Улсын Их Хурлын хуралдааны өөрийнх нь дэгтэй холбоотой сахилгын арга хэмжээ бол журамлагдсан байдаг. Одоо энэ хуулиар ч гэсэн байж байгаа шүү дээ.

Тэгэхлээр Их Хурлын гишүүддээ ч гэсэн хэлмээр байна. Бид энэ зарим журамлагдсан зүйлийг бол хүлээж авах ёстой. шүү. Тэгээгүйгээсээ бол бид бол өөрөө Их Хурал дотроо янз янзаар бие биеэ хэлдэг сүүлдээ энэ чинь нийгмийн хувьд бол Их Хурал бол байж болохгүй болохгүй улсуудын цуглуулга юм шиг ийм ойлголтууд хөтөлж байгаа бол энийг бол хатуу зохицуулах ёстой. Би бол тэр их их газрын загвараар нь явсан нь зөв шүү гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Зочин танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 11<sup>а</sup> ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багшид сурган хүмүүжүүлэх ажилд нь өндөр амжилт хүсэж, сурагч нарт сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье.

Одоо Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууна.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хуралтай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ бол үнэхээр байгаа юм байна. Одоо яг өнөөдөр энэ болж байгаа үйл явдал ч гэсэн илэрхийлэгдэж байгаа юм. Ямар улсын парламентад иргэд нь парламенттайгаа танилцаад орж ирэхэд тэрэндээ зориулж үг хэлээд алга ташуулаад, иргэдээ парламентын гишүүд нь урьж авчирдаг, ордондоо залж авчирдаг тийм улс байхгүй шүү дээ. Гишүүдийнхээ урилгаар биш гишүүд нь дуртай, иргэд нь дуртай үедээ парламенттай орж ирээд зүгээр танилцаад гарч байдаг. Гишүүд татвар төлөгчдийн мөнгөөр энд хуралдаж байхдаа, нийт сонгогчдынхоо итгэлээр энд ажиллаж байхдаа тэр олгосон цаг хугацааг энэ улс орныхоо хувь заяаг шийдэхэд зориулах ёстой. болохоос биш сонгуулийнхаа Пи Ар-ыг хийгээд ингээд тайзан дээр алга ташуулж байгаа юм шиг би иргэддээ ойрхон гээд ингээд зарлаад сууж байдаг парламент байхгүй байхгүй юу.

Хоёрт нь гишүүд ингээд хэлж байна шүү дээ үг хэлэх эрх гээд. Монгол Улсын Үндсэн хууль дээр байж байгаа Улсын Их Хурал бол Монгол Улсын гадаад, дотоод бодлогын асуудлыг бүх асуудлыг санаачлах эрхтэй. Бодлогын асуудлыг санаачилж байгаа энэ Улсын Их Хуралд бодлого дээрээ маргаж мэтгэлцэх парламент байх ёстой. Гишүүдийн үг хэлж байгаа гэдэг энэ байр суурь бол энэ бодлогын асуудлыг хэлэлцэх хамгийн суурь нь. Тийм учраас парламентын танхим буюу чуулганы танхимд зөвхөн мандаттай хүн үг хэлнэ гэдэг зарчим парламентад ёстой. байдаг. Монгол Улсын Үндсэн хууль дээр ч гэсэн үүнийг баталгаажуулчихсан.

Монгол Улсын Үндсэн хууль дээр юу гэж бичсэн байгаа вэ гэхээр би та бүхэнд бүүр зүгээр нэг зүйл, заалтыг уншвал өгье гэж бодоод байгаа юм. 33 дугаар зүйл дээр ингэж бичсэн байгаа юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын, Монгол Улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлэл хийнэ, саналаа оруулна гэж.

Улсын Их Хурлыг болохоор гадаад, дотоод бодлогын асуудлаар гэж бичээд Ерөнхийлөгчид гадаад, дотоод байдлын талаар гэж байгаа юм. Мэдээлэл өгнө гэж бичиж байгаа юм. Тэгэхээр одоо бид хэд үнэхээр Улсын Их Хурлын энэ чуулган дээр хэн дуртай нь үг хэлдгийг болиулах ёстой. Улсын Их Хурлын гишүүдээс бусад этгээд Улсын Их Хуралд мэдээлэл өгнө, танилцуулга хийнэ, саналаа оруулж болно. Улсын Их Хурлын гишүүд бол үг хэлнэ. Энэ үг хэлэхийн эрхийг бид нар энэ Улсын Их Хурлын чуулганаас гадагш гаргаж түрүүн Пүрэвдорж гишүүний хэлдгээр гүтгэсэн, доромжилсон гэдгээр шүүхийн асуудал болгож болохгүй. Үзэл бодлоо илэрхийлээд, байр сууриа илэрхийлээд бодлогын асуудлаар мэтгэлцэж байгаа хүмүүс санаа бодлоо хурц илэрхийлэх хэрэгцээ гарна. Энийг хил хязгаар нь энэ

чуулганыхаа дотор шийддэг байх ёстой. Тэгж байж парламентад ёс, парламентын дархлаа оршин тогтноно.

Дээр нь энэ Улсын Их Хурлын чуулганы зохион байгуулалтыг дахиад өөрчлөх ёстой. Ямар ч хуульгүйгээр энэ индэр дээр 3 сэнтий зарлаад яг феодализм шиг суулгаж байгаа. Ерөнхий сайдын суудал энд байж болохгүй шүү дээ. Парламентад ажлаа хариуцан тайлагнадаг хүн нь парламентын тархин дээр гараад нэгэн дээр сууж байж болохгүй шүү дээ. Энэ дунд, доошоогоо орж ирж суух ёстой. Тэгж байж парламентын мэтгэлцээн явна. Тэгж байж бодлогын асуудал хөндөгдөнө. Тэгж байж парламентынхаа тархин дээр гарсан гүйцэтгэх засаг байхгүй болно. Үг хэлэх эрхийн тухай ярьсан. Ерөнхийлөгчийн энэ индэр дээр микрофон байж болохгүй шүү дээ. Ерөнхийлөгч мэдээлэл өгөх бол энэ индэр рүү орж ирж энэ микрофон дээр ярих ёстой. шүү дээ. Энэ чинь хууль тогтоох байгууллага.

Монголын Үндсэн хууль дээр ард түмнийг төлөөлөх ганцхан институт байгаа. Тэр нь Улсын Их Хурал. Ерөнхийлөгч ард түмнийг төлөөлдөггүй.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүд төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэн билүү, дээдэлнэ гэж нэг тангараг өргөдөг санагдаж байна. Тийм. Тэгэхээр Улсын Их Хурлын үйл ажиллагаатай, Төрийн ордонтой ард иргэд маань танилцдаг. Энэ 1990 оноос хойш л танилцдаг болсон байх. Миний мэдэхийн л танилцдаг. Энэ үедээ Улсын Их Хурлын дарга танилцаж байгаа гишүүдийг танилцуулаад тэр гишүүний урилгаар ирсэн гээд ордон руу ороход чинь бол гишүүдийн зөвшөөрлөөр л ордог шүү дээ. Энэ зөвшөөрлөөр орж ирсэн шүү гэдгийг нь танилцуулаад тэгээд мэндчилгээ дэвшүүлдэг. Энэ бол парламент бас ард түмэнтэйгээ ойр байж байгаа, ард түмэнтэй бас нэг амьд харилцаатай байгаагийн бас нэг илэрхийлэл болов уу. Энэ талаас нь харах юм бол бас нэг энэ парламент, Төрийн ордонтой танилцаж байгаа хүмүүс Улсын Их Хурал дээр очсон чинь биднийг танилцууллаа. Бидний тэр аймгийн, тэр сумын тийм иргэд ирлээ гээд, биднийг бас улс орондоо ирж зарлалаа гээд аягүй их баярладаг юм байна лээ.

Гишүүд маань ч гэсэн бас тэр гишүүний урилгаар гээд хэлэхээр бас миний тойргийн гишүүд, манайхан ирсэн шүү бас баярладаг юм байна лээ. Ийм байдлаар бас парламент иргэдийн хооронд, ард иргэдийн хооронд бас нэг амьд харилцаа, халуун дотно уур амьсгал бий болгож байвал нэг их тийм буруу зүйл биш байх. Хөндий хүйтэн байгаад байвал улам л холдоно. Үүнээсээ болоод улам л үл ойлголцоно. Эргээд л юу гэдэг юм парламент итгэх ард түмний итгэл суларна. Тийм болохоор үндсэндээ парламентын итгэлийг бий болгох, парламентыг илүү ард иргэдийнхээ ил тод, нээлттэй, дээрээс нь иргэдийн оролцоотой болгох энэ тал дээр бол илүү бас бид нар бодлого барих ёстой. Энэ үүднээсээ бол цаашдаа илүү иргэдийн оролцоотой байх тал дээр илүү анхаарах ёстой. гэж би бодож байгаа.

Гишүүд үг хэлж байгаа. Ерөнхийлөгч Ерөнхий сайд үг хэлэх үү, хэлэхгүй юу гэдэг дээр бол хуулиудад бол бас орчихсон юм байна лээ. Ерөнхийлөгч ингээд анхдугаар чуулган дээр үг хэлнэ, мэдээлэл хийнэ. Ерөнхий сайд бол асуудал дээр бас үг хэлнэ гээд үүгээрээ явдаг. Гадна, дотнын бас зочид гийчид ч гэсэн бол парламент дээр үг хэлдэг Монгол Улсын. Зөвхөн Их Хурлын гишүүн үг хэлдэг

бусад нь үг хэлэх эрхгүй гэсэн зохицуулалт манай Үндсэн хууль болон Их Хурлын тухай хуулиуд байдаггүй. Уламжлал нь ч ийм явж ирсэн.

Гадна, дотнын парламент ч гэсэн бас Америкийн Нэгдсэн Улсын парламент дээр ч гэсэн бас Ерөнхийлөгч нь тэгээд дээрээс нь гадна дотнын зочид нь үгээ хэлж л байдаг юм байна лээ. Тийм болохоор бид нар бас нэг тийм их онцгойрох гээд их зөв үү буруу юу. Энийг хэрвээ шаардлагатай бол манай гишүүд өөрсдөө хууль санаачлаад тэрийг нь Их Хурал дээр бас олонхоороо шийдээд явах боломжтой. Бид нар чинь бол тэгээд асуудал бол орж ирдэг чөлөөтэй. Чөлөөтэй санал, хуулиа санаачилдаг, чөлөөтэй зарчмын зөрүүтэй саналаа гаргадаг, энийгээ олонхоороо л шийдээд явдаг. Энэ зарчмаар манай Тэмүүжин.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.7-д заасны дагуу шаардлагатай тохиолдолд хуралдааныг даргалагч 1 цагаар сунгаж болно гэсэн заалтын дагуу 1 цагаар сунгалаа. Үдийн цайгүйгээр шууд явна.

Тэмүүжин гишүүн нэмж тодруулъя.

**Х.Тэмүүжин:** Бид нар хууль зүйн ойлголтуудаа ингээд тодорхой болгохгүй болохоор ингээд зүгээр Монгол хэлний үгээрээ маргалдаад байгаа юм шиг болно. Ер нь нэг хандлагаа солих ёстой. Сонгогчид нь, иргэд нь парламентын ордонд зөвшөөрөл авч орж ирдэг энэ тогтолцоогоо болих хэрэгтэй. Хэн нэгэн гишүүн зөвшөөрч урихаар нь нэвтрэх эрхтэй болдог гэдэг энэ гажуудлаа бас болих хэрэгтэй. Нөгөө улс орнуудад чинь бол иргэд нь дуртай үедээ аюулгүй байдлынх нь үзлэгээр ороод л орж ирээд парламентыг маршрутынхаа тухай танилцаад төлөөлөл нь яаж ажиллаж байгааг хянаад явж байгаа байхгүй юу. Иргэний хянах эрхийг дарга нарын зөвшөөрөл болгочхоод тэрийгээ нэг ард иргэдийн ойрхон харилцаа гэж эндүүрч болохгүй шүү дээ.

Хоёрт нь одоо парламентад явсны хамгийн чухал нэг зарчмыг бид хэрэгжүүлэх ёстой. Олонх нь шийдвэрээ гаргадаг, цөөнх нь хянах ёстой. Энэ Засгийн газрын гишүүд парламентын хяналтын бүтцэд ажилладгийг болиулах хэрэгтэй. Хяна.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Хариултаа Бямбацогт дарга өгье.

**С.Бямбацогт:** Засгийн газрын гишүүд энэ Улсын Их Хурлын ялангуяа хянан шалгах чиг үүрэгтэй бүтцэд ажиллах нь буруу. Хууль тогтоох дээд байгууллага бол Улсын Их Хурал. Хуулийг хэрэгжүүлэх дээд, гүйцэтгэх дээд байгууллага бол Засгийн газар. Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагаанд Улсын Их Хурал тасралтгүй байнга хяналт тавих ёстой. Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих ёстой. Гэтэл өөрсдийгөө хянуулах ёстой. Засгийн газрын гишүүд нь Их Хурал дотроо орж ирээд өөрөө өөрийгөө хянах гээд байх энэ тогтолцоо буруу энэ бол засагдаж байгаа ийм зүйл гарахгүй.

Урьд нь бас иймэрхүү тохиолдлууд байгаад байсан. Тийм болохоор бид нар бол үндсэндээ бол хаана байна Үндсэн хуульд заасан тэр институт хоорондын харилцаагаа улам боловсронгуй болгох шаардлагатай. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль ч гэсэн яг энэ хүрээндээ батлагдсан. Энэ хүрээндээ. Тийм

болохоор энэ рүү бас таны хэлж байгаатай бас санал нэг байна. Энэ бол ингэж засагдаж байгаа. Цаашдаа энэ алдаа.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн нэмж тодруулъя.

**Х.Тэмүүжин:** Энэ ёс зүй, парламентын гишүүний ёс зүйтэй холбоотой асуудал дээр бид нар бас нэг эндүү ойлголтуудаа засах хэрэгцээтэй байгаа юм байна лээ. Парламентад ёс бүхий улс орнуудын парламентын гишүүний ёс зүй гэдэг зүйл дээр 2 зүйлийг л их чухал болгодог юм байна лээ.

1 дүгээрт нь ард түмний нэрийн өмнөөс гүйцэтгэх эрх мэдлийг буюу Засгийн газрыг хянах гэж байгаа гишүүд ямар ёс зүйтэй байх тухайг маш нарийн зохицуулж өгдөг юм байна. Тэр нь улс парламентын гишүүний ёс зүй буюу 1 дүгээр дүрэм нь та бүхэн хянах гэж байгаа бүтцээсээ мөнгө гуйж болохгүй шүү. Та бүхэн хянах гэж байгаа бүтэцтэй хэн нэгнийг ажилд оруулахын тулд санаачилга гаргаж болохгүй шүү. Ийм хэлцэл юм уу яриа бүрдүүлэх юм бол таны парламентын гишүүний ёс зүй чинь маш том доголдож байна гэж үзнэ шүү гэж хэлдэг юм байна лээ.

Гэтэл одоо бид бол олон нийтэд муухай үг хэлж байна уу үгүй юу, үзэл бодлоо буруу илэрхийлж байна уу үгүй юу, чуулганыхаа.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж хариулъя Бямбацогт дарга.

**С.Бямбацогт:** Таны хэлж байгаатай санал нэг. Монгол жижигхэн яах аргагүй л холбогдчихдог. Тэгээд л хүссэн хүсээгүй тэгээд л Засгийн газар, Улсын Их Хурал хэлчихдэг нэг иймэрхүү асуудлууд байгаа. Тэгээд үүнийгээ шийдэх гээд бас хэтэрхий шударга болгох гээд, хэтэрхий зөв болгох гэж байна гээд хэтэрхий туйлшруулдаг бас асуудлууд байна. Тийм болохоор бас амьдрал баян, амьдрал дээр бас аль болох л таны хэлж байгаа зарчим руу бас нийцүүлэх нь зөв байх. Гадаадад томилолтод явахад чинь тэгээд л тодорхой хуулиудыг ажлын хэсэг байгуулдаг. Тэр ажлын хэсэг хуулийг Засгийн газар маань өргөн барьсан байдаг. Тэгтэл гадна, дотнын, төсөл, хөтөлбөртэй хамтраад явахад чинь яах аргагүй л нөгөө Засгийн газрын гишүүдтэйгээ хамтраад явах Засгийн газраасаа тодорхой санхүү зардал гаргуулах гээд л нэг иймэрхүү асуудал үүсээд байгаа юм л даа. Хэтэрхий хатуу болчих юм бол тэгээд Улсын Их Хурлын бас үйл ажиллагаа цаашдаа бас явах бололцоо боломж бид нөгөө Улсын Их Хурлын төсөв мөнгө чинь бага.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн С.Алтангэрэлийн урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1998 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Алтангэрэл гишүүн чинь 98 оных байх аа. Танай ангийнхан уу? Алтангэрэл гишүүний төгсөлтийнхөн байна. Манай Алтангэрэл гишүүн, Хосбаяр гишүүн нар бол орон нутгаараа явж маш их иргэдтэй уулзаж, энэ Их Хурал дээр үг хэлдэг сайн гишүүд байгаа шүү. Баяр хүргэе та бүхэнд.

Лхагваагийн Мөнхбаатар гишүүн асуулт асууна.

**Л.Мөнхбаатар:** Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд байгуулагдсан 126 гишүүнтэй энэ парламентын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бол өмнөх парламент бол тогтоосон, тогтоосон. Ялангуяа энэ Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын энэ чуулганы дэгийн тухай хуулийг бол Нямаагийн Энхболд, Тэмүүлэн бид 3 бас санаачилж батлуулсан ийм хууль байгаа юм. Одоо ингээд 2 жил мөрдлөө. Энэ үед бас мэдээж 126 гишүүнтэй анхны парламент бий болох гэж байгаа учраас энэ үйл ажиллагааных нь эрх зүйн үндсийг хэрхэн яаж тогтоох вэ, хуралдааны дэг нь ямар байх вэ, энэ 50 гишүүнээр нэмэгдсэнтэй холбогдуулан энэ ширээ сандал энэ танхимыг хэрхэн яаж зохион байгуулах уу гээд их ажлууд өрнөж байсныг та бүхэн маань мэдэж байгаа. Энэ 50 ширээ сандлыг чинь Лаос руу би бас өөрөө биечлэн айлчилж байж бэлэгт авчирч энэ ширээ, сандлуудыг ингээд тохижуулж багтааж байсан саяхан байна.

Ингээд үйл ажиллагааны үндсийг бол ингээд тогтоочихсон юм байгаа юм. Гайгүй сайн хууль болсон болов уу гэж боддог. Сая 2 жилийн үр хугацаанд бол Их Хурлын үйл ажиллагаа хэвийн сайн явагдлаа. Гэхдээ Улсын Их Хурал бол өөрийнхөө эрх зүйн байдал, үйл ажиллагааныхаа үндэс энэ дэгээ бол өөрсдөө тогтоох хэрэгтэй учраас илүү боловсронгуй болгоод ингээд явах нь зүйтэй гэдгийг гэдэг агуулгаар би дэмжиж байгаа юм. Энэ бол ингээд цаашаа явах нь зүйтэй байх гэж бодож байна.

Энэ дээр яах вэ хэд хэдэн зүйлүүд байна. Ер нь Байнгын хороодынхоо тоог нэмж байгаа юм байна. Дэд хороодоо цөөлж байгаа юм байна. 11 Байнгын хороо гээд хуулийн төсөл дээр байна. Энэ дээр харин би нэг зүйлийг санал хэлье гэж бодоод байгаа юм. Энэ Эдийн засгийн байнгын хороо гээд их том асуудлуудтай Байнгын хороо эрхлэх асуудал. Эндээс нь мөнгөний бодлого, санхүүгийн болоод энэ эрчим хүч, түлш, зам тээвэр гээд бүгдийг нь агуулчихсан нэг ийм Байнгын хороо байгаад байгаа юм. Энийг бол ер нь тодорхой хэмжээнд салгаад хүнд үйлдвэрийн бодлогын асуудал ч энд байж байгаа. Стандарт, бусад олон чиглэлийн юмнууд байгаа шүү дээ статистик, бүгдээрээ явж байгаа. Энэ болгоныг салгаад дэд бүтцийн байнгын хороо байгуулаад явах нь хамгийн зөв шүү гэж би хэлэх гэж байгаа юм. Ингэж байж энэ зам тээвэр, түлш, эрчим хүч ингээд олон асуудлаараа шуурхай шийдвэрүүдээ гаргадаг энэ тал руугаа явах нь зүйтэй. Нөгөөдөх нь бол илүү эдийн засгийн бодлого талаасаа явдаг энэ рүүгээ явах нь зүйтэй шүү гэж гэдгийг бас хэлье гэж бодож байна.

Дараагийн нэг зүйл бол энэ парламентын нэг чухал зүйл бол энэ иргэдтэйгээ харилцах гол зүйл бол энэ d.parliament буюу энэ нийтийн өргөдлийн цахим систем гэж бий болгосон. Энэ бол их чухал зүйл юм байгаа юм. Манай маш чухал зүйл. Иргэд маань энэ d.parliament-ын энэ цахим систем рүү л хандаж байгаа шүү дээ. Хүсэлтүүдээ өгдөг, саналуудаа өгдөг, түүнийг нь Их Хуралд авч хэлэлцдэг. Ийм учраас энэ бол парламент иргэдийг холбосон гүүр, маш сайн гүүр гэж бодож байгаа.

Гэтэл энэ дээр бол бичсэн байна л даа. Төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан төсвийн зарлагын доод, орлогын дээд хэмжээнд нөлөөлөхүйц нийтийн өргөдлийг хүлээн авахгүй гэгчхэж байгаа юм. Гэтэл иргэд ямар асуудал тавьдаг вэ гэхээр ихэнх нь нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, татвар эд нартай холбоотой л асуудлаа гол нь тавьж байгаа шүү дээ. Тэгээд энийг нь авахгүй гээд хаачихаар чинь цаана нь юу ирэх юм? Юу ирэх юм тээ. Ийм учраас энэ бол би зохимжгүй нь

гэж байгаа юм. Авч үз, үзээд Их Хуралд харин болно гэвэл болох шийдвэрээ гаргаж байх ёстой. Болохгүй бол болохгүйгээ хэлээд явдаг энэ иргэдийнхээ дуу хоолойг сонсдог, статистикийг нь үздэг, энэ иргэдтэй холбоотой энэ системээ бол тасалж болохгүй ээ гэдгийг бас би хэлье гэж бодож байна.

Дараагийнх нь бол энэ гишүүдийн ирц, ёс зүйтэй холбоотой асуудлуудыг бид бас сайжруулж томъёолж байгаа нь зөв байна. Энэ дотроо мэдээж ирцтэй холбоотой гэдэг юм уу, санал хураалтыг хэрхэн тооцох вэ гээд явахад бол олон зүйлүүд байдаг шүү дээ. Анхны хэлэлцүүлэг дээр бол хамгийн олон санал хураалт явагдчихдаг.

1 удаагийн Байнгын хорооны хурал дээр 50 санал хураалт явж байхад 1 удаагийн хурлаар 5 санал хураалт ч явах ч юм байна шүү дээ. Тэгэхээр тоогоор нь хөөцөлдөх юм бол энэ бол өөрөө зохимжгүй шүү. Яагаад гэвэл анхны хэлэлцүүлэг бол хамгийн олон байгаа. Эцсийн хэлэлцүүлэг гэдэг юм уу дараагийн хэлэлцүүлгүүд бол ингээд л цөөхөн байж таараа шүү дээ. Тэгээд ч энийгээ бид нар та нар бас сайн тооцож хийх нь зүйтэй байх гэж бодож байна. Их Хурлын Тамгын газрын дэргэд байсан энэ.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариульъя.

**С.Бямбацогт:** Тийм ээ Мөнхбаатар гишүүний хэлж байгаа Эдийн засгийн байнгын хороо үнэхээр олон асуудалтай үнэхээр том. Тэгээд хэлэлцэж байгаа асуудлуудаа ерөөсөө 7 хоногтоо хэлэлцүүлж дуусдаггүй, их ачаалалтай, хамгийн өндөр ачаалалтай ажилладаг Байнгын хороо. Тийм ч үүднээс Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудал хариуцах чиг үүргүүдийг үндсэндээ 3 удаа хувааж байгаа. Эдийн засгийн байнгын хороон дээр эдийн засгийн асуудал, таны ярьж байгаа дэд бүтцийн асуудал, хүнд үйлдвэрийн бодлого.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудлуудыг нь тусад нь салгаад Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн байнгын хороо руу шилжүүлж байгаа. Байгаль орчин, ногоон хөгжлийн асуудлаа тусад нь яг дагнасан Байнгын хороо болж байгаа.

Дээрээс нь инновацтай холбоотой асуудлуудыг Эдийн засгийн байнгын хорооноосоо салгаад цахим бодлого инновацын асуудлуудаа ийшийгээ ингэж ангилж хуваарилж өгч байгаа. Иймэрхүү байдлаар үндсэндээ бол Эдийн засгийн байнгын хорооны их том данхар бүтцийг маш олон чиг үүргүүдийг ингэж илүү маневрлаж 3 Байнгын хороонд чиг үүргүүдийг нь салгаснаараа Эдийн засгийн байнгын хороо илүү үндсэн асуудал руу анхаарах ийм боломж бүрдэх юм.

Үйлдвэржилтийн байнгын хороо байгуулчихвал зүгээр гэж гишүүд яриад байгаа. Урьд нь Үйлдвэржилтийн байнгын хороог бид нар байгуулж үзсэн. 2 удаа байгуулж үзсэн. Манай Сайнхүүгийн Ганбаатар гишүүнийг ахалж байсан. Дараад нь манай гишүүн асан Өвөрхангай Ганболд гишүүн ахалж байсан. Энэ үед Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хорооны чиг үүрэгтэй давхцаад хэлэлцэж байгаа асуудлаа булаацалддаг, нэг чиг үүрэгтэй асуудлаар үйлдвэржилттэй холбоотой асуудлаар 2 өөр шийдвэр гардаг иймэрхүү бас нэг давхацчихсан, чиг үүргээ булаацалдсан эс үгүй бол хийдүүлсэн ийм асуудлууд

гараад байсан учраас Үйлдвэржилтийн байнгын хорооны асуудлыг хүнд үйлдвэрийг нь Эдийн засгийн байнгын хороо, хөнгөн үйлдвэрийг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн байнгын хороо руу ингэж ангилсан. Одоо ч гэсэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр хүнд үйлдвэрийн асуудал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр хөнгөн үйлдвэрийн асуудал явж байгаа.

Өргөдөл хүлээж авах асуудлыг бас яг та маш чухал асуудал сая ярилаа. Энэ иргэдийн саналыг, иргэдийн оролцоон дээр тулгуурлах, иргэдэд нээлттэй гээд чуулганы хуралдаан, Байнгын хорооны үйл ажиллагааг нээлттэй тавих нь нээлттэй харагдаж байгаа байх. Өшөө илүү нээлттэй, өшөө илүү ил тод байя, өшөө илүү иргэдийн оролцоон дээр тул тулгуурла тэгэхийн тулд өмнөх сайн жишгүүдээ тэр d.parliament.mn, d.petition.mn энэ бас технологийн давуу талуудыг ашиглаж иргэдтэйгээ илүү ойр ажиллая. E-Mongolia-аар үндсэндээ бол төрийн бодлого, үйл ажиллагаа иргэддээ илүү хүрдэг болоод байгаа. Яг үүнтэй адилхан илүү гэрээсээ, гар утаснаасаа парламентын үйл ажиллагааг мэдээллийг авчихдаг, парламентын үйл ажиллагаанд оролцоод саналаа өгчихдөг, дэмжих юмаа дэмжээд, шүүмжлэх юмаа бол шүүмжилчихдэг. Тэр нь бас иргэдийн дуу хоолой парламент дээр тусгал нь болж яригдаж байдаг энэ юмнуудыг бас зохицуулах зохицуулалтуудыг энд Их Хурлын тухай хууль нэлээн сайн оруулж ирсэн байгаа. Мөн хуулийг сурталчлах ажлаа ч гэсэн бас.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

**Б.Батбаатар:** Энэ хууль бол Их. Хурлын даргын өрөөнд Улсын Их Хурлын Тамгын газар дээр Ерөнхий нарийн бичгийн даргын өрөөнд боловсрогдсон хуулиа гэж би ойлгосон. Техникийн хувьд боловсруулах нь зүйтэй ч байх. Тэр процесс нь бол яах вэ. Гэхдээ энэ хуульд нэг асуудал байна. Улсын Их Хурал бол Үндсэн хуулиар ч тэр, онолынхоо хувьд, практикийнхаа хувьд хэдэн мянган жилийн түүх парламент гэдэг энэ хөгжлийн, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагаараа бол энэ өөрөө ард түмний төлөөлөл. Энэ танхим бол Засгийн газрын кабинет биш. Энэ танхим дотор иргэд, олон нийтийн дуу хоолой, олонх, цөөнхийн дуу хоолой, нийгмийн сонирхлын бүлгүүдийн дуу хоолой, хэт цөөнхийн дуу хоолой ч гэсэн энэ танхим дотор яригдаж, хэлэгдэж явах ёстой. юм. Санал, бодол нь орж ирдэг байх ёстой. юм.

Хэрвээ энэ танхим дотор одоо явж байгаа энэ хуулийн төслөөр явах юм бол ард түмний төлөөлөл буюу парламентын мөн чанараа алдана гэж харагдаж байна. Улсын Их Хуралд бүлэгтэй Ардын нам, Ардчилсан нам 2-ын бүлэгт зориулсан тэд нарын эрх мэдэл, дархлааг хадгалах гэсэн, цаашдын засаглалаа бэхжүүлэх гэсэн ийм зорилготой хууль болж орж ирлээ гэж бодож байгаа. Энэ хуулийн төслийг хэлэлцээд даргын дэргэдэх зөвлөл дээр ярьж байх үед 20 хэдэн саналыг хуулийн төсөлд оруулъя гэж өгсөн.

Хэрвээ энийг оруулах юм бол санаачлагчийн нэг болж болно гэж бодсон. Тэрийгээ илэрхийлсэн. Тэр санаачилсан санаачилгуудыг ерөөсөө хүлээж аваагүй. Үгүй ээ Ардын нам дөнгөж саяхан л хэдэн жилийн өмнө жил гаран бүлэггүй л байсан шүү дээ. Энэ чуулганы танхимын үүдэн дээр сандал эгнүүлж тавиад л сууж л байсан шүү дээ. 2005 онд “Эх орон-Ардчилал” эвсэл бүлэг задраад 3 тусдаа хэсэг болоод Ардчилсан нам бүлэггүй болоод зөвлөл гэдэг нэрийн доор үйл ажиллагаа явуулж байсан. Бүлэггүй болсны дараа юу болсон бэ гэхлээр

Ардчилсан намын дарга бөгөөд Монгол Ардын Хувьсгалт намын бүлгийн дэд дарга Р.Гончигдорж гэдэг нэртэй явж байсан шүү дээ. Тэрнээс хойш Батзандан өшөө Болд нар намын бүлгээсээ гараад Ардчилсан нам бүлэггүй болж л байсан шүү дээ. Та нар энэ түүхээ бас бодох хэрэгтэй. Энэ танхим бол ард түмний төлөөлөл юм. Түүнээс биш энэ бол гүйцэтгэх засаглалын танхим кабинетын зарчмаар ажиллах ёсгүй юм.

Их Хурлын гишүүдийг кабинетын зарчмаар ажилладаг захиргааны ажилтан болгож хувиргадаг, ард түмний төлөөлөл биш байлгадаг энэ зүйлийг энэ хуулиар дамжуулж оруулж ирж байна. Цааш цаашаагаа засаглалыг хадгалж хамгаалж үлдэхийн төлөө явж байна. Парламентын үндэс суурь, манай Үндсэн хуулийн үндэс суурь гол зарчмууд руугаа хуулиараа дамжиж халдаж байна гэж ингэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ нийгмийн хэт цөөнх, нийгмийн сонирхлын бүлэг, олон нийтийн санаа бодол, нэг иргэний ч гэсэн санаа бодол энэ танхим руу орж ирэх замыг хааж байна гэдэг чинь иргэд олон нийт Сүхбаатарын талбай дээр төрийн эрхээ эргүүлэх тухай тэр зам руугаа очно гэж ойлгож байгаа. Парламент дотор байгаа 5 нам, 1эвсэл, 4 намын төлөөллийг энэ хуульд саналаа өгөхдөө оролцуулах тэр оролцоо, хандлагыг хангахдаа Их Хурлын дарга учир дутагдалтай ажилласан. Тэгэхээр парламент бол иргэдийн төлөөлөл, иргэдийн толь байх ёстой. Энэ үндсэн зарчим руу халдаж байна гэж. Иргэний зориг ногоон нам бол энэ зарчмыг хамгаална гэж байгаа. Та бүхэнд би бас нэг зүйлийг товчхон сонсоод дахиж асуултаа,

**Б.Пүрэвдорж:** 1 минутаа нэмж аваад дуугаа явуулах уу? Хэн хариулах юм? Хэн хариулах вэ? Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Эрхээ эдлэх асуудлаа ярьдаг, үүргээ биелэх асуудлаа ярьдаггүй бай байж болохгүй л дээ. Тэгээд би л эрхтэй байх ёстой, миний эрх л хангагдах ёстой. ингэхгүй бол ард түмний дуу хоолойг боомилж байна гэж бас ярих хэрэггүй л дээ. Яг хуулийн төслөө аваад үзээд унших юм бол илүү иргэдэд нээлттэй, иргэдийн оролцоотой ийм илүү ил тод болох энэ зарчим руу энэ хуулийн төслийн үзэл баримтлал бичигдсэн. Энэ агуулгаар заалтууд орсон ийм байгаа.

Улсын Их Хурлын гишүүдийг илүү тийм үү эрхээ эдлэх боломжийг нь нээж өгсөн. Илүү нөгөө талдаа бас тийм үүрэг, хариуцлагаа ухамсарлаж парламент дахь үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжийг нь бий болгож өгсөн. Илүү санаачилгатай, илүү хариуцлагатай, илүү ажил хэрэгч гишүүдэд нь улам урагшаагаа тодрох ийм боломж олгосон ийм л зохицуулалтууд орж ирж байгаа. Энийг та энэ өнцгөөс нь харах юм бол ард түмэнд таалагдах байх. Ард түмэн бол энэ парламентыг хариуцлагатай байгаасай, нээлттэй байгаасай, ил тод байгаасай, гишүүдийг ёс зүйтэй байгаасай, энэ парламентын үйл ажиллагаа улам илүү сайжраасай, парламент тэр засаглалаа улам л бэхжээсэй, парламентын нэр хүнд нэмэгдээсэй л гэж хүсэж байгаа. Энэ рүү л чиглэсэн, энэ рүү л зорьсон ийм заалтуудыг оруулж ирсэн. Энэ ч үүднээсээ та хэллээ сая Гончигдоржийн үед бүлэггүй болж байсан, зөвлөл байгуулагдаж байсан, ардын нам өөрсдөө буйдантай суулт хийгээд 25 гишүүнтэй мөртөө бүлэггүй байж байсан гэж ингэж хязгаарласан зүйлүүд ерөөсөө байхгүй.

76 гишүүнтэй байх үед 8-аас дээш гишүүнтэй нам, эвсэл бүлэг байгуулж болно гэсэн заалт байсан. 126 онтой гишүүнтэй болсон үед 10-аас дээш гишүүнтэй бол бүлэг байгуулна гэж заалттайдаа болсон. Уул нь бол юу гэдэг юм 15-аас дээшээ, бараг 12-оос дээшээ болох ёстой. байх илүү уян хатан болсон. Энэний дагуу л үндсэндээ бол та бүлэг байгуулах гэж хүсэж байгаа бол Иргэний Зориг Ногоон Нам энэ бүлэг байгуулах хэмжээний суудал аваад ороод ирээсэй. Бүлэг чинь тодорхой эрхтэй, үүрэгтэй, парламентын үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлэх ёстой, харилцан зөвшилцөх ёстой.

Миний хувьд юу гэдэг юм парламентын дарга болчихоод бас ярьсан зүйл бол улс Улсын Их Хуралд суудалтай энэ 5 намын улс төртэйгөө 5 намтайгаа парламент суудалтай 5 намтайгаа зөвшилцсөнөө, ярилцсанаа асуудлаа нээлттэй зөвшилцдөг байна гэсэн энэ зарчмаар орж ажиллахыг хичээж байгаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу л энэ бүлэгтэй намууд бүлгийнхээ эрхийг эдэлнэ. Бүлэгтэй болох хэмжээнд суудал аваагүй намууд бол энэ зохицуулалтаараа л явуулна. Та бол үндсэндээ би 4 гишүүнтэй. Би гэхдээ бүлэгтэй болмоор байна, бүлгийн эд эрх эдэлмээр байна гэсэн. Одоогийн хуулиар энэ боломжгүй учраас энэ о ороогүй энийг та харин би эрх хязгаарлалаа, боомиллоо гэж.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Зочин танилцуулъя. Монгол Улсын Хөгжлийн банкны ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Батын Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

**Б.Батбаатар:** Одоо байгаа Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар бид нар үйл ажиллагаа явуулж байгаа. Өнөөдөр энэ хуулийн төсөл өргөн мэдүүлж байна, Их Хурлын чуулган дээр орж ирж байна гэдэг чинь өмнөх хууль болохгүй байна, учир дутагдалтай байна л гэсэн санаа шүү дээ.

Тэгэхээр бид нар төслийн тухай ярьж байгаа. Тийм болохоор өмнөх хуулиа хэлээд баймааргүй байгаа юм. Өмнөх хуулиар ийм байгаа учраас энэ хуульд тэр нь ороогүй ээ гэж. Өөрчлөлт оруулж байна, шинэчилж байна, сайжруулж байна гэдэг чинь энэ зүйл дээр дутагдлуудыг нь нөхөж өөрчилье л гэдэг санаа. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн тухай яриагүй, өргөн баригдсан төслийн тухай яригдаж байна гэдэг энэ зааг ялгаагаа хууль санаачлагч бас анхаарч хариултаа өгмөөр байгаа юм. Тэгээд энэ өргөн баригдаж байгаа төсөл дээрээ бид нар 10 мянган иргэний асуудлыг оруулж ирээд ярих боломжийг нээж өгөхгүй юм уу? 50 мянган иргэн ярих тэр боломжийг нээж өгөхгүй юм уу?

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Тийм Батбаатар гишүүн бас нэг гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд бүлэг байгуулах асуудлыг хөндөж хууль санаачилж болно. Энэ нээлттэй байгаа танд. Энэ бүлэг байгуулна гэдэг маань үндсэндээ энэ парламентын зохион байгуулалт, дэг журам, хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал байж байгаа. Энэ дээр үндсэндээ бол бас бүлэггүй байлаа гээд эрх нь хязгаарлагдаж байгаа зүйл ерөөсөө байхгүй. Одоо энэ Дэгийн хууль дээр сайжирсан заалтууд

байгаа. Урьд нь бол бүлгээр дамжуулж Улсын Их Хурлын гишүүдийн асуулт асуух, үг хэлэх энэ зөвшөөрөл нь өгөгддөг байсан бол чуулганы хуралдаанд нээлттэй асуултаа асуух, үгээ хэлэх боломжууд нь нээгдэж байгаа.

Мөн бас мэтгэлцээн явуулах боломжтой болж байгаа юм. Тэр мэтгэлцээн явуулах үед та бүхэн чөлөөтэй асуултаа асуугаад, байр сууриа илэрхийлээд, үгээ хэлээд мэтгэлцэх боломжууд нээлттэй болж эхэлж байгаа юм. Тийм болохоор ганцхан бүлэгтэй л болох юм бол их мундаг болчих гээд байна. Бүлэггүй болоод байгаагаас болоод бид эрхээ эдэлж чадахгүй байна гэж ярих нь бол жоохон зохимжгүй байгаа. Та тэгэхээр бүлгийн байгуулах боломжийг нээх үйлийг бол та санаачил.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Батын Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

**Б.Батбаатар:** Миний хэлж байгаа зүйлийг Их Хурлын дарга бүлэг рүү аваачиж нөгөө бөөсний онигоо гэдэг шиг нэг зүйл дээр аваачиж орхиод байна. Тийм биш ээ ерөөсөө ч тийм биш. Юу вэ гэхлээр Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн бүлэгт олгогдож байгаа эрх мэдэл бол тодорхой хуулийн асуудлаар санал бодлоо нэгтгэх, илэрхийлэх, Ерөнхий сайдтай мэтгэлцэх энэ боломжийг хангаж байх энэ тухай яригдаж байгаа юм. Агуулга талаас нь харах хэрэгтэй. Түүнээс бүлгийн эрх мэдэл гэдэг юм уу, зохион байгуулалт гэдэг утгаар бол яригдаагүй. Түүрүүн миний сонгосон дуу бол иргэний зориг ногоон номын сүлд дууны тахилтад байдаг. Иргэнийхээ нүдэнд итгэл харахыг хүсвэл эрх мэдэлтний тархинд сэтгэл байхыг хүсвэл гэж зоригтой бай гэж. Энэ парламент дотор Монгол Улсын 3 сая 600 мянган иргэний асуудал яригддаг байх ёстой. Монгол Улс 1 ч иргэнээ гэж хаяж болохгүй. Үндсэн хуулиараа ч тийм зохицуулалттай иргэнийхээ араас явах тийм зарчимтай. Тийм болохоор.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Одоо Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууна.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Энэ хууль их л жоохон уг нь бол бүлгүүдэд энийгээ танилцуулж байгаад хэлэлцэх байсан шиг санагдаад байгаа юм. Тэгээд нэгэнт ороод ирчихсэн учраас. Тооноос чанарт гээд уг нь манай социализмын бараг үеийн ийм сайхан уриа байдаг тээ? Гэтэл энэ чинь эсрэгээрээ чанараас тоо руу юм уу эсвэл ямар зорилгоор ийм шалгууруудыг тавиад байгааг ерөөсөө ойлгохоо больж байна л даа. Яагаад гэвэл хэдэн удаа үг хэлснээр хэмжих юм байна. Хэдэн удаа асуулт асууж, хэдэн удаа хууль санаачилсан, тогтоолын төсөл санаачилсан, тэгээд зогсохгүй гадаад, дотоод томилолт гээд үг байж байгаа юм. Тэгэхээр эд нарыг нь шалгуур болгож байгаад Байнгын хорооны дарга энэ тэр болгоход ашиглана гэж байгаа юм. Гэтэл дэлхийн парламентын нэг гол зарчим чинь сениорити гээд зарчим байгаа тээ? Тэгэхээр энэ зарчим хаанаа үйлчлэх юм бэ? 1 дүгээрт.

2 дугаарт, ер нь аливаа зүйлийг ингээд хэмжиж байна. Тэр хэмжиж байгаа зүйлийг л хүн аль болох их хийхийг хүсдэг, өсгөдөг. Тэгэхээр үг хэлээд л байвал сайн, эсвэл асуулт асуугаад л байвал сайн. Би Байнгын хорооны дарга болох юм байна гэдэг юм руу орох юм биш үү. Парламент бол мэтгэлцээний талбар гэж ярьж байгаа бид нар. Гэтэл энэ чинь шоуны индэр болчих юм биш биз дээ.

Нөгөө талдаа бол популизм руу түлхэх юм биш үү. Камерын улс төр нэмэгдэх юм биш үү? Ямар ч байсан л маш олон асуулт асуугаад л үг хэлээд л байвал ингэх юм байгаа юм гэдэг нэг ийм уралдаан руу оруулчих юм биш үү? Дээрээс нь энэ асуулт, үгийн чанарыг яаж хэмжих вэ? Хууль санаачилсан тоо гэж байна. Тэгэхээр энэ хуулийнх нь чанарыг бас яаж хэмжих вэ? Тэгээд гадаад, дотоод явбал сайн юм уу, байвал сайн юм уу гээд ингээд ийм маш олон асуулт дагуулж байна л даа. Тэгээд энийг нь нөгөө албан тушаалтай холбочихдог. Тэгэхээр энэ чинь концепцын хувьд буруу болж байгаа.

Одоо биеэрээ санал өгнө гэдэг нь бол бас зөв. Яагаад гэвэл ийм асуудал үүссэн байхгүй юу. Нөгөө башир арга хэрэглээд дэмжээгүйг дэмжээгүй болгож ирж босгох гэдэг ийм аюул тулгараад байгаа. Тэрэнтэй холбож байх шиг байна. Уг нь бол хүн энд байхгүй байгаагаараа татгалзаж байна, тэрийг эсэргүүцэж байна гэсэн агуулга уг нь мөн. Заавал ч үгүй тэрийг биеэрээ гэх албагүй. Даанч харамсалтай нь манай гашуун туршлага болсон л доо. Тэгээд нөгөө огцруулах гээд байгаа хүнээ огцруулахгүй ээ гэж кноп дарж байгаад тэгээд огцруулахыг нь дэмжээгүй болгож оруулж ирж, дэмжээгүйг дэмжээгүй болгож ирж босгодог ийм башир аргатай байсан учраас энийг засаж байна тийм үү гэж ойлгож байна. Тэгэхээр энийг уг нь бол байхгүй байна гэдэг чинь татгалзаж байгааг илэрхийлж байгаа боловч энэ башир аргад ашиглаад байгаа учраас ингэхээс өөр замгүй болж байгаа нь харамсалтай юм.

2 дугаарт, энэ Ёс зүйн дэд хороонд маш их эрх мэдлийг өгчээ. Үг хэлэх эрх хасах юм байна, асуулт асуух эрхийг хязгаарлах юм байна, цалин бууруулах юм байна. Яах вэ мэдээж зөв. Нөгөө эрхээ эдэлж байгаа юм чинь үүргээ хэрэгжүүлэх ёстой. гэдэг агуулга явж байгаа. Гэтэл нөгөө Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн энэ хуулийн төсөлтэй бас яаж уялдах юм бол оо? Тэнд чинь маш том асуудал явж байгаа тээ? Ёс зүйн асуудлыг хөндсөн тэгээд ёс зүйн зөрчил гаргавал эгүүлэн татна гээд. Тэгэхээр энэнтэй яаж холбогдох юм бэ? Тэр дээр бол гишүүд маш их эргэлзсэн. Хэдийгээр бүгд агуулгаар нь дэмжсэн боловчиг энэ ёс зүйн асуудлыг хөндөж байгаа нь өөрөө сөрөг хүчнээ, эсвэл шүүмжлэлтэй ханддаг гишүүдийг ингэж шийтгэх хэрэгсэл болчих юм биш байгаа гэдэг ийм асуудлыг бол ярьж байсан. Тэгэхээр энэ дээр бол ямар уялдаа холбоо байгаа юм бэ? Энийг яаж зохицуулж байгаа юм бэ гээд .

Ер нь бол Улсын Их Хурлын чиг үүрэг чинь 2 үндсэн чиг үүрэг байгаа шүү дээ тээ? Нэг нь хууль санаачлах, нөгөөдөх нь санаачилсан тэр хуулиудын зөрчил, дутагдал юу болж байна гэдэг дээр хяналт, шалгалт хийх. Тэгэхээр энэ хяналт шалгалт хийхтэй холбоотой энэ хэдэн удаа үг хэлсэн, хэдэн удаа.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя. Шууд асуултаа дуусгачихъя гэж байна. Жудгийн Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Баярмаа:** Тэгэхээр энэ бол хэдэн удаа хууль санаачилсан буюу хууль тогтоох тэр эрх мэдлийг нь хянах гэж байна, хэмжих гэж байна тийм үү? Хэмжих гэж байна. Гэтэл нөгөө хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх энэ үүргийг нь гэх юм уу юугаар хэмжих гэж байгаа юм бол оо? Нөгөө түр хороо байгуулж байж сая энэ эрхээ эдэлнэ атал энэ чинь нь маш зөрчилтэй буюу 1 чуулганы үед 2-хон дэд хороо нь түр хороо байгуулах ийм боломжтой байгаад байдаг. Тэгэнгүүт энэ

үүргээ яаж хэрэгжүүлж байгааг нь яаж хянах гэж байгаа юм бол оо? Энэ дээр тусгасан зүйл байгаа юу?

Дараагийн асуулт энэ Байнгын хороо. Засгийн газар бол ингээд халагдаж солигдоод байж болдог юм байлгүй дээ. Гэтэл энэ Улсын Их Хурал чинь 1 жилийн дотор энэ Байнгын хорооныхоо тоо энэ агуулгыг ямар их өөрчилдөг юм бэ? Одоо яг хууль тогтоох байгууллага нь өөрөө ингэж Байнгын хороогоо ерөөсөө байнгын 3 дахиа өөрчлөх гэж байна миний санаж байгаагаар. Ингээд байх юм бол энэ Улсын Их Хурлын чинь нөгөө залгамж чанар, quantity гэж ярьдаг тээ энэ.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга тодруулъя, хариулъя.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүд 2 үндсэн чиг үүрэгтэй биш 3 үндсэн чиг үүрэгтэй. Ард түмнийг төлөөлөх, хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих. Энэ дээр үндсэндээ бол бид нар ингээд хууль тогтоох чиг үүргээ илүү анхаараад байдаг. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ орхичоод байдаг байсан. Тийм учраас бид нар 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хянан шалгах чиг үүргийн Их Хурлын бүрэн эрхийг нэмэгдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор 20 онд Хяналт шалгалтын тухай хуулийг баталсан. Ингээд энэ хяналт шалгалтын тухай хууль ингээд хэрэгжүүлэх явцад бас энэ хяналт шалгалт гэдэг тэр түр хороо байгуулах л тэр хяналт шалгалтын дээд хэлбэр нь мөн. Мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах.

Гэтэл наад талд нь асуулт тавих, асуулга тавих, нийтийн хяналтын сонголт хийх, ажлын хэсэг байгуулж хуулийн хэрэгжилтэд хяналт тавих гээд олон чиг үүргүүдээ бид нар ашиглахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр та энэ Дэгийн тухай хууль үзэх юм бол энэ дээр Улсын Их Хурлын тухай хууль дээр энэ хяналт тавих чиг үүргүүдийг нэлээн нэмэгдүүлж өгч байгаа. Одоо энэ парламент 2 жил орчим хугацаа болох гэж байна. Ер нь 1 удаа асуулга хэлэлцсэн билүү Их Хурлын гишүүний асуулгаар хэлэлцээгүй байх. Тэгвэл энэ хуулиар сар бүрийн 1 дэх, 3 дахь 7 хоногт Улсын Их Хурлын гишүүдийн тавьсан асуулгыг хэлэлцдэг байх дэг орж байгаа. Асуултуудыг Байнгын хороон дээр хэлэлцдэг байна. Үүгээр үндсэндээ бол хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг нээж өгч байгаа юм.

Дээрээс нь амлалтын бүртгэл хөтөлдөг байна. Чуулганы хуралдаан сайд нар орж ирчхээд л таны асуултад ойлголоо, таны гишүүний таны юманд анхаарна гэдэг. Тэрийг бүгдийг нь нэг бүрчлэн бүртгэж аваад чуулганы хуралдаанд худлаа хэлж болохгүй, худлаа хэлэх юм бол хариуцлага хүлээнэ, тэгнэ ээ шийднэ ээ гэсэн бол шийддэг байх ёстой. Энийг бүртгэж аваад гүйцэтгэл биелэлтийг нь шахдаг байх иймэрхүү байдлаар тодорхой зохицуулалтууд орж ирж байгаа.

Яагаад энэ асуулт, асуулга ингээд гадаад, дотоод томилолт бүртгэж бүртгээд байгаа юм бэ гэж. Угаасаа урьд нь бүртгэдэг байсан. Энийг мэдээлдэг байсан. Энийгээ илүү боловсронгуй болъё, энийгээ сайжруулъя гэж байгаа юм. Тасалсан, гадаад томилолт, дотоод томилолт, чөлөөтэй байсан, өвчтэй байсан, хуралдаандаа суусан, хоцорсон бүх мэдээллүүд одоо ч хүртэл ингээд явж байгаа. Энийг илүү боловсронгуй болъё, энийг илүү нээлттэй рийл тайм, илүү 7 хоног болгон давтамжтай мэдээлдэг байя. Ингэснээрээ гишүүдийн иргэдээс сонгох сонгогчдоо төлөөлөх эрхээ хэрэгжүүлж чадаж байна уу, иргэдийн өмнө хүлээсэн үүргээ Их Хурлын гишүүд биелүүлж чадаж байна уу чадахгүй байна уу гэдэг

мэдээлэл нь иргэдэд нээлттэй ойртуулж өгч байгаа юм. Ингэж ойртуулж өгч байж илүү гишүүд маань хариуцлагатай болох болов уу, болох болов уу.

Дээрээс нь зөвхөн олон сонгогдсон гэдэг туршлагаар нь бус чуулганы үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, оролцоогоор нь гишүүдийн ажлыг дүгнэдэг байя. Энийг Байнгын хорооны дарга болохдоо бас нэг харгалзаж үздэг байя гэж, харгалзаж үздэг. Иймэрхүү бас зүйлүүд орох ёстой. хуулиуд, гүйцээгээд хариулчихъя.

**Б.Пүрэвдорж:** Нэмж хариулъя.

**С.Бямбацогт:** Хууль санаачлахад нь тийм үү оролцоод бичихдэг. Тэгчхээд хууль санаачилсан хуулийнхаа эсрэг зүйл ярьдаг. Ажлын хэсэгт орно орно гээд бусдын боломжийг хаагаад ажлын хэсэгт ордог. Тэгсэн мөртөө ажлын хэсгийн хуралдаа ирдэггүй. Дараад нь тайлагнахдаа би ийм олон хууль санаачилсан гэж тайлагнадаг, би ийм олон ажлын хэсэгт орж ажилласан гээд ийм олон хууль батлуулсан гэж худлаа ярьдаг. Энэ юмнуудыг жоохон бодитой болгоё. Санаачилж байгаа бол санаачилж хуулийнхаа төлөө явдаг бай, ажлын хэсэг орсон бол ажлын хэсгийн хуралдаа идэвхтэй оролцсон юм, бодитой үнэлэмж өгдөг хэлбэр биш агуулга руу нь илүү анхаарсан чанарын өөрчлөлт хийе ээ гэж байгаа юм.

Тэгэхгүй ингээд хэтэрхий хэлбэрддэг, хэтэрхий попордог, хэтэрхий шоуддаг болчихоод болчихоод байна. Нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэлээ гэж Үндсэн хуульд тангараг өргөдөг мөртөө нийт иргэн улсын эрх ашгийнхаа эсрэг хууль санаачилдаг, попордог ийм асуудлууд бас газар авч байна. Тийм болохоор энэ рүү нь илүү бас нийт иргэн, улсын эрх ашиг, эрхийг эрхэмлэлээ гэдгээ илүү бас боддог байгаасай гэдэг рүү нь бас чиглүүлсэн агуулгын.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Жудгийн Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Баярмаа:** Яг энэ асуултыг л асуугаад байгаа юм л даа. Асуултын чанарыг яаж хэмжих вэ, хэлсэн үгний чанарыг яаж хэмжих вэ гэдэг асуулт. Хуулийн чанарыг яаж хэмжих вэ? Дээрээс нь яг энэнтэй холбоотой нөгөө камерын улс төр бий болгох эрсдэлийг үнэлсэн үү? Энэ чинь одоо хуулийн төсөл оруулж ирээд байна шүү дээ гэдэг. Тэр түрүүний нөгөө Байнгын хороотой холбоотой энэ Байнгын хороог ингээд нэг бол томруулаад л нэг бол жижгэрүүлээд л дагаагийн зорилго юу вэ? Энэ яг бодлогын хүрээнд хийгдээд байна уу, эсвэл улс төрийн шалтгаанаар хийгдээд байдаг юм уу? Нөгөө бялуугаа хуваах зорилгоор энийг томруулахгүй бол болохоо байчихлаа, одоо дахиад нэг хэдэн Байнгын хороо нэмж байж хэдэн гишүүдийнхээ амыг таглая гэдэг энэ зарчмаар хийгдээд байна уу? Энэ бол их тийм сонин болж байна шүү. 2-хон жилийн дотор 3 дахиа өөрчлөлт оруулна гэдэг бол бүхэл бүтэн хууль тогтоох байгууллагын хувьд бол боломжгүй зүйл. Энэ бол залгамж чанарыг алдагдуулж байгаа зүйл. Дээрээс нь энэ улсын Ерөнхийлөгчийн .../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Ерөнхийлөгчийн хуультай яаж уялдаж байгаа юм бэ гэж байна. Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Ерөнхийлөгчийн хуультай энэ Нарантуяа-Нара гишүүн, Батбаатар гишүүдийн хуулиуд өргөн барина. Тэгээд тэр үед нь ингээд тусгайлан

ажлын хэсэг байгуулаад энэ асуудал явна. Ерөнхийлөгчийн хуульд жишээ нь ёс зүйн зөрчил гаргавал хуралдааны 30-аас доош хувьд нь чуулган болон Байнгын хорооны хуралдааны хуралдааны 30-аас дээш хувьд нь суухгүй бол эгүүлэн татна гэсэн заалт орж ирж байгаа. Тэгвэл энэ дээр бол эгүүлэн татах биш бусад хариуцлага хүлээлгэх ийм зохицуулалтууд орж байгаа. Үнэхээр гэмт хэрэг үйлдсэн, энэ шүүхийн байгууллага тогтоогдсон бол гишүүдийг эргүүлэн татах асуудал яригдах ёстой. болохоос ёс зүйгээсээ болж тийм үү эгүүлэн татах нь зөв үү буруу юу гэдэг дээр бол энд ёс зүй дээр бол өөр наад талын шатын хариуцлага тэрийг хүлээлгэхээр ийм уян хатан зохицуулалт орж ирж байгаа.

Байнгын хороодыг яагаад нэмээд байгаа юм бэ гэж. Яах аргагүй Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо бол үнэхээр олон асуудалтай том байгаад байна. Эдийн засгийн байнгын хороо том байгаад байна. Хуралдаж дуусдаггүй, асуудлаа хэлэлцэж бардаггүй. Тийм учраас илүү хурдан хугацаанд ажил хэрэгч асуудлаа шийддэг байхын тулд эдгээр асуудлыг бас зохицуулахаар оруу.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Тэр Баярмаа гишүүний асуугаад байгаа тэр үг хэлэх эрхийг хасах тухай асуудал яригдаад байна шүү дээ. Яг энэ заалтын дагуу 7 хоногоор би энэ парламентын түүхэнд ганцаараа би л хасуулж байсан юм л даа. Аюурсайхан дэд дарга энэ хурал удирдаж байгаад миний үг хэлэх эрхийг 7 хоногоор хасаж байсан юм. Урт хугацаа юм байна лээ. Үг хэлж болохгүй суугаад байдаг. Тэгээд сүүлдээ ер нь бол Үндсэн хууль зөрчсөн гэдгээ мэдчихэнгүүтээ намайг үг хэлээч ээ гэж зөндөө гуйсан л даа. Тэгээд би 7 хоногийн гүйцээсэн юм. 30 хоног үг хэлэх эрхийг хасна гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Энэ чинь ер нь байж болшгүй зүйл. Тэгээд энэ иргэнийхээ үгийг яаж хэзээ тэр чухал хуулиуд дээр яаж илэрхийлэх ёстой. юм? Тэгэхээр энэ дээр энийг бас Баярмаа гишүүний асуугаад байдаг зөв шүү гэдгийг хэлье.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 60 дугаар сургуулийн Булганаа багштай 12<sup>а</sup> ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлага хөдөлмөрийн, сурган хүмүүжүүлэх ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

**О.Номинчимэг:** Парламентын нэр хүнд, сахилга батын асуудал ойрын хугацаанд маш их яригдаж байгаа. Тэгээд энэтэй ч холбоотой Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт бас орж ирж байна гэж харж байгаа. Ер нь парламентын нэр хүнд хэзээ өсдөг вэ гэхээр иргэд, олон нийт энэ парламент биднийг төлөөлж чадаж байна, биднийг илэрхийлж чадаж байна гэдэг мэдрэмж авах үед л нэр хүнд нь өсдөг. Тэгээд энийг юугаар бид нар хийх юм бэ гэхээр Үндсэн хуулиар олгосон энэ чиг үүргээ парламент нь хэрэгжүүлж чадаж байна уу л гэдэг асуудал. Гүйцэтгэх засаглалаа бид нар хянаж чадаж байгаа юм уу, төсвөө бодитойгоор бид нар хянаж чадаж байгаа юм уу, хянан шалгах чиг үүрэг чинь зөв ажиллаж чадаж байгаа юм уу Хамгийн гол нь иргэд олон нийтэд тулгамдаж байгаа нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар нээлттэй бид нар сонсоод энийг нь шийдвэрлэж чадаж байна уу гэдгээр л энэ парламентын нэр хүнд хэмжигдэж байгаа.

Яах вэ энэ удаагийн хууль дээр сахилга батын асуудал нэлээн яригдаад, ирцийн асуудал нэлээн орж ирж байгаа. Одоо тэр яригдахаас өөр аргагүй. Ирцээ механикаар ингэж түлхэх хүртэл манай парламентын сахилга бат угаасаа муудсан байна гэдэг нь бодит асуудал. Гэхдээ парламентын нэр хүндэд хамгийн их нөлөөлдөг зүйл бол ерөөсөө л ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гардаг. Олон нийтийнхээ төлөө шийдвэр гаргадаггүй. Авлига, хээл хахуулийн асуудлаар дамжиж энэ төрийн бодлого чинь буруу яваад байна л гэдэг асуудлыг иргэд угаасаа ойлгодог. Тэгээд энэ чиглэл рүү харсан асуудлыг бид бас цаашид маш гүнзгий сайн харж ажиллах ёстой. Тэгээд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж санал хураалтдаа ордог асуудлыг бол бид цаашид үнэхээр нухацтай харах ёстой.

Тэгээд энэ хуулийг бас даргын зөвлөл дээр хэлж байх үед би ч гэсэн саналаа хэлсэн. Ёс зүйн дүрэм гээд байна. Энэ ёс зүйн дүрмээ бид нар өөрчлөх ёстой. Парламентын гишүүний хувьд ёс зүйн асуудал гэдэг бол яг энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэх буюу хууль тогтоох, хянах, олон нийтдээ төлөөлөх ажлыг чин шударгаар хийж чадаж байна уу, эсвэл авлига албан тушаалын асуудалтай байгаад энэ иргэдээ төлөөлөхгүй өөр нэг хэсэг бүлэг хүмүүсийг төлөөлөөд байна уу, төрийн мөнгийг өөр хууль бусаар ашиглаад байна уу, бүүр явах юм бол бэлгийн дарамтад эргэн тойрныхоо ажилтан, албан тушаалтнууддаа бэлгийн дарамт үзүүлээд байна уу гэдэг л асуудлаар байдаг. Тэрнээс хэн нэгнийгээ хэлж мэтгэлцээний үед хэлсэн хэлэх үг юу гэдэг юм энэ асуудал дээр нь цензур тавих бол парламентын гишүүний ёс зүйн асуудал биш ээ. Тэгэхээр одоо байгаа энэ ёс зүйн дүрмээ яаралтай энэ чиглэл рүү нь бид нар өөрчлөх ёстой.

Тэгэхгүй бол яг үнэнийг хэлэхэд сүүлийн үед парламент чи намайг тэгж хэлсэн, хэлээгүй, айлгасан, айлгаагүй гэдэг жижиг сажиг ийм хэрүүлийн дунд явсаар байгаад үнэхээр жижгэрч байна. Манай парламент үнэхээр жижгэрч байна аа. Хэн хамгийн эхэнд ирцэд орсон бэ гэдгээрээ уралдаж сайрхдаг боллоо. Хэн хамгийн их удаан үг хэлсэн бэ гэдгээрээ хэмждэг боллоо. Хэн хоцролгүй чуулгандаа ирсэн гэдгээрээ парламентын гишүүдийг хэмждэг болох гээд байна. Ийм байж болохгүй. Ийм чиглэл рүү бид нар явж болохгүй. Мэдээж бид нар одоо байгаа нөхцөл байдлаа шийдэхийн тулд механик энэ зохицуулалтуудыг оруулж өгч байгаа. Гэхдээ баланстай байх юм бол ийм жижиг юм руу явж эндээ анхаардаг жижигхэн парламент болоод хамгийн чухал бидний яг энэ ард нийт, олон нийтийнхээ эрх ашгийг хамгаалсан энэ чиглэлийн бодлого, хэрэгжилтийнхээ асуудалд анхаардаггүй л гэсэн юм явна. Ийм бол бүүр ч бүүр нэр хүнд нь унана гэдгийг би бас хэлмээр байна.

Парламент өөрөө мэдээж нэр хүндтэй байхын тулд гүйцэтгэх засаглалдаа хяналт тавьдаг байх ёстой. Орж ирсэн хуулийг нь юу гэдэг юм кнопдох байдлаар ямар нэгэн мэтгэлцээнгүйгээр баталдаг байх ёсгүй ээ. Ингээд л байвал бид нарын угаасаа нэр хүнд унана. Энэ байдал дээр бид нар энэ дэгийн хууль эд нар дээр бас өөрчлөлт орж байгаа байх гэж найдаж байгаа.

Би Өргөдлийн байнгын хороог ахлаад жил арай хүрээгүй байна. Тэгээд энэтэй холбоотой бас нэг саналыг хэлэх гэж байгаа юм. Миний 1 минутыг нэмээд өгчхөөрэй хуралдаан даргалагчаас. Өргөдлийн байнгын хороо байгуулагдаад жил хүрээгүй хугацаа болж байна.

**Б.Пүрэвдорж:** Нэмж 1 минут тодруулъя.

**О.Номинчимэг:** Өргөдлийн байнгын хороодод иргэд үнэхээр тулгамдаж байгаа асуудал ирдэг ээ. Ялангуяа юу гэдэг юм гүйцэтгэх засаглал дээр хууль хэрэгжихгүй байгаа, анхаарал тавихгүй байгаа асуудал ирдэг. Тэгээд энэ Байнгын хороог өмнөх жил энэ Байнгын хороог батлахдаа хуулиар нь бол нэг тийм бүх юмыг хариуцах ч юм шиг, тэгсэн мөртөө бүх юмыг хариуцах чадахааргүй ч юм шиг юм бяргүй ийм байдлаар бол хийчихсэн юм. Одоо бүх Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороон дээр хүртэл хүний эрхийн зөрчил гарсан байна. Өргөдөл, гомдол ирэхээр манайх руу шилжүүлдэг байхгүй юу. Тэгээд бид нар эднийх нь мөрөөр арга хэмжээ авах гэж оролддог юм. Тэгээд ингээд Засгийн газарт бид нар одоохондоо ингээд хуралдаад үүрэг чиглэл өгдөг боловч түй ч гэж тоож байгаа юм алга байна. Би 3 сар, 4 сард энэ орон сууц захиалгын асуудал дээр ийм асуудал байна хамтарсан ажлын хэсэг цагдаа эд нараа оруулаад байгуулаадхаач гээд Хэрэг эрхлэхэд хандсан. Түй ч тоохгүй байна. Хэрвээ өргөдөл үнэхээр олон нийтийнхээ асуудлыг сонсоод шийдвэр гаргадаг Байнгын хороо байлгаж байх юм бол шүдтэй болгох ёстой. байгаа юм. Тэгэхдээ энэ шүдийг нь өгөхгүй бол дахиад л нөгөө.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Өнөөдөр үнэхээр парламентын нэр хүнд сул байгаа. Энэ юутай холбоотойгоор парламентын үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой. 2020-24 оны парламентыг харьцуулахад өнгөрсөн 2 жил 24-өөс 26 хүртэл бидний баталсан хууль 20-оос 24 онд баталсан парламентын хуулиудын 10 хувьд нь хүрэхгүй байна. Байнгын хороодын хуралдаан 58 удаа хуралдаагүй байна. Үүнээс 40 орчим хуралдаан ирц хүрэхгүй хуралдаагүй. Үлдсэн 20-иод хуралдаан нь ирц хүрчхээд асуудлаа шийдэж чадахгүй, ирцдээ орчхоод саналаа өгдөггүй гараад явчихдаг. Байнгын хороодын хуралдаан дээр Их Хурлын 5 гишүүн сууж байдаг. Засгийн газраас 50 албан хаагч ирээд хүлээгээд өдөржин хүлээгээд ингээд явж байдаг. Иймэрхүү үйл явдлууд чинь үндсэндээ парламентын нэр хүндийг унагаагаад байна шүү дээ. Энийгээ тэгээд хэрхэн яаж шийдэх юм? Бид өөрсдөө эхлээд нөгөө дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй гэж. Өөрсдөө бусдад үлгэр дуурайлтай, манлайлалтай хүлээн зөвшөөрөгдөхүйц байдалтай ажилладаг болчихоод Засгийн газартаа, ард иргэддээ, бусад байгууллагууддаа шаардлага тавьдаг бидэн шиг ажиллаач ээ гэдэг болмоор байгаа юм. Тийм болохоор эхлээд өөрсдөө дотоод асуудлаа зохицуулъя гэдэг юмнууд орж ирж байгаа юм.

Дээрээс нь Хяналт шалгалтын тухай хууль, Дэгийн хуулиудаа та бүхэн үзээрэй. Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд буруу зөрүү мэдээлэл өгөхгүй байх, хяналт шалгалттай холбоотой зохицуулалтыг Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлж, Засгийн газарт хяналт тавих эрхүүд нэлээд нэмэгдэж байгаа. Энэ асуудлуудаа бас бид нар олж хараад бас ийм заалтууд орж ярихгүй болохоор зөвхөн гишүүд дээрээ их хариуцлагатай болох гээд байгаа юм гэж яригдаад биднийг чангалах хууль юм биш үү, биднийг л боомилох гээд байгаа юм биш үү гэж зөвхөн би эрхээ эдэлмээр байна, дураараа дургиж баймаар байна гэдэг хандлагаар хараад байдаг. Нэг талдаа бид хариуцлагатай байя. Нөгөө талдаа өөрсдөө хариуцлагатай байж байж Засгийн газартаа хяналтаа тавьж хариуцлага тооцох заалтаа илүү бас

зохицуулсан заалтууд байгаа. Энэ рүүгээ хараач ээ. Ингэхгүй л болохоор таны яриад байгаа энэ асуудлууд яригдаад байгаа юм л даа.

Тийм учраас өнөөдөр бүх зүйлүүдийг хэмждэг, хянадаг, ил тод мэдээлдэг, нийтэлдэг байя. Ингэж байж үйл ажиллагаа маань дотоод зохион байгуулалт нь сайжрах байх гэдэг агуулгаар орж ирж байгаа юм.

Өшөө чинь юу ярилаа. Өргөдлийн байнгын хороо бол зайлшгүй байх ёстой. Байнгын хороо юм байна лээ. Гэхдээ илүү би хэлсэн шүү дээ иргэдийн ил тод байдал, иргэдийн оролцоог хангахад тэр d.parliament,d.petition энэ зүйлүүдтэй харилцахад илүү хэрэгтэй байгаад байна. Илүү. Иргэдтэй илүү оролцоотой, харилцаатай болоход. Байнгын хороодын тэр шийдвэр гаргах тогтоол батлах гэдэг бол манай Тэмүүжин нарын гишүүд, Сайнзориг нарын гишүүд шаардлагагүй ээ энэ бол Үндсэн хууль зөрчиж байгаа гэсэн учраас.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Номинчимэг гишүүн нэмж тодруулъя.

**О.Номинчимэг:** Тийм юм байхгүй л дээ. Бид нар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг гаргах гээгүй. Бид нар яг хувь хүний тулгамдаж байгаа асуудлын өргөдлийг шийдвэрлэхийн тулд Засгийн газар гүйцэтгэх засаглалд үүрэг чиглэл өгөх гэж байгаа. Энэ бол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ биш. Энийг бол мэдээж Байнгын хороогоор гаргаж болохгүй.

Тэгээд одоогийн энэ орж ирсэн хуулиар 23.4.4-өөр хуралдааны тэмдэглэлээр албан бичгээр хандах гэж байгаа юм. Бид нар аль хэдийн ийм юм хийдэг. Энэ асуудал ингээд байна та нар засаадхаач ээ, энэ асуудлыг хараадхаач ээ гэж байхаар түй ч тоож байгаа юм алга байна. Засгийн газар нь улсын Их Хурлаа хүндэтгэхгүй байна. Засгийн газар нь Улсын Их Хуралдаа хянагддаг гэдэг тийм мэдрэмж алга байна. Тэгээд энийг нь бид нар байхын тулд Өргөдлийн байнгын хороо иргэдийнхээ энэ асуудлыг шийдэхийн тулд л энэ Өргөдлийн байнгын хороо чинь шүдтэй байх ёстой. юм, шийддэг байх ёстой. гэдэг шаардлагыг тавиад тавиад байгаа юм. Тэгээд энэ бол энэ хуулийн төсөлд бол ороогүй байгаа. Хэлэлцүүлгийн явцад бас хэлэлцээд энэ дээр засах байх гэж найдаж байна.

Тэгээд өөртөө шаардлага тавих болсон Засгийн газартаа ч гэдэг бид нар шаардлага тавих ёстой.Энэ олон хуулиуд чинь тэндээс орж ирэх ёстой.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Хариулах юм уу? Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Тийм. Та бүхэн нөгөө Дэгийн хууль, Хяналт шалгалтын тухай хууль үзэхээр үндсэндээ Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, Засгийн газрын үйл ажиллагааг иргэдэд тайлагнуулах, Засгийн газраас гишүүд, сайд нар орж ирчхээд чуулганы хуралдаанд худлаа хэлдэг, буруу мэдээлэл өгдөг, худлаа баахан амлалт авдаг, тэрийгээ шийддэггүй байдлуудыг хэрхэн, яаж хариуцлагажуулах тодорхой орж байгаа юм. Энэ дээр эхлээд нөгөө 100 төсөл хэрэгжүүлээд 50 хурал хийлээ гээд л ингээд л цаасан дээр тоо яриад байдаг улсын хувьд ажлаа тайлагнадаг энийг яг бодитой иргэдийн амьдралд, ард иргэдийн амьдралд ямар үр дүн гаргав, инфляцаа яаж бууруулав, ямар төсөл,

хөтөлбөрүүдээ яг яаж шийдэв, үнэхээр Их Хурлаас өгсөн үүрэг даалгавар яаж биелүүлэв гэдгийг нь маш тодорхой хэмждэг, хянадаг, хариуцлага тооцдог ийм тогтолцоонууд бас орж ирж байгаа шүү. Энийг та бүхэн бас хуулийн төслөө үзэх юм бол бас тодорхой заалтууд орсон байгаа гэдгийг харах боломжтой байгаа. Бусад асуудлыг бол хэлэлцүүлгийн явцад бас нэмээд сайжруулах, өөрчлөх зүйл байвал бас өөрчлөөд явах бололцоотой.

**Б.Пүрэвдорж:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, П.Мөнхтулга нарын урилгаар Архангай аймгийн Ихтамир сумын иргэд Цахир сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна

Манай Мөнхтулга, Тэмүүлэн нарын гишүүд орон нутагтаа илүү сайн ажиллаж, энэ нутгийнхаа иргэдийн чадварлаг төлөөлөл болж ажиллаж байгаад гишүүдийнхээ өмнөөс талархал илэрхийлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой Лувсаннямын Гантөмөр гишүүн горимын санал гаргана.

**Л.Гантөмөр:** Пүүжээ даргыг хурал удирдаж байгаа дээр горимын саналын үг аваад хэлье гэж бодлоо. Үнэхээр зүрх шимшрүүлсэн үйл явдал Монголд тохиолдож байна удаа дараа. Монгол цэрэг эрчүүд цэргийн анги дээрээ амь насаа алддаг. Өнөөдөр Баянхонгор аймагт бас ийм зүйл болсон гэж байна. Эмнэлэг очиж хүнээ аваагүй байна. Тэгэхээр үнэхээр сахилга хариуцлага ярья гэж байгаа бол Пүрэвдорж даргаа хурлаа завсарлуулах хэрэгтэй. Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл энэ асуудлыг ярих хэрэгтэй. Батлан хамгаалахын сайдыг огцруулах хэрэгтэй. Монголчууд Монгол цэргээрээ, Монгол цэргийнхээ амь насаар тоглодоггүй болгох хэрэгтэй. Ингэж байж бид нар хяналт шалгалтын тухай асуудлаа ярина. Номинчимэг гишүүний хэлж байгаа түмэн зөв. Гарсан ямар шийдвэрийг хэн ч хэрэгжүүлэхгүй байна, нулимж байна, үл тоож байна. Тийм учраас бол Пүрэвдорж дарга бүрэн эрхээ хэрэгжүүлээд одоо энэ хурлыг завсарлуул. Ингээд сууж байгаа нь гунигтай байна. Муухай харагдаж байна. Монголчуудаа хамгаалж чадахгүй байж байж, Монгол хөвгүүдээ хамгаалж чадахгүй байж байж хэдүүлээ энд дэг яриад сууж байгаа нь үнэхээр гунигтай байна. Та бол эрх мэдлээ хэрэгжүүл.

**Б.Пүрэвдорж:** Үг хэлэхээр 2-хон хүн өгсөн байгаа. Тэгээд чуулган завсарлана.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. 2 хүн үг хэлэхээр хүсэлт ирүүлсэн байна. Бадарчийн Хэрлэн индрийн 1 дүгээр микрофоноос үг хэлнэ.

**Б.Хэрлэн:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр Монгол Улсын Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд ерөнхийд нь дэмжиж байна. Улсын Их

Хурлаас батлах хуулийг илүү чанартай, чамбай болгох боломжийг нээж өгсөн хэд хэдэн санаанууд энд бол тусжээ. Гишүүн санаачилсан хуулийн төслийнхөө үзэл баримтлалыг хадгалахын тулд ажлын хэсэгт өөрөө орох, санал хураалтын өмнө ахин үзэл баримтлалаа тайлбарлан хэлдэг байх. Мөн хуулийн төсөлд Байнгын хорооны саналаар хууль зүйн болон эдийн засгийн үр дагаврын тооцооллыг ахин нягталж хийх, шаардлагатай бол 60 минутын хугацаанд гишүүд мэтгэлцэх ийм мэтгэлцээнийг зохион байгуулах гэх жишээтэйгээр гарч байгаа хуулийн төслийг илүү чамбай болгох ийм зохицуулалтууд орж ирснийг бол дэмжиж хүлээж авч байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх, үйл ажиллагааг илүү зохион байгуулалтын хувьд оновчтой болгосон санаанууд энд туссан байна. Дээр нь Улсын Их Хурлын гишүүний сахилга хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг оруулж ирсэн байна. Тухайлах юм бол төслийн 8.6-д ээлжит чуулганы хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, чуулганы хуралдаанд асуулт асуусан үг, хэлсэн тоо, дотоод, гадаад томилот, хууль тогтоомжийн төсөл санаачилсан, хамтран санаачилсан, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал, гаргасан зарчмын зөрүүтэй саналын тоо, энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн эсэх мэдээллийг олон нийтэд ил тод тогтмол мэдээлнэ гэж оруулж ирсэн байна. Энэ бол иргэд сонгогчид төлөөлж байгаа төрд суугаа төрийн зүтгэлтний ажлын явц, байдлыг сонгогчид харж дүгнэхэд бол болохоор зүйл.

Гэхдээ энд эргэж харах бас ганц нэг зүйлүүд бол байна. Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр бол Ёс зүйн дэд хорооны дарга идэвх оролцооны талаар хуралдаанд оролцохоор танилцуулж болно гэж заасан байдаг. Харин энэ төсөлд олон нийтэд тогтмол хэн мэдээлэл хүргэх вэ гэдэг нь бас тодорхой бус байгааг эргэж эргэж харах хэрэгтэй байна.

Идэвх ирц оролцоог ээлжит чуулган дуусахад нэгдсэн байдлаар мэдээлнэ гэсэн энэ зохицуулалт бас байгаа учраас энэнтэй нь энийг нэгтгэвэл яасан юм бэ тогтмол байнга мэдээлнэ гэж байхаар зүгээр чуулганы төгсгөлд нэгдсэн байдлаар мэдүүлбэл яасан юм бэ гэсэн энэ саналыг хэлмээр байна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүний ажил үүргийн онцлог бол бас нэлээн төвлөрч ажиллах ийм шаардлагатай болдог. Тэгэхээр байнга хуралд орно, байнга санал, асуулт хэлнэ гэдэг маань болоод ирэхээр маш их хэмжээгээр бас цаг хугацааг нь авах учраас ерөнхийдөө өөрийнхөө ажиллаж байгаа нь тэр хуулийн төсөл дээрээ илүү төвлөрч ажиллах энэ боломжийг энэ зохицуулалт бас хязгаарлах вий гэсэн ийм бодол төрж байна.

Гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхийн тулд Ёс зүйн дэд хорооны эрх үүргийг нэлээн нэлээд нэмэгдүүлсэн ийм зохицуулалтууд орж ирж байна. Тэгээд ер нь бол Ёс зүйн дэд хороо бол ирсэн гомдол, хүсэлт, ирцийг шалгах хүрээнд ажилладаг байсан бол энүүгээр бол гишүүдийн ирцээс гадна идэвх оролцоо, ёс зүйн хэм хэмжээнд хэмжээний зөрчил гарвал шийдвэрлээд хариуцлага тооцоод явахаар эрх мэдлийг нэлээн нэмэгдүүлсэн ийм зохицуулалтууд орж ирж байгаа. Хүлээлгэх хариуцлага нь ч бас тодорхой. Тэгээд нэлээд бас чангарч орж ирсэн байгааг бол анхаарах хэрэгтэй байна аа.

Улсын Их Хурлын дотоод асуудал, тэр тусмаа гишүүний ёс зүй сахилга хариуцлагын асуудлыг хамаарах тул дэд хорооны статустай байхаар оруулж ирснийг бол ерөнхийдөө дэмжиж байна. Төслөөр Ёс зүйн дэд хорооны гишүүдийн тоог нэмэгдүүлсэн бөгөөд бүүр Улсын Их Хурлын дэд даргыг заавал оруулна. Тэгээд Улсын Их Хурлын дэд дарга нарын аль нэг нь Ёс зүйн дэд хороог ахлахаар оруулж ирсэн байна. Тэгэхээр намын бүлэггүй улс төрийн хүчний төлөөлөл ямар оролцоотой байх вэ? Нэгэнт гишүүний хариуцлагын асуудал яригдах учраас Улсын Их Хурал дахь улс төрийн намуудын намуудын төлөөлөл л жигд орох тухай асуудлыг энд бас тусгах хэрэгтэй гэж харж байна. Ёс зүйн дэд хорооны даргаар насаар хамгийн ахмад парламентын гишүүнийг сонгодог байвал.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж 1 минут.

**Б.Хэрлэн:** Монголчууд ах нь хэлж дүү нь сонсоно гэдэг. Тэгэхээр дөнгөж сая парламентын танхимд гишүүдийн дуу чангарахад Рэгдэл гишүүн ганц дуугарахад бүгдийг нь нам болгож байна. Тэгэхээр энэ соёл өнөөдрийг хүртэл хүчтэй байгаа учраас ахмадаар нь ахлуулах, хамгийн ахмад гишүүнээр ахлуулах ийм саналыг бас эргэж харна уу гэж үзэж байна.

Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг зардалтай болгож байгаа нь бол бас их сайн байна Ёс зүйн дэд хорооны ажил үүрэг нэмэгдэж байгаатай холбогдуулаад ажлын албыг бас бэхжүүлэх тухай тодорхой санаануудыг энд тусгах хэрэгтэй гэж бодож байна. Түүнчлэн ёс зүйн тухай асуудал нь болоод ирэхээр гишүүдийнхээ ёс зүйн асуудал, нэр хүнд, алдар хүндтэй холбоотой асуудлыг авч хэлэлцэж байдаг учраас ер нь Ёс зүйн дэд хороод ажиллаж байгаа гишүүд гишүүний үндсэн үүргээс гадна өшөө илүү жаахан галтай асуудлууд рүү орж ажиллаж байдаг. Тэгэхээр энэ гишүүдийг хамгаалах тухай асуудал энд яах вэ? Энэ гишүүдэд ротац гэж сэлгэн ажиллуулах энэ санаануудыг энд тусгах уу гэсэн ийм зүйлийг хэлмээр байна. Тэгээд энэ хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байна.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн индрийн 2 дугаар микрофоноос үг хэлнэ.

**Р.Эрдэнэбүрэн:** Хуулийн төсөлтэй холбоотой холбоотой 3-хан санал хэлэх гэсэн юм.

1 дүгээрт бол энэ хууль боловсруулах үйл явц ялангуяа энэ Их Хурлын бүтэц, Их Хурлын гишүүдийн эрх, үүрэгтэй холбоотой асуудал яригдаж байгаа энэ үед бол олон гишүүдийг хамруулаад энэ бүлгүүд, намуудыг бүгдийг нь ингэж хамруулж төслөө боловсруулах шаардлагатай, хэлэлцэх шаардлагатай гэж ингэж бодож байна. Энэ хэлэлцүүлгээс ингээд харж байхад бол Их Хурлын даргын өрөөнд боловсруулагдсан төсөл байна гэж ингэж харагдаж байна. Их Хурлын дарга ч гэсэн өөрөө тэрийгээ хүлээн зөвшөөрч байх шиг байна. Их Хурлын даргын хувьд бол мэдээж эмх цэгцтэй байлгая, асуудалгүйхэн шиг энэ их хурлыг удирдаад явчихъя гэсэн ийм бодолтой байгаа байх.

Тийм ч учраас бас нэлээн ийм механик байдлаар хаалт, хоригууд тавьсан ийм төсөл орж ирж байна. Их олон асуудлыг Их Хурлын даргын зөвлөлийн шийдвэрээр шийддэг байхаар ийм заалтууд орж ирж байна. Тийм учраас би энэ бүлгийн дарга, удирдлагууддаа бол уриалж байна. Энэ хуулийн төслийг бүлгээрээ

хэлэлцэх хэрэгтэй. Ардчилсан намын бүлэг бол ялангуяа энийг завсарлага авч байгаад нэлээн сайн хэлэлцэх ёстой. гэж ингэж бодож байна.

Өнгөц өөрчлөлтүүд хийгээд баймааргүй байна. Жил болгон өөрчлөгдөж байна энэ Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль чинь. Тэгээд дээр нь сая бол энэ Байнгын хороо өөрчилж байгаа асуудал бол хууль санаачлагчийн хариулж байгаагаар бол Засгийн газрын бүтэцтэй холбож өөрчлөгдөж байгаа гэж хариулж байна. Хэрэвзээ ингэж явах юм бол Засгийн газар өөрчлөгдөх болгонд Их Хурлынхаа тухай хуульд өөрчлөлт оруулаад байх юм бол юу болох юм бэ? Сүүлдээ энэ Их Хурлын гишүүд чинь Байнгын хорооныхоо нэрийг ч мэдэхээ байлаа шүү дээ. Янз бүрийн нэр өгөөд л шинээр байнгын хороонууд байгуулагдаад яваад байх юм. Тийм учраас энийг бол өшөө сайн ярьцгаая.

2 дугаарт, тэр баахан юунууд гаргаж ирж байгаа юм байна шаардлагууд Их Хурлын гишүүдийн ажлыг дүгнэх, Байнгын хорооны дарга болохын тулд ямар ямар нөхцөл биелүүлсэн байх ч гэнэ үү энэ бол арай болохгүй асуудал. Тэр гадаад явсан байх, үг хэлсэн байх, асуулт асуусан байх, ирцдээ орсон байх ч гэнэ үү. Энэ дээр үед нэг энэ пионерын байгууллага гэж ийм байгууллага байдаг байсан юм. Хэдэн зурам алсан, даалгавраа биелүүлсэн энэ тэр гээд тэгээд сайн, онц сурсан бол Найрамдал зусланд явуулдаг тэр тийм юу байдаг байсан. Энэ Их Хурлын гишүүдийн энэ Их Хурлыг үнэлэх үнэлгээ бол энэ Монгол Улсын хөгжилд ямар түүхэн асуудлуудыг зөв, сайн шийдвэрлэдэг гэдгээр л шийдэгдэнэ.

Дараа нь бол энэ Их Хурлын гишүүдийг ямар улс төрч вэ гэдгээр нь сонгогчид хариуцлага тооцно. Тийм учраас энэ эрхийг нь нээж өгөх хэрэгтэй сонгогчдод. Тийм учраас хэлээд байгаа санаа нь тэр мэтгэлцээнийхээ юуг чөлөөтэй нээж өгье. Заавал ингээд нэр авдаг энэ тэр гээд энэ ер нь бид нарын нэг зүйл дээр анхаарах юм бол энэ парламентыг учиргүй замбараагүй бөөн юм болчихно гэж бодоод байдгаасаа болих хэрэгтэй. Энэ бол маш олон өнгөтэй энэ гишүүд чинь бүгдээрээ өөр өөрийн өнгөтэй. Тэр үзэл санаагаа илэрхийлэх аргууд нь өөр өөр. Зарим нь ингээд сая дуу тавиад л эд нар гээд. Тэгээд ийм олон өнгийг заавал ч үгүй нэг өнгөнд аваачиж, нэг журамд оруулж, нэг стандарт руу оруулах гээд байх хэрэг байхгүй.

Ингэх юм бол энэ парламент чинь өөрөө уйтгартай болно. Энэ парламент дээр хэлэлцэгдэж байгаа асуудлуудыг чинь хүн тоохоо болино.

**Б.Пүрэвдорж:** Нэмж 1 минут.

**Р.Эрдэнэбүрэн:** Тийм учраас санал бол мэдээж энэ нэгэнт ингээд ороод ирчихсэн юуг хэлэлцэх ёстой. байх. Тэгэхдээ өшөө сайн ярьцгаая. Нэг мөсөн энэ сая Тэмүүжин гишүүн маш олон саналууд хэлж байна. Өөр гишүүд олон саналууд хэлж байна. Тэгээд олон дахин өөрчлөгдөөд байхааргүй, жил болгон ингээд л дахин дахин оруулж ирээд байхааргүй, Засгийн газар өөрчлөгдөнгүүт дахиж оруулж ирээд байхааргүй ийм хэмжээнд энэ хуулийн төслийг хэлэлцэх ёстой. гэж ингэж бодож байна.

Тийм учраас намын дарга бүлгийн дарга, энэ бүлгийн удирдлагууддаа бол энэ хуулийн төслийг татаж аваад, завсарлага аваад бүлэг дээрээ дахиж хэлэлцэх шаардлагатай байна гэсэн ийм уриалгыг хэлж байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. гишүүд үг хэлж дууслаа. Үдээс өмнөх чуулганы хуралдаан завсарлалаа.

13.01 цаг

*Пүрэв гараг 21 Тавдугаар сар 2026*

*Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 00 минут*

### **ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААН**

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын чуулганы 05 сарын 21-ний өдрийн үдээс хойших хуралдаан эхэлж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал асуулгыг үдээс хойш, санал хураалтыг үдээс хойш явуулна. Гишүүдийг цуглахаар явуулна. Дараагийн асуудалдаа орёё.

14.01 цаг

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.**

Хууль санаачлагчдын илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урья.

**А.Ариунзаяа:** Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын цэг, цэг, цэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 1992 онд баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль 1997, 2001, 2006, 2007, 2020 онд баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулж ирсэн.

Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан 126 гишүүнтэй Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу чуулганы хуралдааныг зохион байгуулж байна.

Улсын Их Хурлын гишүүдийн болон Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаа төлөвлөлттэй, хэлэлцүүлгийн дэг тодорхой, чуулганд оролцож байгаа гишүүд хариуцлагатай байх чиглэлээр чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг боловсронгуй болгох талаарх Улсын Их Хурлын гишүүдийн санал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хэлэлцэх явцад гарч байгаа нь нарийвчлан зохицуулах хуулийн зүйл, хэсэг, заалтын хоорондын нийцлийг хангах шаардлагыг харгалзан үзэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Улсын Их Хурлын 06/125 дугаартай албан бичгээр бусад Байнгын хороодоос мөн оны 3, 4 дүгээр сард Улсын Их Хурлын гишүүд, тэдгээрийн ажлын албаны ажилтнууд, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудаас санал авч, миний бие, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Бат-Эрдэнэ, Н.Батсүмбэрэл, Ж.Батжаргал, Б.Бейсен, Ч.Лодойсамбуу, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, Ц.Сандаг-Очир, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн нарын 12 гишүүний хамтаар хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд тусгасан өөрчлөлтийг дараах 2 хүрээнд багцлан танилцуулъя.

1 дүгээрт, чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг сайжруулах дэгийн зохицуулалтыг тодорхой болгох хүрээнд дараах гол өөрчлөлтийг тусгахаар бэлтгэлээ.

1.Хууль тогтоомжийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл тогтоож, асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилж байгаа одоогийн зохицуулалтад өөрчлөлт оруулж, хугацааг хувь тэнцүүлэн хуваарилж, урьдчилан нэр авахгүйгээр зохион байгуулахаар төсөлд тусгалаа.

Ингэснээр хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн явцад танхимд байгаа гишүүд зөвлөлийн тогтоосон хугацаанд багтаан урьдчилан авсан тооны хязгаарлалтгүйгээр ирцэд бүртгүүлсэн дарааллаараа асуулт асууж, хариулт авах боломж бүрдэнэ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэгдсэн хуралдаан болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуух, түүнд хариулт авах хугацааг өөр өөрөөр зохицуулсан, зарим тохиолдолд тодорхой зохицуулаагүй тохиолдлууд ч байгаа тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх болон хяналтын сонсголоос бусад тохиолдолд гишүүн асуулт асуух, түүнд хариулт өгөх, нэмэлт асуулт асууж, хариулт авах хугацааг жигд ойлгомжтой болгож, гишүүн 4 минутаас илүүгүй асуух, хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл 2 хүртэл удаа 1 минутаар нэмэлт асуулт асуух түүнд хариулах хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа 1 минутаас илүүгүй байхаар тусгасан.

Хуралдаан даргалагч шаардлагатай бол гишүүний асуултад бүрэн хариулт өгөх зорилгоор нэмэлт тайлбар өгөх хугацааг нэмж өгч болох, гишүүн хүсэлт гаргасан бол нийт 8 минутын хугацаанд асуулт хариултын илүү уян хатан

байдлаар буюу хэдэн ч удаа асуулт асууж, хариулт авах боломжтойгоор зохион байгуулж болох заалт нэмлээ.

3.Хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороонд хуваарилснаас хойш ээлжит чуулганы хугацаанд 1 сарын дотор хэлэлцэх асуудлын тов дараалалд тусгах зохицуулалтыг мөн тусгалаа.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нам, эвслийн бүлэг мэтгэлцээн зохион байгуулахаар санал дүгнэлт гаргасан бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэхээр, түүнчлэн хуралдааны өмнөх өдрийн 16 цагаас өмнө нам, эвслийн бүлэг илтгэгч гишүүнийг томилж ирүүлэхээр заасан. Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш нам, эвслийн бүлэг санал дүгнэлт гаргаж, мэтгэлцээн зохион байгуулаагүй байна.

Тиймээс Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед гишүүн санал гаргаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол тухайн хэлэлцүүлгийн явцад 1 цагийн хугацаанд чөлөөт мэтгэлцээнийг шууд буюу нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргахгүйгээр, илтгэгч гишүүн томилохгүйгээр зохион байгуулах зохицуулалтыг тусгалаа.

5.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх болсон үндэслэлийн талаарх Ерөнхий сайдын, эсхүл холбогдох Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонссоны дараа санал хураалт явуулж шийдвэрлэх өөрчлөлт оруулсан болно.

6.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хууль, тогтоолын төсөл болон төслийн тодорхой зүйл, хэсэг заалт, гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар ямар хүрээг хамруулан гаргах талаар тусгасан.

Түүнчлэн Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналд Тамгын газраар зардлын тооцоо болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар дүн шинжилгээ хийлгэж болох зохицуулалтыг тусгалаа.

7.Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө хууль санаачлагч хуулийн төслийн талаар тайлбар хэлж болохоор тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэхэд гишүүн горимын санал гаргасан бол хууль зүйн нэр томъёог жигдлэх зорилгоор хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх санал, дэмжих эсэх асуудлаар багцлан нэг санал хураалт явуулж болохоор. Мөн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх санал хураалт явуулахад их хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээгүйд тооцох зохицуулалтыг нэмж оруулахаар бэлтгэлээ.

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахтай холбоотойгоор хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулсан бол түүний ахлагч, эсвэл ажлын хэсгийн гишүүн, Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах, нэгдсэн хуралдаанд тухайн Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч, гишүүн асуултад хариулах зохицуулалтыг тусгалаа.

Мөн Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч хуулийн төслийн талаар тодруулга, тайлбар хийж болохоор зааснаар анхны хэлэлцүүлгийн шатад төслийн талаар ерөнхий хариулт, ерөнхий асуулт хариулт явагдаж төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэгтэй давхацсан шинжтэй асуулт, хариулт гарч байгаа тул Байнгын хороогоор хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад гишүүн гаргасан саналаа тайлбарлах, хуулийн төсөлтэй холбогдуулан гарсан зарчмын зөрүүтэй санал дээр хууль санаачлагч тайлбар хийж болох зохицуулалт тусгах зэрэг зарим өөрчлөлтийг төсөлд тусгасан болно.

Улсын төсвийн төслийг 4 үе шаттайгаар хэлэлцэхээр тусгасан. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох болон албан тушаалтныг Улсын Их Хуралтай зөвшилцөх, танилцах бол нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулж байгаа нь Үндсэн хуулийн холбогдох заалтад нийцээгүй гэж тогтоосон тул Цэцийн гишүүнийг томилох болон зарим албан тушаалтныг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөд нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах зохицуулалтыг хуулиас хасахаар бэлтгэлээ.

Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулахтай холбоотойгоор сонсгол даргалагчийн холбогдох Байнгын болон дэд хорооны гишүүдээс сонгох, сонсгол даргалагч эзгүй бол холбогдох Байнгын, эсхүл дэд хорооны дарга сонсголыг даргалах, сонсгол явуулах журмын зохицуулалтыг ойлгомжтой болгох зэрэг асуудлыг хуулийн төсөлд мөн тусгасан болно.

2 дугаарт, багцлан танилцуулахад чуулганы хуралдаанд болон санал хураалтад оролцохтой холбогдох гишүүний хариуцлагыг сайжруулах хүрээнд дараах өөрчлөлтийг тусгахаар бэлтгэлээ. Үүнд:

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан тухайн өдрийн ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн ,эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж, тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцох одоогийн зохицуулалтыг хасахаар төсөлд тусгасан.

Улсын Их Хурлын гишүүн чуулганы хуралдаанд биечлэн оролцож санал өгөх зохицуулалтыг нэмж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр санал хураалтад биечлэн оролцоогүй гишүүнийг санал хураалтын бүртгэлээс хасах. Санал хураалт явуулахын өмнө хуралдааны танхимд байгаа гишүүдийн тоог бүртгэж, тухайн бүртгэлээс санал хураалтын дүнг гаргахаар тусгасан.

Нэгдсэн хуралдаанд хуралдаан даргалагч санал хураалт явуулахаас 10 минутын өмнө 1 минут.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж минут өгье.

**А.Ариунзаяа:** Нэгдсэн хуралдаанд хуралдаан даргалагч санал хураалт явуулахаас 10 минутын өмнө 1 минутын турш санал хураалтын хонх дуугарахаар төсөлд нэмж оруулсан. Эл санал хураалтыг цахимаар, эс үгүй бол гар өргөж явуулах ба гар өргөж санал хураалт явуулах бол гишүүн тухайн асуудлыг дэмжиж байгаа үгүйг тодорхой илэрхийлдэг байх зорилгоор гишүүн бүрийн нэрээр дуудаж саналыг авч, хуралдаан даргалагч дүнг зарлахаар тусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагад тусгагдсан хуралдаан даргалагч хуралдааны явцад хүлээлгэх хариуцлагаас хуралдаанд оролцох эрхийг хасах, тухайн хуралдааныг орхин гарахыг үүрэг болгох хариуцлагыг хуулиас хасахаар төсөлд тусгасан.

Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн, Байнгын, дэд хорооны болон хянан шалгах түр хорооны хуралдаанд идэвхтэй оролцдог байх. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тодорхой хугацаанд оролцоогүй бол эс үгүй бол санал хураалтын тодорхой хувьд шалтгаангүйгээр оролцоогүй бол ёс зүйн дэд хороо хариуцлага хүлээлгэдэг байх зохицуулалтыг нэмж тусгасан болно.

Тодруулбал, гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр болон хуульд заасан үндэслэлээр санал хураалтад оролцоогүйгээ мэдэгдсэнээс бусад тохиолдолд 1 сарын хугацааны нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд оролцоогүй, эсвэл гишүүн ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн, эс үгүй бол харьяалагдах Байнгын хороо, эс үгүй бол дэд хорооны хуралдаанд 5 ба түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол Ёс зүйн дэд хороо гишүүний зөвлөх, туслах, биет төлөөлөгч, туслахын цалингийн зардлаас бусад гишүүний төсвийн 1 сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлагыг хүлээлгэнэ.

Ёс зүйн дэд хороо гишүүний хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдлын мэдээг 7 хоног бүр гарган авч, түүнд үндэслэн гишүүнд хариуцлага оногдуулах. Түүнчлэн Ёс зүйн дэд хороо гишүүний хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдлыг ээлжит хуралдаан, ээлжит чуулган хаасны дараах 7 хоногт олон нийтэд мэдээлэхээр тусгасан.

Гишүүн ажлын хэсгийн хуралдаанд 2 ба түүнээс дээш удаа биечлэн оролцоогүй түр хорооны хуралдаанд 3 ба танаас дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол тухайн ажлын хэсгийн болон түр хорооны бүрэлдэхүүнээс хасах зохицуулалтыг мөн тусгасан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ариунзаяа гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын иргэд

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажил хөдөлмөрийн болон эрүүл энхийг хүсэн ерөөе.

Одоо төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна. Индэрт урьж байна.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүдийн болон Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаа төлөвлөлттэй, хэлэлцүүлгүүдийн дэг тодорхой, чуулганд оролцож байгаа гишүүд хариуцлагатай байх чиглэлээр чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага нэмэгдэж байна гэж үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг боловсронгуй болгох талаарх Улсын Их Хурлын гишүүдийн санал болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хэлэлцэх явцад гарч байгаа нарийвчлан зохицуулах хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондын нийцлийг хангах хүрээнд хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд 1 дүгээрт чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг сайжруулах, дэгийн зохицуулалтыг тодорхой болгох.

2 дугаарт, чуулганы хуралдаанд болон санал хураалтад оролцохтой холбогдуулан гишүүний хариуцлагыг сайжруулах гэсэн 2 үндсэн чиглэлийн хүрээнд тодорхой өөрчлөлтүүдийг тусгасан байна. Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим системд байршуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр чуулганы хуралдаанд гишүүд үг хэлж байхад зэрэгцэн үг хэлэхийг хориглосон заалт, зохицуулалт тусгах нь зүйтэй эсэх талаар болон хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр хууль хуулийн төслийг яаралтай горимоор хэлэлцэх зохицуулалт хэзээнээс үйлчилж эхэлсэн, энэ зохицуулалт байх шаардлагатай эсэх, Улсын Их Хурал төлөвлөсөн асуудлаа хэлэлцдэг байхад анхаарах шаардлагатай талаар болон хуулийн төсөл эцэслэн батлагдахын өмнө тухайн хуулийн төслийн үзэл баримтлал өөрчлөгдсөн эсэх талаар Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа хуулийн төсөлд туссан зарим зохицуулалт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад байгаа талаар, Ёс зүйн дэд хороо Улсын Их Хурлын гишүүдийн ирц, санал хураалтад оролцсон байдлыг хянан хэлэлцэж, гишүүний төсвийн 1 сард оногдох санхүүжилтийг

олгохгүй байх хариуцлага хүлээлгэх нь хэрэгжих боломжтой эсэх, Ёс зүйн дэд хороо хэлэлцэн дүгнэлт гаргах хүрээ, хязгаарын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Ёс зүйн дэд хорооны гүйцэтгэсэн ажлын талаар болон хуулийн төсөлд тусгагдсан зарим зохицуулалт Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн зарим зохицуулалттай давхардсан эсэхийг хэлэлцүүлгийн шатад анхаарах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.9 хувь, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.9 хувь, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.9 хувь, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.9 хувь, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.9 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан ший шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ундрам гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Тийм Дэгийн тухай хууль. Таны нэр байхгүй байна.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн алга байна. Ренчинбямбын Сэддорж гишүүн алга байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Гомбын Ганбаатар гишүүн алга байна. Жудгийн Баярмаа гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Д.Энхтүвшин:** Хуулийн үзэл баримтлалд иргэд, олон нийт Улсын Их Хурлын гишүүний сахилга хариуцлагыг нэмэгдүүлэхээс гадна Улсын Их Хуралд нээлттэй, ил тод байх шаардлагатай байна гэсэн ийм асуудал тавьсан байгаа. Тэгээд хуулийн төсөлд болохоор яг энэ ил тод байлгах асуудалтай холбоотой заалт бараг байхгүй байна. Энэ хууль дээр болохоор чуулганы дэгийн тухай хууль дээр 134 дээр чуулганы хуралдааны нэвтрүүлэх мэдээлэх журам гэж байдаг. Тэгээд энэ дээр бол чуулганы хуралдааныг телевизийн сувгаар шууд нэвтрүүлэх, телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулна гээд ийм ганцхан зүйлээр зохицуулсан байдаг.

Тэгээд энэ зүйл, заалтыг Улсын Их Хурлын чуулганы энэ хуралдааныг ил тод, нээлттэй болгох зорилгоор өнгөрсөн оны 12 сарын 17-нд миний бие хуулийн төсөл санаачилж өргөн барьсан байгаа. Одоо болтол хэлэлцэгдээгүй хэлэлцэх эсэх нь шийдэгдээгүй байгаа. Тэгээд энэ хуулийн төслөөр болохоор агуулгаас гадна яг тухайн асуудлаар, хэлэлцэж байгаа асуудлаар дэмжсэн, дэмжээгүй байр сууриудыг Улсын Их Хурлын гишүүн тус бүрээр нь тухайн өдөр нь гаргах ийм хуулийн төсөл өргөн барьсан байгаа.

Тэгээд одоогийн хуулийн үйлчлэлийн хүрээгээр хар авч үзэхээр бараг 4-н долоо хоногийн дараа л энэ дэмжсэн, дэмжээгүй гэдэг байр сууриудыг жишээлбэл тэр мэдээллийг авах бололцоотой. Бүүр түүнчлэн бараг 2 жилийн дараа ч гэсэн хүсэлт гаргаад дэмжсэн, дэмжээгүй байр сууриудын талаар мэдээлэл авах гээд авч чадахгүй байгаа. Тэгэхээр энэ хэлбэрээс гадна агуулгын хувьд энэ ил тод байлгах, яг ямар асуудлаар гишүүд дэмжсэн, дэмжээгүй гэдгийг ил тод болгох энэ нь бас ийм чухал байгаа. Тэгэхээр хууль санаачлагчийн зүгээс яг ер нь энэ хуулийн миний хуулийн төслийг хамтатгаад хэлэлцэх бололцоотой юу гэдэг ийм асуулт байна. 1 дүгээрт.

2 дугаарт, энэ идэвхтэй үйлдлийг болохоор биечлэн санал өгөх гэдэг. байдлаар тодорхойлоод байх шиг байна. Тэгэхээр яах вэ хэдийгээр бие нь идэвхтэй хуруугаа дарж байгаа ч гэсэн цаана нь сэтгэл нь ингээд идэвхгүйгээр ийм санал өгдөг дэг жаяг гэх юм уу ийм жишиг тогтчихсон байгаа.

Жишээлбэл, намын бүлгүүд дээр тодорхой асуудлууд дээр Улсын Их Хурлын гишүүний бие дааж шийдвэр гаргах эрхийг нь хязгаарладаг. Хэрвээ тэр шийдвэрийг гаргавал жишээлбэл хариуцлага тооцно, үг хэлэх эрх, минутыг нь хасна, хязгаарлана гэх мэтчилнээр ийм асуудлууд гардаг. Ардчилсан нам дээр жишээлбэл 2 билүү, 3 одтой шийдвэр гаргавал тэрийг зөрчсөн жишээлбэл Улсын Их Хурлын гишүүд бас хариуцлага тооцох асуудал яригддаг.

Өнгөрсөн жил бас Монгол Ардын намын бас бүлэг дээр бас яригдаж байсан. Хэрвээ бүлгийн шийдвэр зөрчвөл тодорхой хэмжээний бас оноо, дүгнэлт гаргадаг байх. Тэгэхээр өөрөөр хэлбэл бие нь идэвхтэй хуруу дарж байгаа хэдий ч гэсэн ингээд яг Улсын Их Хурлын гишүүний яг тэр чөлөөтэй иргэдийг төлөөлөх энэ эрхийг хязгаарлаж байгаа энэ агуулгаар энэ хууль дээр өөрчлөлт оруулах бололцоо бол боломж бол нь байсан. Тэгээд энэ талаар та хэд хэлэлцсэн үү гэдэг 2 дугаар асуулт байна.

3 дугаарт нь саналууд авсан гээд гэж байна. Чуулганы дэгийн тухай хууль дээр бас нэг ийм санал оруулсан байгаа юм. 2 долоо хоногоор энэ долоо хоногоор

энэ хэлэлцэх асуудлыг гаргадаг юм. 2 долоо хоногоор болгооч ээ гэсэн. Бусад орнуудаар бас ингэж гаргадаг юм байна лээ.

Ялангуяа энэ Засгийн газар давхар дээлтэй сайд нар байгаа ийм олон байгаа үед бол 2 долоо хоногоор гаргачихвал ажлаа төлөвлөөд тэгээд асуудлуудтай танилцах хугацаа ч гэсэн олгомоор байгаа. Тэгэхгүй бол 1 дэх өдрийн асуудал хэлэлцэх асуудлыг бүтэн сайны орой нь жишээлбэл мэддэг. Тэгэхээр жишээлбэл ямар ч танилцах бололцоогүй ийм байгаад байгаа юм. Өөр энэ талаар та хэд энэ өөрчлөлт оруулах бололцоотой юу гэдэг нэг асуулт байна. Тэгээд дараа нь тодруулчихъя.

**Б.Пүрэвдорж:** Аюушийн Ариунзаяа хууль санаачлагч хариулна.

**А.Ариунзаяа:** Энхтүвшин гишүүний өргөн барьсан байгаа гишүүд яг тухайлсан асуудлаар санал хураалт явагдсан хойно дэлгэцээр л урсаад өнгөрдөг. Тэгээд эхний хэдэн хүмүүс нь нийтэд харагдаад дараа дараагийн хүмүүс Э үсгээр эхэлсэн жишээлбэл хүмүүсийн хэрхэн, яаж санал өгсөн нь олон нийтэд шууд тэр дороо харагдахгүй байна гэдэг үүднээс санал өгсөн байдлыг нь тэр дор нь олон нийтэд бүхлээр нь харуулдаг байх ийм бас хуулийн төслийг өргөн барьсан байгаа.

Тэгэхээр хууль санаачлагчдын зүгээс нэгтгэн хэлэлцэх асуудлыг зөвшөөрөх юм бол нэгтгэн хэлэлцүүлээд явах боломжтой. Тэгэхээр Энхтүвшин гишүүн ч тэр, энэ хамтран өргөн барьсан 12 хүн ч тэр хамтатгаад хэлэлцүүлэх нэгтгэх энэ асуудлыг бол шийдвэрлэж болно.

Ер нь зарчмын хувьд бол чуулганы дэгийн тухай хууль гэхээсээ илүүтэй Улсын Их Хурлын тухай хууль дээр түрүүн шүүмжлэгдээд байсан нөгөө 8.6 дахь энэ заалт бол ээлжит хуралдааны хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн, дотоод, гадаадын томилолтоосоо гадна зарчмын зөрүүтэй санал гаргасан байдал болон энэ саналыг нь өгсөн асуудлуудыг бодит цагийн горимоор олон нийтэд ил тод, тогтмол мэдээлнэ ээ гээд орчихсон байгаа.

Тэгэхээр яг энэ санал өгөлтийн дүн, зарчмын зөрүүтэй санал гаргасан байдал зэрэг бол тухай бүрдээ буюу бодит цагийн горим гэдэг чинь өөрөө рийл тайм буюу яг тухай бүрдээ бас олон нийтэд мэдээлэгдэж байх ийм зохицуулалт бол орсон байгаа. Чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг бол бид нар бүтэн чуулганаар нь нэг баталдаг. Одоо энэ хаврын чуулган дуусахад бол намрын чуулганаар хэлэлцэх асуудлыг бол нийтэд нь баталж байгаа. Түүнээсээ авхуулаад сар бүр бас хэлэлцэх асуудлуудын ерөнхий бүхий л энэ асуудлуудыг хуулиудыг бол бас баталдаг. Тухай бүрээ орж ирж байгаа асуудлуудыг Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ч гэсэн энэ жагсаалтад нэмэх асуудлуудыг тухай бүрээ бас шийдвэрлээд явдаг.

Тэгэхээр ямар нэгэн төлөвлөлт огт байхгүйгээр бол зохицуулалт байхгүй. Тэр 7 хоногийн товыг бол ирэх өмнөх 7 хоногийнхоо сүүлийн ажлын өдөр баталдаг асуудал нь бол тухайн 7 хоногтоо тавигдсан байгаа асуудлууд Байнгын хороо хуралдаж чадаагүйгээс, эс үгүй бол чуулганы хуралдааны явцад аль нэг бүлэг завсарлага авснаас болоод гэдэг ч юм уу түүнээсээ улбайж өөрчлөгддөг учраас 5 дахь өдөртөө бас баталж, тэгээд дараагийн 7 хоногийнхоо хэлэлцэх асуудлын тов

дарааллыг тогтдог ийм уламжлалтай байгаа юм. Мэдээж гишүүд бол хуулийнхаа хэлэлцэх энэ явцдаа зарчмын зөрүүтэй саналуудыг гаргаад өөрчлөх бүрэн боломж нь бол нээлттэй байгаа.

**Б.Пүрэвдорж:** Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Өөр нэг тодруулах асуудал болохоор энэ d.parliament онлайн платформ дээр байгаа энэ мэдээллүүд болохоор анх ирж хэлэлцэх үед л мэдээлэл нь ордог. Тэгээд хэлэлцүүлгийн явцын мэдээллүүд ерөөсөө ордоггүй. Ажлын хэсэгт ороогүй бол яг яаж өөрчлөгдөөд байгаа юм юу болоод байгаа юм ер нь ямар ч мэдээлэлгүй чуулган дээр орж ирэхээр ингээд 2 өөр мэдээлэлтэй ингээд хэлэлцүүлэг явагддаг.

Тэгэхээр энийг бас хэлэлцүүлгийн явцад жишээлбэл тэр саналууд нь яаж өөрчлөгдөж байгаа юм, хуулийн төслүүд нь яаж өөрчлөгдөж байгаа юм гэдэг Байнгын хорооны саналуудыг тухай бүрд нь бас оруулдаг байхгүй бол ийм зөрүүтэй байгаа. Энэ дээр өөрчлөлт оруулах бололцоотой юу гэж асуумаар байна.

Дээр нь тэр би түрүүн хүн асуусан намын бүлгүүд дээр хуруу нь идэвхтэй ч гэсэн яг бодит юу нь бол цаанаасаа өөр намын даалгавраар ч юм уу, бүлгийн даалгавраар ингээд шал өөр өөрийнхөө хүсэл зорилгынхоо эсрэг энэ санал өгөх иймэрхүү харилцаанууд байгаад байна. Тэгээд энийг өөрчилж болохгүй юу? Энэ дээр.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Яах вэ d.parliament дээр байгаа хэлэлцэхээс өмнө, боловсруулагдаж байгаа үе шат, өргөн барьсан хойно нь ямар ажлын хэсэг байгуулагдаж байна вэ гэх мэтчилэн асуудлууд бол Улсын Их Хурлын тогтоолоороо захирамжаараа бол гараад явчихдаг. Энэ болгон нь бол нээлттэй. Хууль санаачлагчид өөрсдөө бол ажлын хэсэгт орж ажилладаггүй. Ажлын хэсэг дээр орж ирж байгаа саналууд нь, зарчмын зөрүүтэй саналууд нь бол Байнгын хороон дээрээ бас танилцуулагдаж тухайн үедээ Байнгын хорооны хуралдаанаас өмнө 2 хоногийн өмнө бас хүргэгдэж тараагдаж явдаг. Улсын Их Хурлын чуулганд орж ирэхээсээ өмнө зарчмын зөрүүтэй саналууд ч гэсэн урьдчилж тараагддаг. Энэ бол олон нийтэд мэдээлэгдээд байдаггүй. Яагаад гэхлээр энэ эцсийн байдлаар шийдвэр биш учраас мэдээлэгддэггүй зөвхөн Улсын Их Хурлын гишүүдэд тараагддаг. Улсын Их Хурлын гишүүд чуулганы явцдаа шийдвэр гаргадаг асуудал. Намын бүлгийн энэ шийдвэрүүд дээр бол нам бүрийн өөрсдийн л.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Би тэр нөгөө нэг Улсын Их Хурлын гишүүдийн мэдээлэл, хэлэлцүүлгийн явцын мэдээллийг Улсын Их Хурлын гишүүд авдаг болмоор байна. Ажлын хэсэгт ороогүй бол тухайн Байнгын хороонд байдаггүй бол өөр хуралдаан давхардаад байгаа байхгүй юу. Тэгээд мэдээлэл авах гэхээр өнгөрчихсөн, өөрчлөгдчихсэн, зөрүүтэй ийм жишээлбэл хуулийн төслүүд дээр ч юм уу байр сууриа илэрхийлэх гээд байгаа учраас энийг мэдээлдэг, адилхан мэдээлэлтэй болох ийм бололцоо боломж энэ хуулийн төслөөр оруулах боломжтой юу л гэж асуусан юм.

**Б.Пүрэвдорж:** Ариунзаяа гишүүнд хариулъя.

**А.Ариунзаяа:** Яах вэ мэдээж аливаа хуулиуд дээр ажлын хэсэг гарч байгаа. Тухайн хуулийнх нь салбараас нь хамаарч тодорхой мэргэжлийн Байнгын хороонд нь харьяалагдаж байгаа. Хэрэвзээ Улсын Их Хурлын гишүүн хүсээд мэдээлэл авахыг хүсэх юм бол тухайн ажлын хэсэг дээр гарч байгаа санал, ажлын хэсгийн хуралдаанд нь оролцох, Байнгын хороонд нь оролцох гэх зэрэг энэ эрхүүд нь нээлттэй байгаа учраас үнэхээрийн танд их ойрхон санаа тавьж байгаа ийм хуулиуд байгаа бол мэдээллийг та авах авах эрх нь бол нээлттэй байгаа.

Тэгэхээр энийг бол нууцалдаг, хаацайлдаг, өгдөггүй асуудал бол байхгүй учраас энийг хуульчилна гэхээс илүүтэй зүгээр гишүүн өөрөө авах эрх нь бол нээлттэй байгаа байхгүй юу. Нийтэд тараадаг больё гэвэл энэ чинь маш олон хуулиуд явж байгаа, олон ч ажлын хэсэг явж байгаа, олон ч саналууд гардаг учраас энэ бол өөрөө бүтээмж талаасаа ч тэр зөв зохистой асуудал биш байх гэсэн ийм л саналтай байна. Гэхдээ санал гаргах эрх нь бол нээлттэй байна хууль дээр.

**Б.Пүрэвдорж:** Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууна.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Хуралдааны дэгийн тухай хууль дээр зарчмын хувьд шинэлэг, бас зарим асуудлыг шийдэхэд хялбарчилсан ийм олон чухал нэмэлт, өөрчлөлтийн санал орж ирсэн байна. Энэтэй холбогдуулаад бас асуух юм нэлээн байгаа юм. Санал хураалтыг яг биечлэн санал өгч явах бол их оновчтой шийдэл. Тэгэхдээ танхимд байхгүй гишүүдийг ирцээс хасчхаад дараа нь санал хураах болохоор чинь нөгөө санал хураах олонх маань бүрдээд өгөхгүй бол яах вэ? Энэ дээр ер нь судалсан юм юу байна вэ гэж 1 асуулт байна.

2 дугаарт, хүндэтгэн үзэх 4 шалтгаанаас бус тохиолдолд хуралдаан, Байнгын хороо, нэгдсэн хуралдаан гээд эдгээр ажилд оролцохгүй юм бол тасалсанд тооцоод тэгээд цаана нь нэлээн санкцууд явах юм байна. Санкцууд явах юм байна. Энэ дээр бол зарчмын хувьд хариуцлагажуулах гэж байгаа энэ санааг бол ойлгож байгаа юм.

Гэтэл тэр 4 хүндэтгэн үзэх 4 шалтгааны чинь 1нь өвчтэй. Бид нар чинь эмийн чөлөөтэй гээд биччихээд байгаа. Энийг ер нь яаж тогтоох юм? Эмнэлэгт очих болгондоо бичиг авчраад Их Хурлын даргадаа өгөөд байх юм уу? Энэнээс чинь болоод хурал тасалсан, таслаагүй, өвчтэй байсан, эрүүл байсан гээд баахан жижиг сажиг маргаан Их Хурал дээр үүсээд тэр нь эхлэл, төгсгөлгүй ийм юм болоод явчих юм биш биз дээ? Энэ дээр та бүхэн маань бас нэг тайлбар хэлж өгөөч.

Энэ ер нь төсөв хэлэлцэх үед зарчмын зөрүүтэй саналаар ерөөсөө баахан юм эргүүлээд хаячихдаг. Зарим гишүүний хэлснээр бол энд бол далайн дээрэмчний зарчмаар явж байна л гэж үздэг шүү дээ. Хаана, ямар хэмжээний ахиухан мөнгө харагдана тэр болгоноос тастаж аваад, л хөрөнгө оруулалтын зардлыг урсгал зардал руу нь аваачаад л, урсгал зардлыг зураг төсөв байхгүй хөрөнгө оруулалтаар тавиулах гээд л ингээд л гишүүд баахан санал гаргачихдаг. Энийг энэ 71.5-аар нэлээн цэгцэлж өгч байгааг бол би их зөв юм байна гэж ингэж

харж байгаа. Тэгэхдээ энэ 71.5 чинь миний л нэг ойлгохгүй нэр томъёонууд яваад байгаа юм.

Бүсийн хөрөнгө оруулалт гэж ямар юмыг ойлгох юм бэ? Бид нар улсын төсөв дээр бүсийн хөрөнгө оруулалт гэсэн нэртэй тийм юм оруулах ер нь боломж байдаг юм уу үгүй юү? Юуг энэ бүсийн хөрөнгө оруулалт гээд байгаа юм гэж тодруулж өгөхийг хүсэж байна.

2 дугаарт, тухайн салбарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зардалд өөрчлөлт оруулна гэж байгаа юм. Тэгэхэд бид нар чинь төсөв дээр салбарын зардал энэ тэр гэсэн юм байдаггүй санагдаад байх юм. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багц, төсвийн багц гэсэн нэг ийм ойлголт яваад байдаг. Тэгэхээр энэ 2 бүсийн хөрөнгө оруулалт, салбарын эрхлэх асуудлын хүрээний зардал гэдэг энэ 2 ойлголтыг тайлбарлаж өгвөл их сайн байна.

Тэгээд үүнтэй холбогдуулаад бид нар чинь яг эд төсвийн хүрээний мэдэгдлээ эд хэлэлцээд явж байгаа шүү дээ. Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэхэд зарчмын зөрүүтэй саналыг гаргахдаа яг энэ зарчмыг энэ 71.5-д заасан зарчмыг энэ төсвийн хүрээний мэдэгдэлд зарчмын зөрүүтэй санал гаргахад ашиглаж болох уу? Энэ эрх зүйн боломж байдаг юм уу гэсэн. Үндсэндээ ийм 4 асуулт байна аа.

**Б.Пүрэвдорж:** Рэгдэл гуайн асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт хариулна.

**С.Бямбацогт:** Санал хураалттай холбоотой бас манай гишүүд байнга бас шүүмжилдэг. Бас үүнээсээ болоод бас Үндсэн хуулийн цэц дээр хүртэл бас Үндсэн хууль зөрчсөн гээд бас шийдвэр гарч байсан ийм асуудлуудыг бас нэг цэгцлэх ёстой. гэж үзсэн. Энэ хүрээндээ санал хураалтыг чуулганы тухай бүрд нь бас тусгайлан цаг гаргаж, урьдчилж зарлаж, санал хурааж гишүүдийг санал хураалтад оролцох боломжийг 1 дүгээрт нь хангана.

Санал хураалтыг бол идэвхтэй үйлдлээрээ буюу заавал өөрийн биеэр бас оролцож саналаа өгнө. Тэгэхгүй ирцдээ орчхоод гараад явчихдаг, байхгүй ардуур нь дэмжээгүй гэж гараад байдаг. Үүнийг хязгаарлах ийм зохицуулалтууд орсон. Санал хураалтын ирц хүрэхгүй бол санал хураалтад ирцийн санал хураалтын, ирцийн санал хураалт явуулахад байхгүй байсан гишүүд дээр бол нөгөө хариуцлагын санкц бас тусаж байгаа. Тухайн Байнгын хороо чуулганы нэгдсэн хуралдааны 50-аас дээш хувийн санал хураалтад оролцоогүй бол хариуцлага хүлээлгэхээр.

Үүнтэй холбоотойгоор санал хураалтад оролцох боломжийг нь бас нээж өгч байгаа. Санал хураалтын зарыг бол урьдчилж тухайн өдрийн чуулган дээр урьдчилж зарлана. Мөн яг санал хураалт явахаас 10 минутын өмнө ордон даяар 1 минутын туршид хонх дуугарч, санал хураалттай шүү гэдгийг мэдэгдэнэ. Улсын Их Хурлын гишүүн өөрөө мэдэх Улсын Их Хурлын гишүүний ажлын алба нь, туслах, зөвлөхүүд нь мэдэх боломжтой байх. Бүлгүүдийн ажлын алба бас мэдэх боломжтой байх. Ийм зохицуулалтууд гээд үндсэндээ санал хураалтад оролцох боломжийг нь урьдчилж бүрдүүлээд байхад санал хураалтад оролцохгүй бол хариуцлага хүлээлгэхээр ингэж оруулж байгаа юм.

Тийм болохоор үндсэндээ Улсын Их Хурал маань илүү бас ажил хэрэгч саналаа өгөөд явах, санал хураалтын ирц хүрэхгүй байх асуудал бас үүсэхгүй болов уу гэж бодож байгаа.

Бүсийн хөрөнгө оруулалт, салбарын хөрөнгө оруулалтын тухайд ялангуяа төсөв хэлэлцэж байх үед их гардаг. Эрүүл мэндийн салбарын төсвийг хасаад боловсролын салбар руу тавьчихъя гэдэг, зам, тээврийн хөрөнгө оруулалтыг хасаад юу гэдэг юм өөр салбар руу тавьчихъя гэдэг иймэрхүү асуудал гардаг. Хэрвээ гишүүн санал гаргаж байгаа бол тухайн салбар дотор нь зохицуулалт хийх, зам, тээврийн 1 төсөл, арга хэмжээнээс нөгөө төсөл арга хэмжээ рүү. Хөдөө аж ахуйн 1 төсөл, арга хэмжээнээс хасаад нөгөө төсөл, арга хэмжээ рүү хасах.

Мөн тодорхой өөрийн тойрог, тойрогтоо гишүүд чинь бид нар бүсээс том сонгогдож байгаа шүү дээ. Тэр тойрогтоо хөрөнгө оруулалт нэмэх гэж байгаа бол Дорнодоос хасаад Ховд руу нэмдэггүй байх. Хөвсгөлөөс хасаад Өмнөговь руу нэмдэггүй байх. Хэрвээ асуудал ярьж байгаа бол тэр хойд бүс дотроо зохицуулалтаа хийх, хойд бүсийн Хөвсгөл, Булган, Эрдэнэт энэ дотроо зохицуулалтыг хийх, баруун бүсээс сонгогдож байгаа бол Увс, Ховд, Говь-Алтай, Завхандаа зохицуулалтыг хийх иймэрхүү бас нэг зохицуулалтууд байхгүй бол хэт ийш тийш нь төсвийн хөрөнгө оруулалтыг, төсвийн салбарын болон бүсийн, бүс нутгийн хөгжлийн бодлогыг бас ингээд.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж 1 минут хариулья.

**С.Бямбацогт:** Тэр Засгийн газрын оруулж ирж байгаа бодлого, дээрээс нь тухайн тийм үү салбарын бодлого, яамнуудыг, мөн бас бүс нутгийн хөгжлийн бодлогуудыг бас хамаагүй эвдэхгүй байх ийм бас хязгаарлалтуудыг зайлшгүй хийж өгөх ёстой. Ингэж байж гишүүд маань төсвийн зардал нэмэгдүүлэх гэж байгаа бол орлого хасах, зардал нэмэх гэж байгаа бол тухайн зардал дотор нь хооронд нь гүйлгэж шилжүүлэх энийг нь ийм бас тодорхой бодлоготой зохицуулалтууд хийж өгье гэсэн ийм Дэгийн хуульд оруулж байгаа. Өшөө бас сайжруулах санал гарах юм бол үүнийг бас хэлэлцүүлгийн явцад нэмээд өшөө тодорхой өшөө сайжруулаад явах бас боломж нь нээлттэй байгаа.

Өвчтэй гэдэг дээр бол урьдчилж заавал мэдэгдэнэ бичгээр. Үнэхээр гэнэт өвдсөн бол бас хуралдаан даргалагчид бас утсаар мэдэгдэх. Ингэж хүндэтгэн үзэх шалтгааныг бол гарцаа байхгүй нотлох баримтуудаар дараад нь бүрдүүлдэг байх, ингэж өгнө. Тэгэхгүй зүгээр хуралдаанд оролцох.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Рэгдэл гишүүн нэмж тодруулья.

**Д.Рэгдэл:** Яах вэ манай энэ эрүүл мэндийн тогтолцоогоор чинь явж явж нэг эмнэлэгт, эмчид үзүүлэх цаг гэнэтхэн олддог. Тэгээд л тэнд цаг дээр очиж үзүүлэх болчихоор дарга даргалагч нартаа мэдэгдэлгүй ингээд явчих тохиолдол бол гарах магадлал өндөр байдаг юм. Тэгэхээр энэ дээр бол бас л анхаарч үзэх ёстой. юм шиг байгаа юм. Эсвэл тэр эмчид үзүүлсэн эмчээсээ бичиг энэ тэр авчирна гэдэг тиймэрхүү юм баймааргүй, байхгүйгээр зохицуулбал их сайн байна л гэж ингэж бодож байгаа юм.

Юуны хувьд бол энэ зарчмын зөрүүтэй саналын холбогдуулаад энэ төсвийн хүрээг хэлэлцэж байх үед яг саяын энэ таны тайлбарласан зарчмаар ийм заалт нэмэлт оруулж өгөх боломж бий юу байхгүй юу салбар дотор зардал шилжүүлэх, бүс дотор нь зардлыг шилжүүлэх ийм боломжийг Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх үед хэл.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулья.

**С.Бямбацогт:** Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх үед үндсэндээ бид нар бол нэг төсвийн хүрээний мэдэгдэлд макро эдийн засгийн үндсэн хэдэн үзүүлэлтүүд 8-9 тоог л ярьдаг. Энэ дээр бол харьцангуй саналууд гарах нь харьцангуй гайгүй. Яг төсөв хэлэлцэх үед ялангуяа хөрөнгө оруулалттай холбоотой зардлууд бол үндсэндээ төсөл, арга хэмжээ нэг бүрээрээ тодорхой орж ирдэг. Үүн дээр л илүү бас зохицуулагддаг учраас энэ төсөвтэй холбоотой, төсөв хэлэлцэж байх үед л энэ саналууд гарах нь нэлээн зохицуулагдах байх. Мэдээж бас таны ярьж байгаа төсвийн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хэлэлцэх бол энэ арай жоохон хязгаарлагдмал байгаа.

Эрүүл мэндийн шалтгаан дээр бол нэг талаасаа бол ингээд урьдчилж эмчид үзүүлэх, цаг авах, шинжилгээ өгөх, эмчид үзүүлэх бол урьдчилж товлох боломжтой байдаг. Гэтэл өнөөдөр нэг өдөр өөр шалтгааны улмаас очих чуулган, Байнгын хороондоо очих бололцоогүй болохоороо би өвчтэй байгаа шүү гэдгийг л бас хэлж зохицуул.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууна.

**Р.Эрдэнэбүрэн:** 2, 3-хан асуулт асуух гэсэн юм. Энэ дэгтэй холбоотой Дэгийн хууль дээр энэ 126 болсноос хойш орсон нэг гол өөрчлөлт бол хуулийн төсөл хэлэлцэх үеэр бүгд санал онол, санал үгээ хэлэх юу боломжгүй болгосон. Бүлгээс заавал нэр авдаг ийм дэгтэй болгосон. Энэ дэгийг ингээд энэ яагаад хаанаас оруулаад ирэв гээд ингээд хараад байсан тэр Германы хуулийг, Германы Бундестагийн туршлагыг судалж явж байгаад Германы парламент дээр ийм байдаг юм байна дэг журамтай болдог юм гэж яриад тэгээд эндээсээ үндэслээд энэ хуулийг, энэ дэгийг ингэж өөрчилсөн юм шиг байна лээ. Тэгээд тэр нь хэр бодитой юм мэдэхгүй байна.

2 жил ингээд харахад бол энэ бол үнэхээр бид нарт бол тохирохгүй байна. Энэ нэр өгдөг юу бол. Өөрөөр хэлбэл би бол юу гэж боддог вэ гэхлээр бүх юмны энэ үндэс нь бол оролцоо байх ёстой. Бүгд оролцох юм бол өнөөдөр бид нар ингээд Бямбацогт даргаас асуумаар байгаа юм. Энэ Дэгийн хууль, Их Хурлын тухай хууль, энэ Хяналт шалгалтын хуулийг дахиад бүлгүүд дээр дахиж хэлэлцүүлэх боломж байгаа юу? Маш олуулаа яриад тал талаас нь яриад оролцоод бид нар ийм дэгтэй шүү гэдэг дээр бүгдээрээ ойлгохдоо нэг болчхоод явах юм бол дэгээ баримтлах тал дээрээ бүгдээрээ л илүү идэвхтэй болох болов уу гэж ингэж бодож байгаа. Ирц ч гэсэн тэр.

Энэ удаагийн энэ дэг энэ хуулиуд болохлоор ингээд би бол таныг Их Хурлын даргын нүдээр хараад ийм өөрчлөлтүүд хийчихлээ гэж бодоод байгаа. Их Хурлын дарга бол юмнуудаа амархан явуулъя, түргэн явуулъя, дэг журамтай байлгая л гэж бодож л байгаа байх. Тэгэхдээ та чинь бол байнга энэ Их Хурлын

дарга байгаад байхгүй юу энэ цаашаа ингээд зөндөө парламент чинь үргэлжлээд ажиллаад явна. Тийм учраас энэ оролцоог тал талаасаа ярих юмыг сайн нээж өгмөөр байна. Одоо энэ хуулийн төслүүд ч гэсэн ямар ч оролцоо байхгүй. Нөгөө хэдхэн ажлын хэсэг бүлгээс нэр нь өгөгдсөн хүмүүс л нэг хагас хугас мэдээлэлтэй ярьдаг, оролцдог. Бусад хүмүүс ерөөсөө оролцож чадахгүй байна шүү дээ.

Тийм учраас энэ нэр өгдөг юмаа больё. Тэгээд овоо энэ өөрчилж байгаа юм байна гэж бодоод ингээд харсан чинь Их Хурлын даргын зөвлөлөөс минутыг нь яана, хэлэлцэх эсэх юуг нь даргын зөвлөл шийднэ, Их Хурлын дарга шийднэ, тэгээд ирцээрээ энэ тэр гээд ингэчихсэн байна. Тэгэхлээр миний санал бол энэ дэг дээр байгаа энэ хуучин дэг дээр байгаа энэ нэр өгөхтэй холбоотой заалтуудыг л бүгдийг нь хасаад чөлөөтэй болгочихъё.

Тэгээд яах вэ хүн болгон хэлэг, яриг. Одоо нэг зовлонтой асуудал ямар бас асуудал гарч байгаа вэ гэхлээр иргэд, сонгогчид чинь энэ дэг нь ийм гээд ийм юм байдаг юм аа эд нар ингээд үг хэлж чадахгүй байгаа, асуулт асууж чадахгүй байгаа, нэрээ өгч чадаагүй ээ, тэр нэрдээ багтаагүй ээ гэдгийг ойлгохгүй байна. Энэ нэг чимээгүй нөхөр л байгаад байх юм. Нөгөө юу ч ярьдаггүй гээд л. Гэтэл дэг нь цаанаа өөр байгаад байдаг. Тийм учраас юу ч ярьж байж болно. Их Хурлын гишүүд бол олон өнгөтэй хүмүүс байгаа. Буруу, зөрүү ч ярьж болно. Сайн, муу ч ярьж болно. Энэ юуг чөлөөлөөд өгөх боломж байхгүй юм уу? Одоо тэр заавал ч үгүй ирц гээд л бас л ингээд л нэг юман дээр ингээд л үлдээгээд л минут юм хумыг нь барина гээд.

3 дугаарт, Их Хурал дээр хэлэлцэж байгаа асуудлыг яг хэлэлцэх явцад зайлшгүй үг хэлэх, санал хэлэх ийм нөхцөлүүд бий болдог. Хэлэлцэж байх явцад тэгээд.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулья.

**С.Бямбацогт:** Эрдэнэбүрэн гишүүн маш чухал асуудал хөндлөө. Улсын Их Хурлын гишүүдийн оролцоог хангах, иргэдийн бас оролцоог бий болгох энэ чиглэлдээ бол Улсын Их Хурлын тухай хууль чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хуульд бол яг энэ рүү чиглэсэн агуулгууд орж байгаа. Ер нь аль болох илүү нээлттэй байж байж, ил тод байж байж, иргэдийн болон гишүүдийн оролцоо нэмэгдэж байж Улсын Их Хурлаар баталж байгаа хууль тогтоомжууд ард иргэдэд олон түмэнд илүү ил тод болно, нээлттэй болно. Ач холбогдол нь иргэд ойлгоно. Тэр хэмжээгээрээ хууль хэрэгжих бололцоо боломж бий болно. Бүрдэнэ хууль хэрэгжих.

Мөн бас Улсын Их Хурлын баталж байгаа хууль тогтоомжийг иргэд ойлгодог болоод, гишүүд маань илүү хариуцлагатай оролцдог болоод Их Хурлын үйл ажиллагаа сайжраад эхлэхээр Их Хуралд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ, төрд итгэх иргэдийн итгэл сэргэнэ. Энэ үүднээсээ үндсэндээ энэ өргөн барьж байгаа хуулиуд бол Их Хурлын даргыг илүү эрхтэй болгосон зүйл ерөөсөө байхгүй. Их Хурлын гишүүдийн болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн. Энэ үүднээсээ таны саяын хэлж байгаа зөвхөн бүлгийн даргаар дамжуулж асуулт асуух, үг хэлэх нэр авдаг байсан бол ингэхгүй. Тухайн Байнгын хороо, чуулганы хуралдаан дээр Их Хурлын гишүүд өглөө ирээд л кнопоо дараад л чуулганы

хуралдаанд оролцоод л чөлөөтэй асуултаа асуух, чөлөөтэй нэрээ хэлэх энэ боломжийг нь бий болгож өгч байгаа.

Даргын зөвлөл дээрээс хуучин тогтоодог байсан цагтай байсан. Энэ цагийг нь бас тогтоодгоор хэвээрээ байя. Энэ цаг дотроо багтаагаад хэн ч ямар ч гишүүд нь асуулт асууж, үгээ хэлэх боломжийг нээж өгч байгаа. Мөн бас 4 минутаар асуугаад л заавал 4 минутаар хариулна гэдэг байсан бол энэ 8 минутынхаа хугацаанд 1 минутаар асуугаад 1 минутаар хариулах, 8 удаа асуугаад 8 удаа хариулт авах энэ боломжийг бий болгож өгч байгаа.

Худлаа мэдээлэл гэх юм бол, буруу мэдээлэл гэх юм бол маш хариуцлага тооцдог байх энэ заалтууд өгч байгаа. Зайлшгүй шаардлагатай. таны ярьж байгаа асуудлууд иргэдийн мэдэх эрх хангагдахгүй, гишүүдийн ойлголтын зөрүү арилахгүй бол асуулт, хариултыг нь горимоо зогсоогоод мэтгэлцэх ийм горим руу шилжээд чөлөөтэй мэтгэлцэж байгаад иргэдийн итгэл үнэмшил их гишүүдийн ойлголтын зөрүү арилсан үед нь санал хураалтыг явуулах, байр суурь илэрхийлэх, саналаа өгөх энэ боломжийг бий болгох гээд иймэрхүү байдлаар гишүүдийн оролцоог илүү хангах тал дээр бол нэлээн тийм өөрчлөлтүүд орж ирж байгаа.

Тийм болохоор юу гэдэг юм энэ бол үндсэндээ Их Хурлынхаа л үйл ажиллагааг сайжруулах, Их Хуралд итгэх, парламентынхаа засаглалыг бэхжүүлэх, иргэдийн оролцоо, гишүүдийн оролцоотой болгох руу чиглэсэн тодорхой зохицуулалтууд гол нь орсон гэдгийг бас хэлье.

**Б.Пүрэвдорж:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбатын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 57 дугаар сургуулийн Ууганчимэг багштай 12<sup>а</sup> ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Багшид сурган хүмүүжүүлэх ажлын болон сурагчдад сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Эрдэнэбүрэн гишүүн тодруулъя.

**Р.Эрдэнэбүрэн:** 2 зүйл дээр тодорхой хариулт авч чадсангүй ээ дарга. Нэг нь бол энэ хуулийн төслийг жоохон дахиад өргөн хүрээнд хэлэлцүүлэх үүднээс бүлгүүд рүү явуулчих боломж байна уу? 2 дахь нь хойшлуулж байгаад, ярьж байгаад нэлээн сайн чанамаар байх юм.

Хоёрт нь бол тэгээд л мэтгэлцээний горимд шилжүүлэх эрх нь хэнд байх юм жишээлбэл? Мэтгэлцээний горимд хэн шилжүүлэх юм? Гишүүд санал гаргаад шилжүүлэх юм уу Их Хурлын дарга шийдээд яваад байх юм уу жишээлбэл?

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Мэтгэлцээний горимд шилжихэд гишүүдийн саналаар энэ асуудлын ойлголтын зөрүүг арилгах, алга болгомоор байна. Илүү нэгдсэн ойлголттой зөв, буруу, үнэн, худлыг нь бас ялгаж шүүж хармаар байна. Мэтгэлцээний горимд шилжүүлэх гишүүд санал гаргавал гишүүдийн саналаар мэтгэлцээний горимд шилжинэ.

2 дугаарт нь бүлгүүд дээр бол өнгөрсөн 3, 2 сард ажлын хэсэг байгуулсан юм байна лээ. Учрал дарга Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулаад 2 сар, 3 сард хэлэлцүүлэг хийгдээд 4 дүгээр сард бас бүлгүүд дээр танилцуулаад би дарга болсноос хойш бас даргын дэргэдэх зөвлөл дээр нэлээн хэдэн удаа ярьсан. Улсын Их Хурлын бүх 126 гишүүнээс санал авсан бичгээр. 126 гишүүний ажлын алба, туслах, зөвлөхүүдээс санал авсан. Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгээс санал авсан. Ингээд үндсэндээ бол бүх саналуудыг нэгтгээд Их Хуралд Их Хурлын гишүүд өргөн барьсан байгаа. Шаардлагатай гэж үзэх юм бол бүлгүүд дээр хэлэлцэх эсэх шийдсэний дараа бол угаасаа ажлын хэсэг байгуулагдана. Энэ үедээ бүлгүүд өшөө сайжруулаад явах боломж нь нээлттэй байгаа. Бүлгүүд нээлт.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

**Л.Соронзонболд:** Энэ 8.4 дүгээр заалт дээр хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт санаачилсан болон төлөөлөх гишүүнийг оролцуулна гэсэн байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр яах вэ тодорхой хэмжээний ийм хязгаарлалт байхгүй байсан уу гэдэг асуудал байгаад байгаа. Яагаад гэхээр бас гишүүд маань бол мэдээж тодорхой зорилгоор тухайн хуулийн төслийг бол санаачилж байгаа. Тэгээд хэрвээ хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгтээ 100 хувь өөрсдөө орчихвол яах юм гээд нэг ийм асуулт байгаа. Энэ дээр тодорхой хэмжээний хязгаарлах заалт байна уу гээд.

Энэ 8.10 дээр болохоор бол энэ Байнгын хороо, Хянан шалгах түр хорооны хуралдаан таслуул эд нар гээд яачихсан байгаад байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсэгтэй холбоотой бол ерөөсөө заалт ороогүй юм байна гэж ойлголоо. Тэгэхээр хэрвээ тухайн хүн тасалсан гээд хасагдсан тохиолдолд орных нь хүнийг асуудлыг яаж шийдэх юм бэ гэдэг нэг ийм энийг ер нь яаж тооцсон бэ гээд асуулт байна.

Энэ 7.4 дээр нэг бичгээр заавал өг гэсэн байгаа нөгөө байхгүй тохиолдолд. Тэгэхээр энийг e-mail-ээр гэж нэмж оруулбал яав ямар вэ гэж асуух гээд байгаа юм. Өөрөөр цахим харилцаагаар бас асуудлуудаа шийддэг байхгүй бол дандаа албан бичгээр заавал өгөх шаардлага байхгүй байх л гэж үзээд байгаа юм.

10.1 болон 10.3 дээр аливаа асуудал яригдахдаа заавал 65 гишүүн байж байж санал хураалт явагдах болж байгаа. Тэгэхээр хэрвээ аль ч тохиолдолд тухайн хурлын зааланд гишүүн байхгүй байлаа гэхэд хаслаа гэхэд бол энэ маань 65 дээр очиж л зогсох юм байна л гэж харагдаад байна. Тэгэхээр энэ дээр бас нэг асуулт асууя.

Энэ 15.7 дээр 30 хоног гээд заасан. Энэ ажлын 30 хоног яриад байна уу хуанлийн 30 хоног яриад байна уу?

33.2 дээр энэ яаралтай горимоор орж ирж байгаа Засгийн газраас болон бусад газраас орж ирж байгаа асуудлуудыг хэлэлцүүлэггүйгээр, хэлэлцүүлэг зохион байгуулалгүйгээр шийдвэрлэнэ ээ гээд байгаа. Тэгэхээр энэ хэлэлцүүлэхгүйгээр явах ямар шаардлага байгаа вэ гэдэг асуулт байна. Тэгээд

яаралтай горимоор ингээд орж ирдэг хэдэн асуудал байдаг юм бэ гээд нэг ийм асуулт байна.

Дараагаар нь болохоор бол энэ 71.5 дугаар заалтыг уншихаар бүс бүрд жишээлбэл төсвийг тэнцүү хуваарилдаггүй шүү дээ тээ? Тэгэхээр ингээд тухайн гишүүн тодорхой санал гаргалаа гэхээр өөрийнхөө бүсийн доторх асуудлаасаа тодорхой задал төсвийг хуваарилах ийм асуудал үүсэх гээд байна л даа. Тэгэхээр энэ маань ер нь бүсүүдэд төсвийг хуваарилахдаа тэнцүү хуваарилна гэсэн үг юм уу? Яг энэ дээр яг ямар асуудал байна вэ?

Дараагаар нь болохоор бол салбарууд яамнууд маань болохоор бол төсөв харилцан адилгүй авдаг. Тэгэхээр тухайн яам тухайн яам салбарын асуудал дээр төсвийн хуваарилалтыг яаж тооцох юм бэ гээд нэг иймэрхүү асуудал гарч ирж байна.

Нэг тодорхойгүй 2 асуулт байгаа юм. Энэ бид нар жилийн хөгжлийн төлөвлөгөөг ингээд Эдийн засгийн байнгын хороогоор бол ярилцдаг, гишүүд маань маш их санал өгдөг. Тэгээд орж ирсэн жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр маш их өөрчлөлт ордог. Тэгэхээр энэ жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэхтэй холбоотой асуудлууд дээр ямар тодорхой саналууд, бас бодлого оруулж ирж байгаа вэ? Энэ дээр би зүгээр яг шууд уншихаар бол харагдахгүй л байгаад байна л даа.

Дараагийн асуудал болохоор бол энэ Их Хурал ингээд завсарлалчихсан байх хугацаанд ажлын хэсэг хуралдах шаардлага үүсдэг. Гэтэл нөгөө гишүүд маань бас томилолттой, янз бүрийн ажлуудтай байгаад байдаг. Яг ажлын хэсгийн хуралд оролцож амждаггүй нэг ийм асуудал үүсдэг. Тэгэхээр нөгөө нэг ажлын хэсгийн ирцийн асуудал үүснэ. Энэ асуудлыг ер нь яаж зохицуулахаар харсан бэ гэсэн ийм асуултууд байна.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Сүүлээс нь эхэлчихье. Ажлын хэсэгт хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцохгүй бол оролцоог бол мэдээж тэр чинь тасалсанд тооцогдохгүй. Хүндэтгэн үзэх шалтгаангүй ажлын хэсгийн хуралдаанд оролцохгүй бол хасна. Хассан тохиолдолд оронд нь хүн оруулах бол нээлттэй. Ийм байдлаар зохицуулсан байгаа.

Яаралтай горимоор асуудлыг зөвхөн Засгийн газар оруулж ирдэг. Засгийн газар оруулж ирэхдээ үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой нэн чухал асуудал гэж үзсэн тохиолдолд яаралтайгаар хэлэлцдэг. Хэлэлцэхдээ хэлэлцүүлэг угаасаа хийдэггүй ийм дэгтэй байгаа. Харин энэ дээр нэмж орж байгаа заалт бол яагаад, ямар учраас энэ нэн яаралтай горимоор орж ирж байгаа юм бэ гэдэг талаар танилцуулга хийнэ. Танилцуулга хийгдээд гишүүд ийм учраас яаралтай юм байна, тийм учраас яаралтай хэлэлцэхийг нь дэмжье гэж саналаа өгөх боломжийг нь хангаж өгч байгаа.

Хууль санаачлагчийн төлөөлөл яагаад ажлын хэсэгт орж байгаа юм бэ гэж. Бүгд 100 хувь орохгүй төлөөлөл орно. Энэ Тэмүүжин гишүүн гаргасан санал. Яагаад гэвэл гишүүдийн болон хууль санаачлагчийн санаачилсан хуулийн төслийг

ажлын хэсэг хэлэлцэж байх явцдаа орвонгоор нь өөрчилчих, үзэл баримтлал нь алдагдуулчих ийм эрсдэлүүд байдаг. Сайн мэдэхгүй, танихгүй учраас ойлгоогүй учраас. Тийм учраас хууль санаачлалын төлөөллийг оруулж, ямар учраас, ямар зорилгоор, ямар үзэл баримтлалтайгаар ийм хуулиуд санаачилсан юм бэ гэдгээ санаачилсан хуулийнхаа үзэл баримтлалыг хамгаалах боломжийг бий болгож өгч байгаа юм. Ингэж оруулж байгаа юм, ийм агуулгаар.

Мөн Засгийн газрын гишүүд нөгөө эрхэлсэн тухайн салбарынхаа Байнгын хороонд харьяалагдахгүй хорьчихсон байсан. Үүнийг бол тухайн харьяалагдах өөрийнхөө асуудал хариуцсан Байнгын хороондоо орж, тэн дээр бас Засгийн газар өөрийнхөө салбар яамныхаа бодлогыг зөв таниулж ойлгуулах энэ бас боломжийг бий болгож өгөхгүй бол Засгийн газрын гишүүн, эрхэлсэн сайд нь мэдэхгүй байх, тухайн асуудал хариуцсан Байнгын хороо нь тэр бас Засгийн газрын болон тэр эрхэлсэн сайдын бодлогоос өөр байдлаар шийдвэр гаргах ийм эрсдэлүүд байгаад байдаг учраас ингэж зохицуулалтыг хийж өгсөн.

Дээрээс нь хуанлийн 30 хоног уу, ажлын 30 хоног уу гэдэг дээр ажлын биш, хуанлийн 30 хоногийн хугацаанд энэ асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх ийм зохицуулалтуудыг оруулж өгсөн.

Мэдээж цахим технологи хөгжиж байна манай бас Их Хурлын энэ цахим шилжилтийг e-parliament дээрээс нь d.digital, d.parliament, d.petition бусад бас албан бичгээ солилцох “Able” гээд программууд байж байгаа. Энэ бас энэ дотоод үйл ажиллагаа зөвхөн цаасаар биш цахимаар хийх томоохон шилжилтүүдийг хийх зохицуулалтууд дэгийн хууль дээр сууж өгсөн байгаа.

Тэгэхээр цаашдаа бол аль болох цааснаас татгалзах, илүү юу гэдэг юм гар утаснаасаа, гэрээсээ бусад байдлаар мэдээллээ авч, мэдээллээ солилцох ийм боломжуудыг бий болгоно. Илүү бас зардал бууруулах, илүү хурдан хугацаанд хугацаанд мэдээллээ солилцох ийм боломжуудыг бий болгох зохицуулалтуудаас орсон байгаа. Ганцхан юу гэдэг юм.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Энэ гишүүд ерөөсөө асуултынхаа минутад багтаж асууна шүү. Ер нь сурах хэрэгтэй. Ер нь бол КОВИД-ын үед 2 минутаар асууж үг хэлдэг тэнд нь 2 минутын дотор 3 агуулга ярьж сурсан байсан шүү дээ. Тэгээд Соронзонболдоос дахиад нэмж тодруулъя.

**Л.Соронзонболд:** Үгүй ээ яах вэ би нөгөө 71.5 дээр гээд асуусан л даа. Өөрөөр хэлбэл нөгөө нэг төсвийн төсөлд санал өгч байгаа гишүүний оруулж байгаа санал нь тухайн бүстэй холбоотой бол бүсийн дотор хөдөлгөөн хийгдэнэ. Тухайн нэг салбар яамтай холбоотой бас салбар яаманд нь хийгдэнэ ээ гээд заалт орчихсон байна л даа. Тэгээд ингээд бодохоор чинь нөгөө бүсүүдэд тэнцүү хуваарилах асуудал үүсэх асуудал гарах юм биш үү гээд байхгүй юу. Яам, салбаруудад бол угаасаа ялгаатай хийж байгаа бол мэдэж байгаа. Тэгээд энэ дээр тодруулаадхаач ээ гээд байхгүй юу.

Жишээлбэл, түрүүн өөрөө ярьсан шүү дээ нөгөө Ховдын баруун бүсийн асуудлыг зүүн бүс рүү хуваарилдаг ч гэдэг юм уу гээд. Тэгэнгүүт нөгөө яг бүс болгонд адилхан хуваарилдаггүй шүү дээ угаасаа. Тэгэнгүүт наадах чинь өөрөө нэг тийм асуудлаар аваачиж байгаа юм биш үү л гэж асуугаад байхгүй юу.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Бид нар бол урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, дунд хугацаагаа баталж чадахгүй байгаа. Богино хугацааны таван жилийн үндсэн чиглэл, дөрвөн жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дээрээс нь жилийн хөгжлийн төлөвлөгөө гэсэн энэ урт, дунд, богино хугацааны бодлогын бичиг баримтууд дээр л үндэслэж, үүн дээр тулгуурлаж үүнийг хэрэгжүүлэх зорилгоор л улс, Монгол Улсын Их Хурал төсөв, төлөвлөгөө баталдаг. Энэ дээр суусан асуудлууд суух ёстой. Үүнээс хальсан асуудлууд би суух боломжгүй.

Ингэхдээ тухайн салбар яам, Засгийн газар энэ бас бүсийн хөгжлийн бодлогуудыг тэгш уялдуулах, төвлөрлийг сааруулах бүс нутгуудаа, ганцхан Улаанбаатар гэсэн ганцхан таталцлын төвтэй биш Улаанбаатараас өөр бусад таталцлын төвүүдтэй болох энэ бодлогоо бол бид төлөвлөгөөгөөрөө Засгийн газарт чиглэлээ өгдөг. Засгийн газар төсөв оруулж ирдэг. Энэ нь хангагдаагүй бол бид нар үүнийг бас дотор нь хөдөлгөх боломжийг нээж өгөх ёстой. Энэ саналыг бас манай Наранбаатар гишүүн бас гаргасан байгаа. Тийм учраас.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхтуяа:** 2026 оны 04 сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын дарга Бямбацогтод 2 тодорхой асуудлаар санал оруулж байсан тийм ээ.

1 дүгээрт нь бол мэдээж Боловсролын байнгын хороог эргүүлж ажиллагаанд оруулъя гэсэн саналыг бол би өөрөө энэ бланкаар оруулж байсан юм.

2 дугаар асуудал бол нөгөө хууль, Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлаад өргөн мэдүүлчихдэг. Тэгээд хав даруулаад одоо миний хууль бол ингээд хэлэлцэх эсэх нь явахгүй бараг ингээд жил тойрч байгаа шүү дээ. Тэгээд энийг дэгийн хуульд яг яаж оруулсан бэ гэдгийг Бямбацогт даргаас асуумаар байна.

Тэгээд 2 дугаар санал бол нөгөө хууль санаачлагч нь өөрөө нөгөө хуулийнхаа ажлын хэсэгт орохгүй гэсэн ийм юм байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хууль санаачлагч энэ яг ажлын хэсэгтээ ороод ажиллах боломжоор хангах тийм журам, заалтыг оруулж өгөх шаардлага байгаа гэж үзэж байгаа юм.

3 дугаарт нь түрүүн Бямбацогт дарга намайг онилж нэг кэйс жишээ болгож ярьсан. Улс орныхоо эрх ашигт харшилсан ийм санал оруулсан гишүүдийг яана яана ч гэнэ вэ? Би бол Монголын боловсрол Монголын ирээдүйн төлөө энэ улс орны ДНБ-ий 7 хувийг боловсролдоо зарцуулъя гэдэг саналыг л гаргаж байгаа. Тэрнээс энэ улс орныг үймээн самуунд уриалан дуудаагүй шүү дээ. Тэгэхээр ингэж намайг ийм буруугаар мушгиж тайлбарласныг чинь бас их гайхсан. Тэгээд энэ дээрээ та бас хариулт өгнө үү гэж хэлмээр байна. Тийм би бол энэ улс эх орны эсрэг гэмт хэрэгтэн бараг болчихсон шүү дээ түрүүн.

Боловсролын салбарт ДНБ-ий 7 хувь, төсвийн зардлын 20 хувь. Ингэж оруулсан миний энэ саналыг эргүүлж мушгиж ингэж ярьсанд бүр гайхаж байна. Тэгээд ер нь бол түрүүн Мэндсайхан сайд хэлсэн шүү дээ Сангийн сайд ДНБ-ий 7 хувь руу Мөнхтуяа гишүүн ээ орчихсон шүү таны санал ер нь бол болчихсон шүү гэсэн. Тэгэхээр энэ чинь боломжгүй эд биш байгаа биз дээ. ДНБ-ий 7, төсвийн зардлын 20 хувьд бол хүрчихсэн гэж хэлсэн шүү Мэндсайхан сайд. Тийм учраас миний энийг ингэж гуйвуулж мушгиж олон түмний нүдэн дээр Мөнхтуяагийн энэ санал бол болохгүй буруу санал гэсэн ийм буруу ойлголтоор та бас ярьж болохгүй байх. Энэ дээрээ бас надад хариулт өгнө үү?

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Мөнхтуяа гишүүнд болон бас иргэдэд тийм буруу ойлголт өгөхөөр хариулт өгсөн бол би бас уучлалт хүсье. Бид нар энэ улс орныхоо төсөв, санхүү, эдийн засгийн нөхцөл байдлаа бас мэдэж, нөгөө хөнжлийнхөө хэрээр нөгөө хөлөө жийж л асуудлаа шийдэх ёстой л доо. Айл өрх ч гэсэн өрхийнхөө орлого, зардлаа тооцож энэ жил манайх ийм орлоготой байх юм байна, ийм орлоготой байх учраас энэндээ таарсан ийм зардал гаргая, энэ жил орлого багатай байх юм байна тийм болохоор энэ зардлаа таная гэдэг шийдлийг гаргадаг. Түүнтэй адилхан бид нар бас улс орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдал маань ямархуу байх нь төсвийн хүрээний мэдэгдэл, тэгээд тодорхой хязгаарууд гарчихдаг.

Үүнээс давсан асуудлыг нэг талдаа яриад эхлэхээр нөгөө талдаа тэр давсан зардлаа яаж санхүүжүүлэх вэ, төсвийн алдагдалтай болгох вэ, эс үгүй бол бусад салбарын зардлуудаасаа хасах уу гэдэг ийм эрсдэлүүд үүсдэг учраас боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг, зардлыг ДНБ 7 хувь, төсвийн нийт зардлын 20 хувь болгоё гээд явчихдаг. Тэгвэл нөгөө талд нь төсвийн алдагдлаа хэвээр нь төсвийн орлого, зарлагыг тэнцүү байлгахын тулд бид нар буцаагаад бусад салбарын зардлаас танах шаардлагатай болно. Эрүүл мэндийн салбараас ч гэдэг юм уу, эсвэл хөрөнгө оруулалтаасаа танах ч гэдэг юм уу. Эс үгүй бол алдагдалтай төсөв батлаад өрөө нэмэгдүүлэх шаардлагатай болно.

Иймэрхүү макро эдийн засгийн болон төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүдийнхээ хүрээнд л саналаа гаргадаг байх ёстой. юм. Таны гаргасан санал үүнээс даваад байсан учраас иймэрхүү саналуудыг л цаашдаа гишүүд гаргах нь зөв үү буруу юу? Иймэрхүү бас саналууд гарах юм бол түүн дээр Байнгын хорооны саналаар, гишүүдийн саналаар энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газар болон мэргэшсэн бас шинжээчдээр, экспертүүдээр бас дүгнэлт гаргаж тодорхой зөвлөмжийг гаргадаг байя гэсэн ийм зохицуулалтууд орж байгаа гэдгийг бас хэлье.

Таны санаачилсны санал өгсний дагуу бол Хүний хөгжлийн байнгын хороог задалж байгаа. Боловсрол шинжлэх ухааны байнгын хороо, нөгөө талд нь Эрүүл мэнд, хүний хөгжлийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо гэж. Яах аргагүй маш том Байнгын хороо болчихоод энэ эрүүл мэндийн асуудал, боловсролын асуудал, нийгмийн хамгааллын асуудал нийлчхээд ингээд энэ Байнгын хороо маш өндөр ачаалалтай асуудлаа хэлэлцэж дийлдэггүй байсан учраас яг таны гаргасан саналын дагуу Боловсрол, шинжлэх ухааны байнгын

хороог тусад нь бие даасан Байнгын хороо болгож салгасан гэдгийг бас танд хэлье.

Таны өргөн мэдүүлсэн хууль бас яг энэ шалтгаанаар ингэчихсэн байж байгаа. Гэхдээ энэ бол яг таны бас гишүүд олон гишүүд гаргасан. Улсын Их Хурлын дарга дээр ингээд өргөн мэдүүлэх гэж байгаа хуулийн тов дарааллыг нь тогтоохгүй удаадгийг больё 1 сарын хугацаанд тогтоодог больё гэж байгаа. Урьд нь бол хэдэн жилээр нь хүлээж авдаггүй байсан бол 1 сарын хугацаанд ямар ч хууль өргөн мэдүүлсэн бай өргөн мэдүүлэхийг хүлээж авч тов дараалалд оруулдаг байх энэ зохицуулалт орж байгаа. Санаачлагч ажлын хэсэгт орж болно гэж байгаа. Тийм.

**Б.Пүрэвдорж:** Тодруулъя Мөнхтуяа гишүүн.

**Ц.Мөнхтуяа:** Бямбацогт даргадаа баярлалаа бас ингээд гишүүдээсээ авсан саналаа ажил хэрэг болгоод ингээд хуулийн төсөл болгоод оруулж ирж байгаад баярлалаа.

Ер нь бол уул уурхай, байшин барилга, зам гүүр болохоор маш их хэмжээний мөнгө улс төсөвлөөд гаргадаг. Боловсролын салбар дээр болохоор харамлаж болохгүй ээ. ДНБ-ий 7 хувь руу хүрчихсэн, хүрэхийг нь мэдээд би энийг энэ саналыг оруулсан шүү дарга аа. Тэрнээс би ерөөсөө тэгээд болохгүй юмыг болгоё гэж зүтгээгүй шүү гэдгийг бас хэлье.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Ойлголоо. Тэгээд санаачилсан гишүүдийн төлөөлөл орж болно гэж байгаа. Яагаад гэвэл ажлын хэсэг маань, ажлын хэсэг дээр бас мэдээллээр хангах, ойлголтын зөрүүг арилгуулах үүднээс төлөөлөл орж болно ажлын хэсэгт. Энэ санаа хууль санаачилсан гишүүний төлөөлөл нь. Олон гишүүн санаачлах юм бол. 1 гишүүн санаачилсан бол өөрөө орж болно. Гэхдээ ажлын хэсэг ахлахгүй, ахлахгүй. Тийм ахлахгүйгээр орж болно. Гэхдээ бүгдээрээ орохгүй. Олон гишүүнээс бүгдээрээ орохгүй төлөөлөл нь л орно.

**Б.Пүрэвдорж:** Энхбатын Болормаа гишүүн асуулт асууна.

**Э.Болормаа:** Чуулгандаа оролцоогүй, хурлаа тасалсан гишүүдэд ямар ёс зүйн хариуцлага тооцох вэ гэдгийг одоо энэ Дэгийн хуулиараа нарийвчилж оруулж ирж байна. Надад бол нэлээн харамсалтай бараг онигоотой мэт л санагдаж байна. Үг хэлэх эрхийг нь хаана гэдэг бол байж болохгүй ээ. Аливаа гишүүн ёс зүйн асуудал гаргахад тэр хувь хүн дээр хариуцлага яригдах болохоос биш төлөөлж байгаа иргэд нь түүнээс болж хохирч болохгүй. Тэгэхээр үг хэлэх эрхэд нь бол халдахыг бол дэмжихгүй байна.

Дараагийн асуудал нь цалингаас нь хасна. Тэгээд төсвийн тойрогтоо ажиллах төсвийнх ч юм уу, гишүүний төсвөөс нь хасна гэж байна. Тэрийг тоохгүй хүн энэ дотор асар олон байгаа шүү дээ. Их Хурал байтугай Монголын топ баячууд энэ дотор сууж байгаа шүү дээ. Тэгээд цалингаараа амьдардаг бид хэд л ингээд л ирцээ бүрдүүлээд л суудгаараа бараг сууна. Тэгэхээр яриад байгаа, нийгэмд тулгамдаад байгаа орлогын тэгш бус байдал бид нар бас татвар,

торгууль, аливаа юм тавихдаа энийг бодох ёстой. Тэр татвар, торгуулийг чинь тоодоггүй нэг хэсэг байдаг. Тэр бодит амьжиргаанд нь нөлөөлдөг нэг хэсэг байдаг. Өнөөдөр яг тийм үзэл бодлоор энэ асуудалд хариуцлагад хандсан байна л даа. Жишээлбэл, Улсын Их Хурлын дарга бид хоёр 1 тойргоос сонгогдсон. Магадгүй тойрогт ажил гараад хаа байсан 1500км-ийн цаашаа бид хоёр хоёулаа явж ажиллах хэрэг гаръя. Түүнээсээ болж чуулганаа таслах хэрэг гарлаа. Тойрогтоо ажлаа хийж байгаа, янз бүрийн л юм болно. Тэгээд цалингаа хасах дээрээ тулбал энийг би огт хувь хүн дээр битгий бодоорой та бид 2-т энэ буух байдал нь их өөр байх аа. Тэгэхээр энэнээс өөр ямар байдлаар хариуцлага гэдэг асуудал яригдаж байгаа вэ? Энэ хариуцлага, чуулганы ирц гэдэг юмаар сенсацлаад харамсалтай нь жижиг асуудал бид нар яриад байна шүү дээ. Энэний оронд тэр үндэслэлгүй хөрөнгөжсөн асуудлаа ярья, авлига албан тушаалын асуудлаа ярья. Тэр хуулиудаа хэлэлцье л дээ. Тэрийгээ бид нар хэлэлцэхгүй суугаад байна шүү дээ.

Саяхан нэг олон улсын байгууллага нээлттэй засаглалын төслөөр нэг айхтар тооцоо, судалгаа гарсан байна лээ. Монгол Улсын 5.8 их наядын тендерийн 70 хувийг нь 10-хан компани авсан байна. 10-хан компани 5.8 их наядын тендерийн 70 хувийг нь авсан байна. Тэгээд л тэн тендерээ зохицуулж яваад л танил талдаа тэгж яваад энэ цалингийн 20, 30 хувь хасагдах огт сонин биш шүү дээ. Тэгэхээр асуудалдаа бид нар бодитой орж чадаж байна уу? Иргэд хариуцлага хүсэж байгаа үнэн. Болормаа хэдэн минут энэ сандал дээр сууж байна уу үгүй юу, ямар үг хэлж байна уу үгүй юу гэдэг зүйлээс илүүтэйгээр шударга, ил тод, үнэн ажиллаж чадаж байна уу олон нийтийнхээ эрх ашгийн төлөө. Тэр янз бүрээр хэмжигдэх зүйл шүү. Энэ сандал дээрээ суудаараа тоологдох зүйл биш шүү. Тэгэхээр бүгдээрээ том асуудалдаа ул суурьтай анхааръя.

**Б.Пүрэвдорж:** Үг хэлчихлээ шүү дээ. Хариуцлагын өөр системийн асуудал. Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Улсын Их Хуралд Улсын Их Хурлын гишүүдэд том асуудал, жижиг асуудал байхгүй. Улсын Их Хурлын гишүүд ард түмнийг төлөөлөх, хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн 3 бүрэн эрхтэй. Энэ эрхээ л хэрэгжүүлэх ёстой. Ард түмнийг төлөөлөх эрх гэдэг маань тэр төлөөлж байгаа юугаар илэрхийлэх вэ? Хуралдаа суух, ажлаа хийх, санал хураалтдаа өөрийн биеэр идэвхтэй оролцож, дэмжиж болно, дэмжихгүй байж болно. Өөрөөрөө ард түмнийг төлөөлөх эрх л биелүүлэх үүрэгтэй.

Энэ үүргээ биелүүлэхгүй байгаа, ажлаа хийхгүй байгаа, хуралдаа суухгүй байгаа таны хэлдгээр тийм үү хувийн ажлаа хөөцөлдөөд байгаа, гадуур, дотуур тэр тендер хөөцөлдөөд байгаа тэр нөхдийг чинь л хариуцлагатай болгоё гэж байгаа юм. Хариуцлагатай. Ийм болж байж Их Хурлын үйл ажиллагаа сайжирна, ард түмнийг төлөөлөх бүрэн эрх нь хэрэгжинэ.

Их Хурлын гишүүдийн төлөөлөх, ард түмнээ төлөөлнө гэж ирчхээд ажлаа хийхгүй байна шүү дээ. Зүгээр хувийн хэвшилд ажиллаж байгаа хувийн компанид ажилдаа ирэхгүй бол, хоцрох юм бол, төрийн байгууллагад ажилдаа ирэхгүй бол, хоцрох юм бол цалингийн арга хэмжээ авхуулдаг дараад нь ажлаас халагддаг шүү дээ. Их Хурлын гишүүд яахаараа тэгээд 7 хоногт 2-хон удаа чуулгантай. 7 хоногт 2-хон удаа Байнгын хороотой, 1 өдөр бүлгийн хуралтай. Энэ хуралдаа ирдэггүй ирээгүйн төлөө үг хэлэх эрхийг нь хязгаарлаад, цалингаар нь торгоно гэхээр наад

2 чинь арай хатуу байна, өөр шийтгэл байж болохгүй юм уу, бараг шийдэхгүй байж болдоггүй юм уу, энэ чинь жижигхэн асуудал байна шүү дээ гэж ярьж байгаа нь жоохон зохимжгүй байна. Олон улсад байдаг жишиг. Энэ маш олон улсын туршлага яасан. Сануулах, үг хэлэх эрхийг нь хасах, нийтэд мэдээлэх, тодорхой санхүүжилт цалинг нь хасах ийм л дэгтэй юм байна лээ. Германы Бундестаг гэх юм бол санал хураалтад оролцоог бол 2000 еврогоос 4000 еврогоор торгодог юм байна лээ.

Ийм учраас тэр санал хураалтад оролцох гээд тэр г парламентын гишүүдэд ерөөсөө санал хураалт гэнгүүт л бүгд л хаана юу хийж байсан бүгдийг нь хаяад л гүйлдээд л гүйлдээд л санал хураалтад оролцдог юм байна лээ. Ийм зохицуулалтуудад бүгд орсон байгаа. Тэр сануулах, үг хэлэх эрхийг нь хасах, нийтэд ирцийг нь мэдээлэх, дээрээс нь тодорхой төрлийн санхүүжилт, цалинг нь хасах ийм зохицуулалтуудаас өөр зохицуулалтууд олон улсад алга байна. Олон улсад байж байгаа хэрэглэдэг бүх туршлагуудыг судлаад оруулж ирсэн зохицуулалтууд нь эд нар. Тийм болохоор бас үүнээс өөр сайн зохицуулалтууд байх юм бол хэлэлцүүлгийн явцад нэмж оруулах, өөрчлөх боломж нь Их Хурлын гишүүдэд байгаа.

**Б.Пүрэвдорж:** Энхбатын Болормаа гишүүн. Эхлээд хууль санаачлагч Лодойсамбуу бас нэмж хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Болормаа гишүүн асуусан дээр, түрүүн ярьсан дээр нэг зүйлийг тодруулж хэлэхгүй бол өчигдөр Байнгын хорооноос хойш бас гишүүд маань яриад байгаа энэ гишүүний тойрогтоо зарцуулах мөнгө гэж ерөөсөө байхгүй хуулиараа ч тэр юун дээрээ ч тэр. Гишүүний төсөв, гишүүний зардал гэж ерөөсөө байхгүй. Одоо нийтдээ ингээд нэг гишүүдэд үйл ажиллагаанд нь гээд нэг төсөв баталж өгдөг. Түүнээсээ тэр дотроосоо зөвлөх, туслахын цалин бүх зардал тэрэндээ ороод явдаг.

Тэгэхгүй бол ингээд гишүүд нь бас нэг цалингаасаа гадна бас дахиад нэг энэ тойргийн мөнгө гэдэг нэртэй бас нэг ийм зардалтай юм шиг гишүүн ард түмэн бас буруу ойлгоод байна шүү дээ. Гэтэл хэрвээ тийм зардал байдаг, гишүүний үйл ажиллагааны зардлаас хасаж гишүүнд хариуцлага тооцно гэх юм бол логикийн хувьд тэр нь гишүүнийг биш парламентын үйл ажиллагаагаа шийтгээд байгаа хэрэг болно. Тийм учраас, тийм учраас харин бид нар хууль санаачлагчид энэ тухай бас санал бодлоо бас хэлэлцээд солилцсон юм. Миний гаргасан санал бол энэ биш цалинг нь бүүр 100 хувь хас гэж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Энхбатын Болормаа гишүүн нэмж тодруулъя.

**Э.Болормаа:** Уучлаарай Лодойсамбуу гишүүн та өргөн барьсан хуулиа уншаагүй юм байна даа. 15.11 дээр бие төлөөлөгч, туслахын цалингийн зардлаас бусад гишүүний төсвийн 1 сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлага хүлээлгэнэ ээ гэсэн байна шүү. Цалин биш шүү. Тэгэхээр ийм зүйл байна гэд ийг хэдүүлээ нуугаад яах вэ.

Би Бямбацогт даргатай санал зөрж байна. Уучлаарай миний хувьд бол том, жижиг асуудал гэж байна. Таны хувьд ялгагдахгүй байж магадгүй. Махны үнэ том асуудал, инфляц том асуудал, өрхийн амьжиргаа буурч байгаа нь том асуудал,

ядуурал нэмэгдэж байгаа нь том асуудал, байгалийн баялгийн тэгш хуваарилалт байхгүй байгаа нь том асуудал, Рио Тинтогийн хэлэлцээр том асуудал. Тэрнээс биш надад Баттулга гишүүн хуралдаа сууна уу үгүй юү, ирц багатай Лүндэг гишүүн тэр дэд хорооны дарга болно уу үгүй юү, Нара гишүүн лайв дээрээ юу гэнэ вэ үгүй юү? Яг үнэндээ надад падлийгүй. Тийм уч.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хажекберийн Жангабылын урилгаар Баян-Өлгий аймгийн Улаанбаатар хотод их, дээд сургуульд суралцаж буй 150х150 тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцаж байна.

Манай Улсын Их Хурлын гишүүн Хажекберийн Жангабыл, Монгол улсын ирээдүй болсон оюутан залуучууддаа хөрөнгө оруулалт хийж, Баян-Өлгий аймгийн 150х150 оюутнуудыг шалгаруулж, тэтгэлэг олгож байгаад нь нийт Их Хурлын гишүүдийн өмнөөс баяр хүргэе. Оюутнууддаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Сархадын Зулпхар гишүүн асуулт асууна.

**С.Зулпхар:** Хуралдаан даргалагч болон Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ амар амгаланг дахин эрье. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль бол энэ хууль тогтоох институцийн өөрийнх нь үйл ажиллагааг зохицуулсан маш чухал хууль. Нэгэнтээ бид Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол дагаад энэ хуульд бас орно. Үдээс өмнө бас бид энэ Улсын Их Хурлын тухай хуулийг хэлэлцэх явцдаа их тодорхой хэлсэн олон нийтээс Улсын Их Хурлын гишүүдийн талаарх тодорхой жишээ нь ойлголтууд бий болчихсон. Ажлаа хийж байна, хийхгүй байна, саяын хэлээд байгаа том, жижиг шийдвэрүүдийг гаргаж байна, гаргахгүй байна гэдэг ийм асуудал яригдаж байгаа. Том ч асуудал байсан, жижиг ч асуудал байсан улс орны асуудал. Энийг бол Улсын Их Хурал бол гаргах ёстой.

Тэгээд гаргах явцдаа бид энэ хуралдаанаа өөрсдөө дэглэж чадахгүй, өөрсдөө дэгтээ жишээ нь захирагдахгүй байгаа учраас энэ хууль бол гарцаа байхгүй өнөөдөр хэлэлцэгдээд та бүхэн маань дэмжээд явах байх гэсэн бодолтой байна. Гэхдээ мэдээж хэрэг ардчилсан парламент учраас бид болсон болоогүй жишээ нь зүйлүүдээ тал талаас нь нарийн ярьж байж, зүйл, заалт болгоноор нь ярьж байж энэ дээр бол шийдвэрээ гаргана. Энэ бол бас эргэлзээгүй шүү гэж байгаа юм. Гишүүн болгоны санал үнэтэй.

Надад бас 4 асуулт байна. Энэ дээр маш чухал асуудал орж иржээ. Зарчмын зөрүүтэй санал Байнгын хороон дээр гарах юм бол энийг чөлөөт мэтгэлцээний горим руу оруулчихъя гэж. Энэ их чухал. Энэ бол уг нь бол бусад улс орнуудын парламентад байдаг жишиг. Эндээс ажлын хэсэг ямар үр дүн гарна гэж хүлээж байгаа вэ? Энийг та бүхэн бас тодорхой ярьж өгөөч ээ гэж байгаа юм.

Хоёр дахь асуудал Ёс зүйн дэд хороон дээр Улсын Их Хурлын гишүүдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой энэ нэг тодорхой зохицуулалт орсон. Энэ маргаан болж байх шиг байна. Гэхдээ маргаан болдог нь бас нэг талдаа сайн гэж ойлгож байгаа юм. Чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд хороодын хуралдаандаа 50-аас дээш хувьд нь суугаагүй бол тэр хүн дээр хариуцлага тооцно гэж байгаа

юм. Энэ бол байж болдог зүйл, байдаг ч зүйл байх. Тэгэхлээр энэ 50 хувь гэдгийг та бүхэн маань бас яаж тооцсон бэ? Энийг бас тайлбарлаж өгвөл их чухал байна. Яагаад гэвэл гишүүд бас энийг сонирхоод байх шиг байна гэж байгаа юм.

Гурав дахь асуулт. Энэ манай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 6-д байгаа юм. Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусдад, бусад гишүүнд шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно гэхчигсэн байгаа юм. Одоо байгаа техникийн нөхцөлөөр угаасаа ийм боломжгүй болгочихсон юм байна лээ шүү дээ. Тэгэхлээр энэ заалт ажиллах уу ажиллахгүй юу энэ дээр та бүхэн маань юу гэж бодож байна вэ бараг илүү заалт болчих уу гэсэн. Би бас буруу ойлгож байж магадгүй. Энийг та бүхэн бас хэлж өгөөч ээ гэж байгаа юм.

Дөрөв дэх асуулт. 19 дүгээр 19.82 дугаар зүйлийн 82.3-д байгаа юм. Нэгдсэн хуралдаан, хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, Байнгын хорооноос оруулсан саналын томъёоллоор ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүний олонх дэмжсэн бол тогтоолыг баталсанд тооцно гэж байгаа юм. Энэ нөгөө үүсээд байсан маргааныг шийдэх гэж байгаа зохицуулалт мөн үү гэж байгаа юм.

Гэхдээ жишээ нь бид бол одоо байгаагаар бол тэртээ тэргүй яг Байнгын хорооноос орж ирсэн тэр саналын томъёоллоор санал хурааж байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг өмнөхөөсөө яаж өөрчлөгдсөн юм бол, энэ дээр та бүхэн бас юу бодсон юм бол? Энийг бас та бүхэнд тайлбарлаж өгөөч. Яагаад гэвэл бидэнд нэг том мэтгэлцээн өрнөчихсэн шүү дээ маргаан. Тэр маргааныг шийдэх гэж байгаа юм байна гэж би ойлгоод байгаа юм. Тэр маргааныг яаж шийдэх гэж байгаа вэ гэдгийг бас бид их илэн далангүй бас тодорхой яримаар юм байна гэж байгаа юм. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Зулпхар гишүүн бас олж харжээ. Томоохон асуудлуудыг шийдэх чухал заалтууд энэ Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд орсон. Сая ярьж байгаа том асуудлуудыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр огт юу ч байхгүй биш маш тодорхой заалтууд орсон. Энэ нь таны ярьж байгаа чөлөөт мэтгэлцээн. Үнэхээр нийгмийн даатгалын асуудал, тэтгэврийн асуудал, үнийн өсөлтийн асуудал, Оюу толгойн асуудал гээд Их Хурал дээр орж ирж хэлэлцэж байгаа асуудлууд дээр хангалттай хариулт гарахгүй бол, ойлголтын зөрүү байгаад байвал, мэдээлэл нь дутуу бол мэтгэлцээн хийнэ ээ. Гишүүд санал гаргаад мэтгэлцээн хийнэ гээд тал талын байр сууриа хамгаалаад мэтгэлцэнэ. Олон нийтийн иргэдийн мэдэх эрх хангагдана. Ойлголтын зөрүү гишүүдийн ойлголтын зөрүү алга болно. Ийм байж байгаа.

Дээрээс нь асуулга, асуулт тавьж, тодорхой асуудлуудаар тодорхой албан тушаалтанд мэдээлэл авах энэ эрхийг нээж өгч байгаа. Мөн дээрээс нь тэр том асуудлуудаар сая Болормаа гишүүний хэлж байгаа махны үнийн өсөлтийн асуудал гэдэг юм уу, одоо бас нийгэмд бухимдал үүсгэж байгаа томоохон асуудлуудаар тухайн 7 хоногийн ирэх 7 хоногийн хуваарь хэлэлцэх үедээ даргын зөвлөлийн дэргэдэх зөвлөл дээр ярилцаад энэ олон нийтийн анхаарал татсан, иргэдийг

бухимдуулсан энэ асуудал дээр ирэх 7 хоногт холбогдох албан тушаалтныг дуудаж ирж мэдээлэл авдаг болъё, мэдээллийг нь тавьдаг болъё, чуулган дээр үү, Байнгын хороон дээр үү гэдгийг нь шийддэг болох ийм зохицуулалтууд орж байгаа. Ийм байдлаар үндсэндээ бол Улсын Их Хурал гадаад, дотоод бодлогын томоохон асуудлууд дээр томоохон өөрчлөлтүүд хийх бололцоо нь бий болсон.

Санал хураалтын 50 хувь гэдгийг юу гэж хэлж байгаа вэ гэхээр нэг санал хураалтад оролцоогүй бол, 10 санал хураалтад оролцоогүй бол тухайн үед чинь зарчмын зөрүүтэй 100 саналтай байвал түүний тал нь гэсэн үг. 2 санал хураалттай байх юм бол тал нь гэсэн үг. Ийм 50 хувь гэж ингэж оруулахгүй бол тодорхой тоо тавихаар болохгүй байна. Нийт тухайн 7 хоногийн санал хураалтын 50 хувьд оролцоогүй бол гэж ингэж өгч байгаа нь бол бас илүү уян хатан, илүү гишүүд бас үүргээ ухамсарлаж хариуцлагаа ойлгож ажиллах боломжийг нь бий болгож өгч байгаа.

Санал өгөх эрхээ бусдад шилжүүлэх. Энийг би 2015 онд хийсэн юм. Түүнээс өмнө бол бусдын гишүүдийн картыг шургуулаад бусад гишүүдийн өмнөөс саналыг нь өгөөд төгөлдөр хуур тоглоод чуулганд оролцож байгаа гишүүд нь өөрсдөө хэлмэгддэг хохирдог, оролцоогоо өмнөөсөө ирцэд бүртгүүлсэн. Өмнөөсөө санал өгүүлсэн гишүүд нь завшдаг байсан. Энийг би 2015 онд хурууны хээгээр ирцээ бүрдүүлж хурууны хээгээр саналаа өгдөг энэ тогтолцоог бий болгосон. Энэ 15 онд хууль санаачилж батлуулж. Үүнийгээ илүү энэ дээр санал хураалт ирцтэй адилхан чухал юм шүү гэдгийг л илүү тодотгож өгч байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол ирцдээ орчхоод саналаа өгөхгүй байгаад байна. Тэгвэл ирц, санал хураалт хоёр чинь хоёулаа адилхан чухал ач холбогдолтой гэдгийг тодотгож өгч, өөрийн биеэр заавал саналаа өгнө гэдгийг тодотгож оруулсан юм гэдгийг танд хариулъя.

Сүүлийн асуултыг Ариунзаяа гишүүн хариулчихъя.

**Б.Пүрэвдорж:** Хэн хариулна? Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Зулпхар гишүүн сая энэ 82.2-той холбоотой асуултыг асуулаа тээ? 82.2, 82.3. Тэгээд энэ 82 дугаар зүйл нь өөрөө хилийн чанадад ажиллах дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин байршлыг нь тогтоох тухай тогтоолын төсөл хэлэлцэх дэгийн тухай байхгүй юу. Тэгэхээр өмнөх байгаа 82.1 нь өөрөө нэг өгүүлбэрээр оруулсан байсныг ерөнхийдөө задалж, Байнгын хорооны саналыг бас аваад, хэлэлцээд, тэгээд Байнгын хорооноос оруулсан саналын томъёоллоор ил санал хураалт явуулна гэж томъёолсон байгаа юм.

Гэхдээ цаад асуух гээд байсан гол агуулга нь юу юм бэ гэхлээр нөгөө Ерөнхий сайдыг огцруулахтай холбоотой Үндсэн хуулийн цэцийн нөгөө асуудлыг ярьж байна уу? Тэр болохлоор Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарсан учраас бид бас үүнийг өөрчилж, яг энэ Ерөнхий сайдыг чөлөөлөхтэй холбоотой санал хураалт нь Байнгын хорооны саналыг сонсоно. Гэхдээ санал хураалт нь бол огцруулах анхны тэр нөгөө саналаар нь явна гэж томъёолсон байгаа. 101 дээрээ байгаа байх. Үндсэн.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Зулпхар гишүүнд нэмж тодруулъя.

**С.Зулпхар:** Бямбацогт дарга энэ 10.6 бол таны тэр нөгөө 15 онд техникийн тийм нөхцөлүүд бий болгоод хүний өмнөөс санал өгөхийг нь болиулдаг угаасаа практик болсон байхгүй юу. Энэ нөхцөлд бол энэ 10.6 бол энэ хэрэггүй заалт гэсэн үг. Техник нөхцөл нь хангагдчихсан өөр хүний өмнөөс санал өгөх боломжгүй байхад энийг бид нар битгий өгөөрэй гэдэг заалт болгоод оруулсан энэ бол шаардлагагүй болчихлоо гэж байна. Гэхдээ яах вэ та бүхэн ажлын хэсгийн түвшинд бол энийг ярих байх гэж би бас бодож байна.

Тэр мэтгэлцээний хувьд бол маш чухал. Энийг бол гишүүд бүгдээрээ бид ойлгох ёстой. Бид ер нь тэр зарчмын зөрүүтэй санал дээр бол мэтгэлцэж чадахаа байчихсан шүү дээ. Мэтгэлцэх боломжгүй болгочихсон юм дэгээрээ бол. Яг яадаг гэхлээр зэрэг санал хураагаад л тэгээд л дуусдаг. Дараа нь яах вэ энэ дээр чуулган дээр бол нэг асуулт асуугаад л тайлбар тавиад л орхидог. Чухал асуудлаар саяын гишүүдийн хэлсэн бид мэтгэлцэж байна шийдвэр гаргадаг бол энэ их чухал заалт болж байгаа шүү гэдгийг бас хэлье. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Зочин танилцуулъя. Баян-Өлгий аймгийн Улаанбаатар хотод их, дээд сургуульд суралцаж буй оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.

Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууна.

**Л.Мөнхбаатар:** Чуулганы нэгдсэн хуралдаанд Дэгийн тухай хууль дээр бас 2, 3-н ч зүйлийг хэлье гэж бодож байна. Бас энэ зарим зүйл, заалттай бол бас санал нийлэхгүй байна. Гишүүд нэгдсэн хуралдаанд асуулт асуух нэрсээ урьдчилан өгдөг байсныг бол болиулъя гэж байгаа юм байна. Энэ заалтыг ер нь яагаад оруулсан юм бэ гэдгийг бас та бүгдэд хэлье. Яагаад гэвэл энэ өмнөх энэ хуулийг бол санаачилсан гишүүний хувьд.

Яагаад гэвэл энд энэ парламентын үйл ажиллагаа, нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны хуралдаануудыг бол үр дүнтэй явуулах ийм шаардлага бол байсан. Яагаад ер нь 76 гишүүнтэй байх үед ч гэсэн ч гэсэн ямар зүйл гараад байна вэ гэхээр ингэж байгаа юм. Чуулганы нэгдсэн хуралдаан дээр бүх гишүүд үг хэлье гээд тухайн асуудлаар бүх гишүүд үгээ хэлнэ гэдэг бол нь бас цаг хугацааны хувьд 126 гишүүн үг хэлэхэд тодорхой хугацаа шаардана. Тодорхой асуудал хэлэлцэгдэнэ.

Түүнээс гадна Байнгын хороон дээр ярьсан асуудлаа чуулгын хуралдаан дээр давтаад ярьдаг, аль эсвэл нэрсээ өгөхөд кноп дараад гарчихдаг. Гараад явчхангуутаа тэр хооронд нь нөгөө ажлын хэсэг чинь бүх асуултад нь хариулчихдаг. Тэгээд нөгөө гишүүн ч чинь сонсоогүй байж байгаад орж ирэнгүүтээ аль хэдийн асуугдсан асуултуудыг давтаж асуугаад л байдаг. Ингээд л сунжирдаг, хэлэлцүүлэг үр дүнгүй болоод байдаг ийм зүйлүүд байдаг. Тийм учраас энийг 1 дүгээрт хязгаарлая үр дүнтэй болгоё гэдэг үүднээс энийг оруулсан юм.

2 дугаарт, ер нь бүлэг гэж яагаад байгаа юм? Бүлэг, нам, эвсэл байгаа. Тийм учраас эдгээр чинь өөрсдөө бодлогоороо хэн асуулт асуух юм, хэн үг хэлэх вэ гэдгээ нэрсээ аваад урьдчилж өгөөд хийх нь хамгийн үр дүнтэй гэж үзсэн асуулт

асуухад. Тэгэхгүй бол танин мэдэхүйн асуултууд л асуусаар байгаад энэ нь дуусдаг шүү дээ энэ цагууд энэ нь.

2 дугаарт, үг хэлэх асуудлыг энэ энд тавьсан энэ 2 индэр дээрээс үг хэлье гэж шийдвэрлэсэн. Яагаад вэ гэхээр үг хэлж байгаа тохиолдолд хэлэлцэж, ямар асуудал ч хамаагүй асуудал дээр гэнэтхэн л кнопоо дараад үг авчихдаг. Энэ ямар асуудал хэлэлцэж байгаа билээ гэж асууж байгаад нэг юу ч хамаагүй ярьдаг, тойруулаад ярьдаг ийм юман дээр.

Тийм учраас үг авч энэ дээр индэр дээрээс үг хэлж байгаагаараа гишүүд хариуцлагатай болж байгаа юм. Намын бүлгийг төлөөлж үг хэлж байгаа гэдгээрээ тухайн хэлэлцэж байгаа хууль, асуудалд маш тодорхой хариуцаж, тодорхой байр суурийг илэрхийлэх гэдгээрээ гишүүд өөрсдөө хариуцлагатай болж байгаа юм. Энэ хэвшиж байгаа чухал зүйл байгаа гэж үзэж байгаа юм. Тийм учраас энийг бол эвдэж болохгүй ээ гэж үзэж байгаа юм энэ.

Би бас бүлгийн олонхын бүлгийн даргаар ажиллаж байсан. Энэ хугацаанд бол гишүүд урьдчилсан нэр өгдөг тодорхой хуулиуд дээр. Энэ ингээд хуулиуд дээрээ нэрээ өгөөд л тогтчихсон зүйл шүү дээ. Энэ дээр гомдол гарч байсан тухай, намайг ажиллаж байхдаа гомдол гарч байгаагүй. Харин ч энд нэрээ өгчхөөд асуултаа асуудаггүй, нэрээ өгчхөөд үгээ хэлдэггүй. Үгүй ээ ийм асуудлууд дүүрэн байгаа шүү дээ. Үгүй ээ тэгээд энэ тогтчихсон энэ сайн жишгийн ингээд явах хэрэгтэй.

Цаашаагаа бол Их Хурал чинь асуудлыг хэлэлцэхдээ бодлоготой явахаас биш гэнэтхэн ямар асуудал хэлэлцэж байгаа билээ гээд асуудал хэлэлцэж байгаа асуудлаа ч мэдэхгүй үг аваад ингээд асуудал сунжруулаад байдаг энийг чинь цэгцэлсэн ийм заалт шүү. Тийм учраас үүгээрээ хуучныг нь үлдээх нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Харин 2 дугаарт нэг засах зүйл харин энд амьдрал дээр гарч ирээд байгаа. Энэ бол зарчмын зөрүүтэй саналыг манай гишүүд анхааралтай хараарай 2 хоногийн, ажлын 2 хоногийн өмнө өгнө гээд одоогийн хууль дээр байгаа. Энийг засах нь зүйтэй шүү харин. Тэгэхгүй бол 5 дахь өдрийн орой, үдээс хойшдоо орой даргын зөвлөлөөс ирэх 7 хоногийн чинь хуваар гардаг, 2 дахь өдрийн үдээс өмнө Байнгын хороо чинь хуралдаад эхэлчхэж байгаа юм. Ингэхээр ажлын 2 өдрийн өмнө зарчмын зөрүүтэй саналаа өгнө гэдэг зүйл чинь ингээд утгагүй болж байгаа юм.

2 дугаарт ер нь өгсөн байлаа ч гэсэн тухайн гишүүн Пүрэвдорж гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад тэр нь дэмжигдчихсэнтэй холбогдуулаад би бас зарчмын зөрүүтэй саналаа гаргах эрх байгаа шүү дээ. Энэ нь өөрөө хэрэгжих боломжгүй байгаад байгаа байхгүй юу. Яагаад гэвэл 2 хоногийн өмнө чинь саналаа өгөөгүй байна гээд явчихна. Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг би мэдэх боломжгүй байгаа дэмжигдэх эсэхийг нь ч мэдэхгүй. Тийм учраас энэ асуудлыг бол аваад илүү уян хатан болгоод зарчмын зөрүүтэй саналаа тухайн хурлууд дээрээ гаргаад явах нь зүйтэй. Энийг харин ингэж өөрчлөх нь зүйтэй. Энэ бол орж ирээгүй байна. Энийг цаашдаа ингээд явах нь зүйтэй шүү гэдгийг хэлье.

3 дугаарт, энэ Байнгын хороодын хуралдах цагийг тодорхой яг цагтаа болгомоор байгаа юм. Тэгэхгүй бол ерөөсөө болно шүү дээ. 11 Байнгын хороо байгаа. Энд энэ танхимд тэд дэх өдөр ийм Байнгын хороо хуралдана. Тухайлбал, Хууль зүйн байнгын хороо 2 дахь өдрийн.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж 1 минут тодруулъя.

**Л.Мөнхбаатар:** Тэгэхээр ерөөсөө Байнгын хороод хийхэд хуралдах цагийг нь тодорхой болгочихъё. Гишүүддээ ч амар, Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа эрдэмтэн, судлаач, төрийн албан хаагчдыг ч гэсэн ингээд залхаагаад байж болохгүй. Тэгэхээр Хууль зүйн байнгын хороо тухайлах юм бол 14 цагт хуралдъя Жанжин Сүхбаатар танхимд хуралдана.

Мэдээж яаралтай гэдэг юм уу байдлаар хуралдах болох юм бол танхимын зохицуулалтаа хийгээд хуралддаг ийм тогтсон юм руугаа орчих юм бол их амар болно шүү. Байнгын хороодын хурлын цагууд их тодорхой, чуулган 10 цагаас хуралдана гэдэгтэй л яг адилхан гэсэн үг шүү дээ. Би ийм болгочихвол их амар юм уу гэж би бодоод байна.

Дараагийн яах вэ зүйл нь бол энэ техникийн шинжтэй ганц нэг зүйлүүд байна. Манайд хууль санаачлагч бас анхаараарай. Гишүүн хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гэдэг томъёолол нэлээн хэд хэд орчихсон байна. Гишүүн бол хууль тогтоох бүрэн эрх бол эр эдлэхгүй шүү дээ. Улсын Их Хурал энийг эдэлнэ тийм ээ? Тийм учраас энэ томъёоллоо бас харах нь зүйтэй байх.

Дараа нь бол энэ харин энэ Элчин сайдыг томилох асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бол би дэмжиж байгаа юм. Би өмнө нь ч бас энэ саналыг гаргаж байсан. Одоо харин энэ дээр нэмээд гадаад харилцаа тогтоох холбоо.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Яг үнэндээ бас Мөнхбаатар гишүүний хэлдэг зөв өө. Хуучин бол Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороо, чуулганы хуралдаанд ямар асуудал хэлэлцэж байгаа нь мэдэхгүй орж ирэнгүүтээ кнопоо дараад тэгээд хажуу талын гишүүнээсээ юу хэлэлцэж байгаа билээ, юу ярьж байгаа билээ гэж асууж байгаад тэгээд ингээд тэгээд санаандаа орсноо ярьчихдаг. Эс үгүй бол бие биеийнхээ хэлж байгаа үгнээс санаа авангуутаа тэгээд л яриад эхэлдэг. Түүнээсээ болоод чуулганы хуралдаан сунжрах, чуулганы хуралдаан зохион байгуулалтгүй болох, хэлэлцэж байгаа асуудлын ач холбогдол буурах гээд иймэрхүү бас үндэслэлүүд байгаад байдаг байсан учраас манай Мөнхбаатар нарын гишүүд бол урьдчилж нэр авч, асуулт асуух, үг хэлэх, нэрийг нь авдаг больё, дээрээс нь үг хэлэхдээ илүү хариуцлагатай больё гэж индрээс үг хэлэх бол ийм заалт орсон. Индрээс үг хэлэх бол хариуцлагатай болгож байгаа маш чухал асуудал. Тэгээд санаанд орсон үедээ юу ч хамаагүй ярьдаг биш бэлдэж хариуцлагатай үг хэлээд бэлддэг байх. Энэ бол хэвээрээ үлдэж байгаа.

Гишүүд бүлгээр дамжуулж урьдчилж нэр өгөх асуудал дээр бол нөгөө Viber-аар бүлгийн групп дээрээ маргаашийн, энэ ирэх 7 хоногийн хэлэлцэх асуудал дээр гээд үг хэлэх, асуулт асуух юм бол нэрээ өгөөрэй гэдэг. Овсгоотой гэдэг юм уу

утсандаа ойр байдаг гишүүд нь бол маш хурдан хугацаанд тэрийг харчхаад би өгнө гэчихдэг. Тэгтэл нөгөө ард талд нь утсаа харж чадаагүй, эс үгүй бол өөр ажилтай байгаад утсанаасаа хол байсан нөхдүүд нь үг хэлэх тухайн асуудал дээр мэргэшсэн, туршлагатай, асуудлыг маш сайн мэдэж байсан хүн нь хоцроод иймэрхүү асуудал байнга гомдол гардаг юм байна лээ.

Дээрээс нь таны хэлдэг ингээд бусад гишүүдийнхээ боломжийг хаагаад урьдчилж нэрээ өгчхөөд асуултаа асуудаггүй, үгээ хэлдэггүй ингээд ийм асуудал болоод байдаг байсан учраас маш олон гишүүн манай Алтанхуяг гишүүн, Сэддорж гишүүн, Батчимэг гишүүн, Ариунзаяа гишүүн, манай бүлгийн дарга Батжаргал дарга гээд энэ олон гишүүд маань энэ ер нь жоохон гишүүдээ тухайн чуулган, Байнгын хороон дээрээ өглөөд нь ирээд л асуулт асуух, үг хэлэх хүмүүс нь яг ач холбогдолтой гэж байвал сайн бэлдэж ирээд кнопоо дараад асуултаа асуучихдаг нээлттэй ийм уян хатан байх нь зөв юм байна гэж санал гарсан учраас энэ олон гишүүдийн гаргасан саналаар энэ заалт орж ирсэн. Ийм байдлаараа явах эсэх нь бас манай гишүүд маань шийдээд явчих байх.

Мөн бас ер нь харж байхад бол хугацаатай. Даргын дэргэдэх зөвлөл дээр ерөөсөө хугацааг л тогтооё. Тухайн чуулганы хуралдах, асуудлыг хэлэлцэх хугацааг нь тогтоочихъё, илүү уян хатан гишүүд нь нээлттэй асуулт асууж, үг хэлэх боломжийг нь нээлттэй орхиё гэдэг ийм саналуудыг бас гишүүдийн саналаар орсон гэдгийг хэлье.

Байнгын хорооноос хуралдахаас 2 хоногийн өмнө зарчмын зөрүүтэй санал авах асуудал яг наад асуудал чинь үүсэж байгаа юм. Хэдэн 100 санал авахаар урд өдөр нь Байнгын хороо ажлын хэсэг хуралдаж дуусаад маргааш Байнгын хороогоор оруулах гээд тэгэхээр нөгөө Тамгын газрын бас нөгөө бэлдэх боломж нь жоохон багасчхаад байдаг учраас Тамгын газар маань бас гишүүдэд чуулганы хуралдаанд бэлдэх, Байнгын хорооны хуралдаанд бэлдэх ийм боломжийг бий болгох үүднээс 2 хоногийн өмнө гэж байгаа. Гэтэл нөгөө талдаа болохоор таны хэлж байгаа хүндрэлтэй асуудлууд гараад байгаа. Энийг хэлэлцүүлгийн явцад өшөө сайжруулаад явчих бас боломжтой. Энэ бас яг яах аргагүй таны ярьдаг ас үндэслэлүүд байгаа.

**Б.Пүрэвдорж:** Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

**Б.Батбаатар:** Хууль санаачлагч болоод хуралдаан даргалагч 2-оос асууя. Энэ ажлын хэсгийг хэн байгуулах вэ энэ хуулийг хэлэлцүүлэх эсэхийг шийдчихсэний дараа? Их Хурлын дарга маань өөрөө хууль санаачлагч учраас ажлын хэсэг байгуулах нь зөв үү? Пүрэвдорж дарга хуралдаан даргалж байсны хувьд ажлын хэсэг байгуулах нь зөв үү гэж асууж байгаа юм.

Зарчмын зөрүүтэй санал гэж байгаа юм. Тийм зарчмын зөрүүтэй санал оруулна гэдэг чинь нөгөө Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхтэй эн тэнцүү зүйл шүү дээ. Тухайн хуульд зарчмын зөрүүтэй санал оруулж байна гэдэг хууль санаачлагчийн эрхийг эдэлж байна гэсэн үг. Тийм болохоор энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулдаг тэр процессоо жоохон эвтэйхэн зөв болгохгүй бол заавал тэр зарчмын зөрүүтэй санал дээр нь Байнгын хороо санал хураадаг, чуулган санал хураадаг, Их Хурлын гишүүн бол зарчмын зөрүүтэй саналаа оруулах нь хууль

санаачилж байгаатай адилхан эрх мэдлээ гэж үзэх нь зүйтэй болов уу гэж ингэж үзэж байгаа.

Энэ Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа асуудлууд, хуулийн төслүүд, төсөв төлөвлөгөө, хөтөлбөр, тайлан, хяналт энэ тэр гээд Их Хурлын хэлэлцэж байгаа асуудлууд дээр бол Их Хурлын гишүүдэд хүндрэл маш өргөн ноогдож байгаа. Захиргааны бүтэц, захиргааны машин, засаглалын машины эсрэг Их Хурлын гишүүд зөвхөн нэгхэн хэсэг ороод ирчихсэн танилцуулгын хэмжээнд, үзэл баримтлалын хэмжээнд, томъёоллын хэмжээнд ороод ирчихсэн хэдэн хавраас эхэлж байгаа төсвийг намар өргөн барихад Их Хурлын гишүүд түүнтэй маргах, тоо бодох, нөгөө төсөв төлөвлөгөөнд чинь өөрчлөлт оруулахаар чинь баахан тоо бодох ёстой болж байгаа шүү дээ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бусад хуулиуд эд нар гээд. Ийм зүйлүүдийг ярьж байгаа учраас Улсын Их Хурлын гишүүд маань өөрсдөө туслах гээд нэг хүүхэд байж байдаг, зөвлөх гээд нэг хүн байж байдаг. Тэд нар нь бол туслах бол бичиг цаасыг нь эмхлэх тэр бусад ажлуудыг нь л хариуцдаг байх. Учиргүй хуулийн асуудлууд дээр суугаад амжаад явна гэдэг бол боломж байхгүй.

Тэгэхээр Их Хурлын гишүүдийн ажлын алба гэдэг зүйл маань ямар байгаа вэ? Энэ маань энэ дэгийн хуулийн энэ хатуу нөхцөл дотор, Засгийн газрын бусад энэ яам тамгын орон нутгийн байгууллага эндээс орж ирж байгаа зүйлийг нь зөв болгох, алдааг нь засах, эрсдэлийг нь багасгах, сайжруулсан болгох энэ зүйл дээр бол үнэндээ дутуу байгаа шүү дээ. Энэ зэргийн хэмжээний тийм бэлтгэл хангах зүйл бол зүгээр бусад улс оронд тэр парламентын гишүүдийнхээ ажлын алба гэдэг бол нөгөө гишүүндээ бараг бүх зүйлийг нь бэлдээд өгчихдөг. Сайд нарт бол яамд институт нь 100 хүнтэй, 200 хүнтэй баг нь бүгдийг нь бэлдээд өгчхөж байгаа шүү дээ. Засгийн газарт бол хэдэн зуун, мянган хүнээрээ бэлдээд өгчихдөг. Тэгэхээр энэ захиргааны засаглалын том машинтай тулж байгаа гэдэг зүйлээ бодох хэрэгтэй.

Дээрээс нь энэ Улсын Их Хурал 126 гишүүнд тангараг өргөснөөс хойш үе үеийн Улсын Их Хурлын дарга нар, засгийн тэргүүнүүд, бусад намын дарга нарт нэг зүйлийг хэлээд байсан. Хэдүүлээ бүгдээрээ нэг нийлж байгаад маш сайн зөвшилцөж ойлгож байгаад хамаагүй жил хамтарч ажилласан ч болно. Үр дүн гаргая. Улс төрийн намын тухай хууль, Их Хурлын тухай хууль, процессын хууль, дагасан процесс, хяналтын хуулиуд, дээрээс нь энэ Их Хурал, орон нутгийн сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль энэ бүх зүйлээ нэг эцэслээд ямар тоглоомын дүрмээр бид нарын энэ ямар нийгэмтэй байгуулсан гэрээ гэж яригддаг хууль, журмаар хэдүүлээ энэ асуудлаа явуулах юм бэ гэдгийг ярьж байсан. Тэгээд энэ санаачилгыг гаргая гээд бүгдээрээ ярьдаг их, бага хэмжээгээр жижиг засвар бас хийсэн үү гэвэл хийсэн. Даргын дэргэдэх зөвлөлдөө парламентад суудалтай намын төлөөлөл орох асуудлыг шийдсэн ингээд явж байгаа юм. Тэгэхлээр энэ асуудлуудаа яаж шийдэх вэ гэдэг дээр.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Батбаатар гишүүний сүүлийн асуултаас эхэлчихье. Маш чухал асуудал. Энэ удаагийн парламент бол анхны 126 гишүүнтэй, дээрээс нь холимог тогтолцоотой 78:48 гэсэн жагсаалт болон тойргийн, мөн Улсын Их Хурал 5 намтай. 5 намын төлөөлөлтэй. Мөн дахиад 16 оноос хойш ийм хүчтэй сөрөг

хүчин байгаагүй. 42 гишүүнтэй нийт парламентын гишүүдийн гуравны нэгийн сөрөг хүчинтэй. Ийм том бас онцлогтой парламент бий болсон.

Тийм болохоор парламент дээр ерөөсөө асуудлыг аль болох зөвшилцөх, ойлголцох, улс орныхоо эрх ашгийг 1 дүгээрт нь тавьж харах энэ талдаа бид илүү зарчим болгож ажиллах ёстой гэж Их Хурлын даргаар томилогдчихоод би бас анхны уулзалтаа бол парламентад суудалтай 5 намынхаа даргатай хийж, ерөөсөө парламентад суудалтай намууд улс орныхоо эрх ашгийг бодож 1 дүгээрт нь тавьж, улс төрийн зөвшилцөл ойлголцол гэдэг үндсэн ажлынхаа зарчим болгож ажиллаж гэж тантай, та бүхэн, бид бүхэн бас уулзаж байсан. Энэ зарчмын дагуу бид ажиллах ёстой гэж ойлгож байгаа.

Улс төржих асуудал байна. Тэн дээр маргалддаг биш мэтгэлцдэг. Хэрэлддэг биш хэлэлцдэг. Асуудлаа маш сайхан ярилцаж ойлголцоод шийдвэр гаргадаг ийм байх нь зөв. Тэгэхгүй бол Улсын Их Хурал дээр ерөөсөө хоорондоо маргалдаад л хэрэлддэг байхаар чинь ерөөсөө л энэ хэдэн гишүүд хоорондоо хэрэлдэж байдаг гээд л. Хэлэлцэж байгаа, тэр мэтгэлцэж байгаа тэр соёлыг нь мэдэхгүй болохоороо Улсын Их Хурлыг ерөөсөө л нэг л хэрүүлч нарын нөхдүүд бие биеэ гүтгэсэн гутаасан, гэмт хэрэгтэн болгосон ингээд Их Хурлын нэр хүнд уначхаад байгаа. Тэгээд энэ дээр бид илүү анхаарах ёстой. Энэ дээр тантай санал нэг байна. Яг энэ зарчмыг л хэдүүлээ бариад цаашдаа ажиллана гэж ярьж байсан энэ байр суурь дээр хэвээрээ гэдгийг бас нэрлээ.

2 дугаарт нь Улсын Их Хурлын гишүүд гар мухар байгаа нь үнэн. Ялангуяа энэ тойргоос сонгогдсон 78 гишүүн бол урьд нь нэг аймгаас, заримдаа аймаг дотроо нэг жижиг тойргоос сонгогддог байсан. Одоо бол ингээд бүхэл бүтэн 4 аймгаас, 3 аймгаас төлөөлөөд сонгогддог. Тэр хэмжээгээрээ орон тоо, төсөв огт нэмэгдээгүй. 20-оос 24 онд Их Хурлын гишүүн хийж байсан хүмүүс нэг аймгаас сонгогддог байсан бол өнөөдөр 4 аймгийг төлөөлүүлээд суудаг. Сонгогчдын тоонд тэр дахин 4 дахин нэмэгдчихсэн байхад гишүүний ажлын алба гээд 3. Бие төлөөлөгч, туслах, зөвлөх гээд 3 хүнтэй яг нэг хэвээрээ байж байгаа. Энэ дээр яах вэ жагсаалтын гишүүд маань 2 гишүүний орон тоотой байсан бол 2 ажлын албанд 2 орон тоотой байсанг 3 болгосон.

Төсөв санхүү маань хүнд байгаа учраас гишүүний ажлын албыг өргөтгөх, нэмэх ийм боломж байхгүй байгаад байгаа юм. Сайд нар бол бүхэл бүтэн яам бас аппарат ажилладаг гэдэг үнэн. Их Хурлын гишүүд ерөөсөө л зөвлөх, туслах 2 л бас асуух асуулт, хэлэх үг, хуулийн төсөл бичих, тодорхой байр сууриа илэрхийлэх, зарчмын зөрүүтэй санал бэлдэх ийм байдлаар явж байгаа. Тэгээд өнөөдөр ганцхан төсөв санхүүгийн бололцоо маань хэцүү байгаа учраас гишүүдийнхээ ажлын албыг бэхжүүлэх, орон тоог нэмэх, төсөв зардлыг нь нэмэгдүүлэх тал дээр хүндрэлтэй байгаа гэдгийг та бас зөв ойлгоорой.

**Б.Пүрэвдорж:** Батын Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

**Б.Батбаатар:** Дутуу хариулсан зүйлээр нэмээд хариулаад өгчихвөл их сайн байна. Одоо энэ хуулийг хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа ажлын хэсэг байгуулагдаж таарна. Хууль санаачлагч ажлын хэсгийг томилох юм уу, энэ хуралдааныг даргалж байгаа Пүрэвдорж дарга ажлын хэсэг томилох юм уу гэдгийг нэг хариулаад өгөөч ээ гэж хэлсэн.

Бусад тэр зарчмын зөрүүтэй санал, хуулийн хэлэлцүүлэг явж байх үедээ ярих зүйлүүдээ яриад санал оруулаад явж болох байх гэж бодож байна. Их Хурлын дарга аливаа ер нь төрийн өндөр албан тушаалд нь легаси үлдээхийг хүсдэг нь ойлгомжтой. Амарбаясгалан дарга бол төгөлдөршил, бодлого, энэ Их Хурал нэг бодлого гаргах ёстой гэж үзсэн. Учрал дарга бол санаачилъя гээд үзсэн. Чөлөөлье, үр дагавар нь бол бас асуудал бий юу гэвэл бий. Бямбацогт дарга бол үр бүтээмж, гүйцэтгэлийн тал дээр нь илүү их анхаарч байх шиг байгаа юм. Ингээд энэ 3 Их Хурлын дарга 3 өөр зүйл ар араасаа ярьж байна. Аль нь ч буруу зүйл гэж хэлэхгүй. Гэхдээ нэг зүйл дээр анхаарах ёстой. Улсын Их Хурал бол ард түмний төлөөллийн төв байгууллага. Захиргааны буюу

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулья.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлаар, чуулганаар хэлэлцэх эсэх нь дэмжигдвэл ажлын хэсэг байгуулагдана. Ажлын хэсгийг бол тэгээд хуульд заасны дагуу байгуулах байх. Гэхдээ энд бол Улсын Их Хуралд суудалтай бүх намуудын төлөөлөл орно. Даргын зөвлөл дээр бид нар бас энэ асуудлыг ярьж байх үед бол ажлын хэсгийн ахлагчийг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ахлуулаад, нам, эвслийн бүлгүүдийн төлөөлөл оруулаад ингээд ажиллая бас Ардчилсан намын бүлгийн дэд дарга Тэмүүжин гишүүн жишээ нь ажлын хэсэгтээ орж ажиллая гэх мэтээр, та бас ажлын хэсэгт оръё гэх юм бол ороод ажиллах ийм байдлаар ингээд явах нээлттэй байгаа.

Тийм болохоор өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуульд заасны дагуу саяын байдлаар ажлын хэсэг байгуулагдана гэж танд хэлье.

**Б.Пүрэвдорж:** Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Уучлаарай би 2 тодруулчихсан гэж бодохгүй юу. 1 юм уу? Батын Батбаатар гишүүн тодруулья.

**Б.Батбаатар:** Тэгэхээр ингээд энэ хуулийг санаачлагч нь Ардын нам, Ардчилсан намын гишүүд л байгаа. Энэ хуулийг санаачилсан хүмүүс нь Ардын нам, Ардчилсан намын гишүүд байгаа. ХҮН намаас байхгүй. Иргэний Зориг Ногоон намаас байхгүй. Их Хурлын 126-г дэглэх асуудлаа Ардын нам, Ардчилсан нам 2 хийх гэж санаачилсан юм. Тэгээд сая харж байгаа биз дээ 2 удаа тодруулах эрх одоо хүчин төгөлдөр байгаа Дэгийн хуулиар байж байдаг. Яах гээд байгаа юм бэ боль гэж байна шүү дээ. Ардын намын хүн, Ардчилсан намын хүн энэ хурал даргалахаар ийм юм болж байгаа шүү дээ. Одоо та нар Их Хурлын даргыг нам бус бол гэсэн. Яг хуралдаан даргалах мөчдөө түр зуур намаасаа түдгэлзлээ гэж байж хурлаа удирдаж байх хэрэгтэй шүү дээ Их Хурлын дэд дарга. Өөрсдөө Их Хурлын даргад тийм шаардлага тавьчхаад одоо тэгээд энэ Дэгийн хуулийг хэлэлцэж байгаа үеэр дэг мөрдөхгүй байхаа больчих. Дээрээс нь парламент гэдэг бол ард түмний төлөөлөл юм. Улсын Их Хурал бол ард.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Би таныг нөгөө 2 тодруулчихсан гэж бодоод хэлчихгүй юу. Ер нь дахиад нэмж тодруулах уу? 3 тодруулж болно. Үг хэлсэн шүү дээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 21 дүгээр сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш нартаа сурган хүмүүжүүлэх ажилд нь өндөр амжилт хүсэж, сурагчдад сурлагын, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье.

Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууна.

**Ж.Баярмаа:** Энэ дэгийн тухай хуульд нэмэлт ,өөрчлөлт оруулж байгаа энэ хуульд жишээлбэл Улсын Их Хурлын гишүүдийг цалинг нь 3 сар хүртэл 20 хувиар бууруулна энэ тэр гээд. Энэ хариуцлагыг ногдуулах тэр заалтууд нэмэгдэж байгаа юм шиг байна. Энийг бол дэмжиж байна. Жирийн төрийн албан хаагчид болохоор тэдэн удаа тэдэн минут хоцрох юм бол цалингаа тэдэн хувиар бууруулна гээд ингэдэг. Тэдэн удаа тасалбал бараг хөөгддөг, ажлаасаа халагддаг. Гэтэл Улсын Их Хурлын гишүүд яг ажил хийж цалин авч байгаагийнхаа төлөө ямар ч хариуцлага хүлээхгүй байж болохгүй. Энэ цалин мөнгөтэй холбоотой хариуцлагыг бол хүлээлгэж болно.

Гэхдээ жишээлбэл энэ 15.7-гоор энэ Ёс зүйн дэд хороонд 30 хоног хүртэлх Улсын Их Хурлын гишүүний үг хэлэх эрхийг хасах ийм эрх олгосон байна. Гэтэл энэ Улсын Их Хурлын гишүүний чинь үндсэн ажил ерөөсөө үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэх, зарчмын зөрүүтэй санал гаргах, тэрийгээ тайлбарлах.

Гэтэл энийг ямар зүйл, ангиар боогдуулах гээд байна вэ гэхээр нэр төр гутаасан, саад учруулсан, хэвийн үйл ажиллагаа алдагдуулсан, эмх замбараагүй байдал үүсгэсэн гэж байгаа юм. Тэгэхээр энэ энийг юугаар хэмжих вэ яасан бол эмх замбараагүй байдал үүсгэсэн гэх юм. Нөгөө л нэг гүтгэх гэдэг асуудал бас явж байх шиг байна лээ. Гүтгэсэн бол гэж байгаа юм. Яасан бол гүтгэсэн гэж үзэх юм? Энэ чинь бүр энэ Дэгийн тухай хуулиараа байтугай энэ чинь нөгөө Үндсэн хуулийн асуудал болоод явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ маш субъектив ийм зүйлээр Улсын Их Хурлын гишүүний үг хэлэх эрхийг 30 хоногоор хасдаг бол маш буруу.

1 сарын дотор 8 удаа нэгдсэн чуулган, Байнгын хорооны чуулган маш их явагдлаа гэж бодъё. Тэгэхэд энэ энэ хооронд хууль бол маш олон төрлийн чухал ,чухал бус гэж байхгүй хэдий ч төсөв, татвар, төлөвлөгөө гээд маш олон чухал хууль хэлэлцэж байх үед бол тэр гишүүний нөгөө олон нийтийг төлөөлөх эрх ингээд бүрэн хасагдаж байгаа юм. Тэгэхээр ийм маягаар бол Улсын Их Хурлын гишүүд ялангуяа цөөнхөд магадгүй дарамт шахалт үзүүлэх улс төрийн ийм шийтгэл ноогдуулж болохгүй ээ. Тэр цалин цавуутай бол ярьж болно. Яагаад гэвэл энэ бол угаасаа байдаг ийм захиргааны арга.

2 дугаарт, энд нэг бас нэг ноцтой зүйл явж байна 71.8-д. Төсөв нэмэх юм бол тэр хасах заалтаа дагуулж оруулж ирдэг тээ? Тэгсэн чинь энд татвар бууруулах санал гаргасан бол төдий хэмжээгээр зардал бууруулах саналыг оруулж өг гэж байгаа юм. Гэтэл одоо манай Засгийн газар, Их Хурал чинь зардлаа нэмэх болохоороо яадаг билээ өөрснөө? 23 оны төсөв 22-хон их наяд байсан шүү дээ. 22-хон их наяд. Тэгээд сонгуулийн төсөв гээд шууд 27 их наяд болгосон 24 онд. Тэгээд өнөөдөр 35 болгож 25 оныхыг оруулж ирж байсан. Одоо энэ төсвийн хүрээний мэдэгдэлд бараг эхний 3 жилдээ 40 рүү орох нь л дээ. Энэ чинь дандаа зардал шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгийг зарж байгаа асуудал. Тэгээд энэ

дээрээ болохоор иргэдээс асуудаг билүү? Бид нар өөрсдийнхөө зардлыг ингэж ингэж нэмэх гэж байна гэж асуудаггүй мөртөө татвар бууруулах саналыг Улсын Их Хурлын гишүүн оруулж ирэхээр чи заавал ч үгүй тэр бууруулах зардлыг нь цуг оруулж ир гэж ингэж дарамталж шахаж байгаа нь бол маш буруу гэж бодож байна. Энэ бол Засгийн газрын хийх ёстой ажил.

Хэрвээ ингэж шаардах юм бол би бүүр төрийн реформ хиймээр байн. Төсвийн реформын чинь ард төрийн реформ явж байгаа юм. Хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгож бууруулна гэдэг санаа чинь ардаа төрийн реформ, төрийн цомхотголыг хийлгэх гэсэн давхар санаа явж байгаа юм. Тэгээд би энийг хийлгэх ийм санал оруулж ирж болох юм уу? Жишээлбэл 2.6 их наядоор хасахын тулд би ийм 10 мянга, 20 мянган төрийн албан хаагчийг цомхотгомоор байна. Хариу.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулна. Нэгмөсөн авчих юм уу? Баярмаа гишүүн нэмж 1 минут тодруулъя.

**Ж.Баярмаа:** Тэгэхээр би цомхотголыг чинь хийх маш мэргэн санаанууд байна л даа. 1 төрийн өмчит компанид сая Барилгын хөгжлийн төвд 3 дэд даргатай болсон гэж яриад байна л даа. 1 байгууллагад шүү дээ. 50 хэдэн орон тоогоор нэмэгдүүлээд тэр дотроо 3 дэд дарга, 1 ерөнхий инженер, бараг 4 дэд дарга. Тэгээд эндээс чинь авхуулаад халаад халаад дарга ангийг чинь цөөлөх боломж зөндөө байна. Тэгээд ийм төрийн реформыг чинь цуг хийгээд оруулаад ирж болох юм уу? Ийм асуулт байна.

Дахиад энд тодруулгаа нэгмөсөн авчихъя. Энэ нөгөө хууль хэлэлцэх даргын зөвлөлөөр ордог тээ? Бүх оруулж ирсэн хуулийг 1 сарын дотор тов дараалалд тусгана гэж байна. Тэгэхээр манай Монголд хуулиас их юм байхгүй. Бараг 900 гаруй, 1000-аад хууль байна. Гэтэл нөгөө хэрэгжилт талдаа, хяналт талдаа сул байна. Энэ Улсын Их Хурлын хамгийн чухал ажил бол.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Хууль 938 хуультай гэдэг. Энд бас яг өдөр тутмын нийгмийн хэм хэмжээ зохицуулж байгаа, дахин давтагдах шинж чанартай хуулиуд нь бол 350 гаруй хууль байгаа. Бусад нь бол хууль хүчингүй болгосон, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан гээд ингээд ингээд 900 болчихдог юм. Тэгээд энэ бол бид нар бас энэ Хууль тогтоомжийн тухай хуулиар энийг би ялгах гэж байгаа. Яг өдөр тутмын иргэдийн нийгмийн харилцааг зохицуулж байгаа хуулиуд нь энэ. Энэ нь бол тийм хууль хүчингүй болсонд тооцох тухай гэдэг юм гэх мэтийн хэрэгждэггүй гэдэг юм уу, шаардлагагүй зүгээр тийм хуулиудын жагсаалт юм гэдгийг ялгаад энэ шийднэ.

Татвар бууруулах бол зардал бууруулах санал. Энийг бид 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 25.1.7-д оруулчихсан. Урьд нь ерөөсөө Улсын Их Хурлын гишүүд ерөөсөө л хязгааргүй зардал нэмдэг. Тэгээд тэр зардлыг нь санхүүжүүлэх гээд чадахгүй болгонгуутаа хий орлого бичдэг. Ингээд ба төсвөө баталчихдаг. Үүнээсээ болоод төсвийн алдагдал гэдэг юм чинь бүүр маш хүнд байдалд ордог байсан. Үүнийг засаж Үндсэн хуульдаа Улсын Их Хурал Засгийн газрын өргөн барьсан төсвийг хэлэлцэхдээ заавал зардал нэмэх гэж байгаа бол

орлого нэмэх биш, зардал нэмэх гэж байгаа бол аль зардлаас нь хасах, баталсан тэр төсвийн зардал дотор л батлах ёстой шүү гэсэн Үндсэн хуулийн зарчим болсон. Энийгээ бид нар бас Улсын Их Хурлын тухай хуульдаа хийгээд өгчихсөн. 71.8 дээр байж байгаа. Өнөөдөр ороод ирчихсэн юм биш Баярмаа гишүүн ээ. Та бид нарыг сая оруулаад ирчихсэн юм бодож байх шиг байна. 19 онд батлаад 20 оны Улсын Их Хурлын тухай хуульд орчихсон заалт одоо хэрэгжээд явж байгаа.

Харин таны санаачилж байгаа 1 хувийн татвартай холбоотой ингээд бүтцийн реформ хийх ийм хууль байх юм бол бүүр талархалтай хүлээж авна. Ингээд төсвийн орлого 1 хувь, хүн амын орлого нь 1 хувь болгосонтой холбоотой ингээд төсвийн орлого ингэж буурна, үүнтэй холбоотойгоор ийм зардлуудыг ингэж цомхотгоё гэсэн санал байвал маш тийм ажил хэрэгч санал хэрэгтэй байна. Одоо манай Алтанхуяг гишүүн эд нар л ярьдаг юм. Гишүүд энэ татвартай холбоотой эрүүгийн хуулийн томоохон өөрчлөлттэй холбоотой заалтыг санаачилгыг бас хуулийн хүрээ хязгаар хумих хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхгүй бол энэ улс орныхоо эдийн засаг төсвөөр тоглочих гээд байна шүү дээ гэж бас манай туршлагатай гишүүд бас ярьдаг. Энийг бас бодох ёстой.

Нөгөө овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ гэж хурлаа таслахгүй бол, санал хураалтад оролцоод байвал Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн хариуцлага яригдахгүй ээ. Ганцхан хууль зөрчөөд, Дэгийн хуулиа зөрчөөд ёс зүйн элдэв зөрчил гаргаад байгаа учраас ёс зүйн хариуцлага ярихаас өөр аргагүй болдог. Урьд нь ч тэгдэг байсан. Урьд нь хуралдаан даргалагч арга хэмжээ авдаг байсан бол одоо Ёс зүйн дэд хороогоор энэ асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр орж байгаа. Аль нэг олонх, цөөнхөд илүү, дутуу үйлчилнэ гэсэн юм байхгүй ээ. Ёс зүйн дэд хороог Улсын Их Хурлын 2 дэд даргын 1 нь ахална гэж орж байгаа. Илүү бас Ёс зүйн дэд хорооны ажлыг нэлээн хариуцлагатай, гишүүдийг хэлмэгдүүлэхгүй байх, хохироохгүй байх.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Баярмаа:** Энэ яах вэ их субъектив л юм болно л доо. Эмх замбараагүй байдал үүсгэсэн. Сая жишээ нь Батбаатар гишүүнийг яаж байна гэж үзэх вэ? Тэгээд үг хэлэх гэж байхад тэнд ингээд давхар яриад эмх замбараагүй байдал үүсгээд байгаа юм уу гэж үзэх юм уу яах юм гэдэг чинь их субъектив учир. Энийг маш сайн бодох ёстой. байх.

1 сарын дотор бүх хур хуулийг тов дараалалд оруулна гэхээр ийм чухал хуулиудыг тэр Байнгын хороонд тэр чанарын хувьд ингэж маш их анхааралтайгаар хэлэлцэж амжих уу? Энэ нэг арай өөр шалгуур байх ёстой юм бус уу? Түүнээс биш өргөн барьсан бүх хуулийг товд оруулна гээд тэгэхээр энэ чинь хэчнээн ч хууль өргөн баригдахыг бас мэдэхгүй. Тэгэхээр нөгөө хуулийн чанарын асуудлыг яаж үнэлэх юм бэ гэдэг асуулт байгаад байна.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Үндсэн хуульд хууль санаачлагч 128 субъект байгаа. Энэ 128 субъектийн өргөн барьсан хуулиудыг хаврын чуулган, намрын чуулган ингэж хэлэлцэнэ ээ гэдгээ бид нар хаврын чуулганыхаа төгсгөлд, намрынхыг намрын чуулганы төгсгөлд хаврынхыг баталчихдаг. Сар сард нь бас төлөвлөгөө баталдаг.

Сар сарын баталсан төлөвлөгөөний дагуу Байнгын хороод асуудал оруулж ирдэг. 7, 7 хоногийн төлөвлөгөө дээр Байнгын хороо саналаа гаргадаг. Байнгын хороодын гаргасан санал дээр үндэслээд даргын дэргэдэх зөвлөл тов тогтоодог.

Тэгээд энэ зарчмаараа л явна. Энэ зарчмаараа үндсэндээ Байнгын хороод нь хэлэлцэх боломжгүй ээ гэж үзэх юм бол энэ бас манайх ирэх 7 хоногт маш их ачаалалтай учраас энэ асуудлыг хэлэлцэхийг нь хойшлууллаа гэх юм бол энэ байдлаар шийдэгдээд явна. Мөн үүнээс өөр өшөө боловсронгуй сайжруулах зохицуулалт байх юм бол энэ хэлэлцүүлгийн явцад манай гишүүд санал гаргаад илүү сайжруулах, өөрчлөх боломжтой. Одоо явж байгаа энэ дэгээ л и жоохон боловсронгуй болгох гээд л урьд нь хязгааргүй сарын хугацаа байхгүй хэдэн жилээр нь хуулийг дардаг байсан бол дарахгүй бай л гэж байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Үдээс өмнөх хуралдаан дээр Гантөмөр гишүүн Баянхонгорт нас барсан цэргийн асуудлаар Их Хурал завсарлаж бас тодорхой арга хэмжээ авах ёстой гэж, энэ зөвлөлийн хурлыг хуралдуулах шаардлага тавьсан. Тэгээд цайны цагаар хуралдсангүй. Тэгээд энэ талаар бас тодорхой мэдээллийг Их Хурлын дарга өгнө үү.

**С.Бямбацогт:** Мэдээлэл аваагүй байна. Засгийн газрын холбогдох албан тушаалтан руу яг ямар асуудал болов, мэдээлэл өг гээд чиглэл өгчихсөн байгаа. Мэдээлэл авангуут бас танд энэ талаар бас эргэж мэдэгдье.

**Б.Пүрэвдорж:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хууль бол зүгээр хэн хэдэн минут ярих вэ гэдэг ийм хууль бол биш. Энэ бол парламентын амин сүнс, олонхын засаглал, цөөнхийн эрхийн тэнцвэрийг хангадаг үндсэн механизм байгаа. Энийгээ би зөв хийхгүй бол манай Улсын Их Хурал өөрөө бодлого гаргадаг, олон талаас нь нягталж судалж мэтгэлцэж ийм гаргадаг ийм институт байх ёстой. Энийгээ зөв хийхгүй бол ерөөсөө л зүгээр улс төрийн шоуны тайз ингээд болоод дуусдаг. Бид нар одоо ч гэсэн жишээг нь харж байна. Улс төржилт нь бодлогын мэтгэлцээнээсээ давчихдаг, популизм, судалгаанаасаа илүү орлодог, олонх нь хурдтай хуулиа батлахыг, цөөхөн шоу хийхийг ингээд илүүд үздэг ийм болчихоод байгаа.

Тэгэхээр энэ Дэгийн хууль дээр бол маш дэвшилттэй ингээд асуудлууд бас орсон байна. Энэ нь юу вэ гэхээр гишүүдийн маань ч хэлж хэлж байсан энэ мэтгэлцээний асуудал байгаа юм. Тэгээд энэ мэтгэлцээний асуудлаар 9.7 дээр ялангуяа нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах хороон дээр гишүүд гаргасан бол би үгээ хэлчхээд яая, тэгээд нийтдээ 8 минутаар гээд ингэсэн байна. Гэхдээ нийтдээ мэтгэлцээн хийхээргүй байх юм бол нийт гишүүдэд хуваарилагдаж байгаа тоо бол асуулт хариулттайгаа 12 минут байгаа. Тэгэхээр хүсэлт гаргасан бол нэгдсэн чуулгандаа ч, Байнгын хороондоо ч өөрөө мэтгэлцээний журмаар нийтэд нь аваад асуулт, хариултаа хий гэдэг маань 12 минутаасаа яагаад 8 минут болж байгаа юм бол, яагаад арай багаар өгсөн юм бол гэдэг дээр 1 дүгээр асуулт байна.

Энэ их чухал юм байгаа. Яагаад гэвэл бид нар одоогийн энэ дэгдээ баригдаад асуулт асуухаар 3 минутад асуулт асуудаг, ихэвчлэн бас камерт хандаж

үг хэлэх болдог. Тэгээд хариулт нь гэхээр 4 минут ингээд ерөөсөө тэр хариулт нь байхгүй ингээд урьтал оршил явсаар байгаад дуусчихдаг. Хайран цаг байдаг байхгүй юу. Тэгэхээр энийг ийм оптимальный сайн мэтгэлцээн, хэлэлцүүлэг явах ийм байдал руу орж байгаа нь зөв. Гэхдээ энэ минут дээр 1 дүгээрт яагаад 8-аар тогтоосон 12 минут байх боломжтойг ингэсэн юм бол гэдэг дээр хариулт авъя.

2 дугаарт, гишүүн энэ санал, зарчмын зөрүүтэй санал гаргасан бол бас мэтгэлцээнийг гаргаж хүсэлт тавьсан бол 1 цагийн дотор шууд мэтгэлцээн явуулах боломжтой болж байгаа гэдэг нь бас сайшаалтай байна. Ер нь бол бид нар ингээд нэг зүгээр хийрхсэн юу гэдэг юм камерт зориулсан байдлаар үг хэлж поппрох гэхээсээ илүү судалгаа тооцоотой 2 талаасаа энийгээ шүүн хэлэлцдэг мэтгэлцээний зарчмыг бол Байнгын хороон дээрээ ч, нэгдсэн чуулган дээрээ ч байгаад байгаа юм. Тэгэхээр энийг одоогоор бол яах вэ зөвхөн Байнгын хороон дээр гишүүн гаргасан өөрийнхөө саналтай холбоотойгоор мэтгэлцээн гаргах хүсэлт тавьж болохоор байгаа юм байна.

Чуулган дээр энийг оруулахад ямар саад гарах вэ, ямар юу нь болохгүй байх вэ гэдэг дээр судалгаа байгаа юм болов уу? Яагаад эхний ээлжид зөвхөн Байнгын хороон дээр гэж оруулж өгч байгаа юм бол гэдгийг 2 дугаарт бас асуумаар байна.

Энэ дээр бол яах вэ санал жоохон цаашид яах бол доо гэж зовниж байгаа асуудал бол энэ санал хураалт явах дэгтэй холбоотой асуудал байгаа. Хуралдааны ирцээс гадна санал хураалтын ирцийг тусад нь авдаг болоод байгаа. Энэ маань өөрөө цаашид яах вэ гэхээр юу гэдэг юм хариуцлагагүй гишүүдийн хувьд бол тэртээ тэргүй л санал хураалтад орохгүй юм чинь гээд орохгүй байх юм бол нөгөө хуралдаанд орж ирсэн хүмүүсийнхээ олонх нь санал хураалтынхаа ирцдээ орохгүй бол дахиад санал хураалт маань гацах эрсдэлтэй байгаа юм. Ингээд гацаад байх юм бол юм маань шийдэгдэхгүй, цаашаа явахгүй гэдэг зүйл байгаад байгаа. Тэгэхээр энэ нь өмнөхөөрөө зөвхөн байхгүй нь тэр хасах буюу дэмжээгүй санал өгсөн гэдэг байдлаараа явчихвал яадаг юм бэ? Үгүй бол энэ бол цаашаа ингээд нэг ийм механик юм руу ороод Улсын Их Хурлын үйл ажиллагаанд саад учруулах ийм хөшүүрэг болчих вий дээ гээд санаа зовниж байгаа юм. Тэгэхээр ийм 3 асуулт байна.

**Б.Пүрэвдорж:** Дэгийн тухай хуулийн 36.7-гоор энэ энэ хуулийн төслийн асуудлаар 90 минутаас хэтэрсэн учраас 1 цагаар сунгаж, 1 цаг хүртэл хугацаагаар сунгаж болох байгаа. Ингээд 2 хүн асууна. Тэгээд цагийг сунгаж байна.

Тэгэхээр ингээд жишээ нь Номинчимэг дарга Байнгын хорооны дарга Номинчимэг үг хэлж байх үед жишээ нь Эрдэнэбүрэн гишүүн ширээ чанга цохиод, аль эсвэл Мөнхбаясгалан гишүүн үг хэлж байхад нь хажуугаар нь ярих юм бол та хоёрт 30 хоногийн банн тавьж үг хэлэх эрхийг чинь хасна. Тэр нь бол даргын үзэмжээр шийдэгдэнэ. Номинчимэг гишүүний асуултад Бямбацогт дарга хариулна.

**С.Бямбацогт:** Их Хурлын дэд дарга хуралдаан даргалагч бас яг мушгиж тайлбарлаж байна. 30 хүртэл хоног Ёс зүйн дэд хороогоор шийднэ ээ гэж байгаа юм. 1 хоног байж болно. 3 хоног байж болно. 7 хоног байж болно. Хуралдаан даргалагч биш Ёс зүйн дэд хороо энэ гишүүний саяын ёс зүйн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ ээ гэж. Тийм болохоор энэ бол илүү уян хатан илүү нөхцөл

байдалтай өөрчлөх. Энийг хэлэлцэх эсэх явцдаа өөрчилж болно, сайжруулж болно. Энэ чинь хэлэлцэх эсэх нь л явж байгаа шүү дээ гишүүд маань. Тийм болохоор энийг 1 дүгээрт ингэж ойлгоосой.

2 дугаарт нь 8 минутаар мэтгэлцээн явах нь сайн боловч яагаад 12 минут биш вэ гэж . Ер нь адилхан болгож байгаа . Одоо чинь Байнгын хороон дээр гишүүдийн асуулт асуух нь 3 минут, хариулт нь 4 минут. Чуулган дээр гишүүдийн асуулт 4 минут, хариулт нь 3 минут гэсэн ийм дэгээр л явж байгаа. Тийм болохоор ийм ялгаатай дэгээ адилхан болгочихъё.

Дээрээс нь манай Лодойсамбуу гишүүн маань ярьдаг байсан Лодойсамбуу гишүүний саналаар орсон. Шатрын цаг шиг 1 минут асуугаад 1 минут хариулаад ингээд бэлийц байдлаар ингээд явдаг болохоор илүү бас таны хэлж байгаа илүү ач холбогдолтой, попордог, шоуддаг биш илүү ажил хэрэгч асуултаа асуугаад ажил хэрэгч хариулдаг болох ийм боломж нээгдэх юм байна гэж үзсэн.

Дээрээс нь мэтгэлцээнийг яагаад зөвхөн чуулган дээр биш Байнгын хороон дээр бэ гэж. Мэтгэлцээн бол мэргэжлийн Байнгын хороон дээр илүү мэргэжлийн тухайн салбарын асуудал илүү тод яригддаг, илүү чөлөөтэй хэлэлцэх боломж бий болдог. Тийм болохоор мэргэжлийн Байнгын хороонд харьяалагдаж байгаа гишүүд маш тодорхой ойлголттой, мэдээлэлтэй, болъё. Тэгээд тэнд хагалчихсан асуудлыг дахиад заавал чуулган дээр мэтгэлцээд байх шаардлагагүй илүү бас төлөвлөсөн хугацаанд ажиллаад зөв зохион байгуулж дуусгах, ажил хэрэгч байх үүднээс ингэж оруулсан.

Хэрвээ үнэхээр чуулган дээр ч бас мэтгэлцээн байя гэж үзэх юм бол хэлэлцүүлгийн явцад бас чуулган дээр мэтгэлцээнийг байлгаж болно. Ер нь мэтгэлцээн бол бас нэг маш том жишиг, соёл бий болох гэж байгаа бид нар. Тэгээд л асуулт нь нэг нь асуусан болдог нөгөөдөх нь хариулсан болдог. Эндээс ард, иргэдийн ойлголт ч сайн гүйцэт ойлголт бий болдоггүй. Гишүүд ч хангалттай хариултаа авдаггүй. Саналаа өгөх гээд тэгэхээр эргэлзээ үүсдэг. Дэмжих үү, дэмжихгүй юу гэдэг дээр. Хэрвээ мэтгэлцэх явцад нь бусад гишүүд нь өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй дэмжиж үү, эс үгүй бол дэмжихгүй байх санал байх илүү итгэл үнэмшил нь бий болж, шийдвэр гаргалт маань зөв болно. Парламентын үйл ажиллагаа тогтоож байгаа хууль тогтоомжийн чанар сайжирна гэдэг үүднээс ийм мэтгэлцээнийг оруулж ирсэн. Шаардлагатай гэвэл чуулган дээр бас мэтгэлцээнийг бас оруулах боломж бас байгаа.

**Б.Пүрэвдорж:** Номинчимэг гишүүн нэмж тодруулъя.

**О.Номинчимэг:** Одоогийн дэгээр бол асуулт асуух 3 минут, тодруулаад нэмэлтээр 1 1 минут гээд дахиад байгаа тээ? Тэгэхээр асуулт асуух хүнд бол 5 минут, хариулт хэлэх хүнд 4 минут 1, 1 гээд 1, 1 байгаа. Яах вэ төсөл дээр бол асуулт 3, 4 гэж байсан. Тэгэхээр ингээд нийлээд үзэх юм бол бараг 11 юм уу, 12 минут байгаад байгаа юм. Хэрвээ тэр хэвээрээ байгаа бол энэ юу гэдэг юм шууд нэмэлт бүтэн цагаа авч байгаад мэтгэлцэх боломжийг нь, асуулт, хариулт явах боломжийг нь ч гэсэн адилхан хугацаагаар болгож тавих нь зүйтэй байх гэсэн саналтай байна. Тэгэхгүй бол ингээд нэг хэлбэрээр явахаараа өөр хугацаатай байдаг нь бас зохимжгүй. Адил тэгш байдлыг нь хангах нь зүйтэй байх гэсэн саналтай байна.

Тэгээд энэ сая сөрөг хүчний хан маань бас нэлээн хэлсэн үгэнд эмзэглэж хүлээж авч байх шиг байна. Олонх бол шүүмжлүүлээд сурсан. Шүүмжлэлээ хүлээж авдаг. Сөрөг хүчин ч гэсэн бас дутагдалтай зүйл дээрээ шүүмжлэл хэлэхээр энэ дээр ингэж бас их эмзэг хүлээж авч байгаад бас гайхаж байна. Гэхдээ парламент маань ч гэсэн яг энэ чиглэлээрээ хүчтэй байр сууриа хийлгээд мэтгэлцдэг хоорондоо ажил хэр.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Лодойсамбуу гишүүн нэмж хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Парламентын гишүүд ээ, асуулт асууж, хариулт авч энэ ажил хэрэгч байж сурмаар байна. Сая одоо цөөнх нь шоудаад гэдэг чинь ямар юмных нь шүүмжлэл байх юм. Доромжлол шүү дээ энэ. Цөөнх шоудаж байгаа биш 12 жил олонх нь шоудаж байгаа шүү дээ энэ төсвийн хамаг хөрөнгөөр. Жинхэнэ шоудаж байгаа хүмүүс чинь дэргэд чинь сууж байгаа шүү дээ. Та нар 28 онд цөөнх болноо Номинчимэг ээ за юу.

**Б.Пүрэвдорж:** Ер нь бол энэ парламент бол маш тийм амьд орчин байх ёстой. Ер нь бол энэ олонх, цөөнх үг хэлж байхад бол мэдээж цөөнхийг нь шүүмжлэхэд олонх нь бас тодорхой реакци үзүүлнэ. Олонх нь дээрэлхэхэд цөөнх нь бас тодорхой реакци үзүүлнэ. Тэр болгон дээр дув дуугүй сууж байх ёстой бол энэ парламент чинь ямар ч эрүүл мэтгэлцээний газар болж ерөөсөө чадахгүй болчихоод байгаа юм л даа. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Миний бие бас парламентад 8 суудалтай ХҮН нам цөөнх сая Номинчимэг гишүүний бас хэлсэн үг дээр бас үг хэлэх хэрэгтэй байна. Ингэж болохгүй ээ. Ингэж юу гэдэг юм цөөнх рүүгээ шоуддаг гэж. Бид ямар шоудах гэж энд үг хэлдэг юм уу. Бид цөөнхийн дуу хоолой болж энэ парламентыг чинь амьд байлгах гэж ингэж явж байгаа хүмүүс. Тэгэхээр энэ дээр бас та бол Англид бас ажиллаж амьдарч байсан Англи улс бол яг энэ парламентын ардчиллын өлгий нутаг. Тэгээд энийгээ сайн та бас мэддэг байх гэж бодож байна.

Миний энэ Улсын Их Хурлын энэ чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бол 34-ийн штрих 1-тэй 1 дэх заалтын тал дээр л би жоохон асууя гэж бодсон юм. Энэ дээр ингэж байгаа юм Улсын Их Хурлын Тамгын газрыг нэлээн эрх мэдлийг нь нэмээд Улсын Их Хурлын гишүүдийн дээр сандайлуулчхав уу даа л гэж би хараад байна л даа. Яагаад гэдгээ тайлбарлая. Ер нь бол эзэн агент буюу “Principal agent” гэдэг ийм онол байдаг юм. Эдийн засгийн онол, компанийн засаглал дээр байдаг онол. Тэгэхээр эзэн гэж хэн юм бэ? Энэ бол иргэд, энэ бол сонгогчид. Тэдний үүргийг гүйцэтгэж, тэдний дуу хоолой болж байгаа Улсын Их Хурал өөрөө.

Гэтэл Улсын Их Хурлын гишүүн өөрөө ингээд хууль санаачлаад ингээд явж байх үед Байнгын хороо шаардлагатай гэж үзүүл гэж байгаа юм. Энэ өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл болон төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар хэлэлцүүлгийн явцад Тамгын газраар хууль зүйн дүгнэлт гаргуулна гэж. Дүгнэлт шүү. Зөвлөмж биш. Энэ бас нэлээн тийм Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын эзэд болсон иргэд, сонгогчдын эрхийг хэрэгжүүлж байх энэ рүү бол бас халдах ийм боломжуудыг бий болгоод байгаа юм биш байгаа. Ийм аюул бий байгаа юм биш байгаа гэж би харж

байна. Би бол хуулийн дагуу Үндсэн хуульд нийцүүлсэн ийм үйл ажиллагаа бол мэдээж хүлээн зөвшөөрнө.

Гэхдээ Улсын Их Хурлын Тамгын газар ингээд шүүлтүүр хийгээд эхлэхээр 1 дүгээрт бол энэ хууль зүйн дүгнэлт гаргаж байгаа нь ер нь бол парламентын энэ захиргааны байгууллага улс төрийн шийдвэр гаргах түвшинд нөлөөлж байгаа хэлбэр биш юм уу гэж асуумаар. Хууль зүйн дүгнэлт гэдэг нэртэй боловч бодит байдал дээр энэ улс төрийн нөлөөллийн хэрэгсэл болж хувирах эрсдэл байна.

Ялангуяа сөрөг байр суурьтай гишүүдийн санал дээр Тамгын газрын дүгнэлт дээр зарим талаараа дарамт үзүүлэх боломж байгаа юм биш байгаа гэж. Ер нь бол Тамгын газар бол тэр агент буюу туслах үйлчилгээний чиг үүрэгтэй ийм байгууллага. Зөвлөмж гаргаж байх явдал. Гэтэл ийм эрх хэмжээ өгөөд хяналт тавих ийм эрх хэмжээ өгөөд эхэлж байгаа нь бол парламентын ардчиллын ардчиллын зарчимтай зөрчилдөхгүй юү? Түүний зэрэгцээ Тамгын газар хууль зүйн дүгнэлт, төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг 10-15 өдрийн дотор гаргана гэсэн үг. Улс төр эдийн засгийн яаралтай нөхцөлд гишүүний санаачилгыг ингэж саатуулдаг ийм механизм бий болох юм шиг байгаа гэсэн ийм болгоомжлол байна.

Тэр шаардлагатай гэж үзвэл гэдэг чинь өөрөө нэлээн тийм субъектив байна субъектив байна. Энэ нь бол зарим нэг гишүүн дээр хатуу хандаад, зарим нэг гишүүн дээр нь дүгнэлт гаргана гээд ингээд эхлэх юм биш байгаа гэсэн ийм болгоомжлол байна. Эцэст нь бол Монгол Улсын Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх гэдэг энэ тал дээр нь Үндсэн хуулийн нийцлийг урьдчилан гаргах ийм чиг үүргийг Тамгын газар ингээд хэрэгжүүлээд эхлэхээр энэ цэцийн бүрэн эрхтэй давхцаж байгаа юм биш байгаа гэсэн ийм болгоомжлол байна. Тэгэхээрээ энэ тал дээр бас энэ хууль санаачлагчид ямар бодолтой байна? Энийг зүгээр тодруулж асуух гэсэн юм. Яагаад гэвэл энэ чинь яг л бид чинь иргэдээ төлөөлж, Улсын Их Хурлын гишүүний хувиар хамгийн чухал үүргээ гүйцэтгэж байгаа улсууд шүү дээ. Ийм л байгаа учраас энэ асуултыг асууж байгаа юм. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын Тамгын газар бол Улсын Их Хурлын гишүүдэд Улсын Их Хуралд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Энэ чиг үүргийнхээ хүрээнд Улсын Их Хурлын баталж гаргах хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн байх, бас бусад хуультай зөрчилдөхгүй байх, илүү боловсронгуй, илүү чанартай, илүү хууль хоорондын хийдэлгүй, зөрчилгүй, давхцалгүй, хууль зүйн техникийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагуудыг хангасан байх гээд энэ дээр л дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Энэ үүднээсээ Байнгын хороо Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан хуулийг хэлэлцүүлгийн явцад Байнгын хороо гишүүд санал гаргавал шаардлагатай гэж үзээд санал гаргах юм бол дэмжин туслах чиг үүргээ л хэрэгжүүлье гэж байгаа юм. Энэ заалт бол 2024 оны дэгийн хуульд байсан. Энийг 25 оны 7 сарын хуулиар аваад хаячихсан юм байна лээ. Гэтэл энийг эргээд бас байх нь зөв юм байна гэж маш олон гишүүдээс санал гарсан юм. Тэгээд эргэж орж ирж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын баталсан хууль тогтоомжид хайхрамжгүй хандаад баталчихдаг. Дахиад нөгөө Цэц дээр очоод бөөн асуудал

болдог. Тэгээд л ба Их Хурлын баталсан хууль болгон Цэц дээр очоод Үндсэн хууль зөрчсөн байна гэж гарахаас л урьдчилан сэргийлэх, Үндсэн хууль зөрчөөгүй, бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй байлгах үүднээс гишүүд өөрсдөө санал гаргаад алив та нар мэргэжлийн хүмүүс үзээдэх, хараадах бид нар буруу хууль батлах гэж байна уу, Үндсэн хууль зөрчсөн хууль батлах гэж байна уу алив нэг хууль зүйн дүгнэлт гаргаад өгөөдөх гэх юм бол Тамгын газар гишүүдийн үүрэг, даалгаврыг биелүүлж ажиллана.

Бусдаар өөрийн санаачилгаар, өөрийн үзэмжээр хууль зүйн дүгнэлт, зөвлөмж гаргахгүй. Одоо бол зөвлөмж гэж байж байгаа. Урьд нь бол дүгнэлт гэж байсан. Энийг бол ингээд гишүүд олон гишүүдээс санал гаргасан учраас оруулж ирсэн юм. Ийм бас ялгаатай байгаад байгаа. Тэгээд Улсын Их Хурлын хэлэлцэж байгаа Их Хурлаар батлах хууль тогтоомжууд маань илүү чанартай, Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй байх илүү хууль тогтоомжийнхоо чанарыг сайжруулах л үүднээс орж ирж байгаа санал. Энд бол түрүүн дахин хэлэхэд гишүүд өөрсдөө санаачилж, шаардлагатай гэж үзэх юм бол гэдэг маань гишүүд энэ ер нь эрсдэлтэй хууль байна шүү, энийг нэг үзчихмээр байна шүү. Тэгээд Байнгын хороон дээр гишүүд маань санал гаргаад аливаа Тамгын газар мэргэжлийн хүмүүсээ суулгаад ажиллаадах гэх юм бол шаардлагатай гэж үзнэ гэдэг маань тэгж байгаа юм.

Шаардлагатай гэж үзэх юм бол гээд түрүүн бас бид нар ярьсан шүү дээ. Мэтгэлцээн зохион байгуулна гэж. Түүнтэй адилхан шаардлагатай байна мэтгэлцье ээ энэ дээр итгэл үнэмшилтэй болъё, санал өгөхөд жоохон эргэлзээтэй байна гэсэн үед тэрэнтэй адилхан л шаардлагатай гэж үзээд гишүүд маань санал гаргавал ажиллана. Тэгэхгүй бид санаачилж байгаа хэлэлцэж байгаа хуулиа мэдэж байна, асуудал байхгүй гээд явах юм бол Тамгын газар хөндлөнгөөс оролцохгүй.

**Б.Пүрэвдорж:** Наранбаяр гишүүн нэмж тодруулъя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр Бямбацогт даргын яг санааг бол би шууд хүлээн зөвшөөрч байна. Энэ байх ёстой. Энэ ингээд хууль зүйн дүгнэлт, мэргэжлийн ийм хууль зүйн ийм зөвлөмжүүдийг бол байж болно. Дүгнэлт гэж уучлаарай би сая андуураад ярьчихлаа. Гэтэл байна шүү дээ энэ 34-ийн штрихтэй 1.1 дээр болохоороо юу болоод байна вэ гэхээрээ хууль зүйн дүгнэлт гаргуулна гээд биччихсэн байгаа байхгүй юу. Зөвлөмж гэж бичээгүй байна. Энэ дээр яг энэ дээр бол.

Тэгэхээр зэрэг таны тайлбар болохоор үгүй ээ дүгнэлт биш ээ зөвлөмж гээд. Энэ чинь нөгөө 25 оныхоо юун дээр бол зөвлөмж гэж байсан шүү дээ. Тэгэхээр энэ зөвлөмж гэдэг нь хэвээрээ явж байна гэж би ойлголоо. Зөв үү? Энэ дүгнэлт гэдэг үгээр л яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг энэ дүгнэлт гэдэг үг чинь бас өөрөө аюултай. Энэ зөвлөмж бол байж болно. Яг зөвлөн туслах ийм чиг үүрэгтэй байгууллага шүү дээ. Түрүүнд ярьсан тэр эзэн агентын онолоороо бол эд нар чинь хамгийн мэдээлэл сайтай мэргэжлийн байгууллага. Энэ утгаараа зөвлөмж бол өгч болно, зөвлөгөө өгч болно. Тэгэхээр ийм байгаа гэж ойлго.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэг юм би бас нэмээд та тодруулаад хэлчхээч. 1 гишүүний бас нэг Үндсэн хууль зөрчсөн тул энэ асуудлыг тогтоолыг хэлэлцэхгүй гэдэг нэг

ийм бас дүгнэлт гарсан шүү дээ. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн цэцийн хийх ёстой ажлыг үүгээрээ зохицуулж өгч байгаа биз дээ. Өөрөөр хэлбэл, бусад байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар давхцаж юм хийх, дүгнэлт гарахгүй биз дээ гэдэг ийм бас асуултыг. Бямбацогт дарга 1 минут.

**С.Бямбацогт:** 24 онд баталсан хууль дээр бол дүгнэлт гэж байсан. Тэгээд 25 онд энэ дүгнэлт биш зөвлөмж болгоё, зөвлөмж болгосон юм байна лээ. Одоо сая гишүүд ингээд дүгнэлт гаргая. Зөвлөн туслах Улсын Их Хурлын баталж байгаа хууль тогтоомж илүү чанартай байх, энэ дээрээ зөвлөх биш дүн шинжилгээ хийж байгаад зөвлөн туслах энэ агуулгаар дүгнэлт болгосон. Зөвхөн энэ төслийн хүрээнд гаргаж байгаа тухайн санаачилсан хуулийнх нь төслийн хүрээнд л зөвлөмж гарна. Бусдаар Пүрэвдорж даргын хэлж байгаатай адилхан Үндсэн хууль зөрчиж байгаа, зөрчихгүй байгаа гэдэг асуудал яригдахгүй.

Тийм болохоор дүгнэлтийг та бас хэрвээ дүгнэлт биш ээ энэ зөвлөмж хэвээрээ байя гэх юм бол буцаагаад зөвлөмж болгох болно. Ер нь Улсын Их Хурал дээр баталсан хуулиуд маань тэгээд л очоод л Цэц дээр очоод л хад мөргөдөг, эс үгүй бол үндэсний аюулгүй байдал зөрчсөн байна. Улс орны эдийн засагт нэлээн тийм ноцтой, хор хохирол учруулахаар байна ингээд байвал бид нар чинь өөрсдөө л нөгөө өөрсдөө л нэр хүнд маань.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Ариунзаяа нэмж хариулах юм уу болчихсон уу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалалгүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Зулпхар гишүүн индрийн 1 дүгээр микрофоноос үг хэлнэ.

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Бидний хувьд бас их чухал хуулиудыг энэ хаврын чуулганаар хэлэлцэж байна. Хууль болгон чухал. Түүн дотроо Улсын Их Хурал Монгол Улсад хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн эрх дээд байгууллагын хувьд өөрийнхөө үйл ажиллагааг цаашид илүү боловсронгуй болгох, нөгөөтээгүүр иргэдийн хүсэлтэд нийцсэн байдлаар шийдвэр гаргадаг, иргэдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглэсэн үйл ажиллагаагаа илүү чамбай болгох чиглэлээр энэ хуулийн төслийг оруулж ирж хэлэлцэх гэж байгааг бол би хувьдаа бол бүрэн дэмжиж байна.

Гэхдээ мэдээж хэрэг хуультай холбоотой талуудын байр суурь бол бүрэн мэтгэлцээний зарчмаар явах ёстой гэж ойлгож байна. Ардчилсан намын жишээ нь байр суурь их тодорхой байр сууриуд байна. Манай Иргэний Зориг намын, ХҮН намын байр суурь байна. Тэгэхлээр Их Хурал бол өөрөө ардчилсан засаглалын гол шалгуур болсон мэтгэлцээний талбар. Тэгэхлээр энэ талбар дээр бид бол энэ хуулийг нарийвчлан зүйл, заалт болгоноор нь жишээ нь хэлэлцэж байж Их Хурлаар жишээ нь бидний гаргах хуулийн болон бусад бодлогын шийдвэрүүд нь иргэдийн хүсэл, сонирхолд нийцсэн байдлаар гаргах энэ дэг бол өөрөө сахигдана гэж ойлгож байгаа юм.

Нөгөөтээгүүр жишээ нь энэ хуульд бол бас зарим нэг шинэ зүйлүүд бол байгаа. Тэр бол мэдээж хэрэг Их Хурлын өөрийнх нь жишээ нь сахилга хариуцлагатай холбоотой асуудал. Энэ сахилга хариуцлагатай холбоотой асуудлыг бид бас олон улсын туршлага, өнгөрсөн хугацаанд бид парламент ёс Монгол улсад бэхжих явцад бий болсон бас өөрсдийнхөө туршлагатай тулгуурласан байдлаар, нөгөөтээгүүр бидэнд тулгамдсан зарим сорилттой уялдсан байдлаар бас сайжруулах чиглэлээр бас зоригтой орох ёстой гэж бодож байна.

Учир юу гэхлээр зэрэг би 126 гишүүнтэй шинэ парламент гэж өөрсдийгөө нэрлэдэг. Шинэ гэдэг нь бол бид бүрэлдэхүүний хувьд бол шинэ. Тэрнээс бид бол парламент өөрөө Монголын ардчилсан парламент өнгөрсөн 36 жилийн үндсэндээ ардчиллын үйл явцыг бол бэхжүүлэхэд гол үүрэг хүлээсэн парламент буюу хууль тогтоох институт учраас бидний хувьд бол энэ хууль их чухал. Тийм учраас хууль санаачлагч нарын энэ санаачилгыг бол бид бүрэн дэмжээд гэхдээ мэдээж хэрэг тодорхой асуудлуудын тодорхой нөхцөлүүдийг нарийн судалж, нарийн хэлэлцэж, энэ шийдвэрийг энэ хаврын чуулганаар гаргах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байна. Ийм учраас та бүхнийг бас дэмжиж саналаа өгөхийг бас уриалж байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Зулпхар гишүүнд баярлалаа. Бадарчийн Хэрлэн гишүүн үг хэлнэ. Индрийн 1 дүгээр микрофон.

**Б.Хэрлэн:** Эрхэм гишүүддээ өдрийн амрыг амар амгаланг айлтгая. Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль энэ 3 хуульд нэмэлт, өөрчлөлтийг нэг дор оруулж ирж байгаа нь тун зөв гэж үзэж байна. Тэгэхээр нягт уялдаатай энэ 3 хуулийг хамтад нь авч үзэж байж бид нар Их Хурлын үйл ажиллагаанд дорвитой өөрчлөлтийг хийж чадна байх.

Хуулийн өөрчлөлт хийх үндсэн шалтгаан нь Их Хурлын үйл ажиллагааг илүү үр бүтээлтэй болгох, бүтээмжийг дээшлүүлэх явдал гэж харж байгаа. Тэгэхээр Их Хурлын үр бүтээл, бүтээмжийг дээшлүүлэхийн тулд нэн тэргүүнд гишүүдийн ажиллах боломжийг нэмэгдүүлэх явдал бол хамгийн чухал гэж харж байна.

Тэгэхээр хууль санаачлагчдын хуулийнхаа төслийн үзэл санааг хадгалах, хамгаалах, тайлбарлах, гишүүд үзэл бодлоо уралдуулах, бүтэн 1 цагийн туршид мэтгэлцэх зэрэг ийм дэвшилтэт санаанууд орж ирсэн нь бол энэ хуулийн төслийн бас нэг сайн тал гэж харж байна.

Түүнчлэн энэ хуулийн төсөлд Их Их Хурлын үр бүтээл, бүтээмжийг дээшлүүлэхийн тулд хуралдааны бэлтгэлийн тухай бас тодорхой хэмжээгээр оруулах зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна. Тэгэхээр хуралдааны бэлтгэл гэдэгт чухам бид нар яг хуралдааны зарыг хүргэх, танхим, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах хэмжээнд бид нар ойлгохгүй болов уу. Тэгэхээр хуралдааны бэлтгэл гэдэг бол хурлаар хэлэлцэх асуудалд холбогдох зарим материалыг хуралдаан дээр тарааж байдгийг зогсоож, харин шийдвэр гаргахаар орж ирж байгаа хуралдааны Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэх асуудлын талаар урьдчилан материалыг авч судалж, санаа бодлоо цэгцэлж, шийдвэрийг өөрөө

өөртөө гаргаад орж ирэх ийм нөхцөлийг бүрдүүлэх явдлыг хуралдааны бэлтгэлийг хангах гэж ойлгох болов уу. Тэгэхээр энэ талын асуудал дээр Дэгийн тухай хуульд бас тодорхой зааж өгөх хэрэгтэй байна.

Их Хурлын үр бүтээл, бүтээмжийг дээшлүүлэхийн тулд сахилга батыг сайжруулъя гэсэн санаа нэлээн түлхүү орж ирсэн байна. Тэгэхээр Улсын Их Хурлын ёс зүйн дүрмээр өмнө нь жилийн нийт хуралдаанд 50-аас дээш цагаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хурлаар оруулж хариуцлага хүлээлгэдэг байсан. Одоо ээлжит чуулганы буюу 75 хоногийн хугацааны энэ хуралдаанд 5-аас дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол 1 сарын хугацааны чуулганы чуулганы, Байнгын хорооны, дэд хорооны ажлын хэсгийн хуралдааны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд оролцоогүй бол Ёс зүйн дэд хороо хариуцлага хүлээлгэж тогтоол гаргахаар ингэж зааж оруулж ирсэн байгаа.

Өөрөөр хэлбэл, хүлээлгэх хариуцлага нь илүү чангарч орж ирсэн. Тэгэхээр ер нь бид нар төсөв батлах үед бол бид нар хэдэн зуун гаран санал хураадаг. Олон гишүүн магадгүй энэ хариуцлага тооцоход хүрч магадгүй. Хэдийгээр хууль нь байгаа ч гэсэн магадгүй бас олон хүн хариуцлага тооцох болоод ирэхээр энэ хуулиа яг бүрэн хүчин чадлаар нь хэрэглэхгүй болчих вий, ийм байдал үүсэх вий гэж би бас бодож байна.

Хариуцлага хүлээлгэхдээ ер нь бол зөөлнийг нь хатуутай нь уялдуулах, тэнцвэртэй байдлыг хадгалах талаас нь бодолцох хэрэгтэй байна гэж ажлын хэсэгт хэлмээр байна. Зан үйлийн шинжлэх ухаанд албадлагын аргыг түлхүү хэрэглэх нь богино хугацаандаа үр дүнгээ өгөх мэт боловч алс хэтдээ сөрөг нөлөөтэй байдаг, үр бүтээлийг бууруулдаг гэж ерөнхийдөө тайлбарладаг. Албадах тусам улам зөрдөг талтай гэж зан үйлийн шинжлэх ухаанд авч үздэг. Тэгэхээр үүнийг хууль санаачлагчид цаашдаа анхааралдаа авна уу гэж хэлье.

Тэгээд хуулийн төслийн үзэл баримтлалыг ерөнхийд нь дэмжиж байна. Хэлэлцүүлгийн явцад улам чамбайруулаад явахыг та бүхнээс хүсье.

**Б.Пүрэвдорж:** Хэрлэн гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалтыг 3 хуулийг хэлэлцэж дууссаны дараагаар явуулна. Дараагийн хуулийн төсөлд орьё.

16.25 цаг

**Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуульд тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**А.Ариунзаяа:** Эрхэм Улсын Их Хурлын дарга, дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурал хууль Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй. 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн эдгээр заалтад нийцүүлэн 2021 онд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг батлан 2024 онд шинэчлэн баталснаар нийт 5 жилийн хугацаанд Улсын Их Хуралд хянан шалгах бүрэн эрхээ энэхүү хуулийн хүрээнд хэрэгжүүлж ирлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд парламентын хяналт шалгалтаа зохион байгуулж ирсэн 5 жилийн хугацаанд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чамгүй туршлага хуримтлуулж, холбогдох мэдээллийн нэгдсэн сан, бүртгэл хяналттай хяналттай болсны зэрэгцээ цаашид сайжруулбал зохих хууль хоорондын нийцлийг хангах тодорхой асуудлуудаа таньж эрэмбэлж авсан. Үүнд:

Хяналт шалгалтын төлөвлөлт, цаглаврын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт сул, бүрэн төлөвшөөгүй байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлгээ, дүн шинжилгээ хийх, түүний үр дүнг Улсын Их Хурлаар хэлэлцэх үе шат, үйл ажиллагааны зохицуулалт оновчгүй үр дүн, зохион байгуулалт хангалтгүй байна.

Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд тавих хяналтын механизмыг зайлшгүй сайжруулах шаардлагатай. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэл үр дүнг Улсын Их Хурлаар хэлэлцэх хүрээ хязгаарыг оновчтой болго, цаглаврын хувьд хууль хоорондын зөрчлийг арилгах шаардлагатай. Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох, давтан болон гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүд холбогдох албан тушаалтан мэдэгдэл, хариулт, арга хэмжээний талаарх үүрэг амлалтыг системтэйгээр бүртгэх, мэдээлэх, хянах нэгдсэн механизм хангалтгүй байна.

Хянан шалгах түр хорооны зарим зохицуулалтыг оновчтой тодорхой болгох зэргээр сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойллоо.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн явцад үүсэж буй хүндрэл, эрх зүйн хийдэл, давхардал, процедурын тодорхойгүй байдлыг арилгах, парламентын хяналтын үр нөлөө, хараат бус, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Бат-Эрдэнэ, Н.Батсүмбэрэл, Ж.Батжаргал, Б.Бейсен, Ч.Лодойсамбуу, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, Ц.Сандаг-Очир, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн нарын хамтаар миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлэх төслийг боловсруулж, 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ.

Хуулийн төсөлд туссан зарим асуудлуудыг багцлан танилцуулъя. Төрийн байгууллагуудын хяналт шалгалтын давхардлыг бууруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөлт, цаглаврын зохицуулалтыг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, хяналт шалгалтын цаглаварт санал өгөх давхардлыг арилгах зорилгоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн холбогдох хэсгийг өөрчлөн найруулж, хяналт шалгалтын ачаалал, үр дүнгүй давхардлыг бууруулах санал боловсрууллаа.

Байнгын, дэд хороодын хяналт шалгалтын ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хяналт шалгалтын ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулах эрх олгож, ажлын хэсэг байгуулсан тогтоолын хавсралтаар ажиллах удирдамжийг хамтад нь батлах зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх боломжтойгоор өөрчлөн найрууллаа.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой зааж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эсхүл хүчингүй болгох арга хэмжээ авах, биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, шаардлагатай гэж үзвэл Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох гэсэн тодорхой 3 төрлийн арга хэмжээ авдаг байхаар өөрчлөн найрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд хэрэглэсэн хууль тогтоомжийн биелэлт гэдэг ойлголтыг хууль тогтоомжийг сахин биелүүлэх, дагаж мөрдөх гэдэг утгаар хадгалж, орчин үеийн парламентын хяналт нь хууль хэрэгжиж байгаа эсэх, тухайн хууль тогтоомж зорилгодоо хүрч байгаа эсэх, бодит үр нөлөө үзүүлж байгаа эсэх, эерэг, сөрөг үр дагавар үүсгэж байгаа эсэх зэргийг хамарсан өргөн хүрээний үнэлгээний тогтолцоо болон хөгжиж байгаа тул хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн хэрэгжилт гэх ойлголтыг хэрэглэх, хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээний нэгдсэн дүн холбогдох Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэн санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд, Хууль зүйн байнгын хороо шалтгаан үр дагаврын үнэлгээний хамт хэлэлцэн нэгдсэн хуралдаанд оруулахаар тусгалаа.

Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн хувьд холбогдох Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэн Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, Улсын Их Хурлын шийдвэр холбогдох заалтыг хяналтаас хасах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж, Төрийн байгуулалтын байнгын хороо 06 дугаар сарын 15-ны дотор жил бүр нэгдсэн хуралдаанд оруулахаар тусгалаа.

Нэгдсэн хуралдаан шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр даалгах, эсвэл Улсын Их Хурлын шийдвэр, түүний холбогдох зүйл, хэсэг, заалтын хяналтын бүртгэлээс хасах, хасахыг даалгах нь зүйтэй гэж өөрчлөн найрууллаа.

Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын, түр, дэд, түр хорооны хуралдааны явцад Засгийн газрын гишүүн хуулиар тогтоосон бусад байгууллагын удирдлагаас өгсөн тодорхой хугацаатай, хэрэгжих боломжтой амлалтыг бүртгэн хэрэгжилтэд

хяналт тавих амлалтын биелэлт хангалтгүй, эс үгүй бол хугацаа хоцорсон тохиолдолд холбогдох Байнгын хороо тухайн албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай бол хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх, үүрэг амлалтын бүртгэлд түүний хэрэгжилтэд хяналт тавих, нарийвчилсан журмыг батлан хэрэгжүүлэх зохицуулалтыг шинээр нэмлээ. Давтан хяналтын журмыг тогтоох буюу хяналт шалгалтын үр дүн санал, дүгнэлт гарснаас хойш тодорхой хугацааны дараа давтан хянах зохицуулалтыг шинээр тусгалаа.

Энэ нь Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хянах, үйл ажиллагааг сайжруулах бөгөөд цаашид цахим хяналтын систем, хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан хянах боломжийг бүрдүүлнэ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнг Улсын Их Хурал хэлэлцэхдээ үйл ажиллагаа төсөл, арга хэмжээний биелэлтээр бус зорилго, зорилтын хүрсэн түвшин, нийгэм, эдийн засаг, салбарын үндсэн үзүүлэлтэд гарсан өөрчлөлт, иргэдийн амьдралд үзүүлсэн үр нөлөөгөөр үнэлэх 2 түвшний аргачлалыг хэрэглэдэг болох эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр тусгалаа.

Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Улсын Их Хурлаар хэлэлцэх, тайлагнах хугацааг хөгжлийн бодлого, төлөвлөлт, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан цаглавартаа нийцүүлэх замаар бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн уялдаа, хариуцлагыг сайжруулах өөрчлөлт боловсрууллаа.

Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд тухайлсан зүйл, заалтуудыг мөн тусгасан.

Хянан шалгах түр хороо байгуулах, бүрэлдэхүүнийг томилох, татан буулгах, шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой одоогийн зохицуулалт тодорхой бус, практикт хүндрэл үүсгэж байгаа тул процедурын зохицуулалтыг нарийвчлан тодорхой болгохоор хичээлээ.

Тухайлбал, түр хороо байгуулах тогтоолын төслүүдийг өргөн мэдүүлсэн дарааллаар хэлэлцэж, түр хорооны бүрэлдэхүүнд олонх, цөөнхийн төлөөллийг бодитой хангах, ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн оролцохоос сэргийлэх, түр хорооны тогтоол гаргах асуудал, хүрээг тодорхойлох, түр хороо тайлангаа танилцуулснаар татан буугдсанд тооцох зэрэг харилцааг тодорхой зохицууллаа.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд хянан шалгагч, шинжээчийг сонгон шалгаруулах, санал болгох, томилох, ашиг сонирхлын зөрчлийг шалгах, хариуцлага тооцох зохицуулалт хангалтгүй байгааг нарийвчлан зохицууллаа. Тухайлбал, хянан шалгагч шинжээчид тавигдах мэргэжлийн болон ёс зүйн шаардлага, ашиг сонирхлын зөрчилгүй байх баталгаа, томилох, чөлөөлөх журам, ажлын даалгавар, бүрэн эрхийн хүрээ, хараат бусаар дүгнэлт гаргах нөхцөл, мэдээллийн нууцлал, хариуцлагын зохицуулалтыг тодорхой болгож, хянан шалгагч, шинжээчийн эрх зүйн байдлыг нарийвчлан зохицууллаа.

Хянан шалгах түр хорооны нотлох баримт шинжлэн судлах сонсголын тусгай журмыг нарийвчлан тогтоосон бөгөөд гэрч дуудах үндэслэл, мэдэгдэх хуудасны агуулга, сонсголын дараалал, оролцогчдын эрх үүрэг, хянан шалгагчийн

тайлан, шинжээчийн дүгнэлт, сонсох ажиллагаа, гэрчээс асуулт асуух, хариулт авах журам, сонсголын ёс зүй, дэгийг тусгайлан зохицуулсан.

Эцэст нь хянан шалгах түр хороо нь үйл ажиллагааныхаа үр дүнг Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсан бол холбогдох Байнгын хороонд танилцуулж, түр хороо тайлан, санал, дүгнэлт болон шийдвэрийн төслөө холбогдох Байнгын хороо санал, дүгнэлтийн нэгдсэн хуралдаанд танилцуулах шийдвэрлүүлэх зохицуулалтыг тус тус тусгасан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Доржзовдын Энхтуяа гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Энхтуяа:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ хуулийн төслийг танилцуулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавих юм бол Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн явцад үүсэж байгаа хүндрэл, эрх зүйн хийдэл, давхардал, процедурын тодорхойгүй байдлыг арилгах, парламентын хяналтын үр нөлөө, хараат бус, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь төслийг боловсруулах үндэслэл болсныг дурдсан болно.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр нийгмийн амьдралыг хуулиар засаглаж, дэг журам төлөвшүүлэхэд Улсын Их Хурал манлайлал үзүүлж, цаашид аливаа журам батлах зохицуулалтыг хуульд тусгахгүй байхад анхаарах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Гантөмөр Улсын Их Хуралд худал мэдээлэл өгсөн хүмүүст тооцох хариуцлагын талаар, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай хуулийн хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих, Улсын Их Хурлын гишүүн хууль тогтоомжийн төслийг дэмжсэн, дэмжээгүй, байр сууриа илэрхийлэхдээ индэрт гарч үг хэлж байгаа нь зохимжгүй талаар, Улсын Их Хурлын

гишүүн Баярбаатар хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хянан шалгах түр хорооны сонсголыг зохион байгуулахдаа улс төрийн зорилгоор ашиглаж болохгүйг анхаарах, ерөнхий хяналтын сонсгол болон түр хорооны нотлох баримт шинжлэн судлах, сонсголын ялгааг олон нийтэд зөв ойлгуулахад анхаарах нь зүйтэй талаар тус тус байр сууриа илэрхийлсэн болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Энхтуяа гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчдын илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрийн дагуу асуулт асууна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Энэ хуулийн төсөлд амлалт гээд нэг шинэ нэр томъёо орж ирсэн байгаа. Тэгэхээр энэ 16.11 дээр Засгийн газрын гишүүн нь Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын, дэд болон түр хорооны хуралдааны хэлэлцүүлгийн шатад өгсөн тодорхой хугацаатай хэрэгжих боломжтой амлалт, үүрэг бүхий тайлбар, амлалт чуулганы үед хэлчхээд тэр нь биелэгдэхгүй болбол хариуцлага тооцох ийм агуулгатай заалт байгаа.

Гэтэл Улсын Их Хурлын тухай хуулийн 41.2 дээр Улсын Их Хурлын гишүүн нь яг нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны үеэр хэлсэн үг хүнийхээ төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хариуцлага хүлээхгүй ээ гэдэг ийм заалт байгаад байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл одоо Засгийн газрын гишүүд чинь бүгд давхар дээлтэй Улсын Их Хурлын гишүүд байгаа учраас. Тэгэхээр энэ 2 хуулийн заалт чинь энэ амлалт дээр Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурлын гишүүн гэдэг бас агуулгаар нь харж үзвэл энэ хуулийн тэр

хариуцлага тооцох заалт чинь хэрэгжүүлэх бололцоогүй харагдаад байна. Тэгээд энэ дээр нэг тайлбар хийж өгөөч. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Энхтүвшин гишүүн маш чухал асуулт асууж байна. Тэгээд Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн хоёр бол хоёулаа тодорхой чиг үүрэгтэй. Улсын Их Хурал бол хууль тогтоох дээд байгууллага. Засгийн газар бол хуулийг хэрэгжүүлэх, гүйцэтгэх дээд байгууллага.

Тэгэхээр. Улсын Их Хурлын гишүүн чуулганы хуралдааны танхимд өөрийнхөө хэлж байгаа үгтэй холбоотой хариуцлага хүлээхгүй гэсэн заалттай. Энэ бол Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд.

Засгийн газрын гишүүн бол Улсын Их Хурлын хуралд хүндэтгэлтэй хандах, Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх, хариултыг хангалттай гүйцэд хариулах. Хэрвээ дутуу мэдээлэл өгвөл гүйцэд хариулахгүй бол араас нь бичгээр хариултуудыг бас өгөх ийм бас хуулиар хүлээсэн үүрэгтэй. Тийм болохоор Их Хурлын гишүүнийхээ би хувьд биш Засгийн газрын гишүүнийхээ хувьд Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандвал холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ ээ гэсэн зохицуулалт өнөөдрийн хуульд байж байгаа. Энийг бид нар бас 20 оны Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар энийг оруулж өгсөн.

Дараагийн нэг асуудал бол нэмж оруулж байгаа юм бол амлалтын биелэлт гээд. Их Хурлын гишүүдийн асуусан асуулт, тавьж байгаа санал дээр манай сайд нар, Засгийн газрын гишүүд хариулт өгөхдөө ойлголоо, анхааръя, би шийдье, судалъя, шийднэ ээ, шийдэхэд хичээнэ ээ, анхаарна гээд хариулчихдаг. Тэр үедээ үндсэндээ бол нөгөө нэг хариулсан болоод аргалаад өнгөрөөчихдөг араас нь хаячихдаг. Үүнийг бол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулиар араас нь байнга бүртгэлийг нь хөтлөөд Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо хуралдаан дээр эрхэм сайд та ийм асуулт дээр ингэж хариулахдаа шийднэ гэсэн, ингэж ингэж ирүүлнэ гэсэн үүнийгээ биелүүл гэж араас нь нэхэж араас нь хөөцөлдөх болно. Ингээд худлаа амлавал, амлалтаа биелүүлэхгүй бол буруу мэдээ, дутуу мэдээлэл өгсөн бол хариуцлага тооцдог болох ийм зохицуулалт нэмж орж ирсэн байгаа.

Тэгэхгүй тэгээд Улсын Их Хурлын бас үйл ажиллагаа гишүүд асууж л байдаг юм. Тухайн үед нэг хариулсан болоод өнгөрөөд болоод л байдаг юм гэдэг хандлагаас чинь болоод Улсын Их Хурлын бас үйл ажиллагаа сулраад байгаа юм. Улсын Их Хурлын гаргаж байгаа тогтоол, шийдвэр хэрэгжих хүчин сулраад байгаа. Ийм учраас Улсын Их Хурлын гаргаж байгаа шийдвэр хүчтэй байх, Улсын Их Хуралдаа их хүндэтгэлтэй хандаж, Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуулт, хэлсэн саналд хүндэтгэлтэй хандах ёстой шүү, ажил хэрэгч байх ёстой шүү гэдгийг илүү хатууруулж, чангаруулж өгсөн зохицуулалтыг оруулахаас өөр аргагүй байгаа юм. Тэгэхгүй тэгээд л энэ худлаа мэдээлэл өгдөг, буруу мэдээлэл өгдөг, нэг аргалаад өнгөрдөг, болно болгоно доо гээд ингэдэг найз дундаа гэдэг юм уу энийг л бас нэг ажил хэрэгч болгоё, яг зарчмаа барьж асуудалдаа ханддаг ажил хэрэгч болгоё гэдэг үүднээс энэ заалтыг оруулсан гэдгийг оруулсан.

**Б.Пүрэвдорж:** Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Жишээлбэл Дамдинням сайд энэ сард бензиний үнэ нэмэгдэхгүй ээ гээд ярьчихаж байна шүү дээ. Тэгээд бензиний үнэ ингээд нэмэгдчихвэл жишээлбэл тэр чинь давхар дээлтэй учраас тал, Засгийн газрын гишүүнийх нь хувьд, Улсын Их Хурлын гишүүн биш Засгийн газрынх нь гишүүнийх нь хувьд хариуцлага тооцно гэсэн асуудал яригдах гээд л байх шиг байна л даа. Зарим жишээлбэл хуралдаанууд дээр нэгдсэн чуулган дээр хэлэлцүүлгийн явцад бас энэ сайд нар хэлэлцүүлэгт оролцох явцдаа бас яг ийм амлалтын шинжтэй ч юм уу үйлдлүүд гаргадаг. Тэгэхээр энэ нь хоорондоо ялгахад төвөгтэй болж магадгүй. Тэгээд энэ дээр Ерөнхий биччихсэн учраас яг жишээлбэл Улсын Их Хурлын гишүүнийх нь хувьд бол хариуцлага тооцохгүй ээ, Засгийн газрын гишүүнийх нь хувьд яаж хариуцлага тооцох юм гэдэг асуудлууд нь тодорхойгүй болохоор л лавлаад байна л даа. Тэгэхээр.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Маш чухал бас тийм. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд биш холбогдох албан тушаалтан Засгийн газрын гишүүнийхээ хувьд хариуцлага хүлээнэ ээ. Тэр нь ямар хариуцлага хүлээх юм бэ гэхээр сая ярьж байгаа шатахууны үнэ нэмэгдэхгүй гэж хэлчхээд шатахуун нь нэмэгдэх юм бол Засгийн газрын гишүүнийхээ хувьд Улсын Их Хуралд худлаа мэдээлэл өгсөн, буруу мэдээлэл өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй гэдгээр Засгийн газрын гишүүнээсээ огцрох хариуцлага хүлээнэ. Холбогдох албан тушаалтан, агентлагийн дарга, тэр яамны газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга холбогдох албан тушаалтнуудаас тухайн албан тушаалаа огцрох хариуцлага хүлээнэ. Ийм байдлаар үндсэндээ бол Их Хурлын гишүүнийхээ хувьд байна шүү дээ Их Хурлын гишүүнийхээ хувьд Их Хурлын гишүүн хэвээрээ, Засгийн газрын гишүүнийхээ хувьд хариуцлага хүлээх үндэслэл болох юм. Үүгээр ийм ялгаатай.

Тэгээд амлалт нь би бүртгэлийг хөтөлнө гэдэг маань бас тэгээд л амлаад л, аргалаад л өнгөрчихдөг биш яг хэлсэн үгэндээ л хариуцлагатай байх ёстой шүү гэдгийг л Улсын Их Хурал Хяналт шалгалтын.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Болдын Уянга гишүүн асуулт асууна.

**Б.Уянга:** Энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр бүгдээрээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Хэлэлцэх эсэхийг нь. Энэ хууль болохоор өөрөө 2024 оны 05 сарын 16-ны өдөр батлагдсан хууль байгаа. Тэгээд Хууль тогтоомжийн тухай хуулиа харахаар бол ер нь хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийдэг больё, 5 жил тутам хийж болно. Шаардлагатай тохиолдолд өмнө нь хийж болно гэж байгаа юм. Тэгэхээр яг ямар шаардлага үүссэн болоод энэ хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулахад хүрсэн бэ гэдгийг хууль санаачлагчдаас эхлээд асууя.

Ингээд өөрсдийн үзэл баримтлал дээр бичсэн байгаа шаардлагыг нь нэгд нэгэнгүй харж байгаа юм. Хяналт шалгалтын төлөвлөлт, цаглаврын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт сул, бүрэн төлөвшөөгүй. Тэгээд энэ бол батлагдаад 2 жил болж байх үед сул, бүрэн төлөвшөөгүй л байх болов уу. Тэгэхээр энэ бол нэг шаардлага нь болж орж иржээ. Ингээд өөр зөндөө олон асуудал байна гэж бичээд зүгээр нэг

тодруулаад хэлэх зүйл нь бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явц, гүйцэтгэл, дүн шинжилгээ хийх хугацаа зэрэг нь холбогдох хууль тогтоомжтой уялдаагүй байна. Тэгэхээр Улсын Их Хурлаас системтэйгээр хэлэлцэх нөхцөл бүрдээгүй байна. Ийм учраас сая хууль санаачлагчдын танилцуулсан танилцуулгад гарсан давуу талуудыг оруулж байна гээд ингээд энэ хуулийн төсөл бэлтгэгдэж орж иржээ.

Тэгэхээр ер нь Их Хурал дээр орж ирээд батлагдаж байгаа хуулиуд судалгаа муу хийгдэж байгаа нь л энэнээс харагдаж байгаа юм шиг байгаа юм. Тэгэхээр цааш цаашдаа энэ дээр яаж анхаарах вэ? Маш олон хуулиуд нь Үндсэн хууль зөрччихсөн гээд ар араасаа Цэцийн дүгнэлтүүд нь ороод ирдэг. Яг энэ Хяналт шалгалтын хууль нь болохоороо асуудалтай байна гээд 2 жил хэрэгжиж эхлээд больюу үгүй юү ийм олон өөрчлөлтүүд, нэмэлт, өөрчлөлт байдлаар орж ирж байдаг. Хугацаа нь яг болсон юм болов уу, жаахан харах байсан юм биш үү?

Ингээд хуулийн төслийн 7.2-т 1 өгүүлбэр байгаа. Улсын Их Хурал хянан шалгах үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд төрийн албан хаагчдыг дайчилж байгаа. Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл гээд. Тэгээд яах вэ өөрөө төрийн албан хаагч байсан хүний хувьд нэг хэлэхэд төрийн албан хаагчдыг бол маш их ажлаар дардаг, олон сонсгол бас явлаа, хяналтууд хийгдлээ, өөрсдийнх нь ажлын байрны тодорхойлолт заагдаагүй асуудлуудаар хүртэл дайчлах асуудал гардаг. Тэгэхээр энийг бол хязгаарлах хэрэгтэй юм шиг санагдаад байгаа юм. Тэгэхээр яаж энэ асуудал хуульд туссан бэ яах вэ? Энэ 7.2-т болохоор болно гэсэн байгаа юм. Тэгээд мэдээж, дайчилна шүү дээ. Орж ирээд л ажиллана.

Тэгэхээр энэ дээр нэг ийм төрийн албан хаагчид үнэхээр ажилд нухлуулдаг хэсэг бүлэг хүмүүс байгаа шүү дээ. Тэр хүмүүс маань дахиад л ороод ирнэ. Эд нарыгаа яаж хамгаалах юм бэ? Ингээд хуулийн төсөл ер нь батлагдлаа гэхэд хэрэгжилт хангалтгүй байна гэдгийг бид нар байнга ярьдаг. Улсын Их Хурал нь хуулиа тогтоочихдог, хэрэгжүүлэх субъект нь болохоороо Засгийн газар агентлагуудаараа дамжуулна, эсвэл нутгийн захиргааны байгууллагаараа ингээд дамжаад хэрэгжүүлдэг.

Ингээд хэрэгжилт нь хангалтгүй байна аа, хяная аа, шалгая гээд. Тэгээд энэ хуулийн төслөөр харахаар хяналт, шалгалт нь ингээд янз бүрээр орж ирж байгаа. Дахин хяная, үр дүн дээр нь давхар хяная гээд ингээд 7 дугаар зүйлдээ нэмж бичиж байгаа байхгүй юу. Энэ их хяналтуудыг оруулж ирэхээс өмнө аливаа хуулийн төслийг бэлтгэхдээ журмууд нь гарахдаа хариуцлагаа ухамсарладаг байлгах дээр нь дагаж хуулиудад өөрчлөлт орж байна уу? Ер нь ингээд хэрвээ төрийн субъект нь өөрсдөө ажлаа хийхгүй байгаа юм бол иргэн хүн дээр иргэний энэ хариуцлага гэдэг зүйлийг яаж хуульчилж болох вэ? Ийм асуултууд байна.

**Б.Пүрэвдорж:** Зочин танилцуулаадахъя. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Жаргалант сумын иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Манай Тэмүүлэн гишүүн ард, иргэдтэйгээ ойрхон учраас ард түмэн дотроо ороод суучихсан байна. Би Жаргалант сум дээр нэлээн хэдэн жилийн өмнө уулзалт хийж байсан. Энэ сумын гол асуудал бол борооны улирлаар намаг ихтэй. Сумын төв дотроо засмал

зам тавих нь их чухал юм гэж ярьдаг юм байна лээ шүү. Тэмүүлэн гишүүн анхаараарай.

Равжихын Эрдэнэбүрэн. Уянга гишүүний асуултад Бямбацогт дарга хариулна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын нэг онцгой бүрэн эрх, Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрх бол хянан шалгалт хийх, хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх. Энийг бид нар 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Их Хурлын томилгооны бүрэн эрхийг жоохон хязгаарласан. Засгийн газрын гишүүдийг, сайд нарыг томилдог, огцруулдаг эрхийг хязгаарлаад нөгөө талдаа энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрхийг нэмж өгсөн.

Үүний дагуу энэ хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг би 21 онд анх санаачилж Их Хурлаар батлуулж байсан юм. 24 онд бас тодорхой нэмэлт, өөрчлөлтүүд орсон. Одоо ингээд яг амьдрал дээр ингээд 5 жил гаруй хугацаанд хэрэгжиж байх явцад энэ хуульд зайлшгүй бас өөрчлөлт оруулах нэлээн олон шаардлага үүсэж байгаа юм. Тийм учраас бас энэ хуулиуд бас энэ хяналт шалгалтын төлөвлөлт, цаглаврын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт сул бүрэн төлөвшөөгүй байна. Сая ярьж байгаа бодлогын бичиг баримтууд. Ялангуяа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх дээр маш том асуудлууд үүсэж байна. Нэг.

Хоёрдугаарт нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх. Энэ бас маш их асуудалтай байна. Давхардалтай хууль олон байна. Хийдэлтэй хууль олон байна. Хэрэгждэггүй, үр дүнгээ өгдөггүй өгөөжгүй хууль олон байна. Үүнд яаж үр дагаварт нь үнэлгээ хийх вэ гэдэг асуудал ерөөсөө маш том асуудал болж байгаа. Улсын Их Хурлын гаргасан шийдвэр, хууль тогтоолын шийдвэр гэдэг юм уу хэрэгжилт байдаггүй. Улсын Их Хурлаас баахан тогтоол батлаад л үүрэг даалгавар Засгийн газарт өгөөд байдаг тэр нь биелсэн ч, биелээгүй ч мэдэгддэггүй. Биелээгүй бол хариуцлага тооцох механизм байхгүй. Иймэрхүү юмнуудыг өөрчлөх шаардлагатай байгаад байгаа юм.

Мөн хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох. Одоо бид нар хянан шалгах түр хороо байгуулаад тогтоол гаргадаг. Гаргасан тогтоол маань хэрэгждэггүй. Нүүрсний сонсголтой холбоотой асуудал, Оюу толгойн түр хорооны сонсголтой холбоотой асуудал гээд олон тогтоол батлаад өгөөд хэрэгждэггүй. Хэрэгжихгүй бол яах юм гэдэг хариуцлага нь сул иймэрхүү юмнуудыг шийдэх ёстой болчихоод байгаа юм.

Дээрээс нь Улсын Их Хурал чуулган дээр асуулга тавьж 7 хоногт сард 2 удаа асуулга тавьж Засгийн газрын хийж байгаа үйл ажиллагаатай холбоотой хяналт тавьдаг байсан. Байнгын хороон дээр дуртай үедээ асуулт тавиад хянадаг байсан. Дээрээс нь шаардлагатай үед яаралтай нэгдсэн мэдээлэл сонсдог байсан. Ерөнхий сайдын мэдээлэл сонсдог, дээрээс нь сайд нарын мэдээлэл сонсдог. Энэ бүгд алга болчихоод байгаа юм.

Өнгөрсөн 20-оос 24 оны парламентын үед 102 асуулга тавигдаж, 32 асуулгын хариу хэлэлцэж байсан бол 24-өөс 26 оны парламентын үед 59 асуулга тавигдсан. Ерөөсөө асуулга чуулган дээр 1 ч хэлэлцэгдээгүй байгаа юм. Тийм

болохоор энэ хуулиар үндсэндээ бас энэ хяналт, шалгалтын үйл ажиллагааг л илүү сайжруулъя. Ялангуяа энэ зөвхөн түр хороо байгуулах бус асуулга, асуулт тавих, сард 2 удаа бас энэ хяналт, шалгалтын чиг үүргийг бас яг хэлэлцдэг байх энэ.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Уянга гишүүн нэмж тодруулъя.

**Б.Уянга:** Олон асуулт асуучих шиг боллоо. Яг хангалттай хариултаа авч чадахгүй юм. Тэгэхээр энэ дэгийн хууль дээрээ энэ минутын яг оновчтой хариулах дээр нь бас яаж хуульчлах ёстой юм бол? Одоо энэ бид нарын хэлэлцэж байгаа хуулийн төсөл болохоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль шинэчилсэн найруулга нь 2024 оны 05 сарын 16 байгаа юм. 24 оны 05 сарын 16. Хэрэгжиж эхэлсэн нь Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Хэрэгжиж эхлээд 2-хон жил болж байгаа юм. Тэгэхээр үндсэн асуулт нь яг ямар шаардлага гарсан юм бэ гэнгүүт гаргаж байгаа бичиг баримтууд ерөөсөө хэрэгжихгүй байна гээд байгаа юм.

Тэгээд хэрвээ хэрэгжихгүй байгаа бол тухайн бичиг баримт энийг хийхгүй бол яах вэ, маргааныг нь яаж шийдвэрлэх вэ гэсэн дандаа хэсэгтээ сүүлдээ явдаг. Тэгэхээр тухайн хууль тогтоомж дээр өөрчлөлт орох ёстой юм шиг ойлгогдоод байгаа юм. Тэгэхээр яг энэ хуулийг дагаад өөр хууль тогтоомжид өөрчлөлт орж байна уу? Хянаад, дахин хянаад, давтан хянаад өөрчлөгдөхгүй бол яах вэ?

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг жилд 1 удаа Улсын Их Хурал ярихдаа шалтгаан үр дагаврын шинжилгээний хамт нь ярина аа. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох эсрэг хүчингүй болгох арга хэмжээ авна. Биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар хийсэн зөрчлүүдийг арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах арга хэмжээг авна. Бүүр шаардлагатай гэж үзэх юм бол Засгийн газрын гаргасан шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авна. Ингэж илүү жоохон тийм хүчтэй болгохгүй бол өнөөдөр энэ Хяналт шалгалтын тухай хуулиар тодорхой шийдвэрүүдийг Засгийн газарт чиглэл өгөөд гаргаад байдаг. Хэрэгждэггүй. Хэрэгжихгүй болохоор нь ямар ч тийм хариуцлага тооцсон юм байхгүй байгаад байгаа. Энэ ингээд шат үе шаттайгаар хариуцлагыг нь үе шаттайгаар чангаруулж арга хэмжээ авах тодорхой зохицуулалтуудыг маш тодорхой хуульд тусгасан байгаа.

**Б.Пүрэвдорж:** Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууна.

**М.Ганхүлэг:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэж байна. Хэлэлцэх эсэх асуудлыг бол дэмжиж байгаа. Хэлэлцүүлгийн явцад бас тодруулах, анхаарах бас хэд хэдэн асуултууд бас байна. Үндсэндээ бол Монголд бас хууль бол багадаагүй ээ. Байгаа хуулийн хэрэгжилт дээр хяналт тавих чиг үүрэг тодорхой бас процессын хувьд ч тэр, зохион байгуулалтын хувьд ч тэр бас нэлээн алдаатай юмнууд бас нэлээн байгаа гэдэгтэй бол санал нийлж байгаа.

Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирж байгаа хэд хэдэн асуудлууд дээр суурь нэг асуудал нь бол өөр өөрсдийгөө бид үнэлээд байгаа юм шиг ийм нөхцөл байдал харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ хөндлөнгийн үндсэндээ үнэлгээ хийх, Их Хурлын Тамгын газарт энэ хяналтын чиг үүргийг илүү нэмэгдүүлсэн бүтцийг, дээрээс нь судалгаа шинжилгээний энэ үйл ажиллагааг бас нэмэгдүүлэх чиглэлийн ялангуяа референтүүдийн судлаачдын үндсэндээ ажиллах чиг үүрэг дээр хяналт, шалгалтын чиг үүргүүдийг нэмэгдүүлэх, түүнтэй холбогдолтой төсөв санхүү, бүтцийн өөрчлөлтүүдтэй холбогдолтой тодорхой ийм ямар өөрчлөлтүүд байгаа вэ гэдгийг нэмж тодруулж бас асууя.

Бас бид өөр өөрсдийгөө хянахаас гадна иргэний нийгмийн байгууллагууд, бусад энэ мэргэжлийн энэ байгууллагуудын хяналтын үндсэндээ тогтолцоог бид нар яаж нэмэгдүүлж болох вэ? Ингэж чадвал бас тодорхой үр дүнгүүд бол гарна. Энэ дээр бас эхний тодорхой асуулт асууя.

Амлалт өгөхтэй холбогдолтой асуудал нэг талаасаа харахаар их тийм зөв, сайн агуулга орж ирж байгаа юм шиг боловчиг нөгөө талаасаа хэрэгжихэд нэлээн тийм бас эргэлзээтэй ийм асуудал л бас орж ирж байна. Засгийн газрын гишүүд амлалт өгөөд тодорхой хариуцлага үүрнэ ээ гэж байна. Тэгэхээр яг ямар хариуцлага үүр үүрэх вэ? Сайд хэрвээ амлалт өгөөд амлалтаа биелүүлэхгүй бол Их Хурал тэр сайдыг огцруулах байдаг юм уу? Тэр хэмжээний арга хэмжээ авах нөхцөл бол одоогоор бол байхгүй байгаа. Ерөнхий сайдын нөгөө бүрэн эрхийн асуудал яах билээ, кабинетаа сонгох, сонгохгүй байх асуудал яах билээ? Цалингийн арга хэмжээ авах юм уу, ажлаас нь халах юм уу энэ тэр гэдэг дээр нарийн бас ийм тодорхой чиглэлүүд бас байхгүй байна.

Дөнгөж саяхан энэ махны үнэтэй холбогдолтой асуудал дээр Энхбаяр сайд жишээлэх юм бол Засгийн газраас ямар нэгэн үнэд өөрчлөлт оруулах асуудал хийхгүй ээ гээд мэдэгдэж байхад хэдхэн хоногийн дараа бол үндсэндээ энэ асуудлаар бид нар нийслэлийнхээ даргыг огцруулж байх жишээтэй. Тэгэхээр энэ Засгийн газрын үндсэндээ яг нэгдсэн байдлаар мэдээлэл өгөхтэй холбогдолтой асуудал бол бас яг яаж хэрэгжих бол гэдэг дээр эргэлзээтэй байна.

Нөгөө талаасаа сайд нар амлалт өгөх байтугай хуралдаа ирэхгүй байгаа шүү дээ. Байнгын хорооныхоо хуралдаа ирж оролцохгүй байгаа. Тодорхой сайд нарыг орлохтой холбогдолтой Төрийн нарийн байдаг юм уу, дэд сайд байдаг юм уу тодорхой хүмүүс орж ирээд амлалт өгвөл яах вэ? Эс үгүй бол сайд байхгүйгээс болоод тухайн ажил бас явахгүй байх уу энэ тэр гээд ийм нарийн зохицуулалттай холбогдолтой асуудлууд бас нэлээн дутагдалтай бас харагдаж байна.

Нэг бас дэвшилттэй байгаа нэг зүйл нь бол нээлттэй, ил тод болгох юм байна. Ямар системээр, ямар байдлаар энийгээ үндсэндээ танилцуулах вэ? Олон нийтэд үндсэндээ яам яамаар нь тодорхой Засгийн газрын хөтөлбөрүүдээрээ тухайн жилийн хэрэгжилтээр нь ингээд бас явах юм байна гэж ингэж үзэж байна. Тэгэхээр энэ нөгөө нэг систем хөгжүүлэлт, түүнтэй холбогдолтой ажил дээр бас бүтэц бүрэлдэхүүний болон чадамжийн хувьд бид нар бас хэр бэлэн байдалтай байгаа вэ? Энэ дээр яаж ажиллах вэ гэдгийг нэмж асууя.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулья.

**С.Бямбацогт:** Хөндлөнгийн үнэлгээ ер нь ямархуу бүтцээр хяналт шалгалт хийх гэж байна вэ гэж. Улсын Их Хурал маань өөрөө ба хамгийн том хяналт, шалгалтын нэг том функц нь бол Байнгын хороо. Байнгын хороо үндсэндээ өөрийн эрхэлсэн асуудлын хүрээнд байнгын хяналт шалгалт тавьж, тайлан, мэдээллийг сонсдог. Шаардлагатай бол ажлын хэсэг байгуулдаг. Гишүүд шаардлагатай бол хяналтын ерөнхий сонсгол хийх, хянан шалгах түр хороо байгуулах, асуулга тавих, асуулт тавих ийм функцүүдээр сонсгол хийдэг байгаа хяналтууд.

Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцэд бол Хяналт шалгалтын газар, Хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх газар 2 бас хяналтын функц байж байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба гээд бас хяналтын функц байж байгаа. Улсын Их Хурлын Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, мөн Үндэсний аудитын газар гэсэн функцүүд байгаа. Тэгээд үндсэндээ энэ функцүүдээ хүрээнд бас хяналт шалгалтынхаа чиг үүргийг Улсын Их Хуралд хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Дээрээс нь шаардлагатай гэж үзэх юм бол хөндлөнгийн судлаачдыг үнэлгээ хийлгэх хяналт шалгалт хийх зорилгоор гэрээгээр татаж оролцуулж болно.

Мэргэжлийн холбоодын төлөөлөл мэргэшсэн судлаачдыг бас оролцуулж болно. Ажлын дэд хэсэг байгуулж бас энэ хянан шалгах үйл ажиллагаандаа татан оролцуулж болох боломжтой ийм зохицуулалтууд хийж байгаа. Энэ хуульд орсон байгаа.

Байнгын хороондоо амлалтад буруу мэдээлэл өгчхөөд хариуцлага хүлээдэггүй, тэр байтугай Байнгын хорооны хуралдаа суудаггүй гишүүдийг яах вэ гэж. Байнгын хорооны хуралдаа суудаггүй сайд нар, сайд нар давуу эрхтэй байхгүй ээ. Сайд нарыг 2 биш 1 Байнгын хороонд орж байгаа. Үүгээр үндсэндээ бол ингээд асуудал шийдэхэд 2 дахин бага болчхож байгаа.

Нөгөө талдаа Их Хурлын гишүүдтэй адилхан сайд байгаа нь Байнгын хорооны хуралдаан, чуулганы хуралдаанд оролцохгүй байх хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй. Улсын Их Хурлын гишүүдтэй адилхан Байнгын хороо, чуулганы хуралдаанд оролцох үүрэгтэй. Оролцохгүй бол яг Их Хурлын гишүүдтэй адилхан хариуцлага хүлээнэ. Ийм байдлаар. Тийм болохоор илүү өндөр ачаалалтай илүү ажлаа сайн хийх ёстой. Даана гэж давхар дээл өмссөн.

Тийм болохоор даах ёстой. Тийм учраас хариуцлагын хувьд тэр. Дээрээс нь илүү үнэн, зөв бодитой мэдээлэл өгнө. Худлаа мэдээлэл өгдөг, буруу мэдээлэл өгдөг бол түүнийхээ төлөө Засгийн газрын гишүүнээсээ огцрох хүртэл хариуцлага хүлээлгэх ийм заалтууд орсон байгаа. Тийм болохоор энэ заалтууд маань үндсэндээ бол хэрэгжээд явахаар илүү Улсын Их Хурлын үйл ажиллагаа, сайд нарын Улсын Их Хуралд ханддаг хандлага өөр болно гэж харж байгаа юм. Яг одоо бол ингээд хуралдаандаа суухгүй байгаа, худлаа мэдээлэл өгч байгаа чинь үндсэндээ бол Улсын Их Хурлын хяналт шалгалтын Улсын Их Хурлын энэ холбогдох албан тушаалтан, Засгийн газрын гишүүдэд хариуцлага тооцох механизм сул байгаатай холбоотой. Тийм болохоор л чангалж байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Ганхүлэг гишүүн нэмж тодруулъя.

**М.Ганхүлэг:** Ярьж байгаагаар бол бас сайд нартаа тодорхой хариуцлага үүрдэг болгоод явчихвал бол бас яах вэ дэвшилттэй л байна. Гэхдээ яах вэ нөгөө Ерөнхий сайдынхаа бүрэн эрхийн асуудал дээр яах билээ? Ганц нэгэн сайдыг нь сугалаад бид нар ингэж явж чадах уу гэдэг дээр нарийвчилж асуугаад байгаа юм. Дээрээс нь илүү сайжруулахын тулд бид нар дэвшилтэт технологи, хүнээс хараат бус байх зүйлүүдийг бид нар ашиглах, нээлттэй болгох ийм бас саналуудыг бол дэмжиж байна. Тэгэхийн тулд зайлшгүй бүтэц болон тодорхой бас энэ хөрөнгө санхүүгийн асуудлыг бол үндсэндээ тооцох шаардлагатай. Энийг бас нарийвчлан бас оруулж ирэх нь бас зөв байх гэж ингэж харж байна.

Дахиад нэг бас чухал асуудал нь болохоор бид нар нэг ээлжит чуулганы хугацаанд 2 үндсэндээ сонсгол явуулах ийм заалттай байгаад байгаа. Тэгэхээр цаг үеийн болон зайлшгүй шаардлагатай тохиолдолд бас үндсэндээ энэ тоог нэмэгдүүлэх чиглэлийн ийм саналуудыг бас оруулж болох уу гэдэг асуултыг асууя.

**Б.Пүрэвдорж:** Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Засгийн газрын гишүүдийн хариуцлагагүй асуудал дээр Ерөнхий сайдын бүрэн эрхэд халдахгүй, Ерөнхий сайд руу энэ Засгийн газрын гишүүн ингэж ингэж Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль зөрчсөн учраас хариуцлага тооцно уу гэсэн ийм саналыг хүргүүлдэг ийм зохицуулалтыг энэ хуульд нэмж оруулж байгаа юм. Энэ хуульд.

Тэр хянан шалгах түр хороо байгуулах маань бол бас нөгөө төсөв мөнгөтэй холбоотой. Хянан шалгах түр хороо байгуулах, хяналтын сонсгол хийх чинь бол нэлээд өндөр зардал гардаг. Дэд ажлын хэсэг ажиллуулдаг, ажиллах бас маш их судалгаа, тооцоо, материал үздэг, гадаад, дотоод томилолт гээд маш их зардлууд гардаг. Тийм болохоор энэ асуудлыг бид нар төсөв, мөнгөтэй холбоотойгоор л урьд нь 1 чуулганы бүрэн эрхийн хугацаанд 2-оос доошгүй, илүүгүй түр хороо байгуулах гэж орсон юм байна лээ. Үүний наана бол бидэнд ерөнхий хяналтын сонсгол хийх боломж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

**Л.Соронзонболд:** Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг бол дэмжиж байгаа. Энэ Байнгын хороод дээр ер нь нөгөө хууль тогтоомжийн биелэлт болон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан гээд танилцуулагддаг Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд. Тэгээд тэдгээр тайланг гээд харж байхаар ерөөсөө биелэгддэггүй, гүйцэтгэл муутай ийм ажлууд бол олон жил дараалан ингээд хэлэлцэгдэж байгаа байдал харагдаад байдаг. Тэгээд гүйцэтгэлийнх нь үнэлгээнд нь бас нөлөөлөөд байдаг. Тэгэхээр эдгээр асуудлуудын талаар ер нь энэ нэмэлт, өөрчлөлт дээр манай хуулийн төслийн санаачлагчид маань ямаршуу өөрчлөлт оруулж байгаа вэ? Энэ дээр ямар ахиц дэвшил гаргана гэж бодож байна вэ?

**Б.Пүрэвдорж:** Аюушийн Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Баярлалаа. Яг энэ асуудлыг олж хараад өнгөрсөн жил Засгийн газрын Хэрэг эрхлэхийн сайд Учрал сайд тухайн үедээ бас яг энэ

шийдвэрийн биелэлтийг хэлэлцүүлж байсан. Тэгээд үүн дээр учир шалтгаан нь яг юу байдаг юм бэ гэж асуусан. Ер нь үүрэг, даалгавар нь өөрөө анхнаасаа тодорхой бус өгөгдөөд буруу үүрэг даалгавар өгөөд байгаа юм биш биз дээ гэдэг ийм асуултыг асуугаад тэгээд эрхэм гишүүд ямар даалгаврууд өгнө үү, Улсын Их Хурал юу гэж Засгийн газарт чиглэл болгоно вэ тэрийг л биелүүлэх үүрэгтэй шүү дээ гэж ийм хариултыг авч байсан. Гэтэл яг яс юман дээрээ болох болохлоор болохлоор би биелэгдэшгүй даалгаврыг өгчхөөд биелэлтийг нь нэхээд байгаа бол энэ чинь Улсын Их Хурлын буруу шүү дээ.

Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бид бас ажлын хэсэг гаргаж яг ямар үүрэг, даалгаврууд дээр хэрэгжилтээ тайлагнаад байгаа юм бэ гэдгийг авч үзсэн. Ингээд аваад үзэхэд бүүр 2017, 2016 оны тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгавруудыг одоог хүртэл тайлагнаж явдаг юм байна лээ. Тэгээд системд нь бол Засгийн газрын Хэрэг эрхлэхийн энэ мониторингийн системд нь бол 5000 гаруй үзүүлэлтээр тайлагналтаа хийж байгаа юм байна лээ.

Тэгээд тэр 5000 гаруй үзүүлэлт нь бол 2016, 2017 оноос хойш бүхий л энэ Улсын Их Хурлуудын үед, бүхий л Байнгын хорооны үед өгөгдөөд байсан ийм даалгавруудтай. Тэгээд тэрийг нь яагаад хяналтаасаа гаргаж болдоггүй юм бэ гэж асуухлаар үүрэг, даалгавар өгсөн газар нь өөрөө энийг хяналтаас гаргадаг шийдвэрийг гаргадаг юм байна гээд. Тэгээд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо ямар ч байсан 150-аад үзүүлэлтийг бол хэрэгжилтээс, энэ хяналтаас хасах ийм шийдвэрийг гаргасан. Шууд тэр дороо тайлагналтын үзүүлэлт сайжраад ороод ирж байна лээ.

Тэгэхээр энэ агуулгаараа бусад төрийн байгуулалтын болон бусад Байнгын хороодоор өөрсдийнхөө өгсөн энэ үүрэг, даалгавруудын хяналтыг эргэж хардаг, хяналтаас эргэж гаргадаг, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгааныг нь учир шалтгаанаар нь авч үзээд зохион байгуулалтын асуудал байна уу, төсвийн асуудал байна уу, эс үгүй бол өөр шалтгаан байна уу гэдгээс хамаарч тодорхой тодорхой арга хэмжээнүүдийг авдаг.

Мөн түүнчлэн нэгдсэн ийм нэг цахим системтэй байж, гарч байгаа үүрэг даалгаврууд нь хэнд харьяалагдаж байгаа юм тэр хүн нь биелүүлж байна уу үгүй юү гэдэг 2 талын гарцтай ийм нэгдсэн системтэй, нэгдсэн мэдээллийн платформтой байя гэдэг ийм зохицуулалтуудыг энэ хуульд шинээр оруулж ирж байгаа. Тэгэхээр цааш цаашдаа бол сайжраад явах байх гэсэн ийм хүлээлттэй байна.

**Б.Пүрэвдорж:** Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна.

**Ж.Галбадрах:** Оройн мэнд хүргэе. Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжиж байгаа. Тэгээд хэд хэдэн асуулт байна. Хяналт шалгалтын олон улсын шилдэг туршлага, шинэ арга хэрэгсэл нэмэгдүүлэхээс илүүтэйгээр өнөөдрийн манай Их Хурлын хяналтын механизмыг мэдээлэл, дүн шинжилгээ, судалгаа, давтан хяналт, олон нийтийн оролцоонд суурилан сайжруулж бэхжүүлэх ямар арга байгааг л энэ хуулиар гаргаж ирэх үндсэн зорилготой гэж ингэж харж байгаа.

Тэгээд энэ гишүүд маань яриад байна. Албан сайд, Засгийн газрын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнуудын өгсөн тэр хугацаатай хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээ, хариуцах субъектийн тодорхойлсон тэр мэдэгдлүүдийг миний хувьд бол энийг албан мэдэгдэл гэж үзээд амлалт гэхээсээ албан мэдэгдэл гэж үзээд энийг нэг ингээд бүртгээд, бүүр ил тод болгоод энийг ингээд хэрэгжүүлэх тийм арга, механизм байвал ямар вэ гэсэн ийм тэр нөгөө хэрэгжүүлэх арга зүй талаас нь л ярьж байна л даа.

Тэгээд энэ бүгдийгээ сайдынхаа, сайд нарын мэдэгдэл, энэ өндөр албан тушаалтны мэдэгдлийг бүртгэдэг энэ системийг хийгээд тэгээд энэ дээрээ нэг хугацаа тавиад, жишээлбэл, 3 сарын дараа, 6 сарын дараа, жилийн дараа ч гэдэг юм уу, тийм биелэх тийм биелэлтийн тайлан гаргах гэдэг юмыг нь тавьж өгөөд тэгээд бүр энийгээ гаргаад ирэхээр биелэгдээгүй амлалтын амлалт тус бүрээр нь тэр шалтгааныг нь гаргаж тайлагнаж байвал гишүүдэд хаа хаанаа ийм амлалт нь ч хариуцлагатай болоод, гишүүд ч мэдээллээ ингээд аваад явах. Мэдээж энэ гишүүд гэхээсээ илүү төр засаг, гүйцэтгэлийнхэн орно.

2 дугаар асуух асуулт нь бол хяналтын байгууллагуудынхаа уялдаа холбоог хэрхэн сайжруулах вэ? Гол нь бид нар аудит гэж байгаа. Үндэсний аудитын газар зэрэг энэ хяналтын байгууллага үйл ажиллагааны давхардал, орхигдлыг арилгаж, нэгдсэн мэдээллийн сан, хяналтын дүнг арилгах, ашиглах тэр механизмыг бий болгох. Өөрөөр хэлбэл, би энд бол аудитын газрыг бол ерөөсөө л хамгийн чухал үүрэгтэй төрийн аудитын байгууллагын дүгнэлт нь парламентын хяналтын ажиллагааг эхлүүлэх үндэслэл болно гэсэн зүйлийг хуульдаа заавал ямар вэ? Бид нар энэ аудитын байгууллагынхаа дүгнэлт дээр бид бол ингээд хөгжлийн төлөвлөгөө ч хэлэлцэж байна, аудитаас ийм дутагдал, зөрчил гарсан энэ тэр гээд ингээд дүгнэлтүүд гардаг. Төсөв хэлэлцэж байдаг, дүгнэлтүүд зөндөө байж байдаг. Тэгсэн мөртөө дараа нь ахиад л яг тэр төсөл, хөтөлбөр нь тэр зөрчилтэй мөртөө ахиад ороод ирдэг.

Тийм учраас энэ аудитын шалгалтын мэдээллийг их чухалчилж үзэх нь чухал байна гэж бодож байна. Улсын Их Хурлын хяналт, шалгалтын мэдээллийн нэгдсэн сан гэж байгаа юу? Тэр байгаа бол энийг хэрхэн өргөжүүлж, хөгжүүлэх боломжтой байна вэ? Гишүүд ч бай бүх л оролцогч талууд энийг ингээд харж байдаг. Шалгалтын тайлан, аудит, дүгнэлт, хэрэгжилтийн явцыг нэг платформ дээр төвлөрүүлээд тэрийгээ тэр бодит цаг хугацаанд нь харж байдаг ийм байх нь их бид нарыг үр дүнтэй, энэ хяналтын үр дүнг нь гаргахад хэрэгтэй. Бид нарын чинь хамгийн гол сул тал бол хяналт, дүгнэлтийнхээ хэрэгжилтийг баталгаажуулах энэ тогтолцоо маань л энд сул байгаад байгаад. Эндээс болоод, шалгасан ч мартсан ийм асуудал болоод нэг шалгалаа тэгээд эргээгээд ингээд мартаад тэр нь ингээд орхигдчих явдал байгаад л асуудал байна гэж бодож байна ийм асуултуудыг асууя. Тэгээд тодруулна.

**Б.Пүрэвдорж:** Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Би хариулъя. Галбадрах гишүүн бас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр өгөгдсөн үүрэг, даалгавруудыг бас хамт харж байсан маш олон үүрэг, даалгавруудыг дахин дахин өгөөд байдаг. Тэгээд хэрэгжээгүй асуудлууд дээрээ хариуцлага тооцоогүй явчихсан байдаг гэх

мэтчилэн ийм ямар ч хяналтгүй байна гэдгийг бол бас харсан. Тэгээд энэ бол 2 талын алдаа, дутагдалтай байна.

Нэн ялангуяа бид нар, гишүүд, Байнгын хороод ч гэсэн өөрсдөө өгч байгаа үүрэг даалгаврууд нь биелэх боломжтой байна уу, үгүй байна уу гэдгийгээ ч гэсэн харах ёстой. Тэгээд ийм ч учраас ер нь энэ Тамгын газар өөрөө энэ хууль зүйн дүгнэлтүүдийг ч гэдэг юм уу яг мэргэжлийн байдлаар хандаж бас зөвлөгөө өгдөг байгаасай гэсэн ийм агуулгуудаар нийтлэгээр бол орж байгаа.

Нэгдсэн цахим систем бол бүрдүүлж, Улсын Их Хурал ч тэр, Засгийн газар ч тэр, мөн түүнчлэн олон нийт ч тэр харж болох бололцоотой ийм нэгдсэн системийг хөгжүүлэе ээ гэсэн ийм зорилтыг 16.10 дээр бол оруулаад өгчихсөн. Цахим системүүд байхгүй гэсэн үг бол биш тус бүрдээ байгаа. Харин хооронд нь интеграцчлах, мөн түүнчлэн олон нийтэд нээлттэй болгох асуудлыг бол чухалчилж оруулж өгсөн.

16.11 дээр манай Засгийн газрын гишүүд бусад байгууллагын удирдлагуудыг нь амлалт гэдгээс айчих вий. Үүн дээр нь бол тодорхой хугацаатай, хэрэгжих боломжтой амлалт, үүрэг гэж байгаа юм. Тэгэхээр жишээлбэл би танд бичгээр хариулт өгнө гээд эндээ амлалчихдаг тэрийгээ биелүүлдэггүй, эс үгүй бол би энэ ажлыг дараагийн сар яг оруулах гэж байна, дараагийн Засгийн газрын хуралдаанаар яг оруулах гэж байна гээд л хэлээд байдаг. Гэтэл нөгөөх нь биелдэггүй гэх мэтчилэн асуудлуудыг бол тодорхой бүртгэж аваад энэ дээрээ хариуцлагыг нь ч гэсэн бас ярь дэг байх нь зүйтэй гэж оруулсан.

Хуулийн 17.6 дээр яг энэ аудитын тайлантай холбоотой аудитын тайланг нь авч үзээд дүгнэлт, саналыг нь хамт хэлэлцэнэ. Үүнтэйгээ холбоотойгоор яагаад ер нь ямар ч хариуцлагууд үр нөлөө гарахгүй байна вэ гэхлээр бид нар өөрсдөө хариуцлага тооцох энэ саналуудаа, энэ шийдвэрүүдээ өөрсдөө гаргахгүй байна. Өөрсдөө үүнийгээ тайлангуудаа уншихгүй байна. Тэгэхээр энэ нөгөө агуулгаараа бид нар өөрсдөө хариуцлагыг нь чангатгаад ирэх юм бол яг энэ аудитын тайлан ч гэсэн өөрөө ач холбогдолтой, үр нөлөөтэй болж орж ирнэ ээ гэсэн ийм төлөвлөгөөтэйгээр энэ хуулийн өөрчлөлтүүдийг хийж оруулж ирлээ.

**Б.Пүрэвдорж:** Галбадрах гишүүн тодруулъя.

**Ж.Галбадрах:** Баярлалаа. Тийм, бид нар хамтдаа бас энэ Их Хурал дээр гарч байгаа, Байнгын хороон дээр гарч байгаа тогтоол, шийдвэрийг хянаж үзсэн. Энэ дээрээс бол бас нэлээн олон зүйлийг бас ингээд харагдсан. Тийм учраас бид нарт энэ сайжруулах зүйл их байгаа нь харагдсан. Тэгэхээр хамгийн гол нь бид бас энэ давхардлыг бууруулах тал дээр энд тэнд л олон газар хяналтын байгууллагууд тус тусдаа ингээд хийгээд байгаа бол, байгаад байгаа бол энэ хяналтын төлөвлөгөөг ингээд байгууллага хоорондуур нь уялдуулаад хамтарсан шалгалтыг орхигдуулдаг, энийгээ төлөвлөдөг ийм болговол ажил сайжрах юм байна гэж ингэж харагдаж байгаа.

Тэгээд би түрүүн хэлээд байгаа аудитын дүгнэлт бол парламентын хяналтын эх сурвалж байна гэсэн зүйлийг л энэ хуульд тодорхойлж өгөөд аудитынхаа дүгнэлт дээр үндэслээд, аудитынхаа дүгнэлтийг бид нар маш сайн

харж, тэрийг мөрддөг байх хэрэгтэй байна. Тэгээд парламентын хянан шалгах сонсгол, хяналтын сонсгол зэргийг.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

**Б.Батбаатар:** Өнөөдөр ингээд Их Хурлын даргын санаачлан өргөн мэдүүлж байгаа, мэдүүлсэн хуулийг Их Хурал өөрөө хэлэлцэж байна. 3 хууль хэлэлцэж байна. Хяналт шалгалтын тухай, Их Хурлын хяналт шалгалтын тухай гээд. Тэгээд Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг яагаад өөрчлөх шаардлага үүссэн юм бэ гэхээр жишээлэх юм бол энэ мэдээлэл дээр байж байгаа л даа 64 гишүүнээс давхардсан тоогоор 59 асуулга тавигдаад Байнгын хороогоор ердөө 7-хон хэлэлцэгдээд нэгдсэн чуулганаар нэг ч асуулгын хариу хэлэлцэгдээгүй байна гэдэг “0” үзүүлэлттэй.

Тэгэхээр ингээд Их Хурал маань өөрөө хяналт, шалгалтаа хийж чадахгүй бол төсөөтэй төлөвлөгөө цаашлаад Их Хурлын баталж байгаа хуулиудын үр дүн байхгүй болж байна гэдэг зүйлээр ярьж байгаа. Энэ үүднээсээ хяналт шалгалт явж байгаа. Тэгэхдээ Их хурал Засгийн газрын хяналт шалгалт дээрээ бас энэ асуудлаа сайжруулахаасаа гадна Их Хурлын харьяа байгууллагуудыг хянадаг, шалгадаг зүйл дээрээ бас давхар анхаарсан уу үгүй юу гэдгийг энэ хуулийн төслөөс асуумаар байгаа юм. Их Хуралд зөвлөн туслах, дэмжих, дүгнэлт гаргаж өгөх гээд гишүүд янз бүрээр асуугаад хариултууд аваад байна шүү дээ. Би тэгээд энэ ярьж байгаа зүйлийгээ их хүчин төгөлдөр байгаа хууль гэхээсээ илүү өөрчлөх гэж байгаа хуулийн төслөө хэдүүлээ ярьж байгаа учраас өөрчлөх гэж байгаа хууль дээрээ ингэж байгаа гэж яриасай гэж хүсээд байгаа юм.

Одоо манай Их Хурлын дэд дарга хуралдаан даргалагч Пүрэвдорж бид 2 энэ зааланд яах вэ микрофонгүйгээр нэг муудалцаад авсан л даа. 390 сая төгрөг орон сууцын дэмжлэг авсан гээд Их Хурлын дэд дарга нь намайг хэлчихсэн. Зүгээр байгаарай тийм юм байхгүй ээ гээд хэлсэн. Үгүй ээ цахим орчинд тэгж байна чи авсан л байна шүү дээ гэж. Тэгээд Их Хурлын дэд дарга анх энэ хэл яриаг үүсгэсэн юм байна гэж ойлгосон. Сая Их Хурлын Тамгын газар энийг олон нийтэд хэлээрэй гэсэн. Хэлэхгүй байж байж нэг ийм 40 гишүүн авсан гэхээр 1 ч гишүүн аваагүй гэдэг нэг юм гаргаж байгаа юм.

Тэгэхээр Их Хурлын даргын байгуулж байгаа ажлын хэсгээр Их Хурлын бас нэр хүнд, Их Хурлын ажиллах энэ сайн, муу мэдээлэлтэй холбоотой нэг ажлын хэсэг байгуулагдаад өнөөдөр хуралдах гэж байна гэж ойлгосон. Тэгэхээр ийм зүйлүүд дээрээ буюу Их Хурлаас томилогддог харьяа байгууллагууд дээрээ хяналт, шалгалтаа хэрхэн явуулах юм бэ гэдэг зүйл байж байгаа.

Сайжруулна гэдэг бол улс төрийн тайлбар болохоос биш хууль зүйн баталгаа биш. Тэгэхээр энэ Байнгын хороо, чуулганы хуваарийн ард, хурлын ард алга болдог энэ зүйлүүдийг хэдүүлээ бас нэг энэ хуулиудаас нь хараад л байна л даа. Тэгэхээр энэ биелэх механизмуудыг нь оруулъя. Одоо ингээд гишүүдийн асууж байгаа асуултад сайжруулна ийм зүйл орсон тусгай журмаар энэ тэр гээд ингээд яваад байдаг. Цаглавар баталж байна. Энэ цаглавар баталж байгаа нь бол их сайн зүйл ээ гэж байгаа юм.

Тэгэхдээ энэ цаглавар чинь төлөвлөлт, хэрэгжилт л байгаад зүгээр архивд ордог, зүгээр бичиг хэрэгт ордог тийм л дагалдах хавсралт материал болж байгаа байхгүй юу. Хариуцлагагүй цаглавар бол ерөөсөө хяналтын ... ч зүгээр л чуулганы санал, бичиг болчихоод байгаа юм. Тэгэхээр цаглаварынхаа хэрэгжилтийг танилцуулдаг, хэрэгжилт нь 70 хувь ч байдаг юм уу, 60 хувь ч байдаг юм уу 80 хувиас доош байвал шалтгаан хариуцагч тэр дараагийн арга хэмжээгээ яаж төлүүлэх юм бэ гэдгийг оруулахгүйгээр энэ хууль амь орж, Их Хурал хяналт шалгалтын чиг үүргээ, эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй ээ гэж.

Сайдын амлалтын асуудлыг гээд ингээд байж байна. Тэгэхээр сайдын амлалт бол мэдээж шинэ дэвшилттэй бас орж ирж байгаа зохицуулалт. Тэгэхдээ үүн дээр бас хэрэв сайд амлалт биелүүлээгүй бол яах юм бэ гэдэг. Тэгэхээр энэ амлалтынхаа бүртгэлийг хэдүүлээ бас нэг хэд хэдэн зүйлээр бодмоор байгаа юм. Байнгын хороонд мэдээлэл хийгээд 3 юм уу, 5 удаа Их Хуралд чуулганд мэдээлэл хийгээд энэ хүрээндээ хэрвээ түрүүн хууль санаачлагч Ерөнхий сайдад санал явуулна гэж.

Тэгэхээр бид нар энэ Хяналт шалгалтынхаа хуульдаа хуулийнхаа.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Хэн хариулах вэ? Бямбацогт дарга хариулъя.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлаас хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ сая та бас их хөндөж ярилаа 20-оос 24 оны парламент дээрээс 166 гишүүн 102 асуулга тавиад тэрнээс 32 асуулга хэлэлцэгдэж байсан байгаа юм. 24-өөс 26 оны энэ 2 жилийн хугацаанд 4 ээлжит чуулганы хугацаанд 64 гишүүнээс 59 асуулга тавигдсан. Чуулганаар 1 ч асуулга хэлэлцэгдээгүй байгаа юм. Тийм болохоор сар бүрийн 1 дэх, 3 дахь, 7 хоногийн үдээс хойш баасан гаргийн 14 цагаас гишүүдийн асуулгыг хэлэлцдэг байх энэ дэгийг, зохицуулалтыг нэлээн оруулж өгч байгаа.

Мөн бас тулгамдсан асуудлуудаар нэн яаралтай гэж үзэх юм бол Байнгын хороо, чуулган дээр бас ирэх 7 хоногт нь шууд мэдээлэл сонсдог байх Ерөнхий сайд, холбогдох сайд нараас. Дахиад Их Хурлын гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэл дээр хянан шалгах түр хороо бол хамгийн дээд функц. Түүнээс гадна хяналтын сонсгол хийх энэ функцээр хэрэглэнэ. Үүнээс гадна Их Хурлын дэргэдэх байгууллагуудаа оролцуулж болно. Оролцуулахдаа бол үндсэн үйл ажиллагаанд нь нөлөөлөхгүйгээр оролцуулах ийм зохицуулалтууд орж байгаа.

Цаглавартай холбоотой асуудал дээр ялангуяа энэ төрийн хөгжлийн бодлогын бичиг баримт, төрийн бодлогын бичиг баримтуудын хэрэгжилт хоорондоо уялдах, хэрэгжүүлэх. Сая бид нар ингээд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлт хэлэлцсэн. Нөгөө 8 Байнгын хороогоор дамжуулж хэлэлцсэн. Тэгээд Байнгын хороо болгон дээр үндсэндээ 5 гишүүн сууж байдаг, ирцдээ орчихоод тал нь алга болчихдог. Нөгөө мөрийн хөтөлбөрийн биелэлт, тайлан хэлэлцэж байгаа учраас 50 төрийн албан хаагч яам болгоноос 2-3 хүн ингээд ирчихсэн. Ингээд 50-аад хүн бол 8 Байнгын хороо дамжаад ингээд л яваад байдаг. Үр дүн багатай. Энэ юмнуудыг бас зохицуулж байгаа юм.

Мөн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнг Улсын Их Хурал хэлэлцэхдээ үйл ажиллагаа, төсөл арга хэмжээ нэг бүрээр нь, тэрний биелэлтээр нь биш Улсын Их Хурлаас баталж өгсөн зорилго, зорилтын хүрсэн түвшин, нийгэм, эдийн засгийн салбарын үндсэн үзүүлэлт гарсан өөрчлөлт, салбарын үндсэн үзүүлэлт, хүний хөгжлийн индекс, эрүүл мэндийнх, боловсролынх яг ямар байх ёстой, ямар байгаа юм, ямар болох зорилт тавьсанд хүрсэн үү, үгүй юү. Ингээд энэ бодлого зорилго, зорилтын түвшиндээ хүрсэн үү, хүрээгүй юу хэмждэг байх, илүү бас ерөнхий байдлаар хэмждэг байх, бодлогын түвшинд анхаардаг байх.

Тэгэхгүй хэтэрхий дотоод оношлол руу гэдэс, бөөр рүү нь орохгүй Засгийн газрын Хэрэг эрхлэх, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэгч ерөнхий газар зэрэг байгууллагууд нь тэр үйл ажиллагааныхаа төсөл, арга хэмжээ, хөтөлбөр нэг бүрээр нь ярилцана биз. Бодлогын түвшиндээ Их Хурал хяналтаа тавьдаг байх ийм зохицуулалтуудыг бас цаглавартай холбогдуулж бас оруулсан байгаа гэж бас хэлье. Гарсан үр дүн, үр нөлөөгөөр иргэдийн амьдралд нөлөөлсөн нөлөөллөөр нь хэмждэг байх.

**Б.Пүрэвдорж:** Батын Батбаатар гишүүн тодруулъя.

**Б.Батбаатар:** Тийм ээ хэдүүлээ энэ Их Хурал буюу төрийн Үндсэн хуулиар заагдсан төрийн удирдах дээд байгууллагынхаа хяналт шалгалтын эрх, чиг үүргийг бас үр дүнтэй болгох нь зүйтэй. Энэ Англид бол хамгийн хүчтэй ийм хяналтын хороо байж байдаг. 60 хоногийн дотор Засгийн газар хорооны зөвлөмжид хариу өгөх үүрэгтэй байж байдаг. Канадад бол 120 хоног буюу Сенаттай бол 150 календарийн хоног гээд байж байдаг. Энэтхэг бол сайдын амлалтыг хянах тусгай хороотой. Бүртгэдэг тэгээд тэр бүртгэснийгээ бүртгэлийнхээ дагуу нөгөөдхөө хянаж үзээд тэр сайдыг өөрчлөх эсэх. Герман бол цөөнхийн эрхтэй. Конгресс болохоор тийм хажуудаа ... буюу байж байдаг. Тэгэхээр Монголд энэ тохирох хяналтынхаа схемийгээ ямар байдлаар хэрэгжүүлэх юм бэ? Бид нарын энэ хяналт чинь одоо байгаа.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Хэн хариулах вэ? Аюушийн Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Би Батбаатар даргатай нэг юман дээр, ер нь санал нэг байна. Бид нар ердөөсөө нөгөө өгч байгаа үүрэг, даалгаврууд ч тэр, хяналт нь ч тэр ердөөсөө зөв, зохистой явахгүй байгаад байна. Тэгээд эхний ээлждээ ямар ч байсан нэгдсэн системтэй болъё. Тэр нь олон нийтэд нээлттэй болъё. Засгийн газар ямар үүрэг, даалгавар эндээс ирж байгаагаа хардаг болъё. Улсын Их Хурал ч гэсэн хэрэгжилт нь ямар байгаа вэ гэдгийгээ хардаг болъё. Зөвхөн Засгийн газар гэлтгүй Улсын Их Хурлын харьяа байгууллагуудыг ч гэсэн үүрэг, даалгавруудыг хэрхэн яаж биелүүлж байгаа вэ гэдгийгээ бид нар энэ системээрээ харна. Нэгдсэн байдлаар байна гэж.

Тэгээд ер нь таны яг хэлж байгаа энэ Улсын Их Хурлын харьяа байгууллагуудтайгаа бид нар бас өөрсдөө Улсын Их Хуралд бас сайн ажиллах хэрэгтэй. Яагаад гэвэл бид нар Засгийн газрын ажлыг л хянаад байгаа юм шиг ийм л ажиллагаа яваад байдаг. Гэтэл Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын энэ ажил бас их чухал. Бид нар тэндээ ч гэсэн бас хяналт, шалгалтыг бас сайн явуулах хэрэгцээтэй юм байна гэдэг бол бас ажиглагдсан. Үнэн зөв.

**Б.Пүрэвдорж:** Батын Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

**Б.Батбаатар:** Тэгэхээр бол мэдээж энэ сайн жишгүүд олон улсад байгаа. Дээрээс нь хууль өргөн барьж байгаа Их Хурлын гишүүдийн хүсэл, санаачилга, манлайллыг бол дэмжиж байгаа. Гэхдээ энийгээ хэдүүлээ бас нэг тийм зөөлөн зүгээр бүртгэдэг, зүгээр асуугаад орхидог зөөлөн механизм болгоод толгой илдэг механизм болгож болохгүй. Энэ хяналт гэдэг чинь бол бид нар асуулт тавиад өнгөрөхийг бол дангаар нь хэлэхгүй л гэж ойлгоод байгаа юм шүү дээ. Хариу өгөх хугацаа, биелүүлэх үүрэг, цөөнхийн санаачилга, сайдын амлалтын бүртгэл, хараат бус аудит, хэрэгжилтийн хариуцлага гээд ингээд тэгээд олон нийт, иргэдийн оролцоо, оролцоог хангах энэ бүхэл бүтэн ийм схем, системийг нь угсарч өгөх юу хэрэгтэй юм байгаа юм. Одоо өнөөдөр Их Хурлын аливаа нэг ажлын хэсэг байгуулах, хяналтын хорооны даргаар бол цөөнхүүд огт ажиллахгүй байгаа шүү дээ. Энэ бол хяналт бас бүдгэрч байгаагийн нэг шинж шүү дээ. Тэр нь.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Жудгийн Баярмаа гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн алга байна. Нэг зүйлийг бас энэ Ардчилсан намын бүлгийнхэнд хэлэхэд энэ цөөнхийн үг энэ Их Хурал дээр хэлэх чинь их үнэ цэнтэй байдаг. Тэгээд 90 минутад маш цөөхөн хүмүүс их цөөхөн Ардчилсан намын бүлгээс цаг авч байгаа үг хэлэх тэгээд тэрийгээ ингээд орхичоод явчхаж болмооргүй байна. Энэ дээр Тэмүүжин дарга энэ гишүүдийнхээ энэ үгээ хэлэх тэр хуваариа сайн ирж үгээ хариу энд байж байж үгээ хэлж байх ёстой. шүү. Дараагийн.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль тогтоолын төслүүдийн талаарх Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлж үг хэлнэ.

Соронзонболд гишүүн алга байна. Алтангэрэл гишүүн алга байна. Гишүүд үг хэлсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалтыг түр хойшлууллаа. Дараагийн асуудалд оръё. Дараагийн асуудалдаа оръё.

17.29 цаг

**Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Л.Мөнхбаясгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэсүрэнгийн усан цахилгаан станц барихыг дэмжиж байгаа ч хуулийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх нь зөв эсэх, уг төслүүдийг Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан төслүүдийг хэрэгжүүлэхийг дэмжиж байгаагаа илэрхийлж, ажлын хэсэг гарган тухайн төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийн үйл явцтай газар дээр нь очиж танилцах нь зүйтэй бөгөөд төсөл батлагдсанаар гарах үр дагаврын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэн горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 62.5 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Эрчим хүний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Дашдаваагийн Алтанцэцэг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчийн хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал.

Ажлын хэсгийнхэн, албан тушаалтнууд үнэн, зөвөөр худлаа мэдээлэл өгөхийг хориглоно гэсэн ийм заалттай байгаа. Тэгээд зөв мэдээлэл өгөхийг хүсье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Гадаад зээлийн ашиглалт энэ холбогдуулсан энэ хуулийн төсөл болохоор ер нь бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагаас болж байгаа. Тэгэхээр дотоодын төсвийн суурь тэнцэл нь ДНБ-ий 2 хувиас дээш үгүй хэмжээний ашигтай байна гээд, доошгүй хэмжээний. Тэгэхээр энэ дүрэмтэй холбоотой энэ 2 хувь ДНБ-ий 2 хувиас доошгүй хэмжээний суурь тэнцэл ашигтай байх энэ дүрмийг ер нь өөрчлөх, энэ 2 хувь ер нь яаж тогтсон юм, тэгээд цаашдаа энэ 2 хувийг өөрчлөх бодлого байгаа юу? 1 дүгээрт.

2 дугаарт энэ суурь тэнцэлд тооцохдоо зарим зардлуудыг бусад орнууд болохоор энэ хөгжлийн төсөлтэй холбоотой хөрөнгө оруулалтын зардлуудаа болохоор энэ хасагдах суурь тэнцлийн зардалдаа тооцдоггүй. Тэгснээрээ энэ энэ дүрмээсээ гадуур хөгжлийн төслүүдээ авч явдаг иймэрхүү жишгүүд бас байдаг. Тэгэхээр энэ талаар Сангийн яамнаас энэ суурь тэнцэлтэй холбоотой энэ дүрмийг ер нь ойрын үед өөрчлөх шаардлага хэрэгцээ гарах уу? Өөрчилбөл ямаршуу орон зай байгаа вэ? Олон улсын валютын сангийн зөвлөмж дээр ч гэсэн ер нь бол 2 хувь гэдэг бол нэлээн өндөр, хатуу ийм шаардлага гэсэн дүгнэлтүүд бас байгаа харагддаг. Бусад улсуудтай харьцуулахад ч гэсэн нэлээн өндөр харагддаг. Тэгэхээр энэ талаар тайлбарлаж өгөөч ээ гэсэн ийм асуулт байна.

**Б.Пүрэвдорж:** Сангийн сайд Мэндсайхан хариулъя.

**З.Мэндсайхан:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн зорилго бол мэдээж гадаад зээлийн ашиглалтаа явуулах. Гол нь Төсвийн тогтвортой байдлын хууль дээр нэгдсэн төсвийн суурь тэнцэл тухайн жилийн ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх гэдэг заалт байгаа. Энэ заалт бол 2024 онд энэ зохицуулалт нь орсон хийгдсэн өөрчлөлт. Төсвийн тогтвортой байдлаа төсвийн сахилга баттай бол уялдаатайгаар хийсэн.

Тэгэхдээ бид нар ер нь алдагдалгүй төсөв батална гэдэг бол цаашдаа бид нар энэ хөрөнгийн зардлыг бол тэлж чадахгүй байдал руу л орж байгаа. Тэгэхээр энэ дээр бол өөрчлөлт хийх эрх нь бол мэдээж Их Хурлын гишүүдэд л байгаа гэж хариулахаар байна. Зүгээр яг юуны талаар нь өөрчлөх эсэх дээр бол бид нар хэрэгжилтэд нь үнэлэлт, дүгнэлт хийж байж 24 онд орсон өөрчлөлт учраас энэ хэрэгжилтийнх нь талд нь бас тодорхой хэмжээнд хугацаанд дүгнэлт хийж үзэх нь зөв байх гэж бодож байна. Өөрчлөлт хийхээс өмнө.

**Б.Пүрэвдорж:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Энэ хувийг 2 хувийг суурь тэнцэл 2-оос доошгүй хувийн ашигтай байх энэ дүрмийг өөрчлөхөд Олон улсын валютын сан ч юм уу энэ олон улсын санхүүгийн байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн хүрээнд заавал ийм байх ёстой гэсэн тохирсон зүйл байдаг уу? Энэ талаар мэдээлэл өгөөч.

**Б.Пүрэвдорж:** Мэндсайхан сайд хариулъя.

**3.Мэндсайхан:** Тийм зөвлөмж энэ тэр бол байхгүй. Зүгээр суурь зарлага гэдэг бол урсгал болон хөрөнгийн зардал байгаа. Тэгэхээр энийг яагаад гаргасан гэхээр гадаад зээлийн орон зай гаргаж чадахгүй байсан учраас л энэ суурь тэнцэл байх ёстой гэж гаргаж ирсэн байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

**А.Ариунзаяа:** Би өнгөрсөн хуралдаан дээр яг энэ хуулийг оруулж ирж байхад энэ хүүхэд нуугдаж тоглохдоо зүгээр нэг нүдээ хаагаад л тэгээд л би нуугдчихсан шүү гэж хэлж байгаатай яг адилхан зүгээр өөрийгөө хуурсан л ийм асуудал байна гэж хэлсэн. Тэгээд яах вэ яг нүдээ хаасан тэр хэсэг нь л явж байгаа л гол агуулга нь ердөөсөө хүмүүст сайн хүрсэн болов уу үгүй болов уу гэдгийг бас гайхаад байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 24 оны 08 сарын 30-ны өдөр өөрчлөлт оруулсан буюу Улсын Их Хурлын сонгуулийн дараагаар шинээр Засгийн газар хамтарсан Засгийн газар бүрдээд төсвийн тодотголоо оруулж ирээд явж байхад алдагдалтай төсөв батлахгүй ээ гэж хэсэг нөхөд попорч, түүний дараагаар Тэмүүлэн нарын гишүүд шиг санаад байх юм энэ хуулийн өөрчлөлтийг бас өргөн барьж 24 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 24 онд энэ ДНБ-ий 2.8 хувиас хэтрэхгүй, 25 оны төсвийн жилээс эхлэн төсвийн нэгдсэн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, эс үгүй бол ашигтай байна гэж орсон юм.

Тэгэхээр алдагдалгүй төсөв байна гэсэн тэр хийрхлээс чинь үүсэж, өнөөдөр яг тухайн тэр Засгийн газар нь хамтарсан Засгийн газар маш олон мега төслүүдийг эхлүүлээд ингээд гэрээ хэлэлцээрээ хийгээд, ажлуудаа эхлүүлээд, зээлээ аваад ингээд явж байгаа, шинээр эхэлж байгаа, үргэлжлэн явж байгаа маш олон хэлэлцээрүүдтэй байгаад гагцхүү өөрөө өөрсдийгөө чөдөрлөсөн ийм л асуудал.

Тэгээд энэ хууль нь өөрөө юу вэ гэхлээр энэ тэнцлийн алдагдалд энэ 2 төслийг оруулахгүй шүү гэж гадна гаргаж байгаа ийм хуулийн төсөл юм. Энэ хуулийн 3.1 дээр бол яг энэ 2 заагдсан гадаад зээлийн төслийг энэ зардлын хэмжээнд тооцохгүй ээ. Гэхдээ 3.2 дээр нь болохлоор энэ хасагдсан 2 төслийн гадаад зээлийн энэ ашиглалтын зардлаар нь бусад гадаад зээл, тусламжийн энэ зардлыг бол нэмэгдүүлж болно гээд ингээд оруулаад өгчихсөн.

Тэгэхээр дефакто тэр 2 хувийн юу гэдэг юм тийм алдагдал чинь тийм ээ нэмэгдээд явчхаж байгаа. Зарцуулалт бол нэмэгдээд явна. De jure магадгүй зүгээр юу гэдэг юм энэ 2 төслийг чинь оруулахгүй ээ гээд л өөрөө өөрсдийгөө хуурч байгаа асуудал байхгүй юу даа. Тэгээд та бүхэн маань хэрэвзээ санаж байвал тухайн үедээ бас дараа оных нь төсөв нь орж ирэхэд яг энэ энэ 2 хувьдаа багтахгүй байна.

Ер нь төсөв хэцүү байна гээд төрийн албан хаагчдын маш олон жил ажиллаад төрдөө зүтгээд, тэгээд өндөр насны тэтгэвэртээ гарахад 36 сарын тэтгэмжийг 1 удаадаа олгодог энэ тэтгэмжийг нь хүртэл 50 хувийг нь л өгсөн шүү дээ. Тэгээд 50 хувийг нь дараа жил рүү шилжүүлнэ ээ гэсэн. Тэгээд одоо энэ

дараа жил нийт тэтгэвэртээ гарах төрийн албан хаагчдын 36 сарыг нь 100 хувиар өгөөд энэ жил гарч байгаа төрийн албан хаагчдын 50 хувийг нь тэтгэврийнх нь тэр 36 сарын 50 хувийг нь өгч чадах уу? Урсгал зардал, цалин хөлсний энэ нэмэгдэл, тэтгэврийн энэ асуудал дараа жилийн төсөвтөө оруулж чадах уу? Яг энэ 2 хувийн хязгаартайгаа хэвээрээ тэгээд яг яаж энэ амьдрал чинь, энэ улсын хөгжил чинь явах гээд байгаа юм бэ гэдэг ийм асуудлыг би асуугаад байгаа юм. Тэгэхээр энэ 2 хувийн тавьсан энэ өөрийн өөртөө тавьсан энэ чөдөр тушаа чинь буруу юм аа, энийг үнэлээд байх ямар ч шаардлага байхгүй угаасаа ойлгомжтой. Тэгэхээр энийг ядаж нэг 4 хувьд хүргэх ийм хуулийн төслийг болохгүй л бол би санаачилъя. Гишүүд маань дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна. Яагаад гэхлээр.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** 1 минутаа нэмж явъя.

**А.Ариунзаяа:** 2017 онд тухайн үед чинь манай улс бас нэлээд сайн Mining Boom явж байлаа шүү дээ. Mining Mongolia гээд л дэлхийд алдартай цаг үе байсан, хөрөнгө оруулагчдыг Монгол Улсдаа дуудаж урьж оруулж байлаа шүү дээ. Уралдан манай улсад ирж байсан. Тэгэхэд бол манайх энэ яг энэ 2 хувь чинь бол 17 онд 10.4 хувийн хязгаартай байсан байхгүй юу. Тэгээд уул энэ улс хөгжих гээд байгаа юм уу хөгжихгүй ингээд л байгаад байх юм уу гэдэг ийм л асуултын өмнө ирж байгаа. Тэгэхээр тэр нүдээ хаах ч яах вэ гэхдээ ямар ч байсан энэ чөдөр тушаагаа бол авч хаях ёстой юм. Тэгээд энийг Засгийн газар өөрөө ингээд тэгээсэй гэж хүсээд гэхдээ нээлттэй энийгээ хэлж чадахгүй тэгээд цөөхөн хэдэн ийм эдийн засгийн алуурчин гэхэд ч хаашаа юм ийм асуудлыг бол бас засах ёстой шүү дээ. Улс орны хөгжлийн энэ асуудлыг бол бид нар анхаарах ёстой байхгүй юу даа. Хэнийг зальж дараагийн удаа урсгал зардлаа хасах вэ хэцүү шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** Мэндсайхан сайд хариулъя.

**3.Мэндсайхан:** Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр суурь тэнцэл чинь гадаад зээлийн ашиглалт хасаад 2 хувийн ашигтай байна. Тэнцвэржүүлсэн тэнцэл нь бол 2 хувийн алдагдалтай байна гээд энэ 2-ын зөрүүгээр буюу 4 хувийн зөрүүгээр бид нар гадаад зээлийг санхүүжүүлээд явж байгаа, гадаад зээлийн ашиглалтаа хийгээд.

Тэгэхээр гадаад зээлийн ашиглалт бол төсвийн орлого тооцохгүй, санхүүжилтийн эх үүсвэр болоод явчихна. Тэгэхээр алдагдлаа нэмээд нөгөө гадаад зээл аваад бонд гаргаад цалин тавьдгаараа тавина гэсэн ойлголт бол байхгүй.

**Б.Пүрэвдорж:** Ариунзаяа гишүүн тодруулъя.

**А.Ариунзаяа:** Тэгээд тэмээ гэхээр ямаа гээд би ямар гадаад зээлээр цалин хөлс тэтгэвэр тавьж байгаа гэсэн биш дээ. Би урсгал зардлыг яриад байна шүү дээ. Ер нь бол байна шүү дээ 26 оны байдлаар Монгол Улс 20.9 их наяд төгрөгийн 74 төсөл хэрэгжүүлж байгаа. Тэгээд эдгээр нь 34 хувийг нь л бид нар ашигласан 66 хувийг нь бол одоо хүртэл ашиглаж чадаагүй ингээд хэвээрээ байгаад байгаа.

Тэгээд энэ төслүүдийн 82 хувь нь бол 26-аас 29 онд хэрэгжиж дуусахаар гэрээ хэлэлцээр хийчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хугацаандаа бид нар авсан зээлээ уг нь бол дуусгах ёстой. Тэгээд ингээд өөрийн өөртөө тавьсан бусад

энэ чөдөр тушаагаараа одоо энэ зээлийн бүрэн ашиглалт явагдахгүй байна. Хугацаа хойшилно, зээлийн төлбөр, хүүгийн төлбөр нэмэгдэнэ. Хүн ч дээ тэгэхээр яах вэ нэг би уг нь Засагт туслах гээд байгаа байхгүй юу санаа нь бол. Тэгэхээр тэмээ гэхээр ямаа гэж битгий хэлээч ээ. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууна.

**Р.Эрдэнэбүрэн:** Энэ юуг дэмжиж байгаа хуулийн төслийг. Тэгэхдээ 2, 3 асуулт асуучих гэсэн юм.

1 дүгээрт нь Сангийн сайдаас энэ төсөл хэрэгжүүлж байгаа хүмүүсээс ч юм уу асуух гэсэн юм. Энэ 2 төсөл ялангуяа энэ Зүүнбаянгийн нефтийн үйлдвэр, Эрдэнэбүрэний усан цахилгаан станц-II дээр дахиж янз бүрийн асуудал гарах уу? Дахиад ийм юм болохгүй байна зээл нэмж авахгүй бол болохгүй байна энэ тэр гэсэн ийм асуудал гарах уу, гарахгүй юу гэдэг дээр нэг хариулт өгчхөөч 1 дүгээрт нь. Ингээд энэнээс хойш ямар ч асуудал байхгүй ээ гэж яг үнэхээр хэлж чадах уу гэдгийг 1 дүгээрт асуучихмаар байгаа юм.

Хоёрт нь бол бид нар бол энэ маргаан юун дээр явагдаад байна гэхлээр одоо байгаа тогтолцоо дээр тогтолцоо чинь ийм байгаа гэдэг маргаан л яваад байгаа шүү дээ. Гэтэл бол яг логикоороо бол жишээлбэл хувийн хэвшлийнхэн ийм зээл авчих юм бол маш хурдан хугацаанд зээлээ ашиглаад үр ашгаа хурдан авч зээлээ эргэж төлөх тухай л бодно шүү дээ өдөр, шөнөгүй. Тэгээд нэгэнт л ийм мангар юм байж болохгүй шүү дээ зээл авчхаад тэрийгээ ашиглаж чадахгүй тэгээд бид нарын тогтолцоо ийм гээд суугаад.

Тэгэхлээр энэ тогтолцоогоо өөрчлөх хэрэгтэй. Зоригтойнхон. Тэгээд энэ дээр ямар саналтай байгаа вэ Сангийн сайд? Тэгээд тэр их энэ эхний юу их чухал байгаа шүү. Дахиад л ингээд бас баахан асуудал ер нь бол хүмүүсийн бас зарим шүүмжилж байгаа зүйлүүд бас ор үндэстэй тэр менежмент хийж байгаа, зохицуулж байгаа улсууд чинь хаана явсан юм бэ өдий болтол гэдэг их юм их ярьж байгаа шүү.

**Б.Пүрэвдорж:** Сангийн сайд Загджавын Мэндсайхан хариулна.

**3.Мэндсайхан:** Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя. Сүүлд 2025 оны 1 сард Улсын Их Хурлаар соёрхон баталсан зээлийн гэрээнд хэрэв нэмэлт зардал гарвал Монгол Улсын тал Монголын тал өөрсдөө хариуцахаар заасан. Өөрөөр хэлбэл, бид нар нэмж зээл авахгүй. Улсын төсвийн хөрөнгө оруулалтуудыг шийдээд явахаар заасан байгаа юм. Тэгэхээр бид нар энэ хуулийг оруулж ирж байгаа зорилго бол тэр төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүй хугацаанд нь зээлийн ашиглалтаа бүрэн ашиглаад, шаардлагатай санхүүжилтийг нь тухайн онд нь хийгээд хугацаанд нь оруулах энэ зорилгоор оруулж ирж байгаа юм. Иймгүй бол бид нар дээр гэрээнийхээ дагуу нэмэлт зардал гарахаар байгаа.

Тийм учраас энэ нэмэлт зардал болон төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүйн тулд хугацаанд нь зээлээ ашиглаад хугацаанд нь энэ нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төслүүдээ ашиглалтад оруулъя гэдэг энэ зорилгоор оруулж ирж байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

**Г.Очирбат:** Гишүүддээ оройн мэнд хүргэе. Энэ 7 хоногийн 1 дэх өдөр Ардчилсан намын бүлэг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхнийг бүлгийн хурал дээрээ дуудаад гадаад зээл эрхлэхтэй холбоотой танилцуулга мэдээлэл өгөөч ээ гэж хүсэлт тавиад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань ирсэн юм. Материал нь энэ байна. Энэ материалтай холбоотой 12 хуудас орчим материал байна. Тэгээд минут бага байгаа болохоор би шууд дүгнэлт рүү нь орё гэж бодож байгаа юм. Дүгнэлт дээр 2-хон зүйл, заалтыг нь эхлээд уншиж үзүүлье. Төсвийн тодорхой тодорхой зүйл, заалтуудтай холбоотой асуудлууд шүү. 2010 оноос хойш эдийн засгийн таатай нөхцөл байдалд дулдуйдан төсвийн зарлагыг хэт өндрөөр тэлсэн төсвийн бодлогын орон зайг хумьж өнөөдрийн нөхцөл байдал бий болгоход тодорхой нөлөөлөл үзүүлсэн байна. Тодруулбал, төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг бодитой хэрэгжүүлж чадаагүй нь энэ нөхцөл байдлын нэг том шалтгаан болсон. Нэг.

Хоёрт нь энэхүү хууль батлагдвал төсвийн тогтолцоо эрх зүйн орчинд томоохон сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд 2 төсөвтэй болох, төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээний хязгаарлалтаас гаргах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн бодлогын ач холбогдлыг сулруулах зэрэг үр дагавар гарахаар байна гэж байгаа юм. Ингээд Сангийн яам энэ дүгнэлттэй танилцсан уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ өгөөд байгаа зөвлөмжийг авч ажиллах гэж байгаа юм уу? Авахгүй муйхарлаж ажиллаад цаашдаа гарах үр дагаврыг нь манай Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамныхан хариуцаж чадах уу гэдэг асуулт байна.

Дараагийнх нь зөвлөмж. Би бас нэгийг нь л уншиж өгье минут бага байна. Хөгжлийн болон эдийн засгийн үр ашигтай төслүүдийг Хөгжлийн банк зэрэг бусад институцийн орон зайг ашиглаж хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх гэж байгаа юм. Тэгээд ийм боломж, бололцоо байна уу байхгүй юу Сангийн яамныхан? Бид Хөгжлийн банк гээд банктай. Хөгжүүлэе гээд төсөл, хөтөлбөр оруулж ирээд явуулъя гэхээр явж өгдөггүй. Хийж хэрэгжүүлэе гэхээр бодлогоор дэмждэггүй, бүх юм төр мэдэх ёстой. Төрийн өмчит компани байх ёстой гэдэг ийм агуулгаар цаашаа явах юм уу? Төр иргэддээ ээлтэй аж ахуйн нэгжийнхээ эдийн засгийн боломжийг олгосон ийм шийдвэрүүдээ гаргаад бодлогын шийдвэрүүдээ гаргаад л явах ёстой. Хууль, эрх зүйн орчноор нээж өгөөд л явах ёстой.

Тэгэхэд өнөөдөр төрийн өмчийн компаниуд чинь хэдэн зуун хэдэн мянгаараа бараг нэмэгдчихсэн. Бүх эрх мэдлийг төр авчихсан. Сайд дарга болж байж, ямар нэгэн тушаал шийдвэр гаргаж байж тэнд ажил явуулдаг. Хамгийн том ажил олгогч төр болсон. 226 мянга байсан. Хамтарсан засгийн үед 9 хувь бууруулсан л байх. Ингээд цаашдаа ингээд яваад байх нь энэ Монгол Улсын энэ эдийн засгийн нөхцөл байдалд ер нь зөв үр дагавар авчрах юм уу, буруу сөрөг үр дагавар авчрах юм уу? Сангийн яамныхаа нэг олон жил Монгол Улсын сан хөмрөгийг барьж байсан хүмүүст нэг тодорхой хариулаад өгчхөөрэй.

Алтанширээтийн газрын тосны үйлдвэрийн Алтанцэцэг захирал байна. Би Аж үйлдвэрчдийн бодлогын байнгын хороонд ажлын хэсэгт орж ажилласан. Танай дээр очиж үзсэн. Явж байгаа ажлууд бол байна. Явахгүй дээрэмдүүлж тонуулж байгаа ажлууд ч зөндөө байгаа. Энэ орлоо гэхэд яг үр өгөөжөө өгч чадах уу? Нөөц

хаа байсан Тамсагаас Дорнодоос наашаа шугам олоод татсан өргөх станцуудынх нь тоноглол хэрэглэл нь хулгайд алдагдаад дуусаж байсан шүү дээ. Энэ үйлдвэрлэж чадах уу, бүтээгдэхүүн гарч чадах уу?

**Б.Пүрэвдорж:** Эхлээд хэнээс асуух вэ? Мэндсайхан сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Очирбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөмжийг уншсан. Жишээлбэл Төсөв тогтвортой байдлын зөвлөмж бол зарлагыг ДНБ-ий 25 хувьд байх ёстойг зөвлөдөг. Энэ тооцоогоор бол одоогийн 32 их наяд 7 их наядар буурна. 25 их наяд болох ийм ёстой зөвлөмж байгаа. Одоо явж байгаа урсгал зардал 24.9 байгаа.

Тэгэхээр бид нарт бол шийдлээ хүлээж байгаа маш олон асуудлууд байгаа гэдгийг та бас надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа. 2 төсөвтэй болохгүйн тулд хуулийн зохицуулалтыг бид нар хийж өгсөн байгаа. Гадаад зээлийн ашиглалт дээр нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцвэр тэнцлийн алдагдлын хэмжээ энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн тухайн жилийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болох бөгөөд нэмэгдсэн дүн нь дээрх хязгаарт хамаарахгүй ээ гэж оруулж өгсөн. Нөгөө заалт нь бол тухайн жилийн Төсвийн тухай хуулиар баталсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал нь энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтаар зардлаар нэмэгдэж болно гэж зааж өгсөн байгаа.

Хөгжлийн банктэй холбоотой асуудал дээр бол дунд хугацаандаа бол бид нар Хөгжлийн банкаар дамжуулаад явж болно. Одоо байгаа зээл, төслүүдэд бол бүгдээрээ Монгол Улсын Засгийн газарт өгсөн нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлүүд тэгээд тусламжууд явж байгаа. Цаашдаа бид нар дунд хугацаандаа олон улсын байгууллагатай ер нь бол энэ талаар уулзалт хийж байгаа. Яагаад гэхээр бид нар цаашдаа арилжааны хүүтэй зээл авах нь ээ Монгол Улс.

Тийм учраас Хөгжлийн банкны балансыг сайжруулах, засаглалыг сайжруулах, тэгээд үүний дараа нөгөө нэг засаглалаас гадна Хөгжлийн банкаа бид нар олон улсын тэр тавиад байгаа, донор байгууллагуудын тавиад байгаа хууль, эрх зүйн орчинд нь нийцүүлж өгөх ёстой байгаа юм. Энэнээс цаашаа бид нар нэгэнт арилжааны хүүтэй зээл авах юм чинь Хөгжлийн банкаараа дамжуулаад Засгийн газрын баталгаа гаргаад Засгийн газар баталгаа гаргаад энэ гадаад зээлүүдээ Хөгжлийн банкин дээр нийгэм, эдийн засагт ашигтай төслүүдээр нь эрэмбэлээд зээлээ аваад явах боломж байгаа. Тэр Алтанширээгийн асуудлаа та хариулчих уу?

**Б.Пүрэвдорж:** Индэрийн 4 дүгээр микрофон нэр албан тушаалаа хэлээд хариулаарай.

**Д.Алтанцэцэг:** “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал. Очирбат гишүүний асуултад хариулъя. Газрын Дорноговь аймгийн Алтанширээт сумын нутагт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн тоног төхөөрөмжийн инженерчлэл, худалдан авалт, тээвэрлэлт, барилга угсралт энэ бүх үе шат бол

энэ үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэгч хяналт тавьдаг төслийн менежментийн зөвлөх, зураг төсөл зохиогч, зураг төслийн хяналт, санхүүжүүлэгч байгууллага салбарын яамнуудын хараа хяналт доор энэ бүх үе шаттайгаар зураг төслийг нь зохиож, үйлдвэрлэгдэж, худалдан авалт хийгдэж, тоног төхөөрөмж угсрагддаг учраас энд бол тийм тоног төхөөрөмжийн алдагдсан, тоногдсон гэсэн асуудал бол байхгүй.

**Б.Пүрэвдорж:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Сангийн яамны сайд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхний зөвлөмжийг авч байгаа гэж ер нь хэлж байна тийм үү цаашдаа ер нь Монгол улс бол энэ төрийн өмчит компани гэхээсээ илүүтэйгээр Хөгжлийн банкаараа дамжуулаад хөгжлийнхөө төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь зөв өө гэдэг дээр бол өнөөдөр та хэллээ шүү. Тэгээд дараа нь энэ үгнээсээ буцав аа, асуудлуудыг нь эрхийг нь нээж өгөөрэй гэдгийг танд 1 дүгээрт хэлье.

Хоёрт гэх юм бол газрын тосны үйлдвэрийнхэн маань хариулаад сурчихсан байна шүү дээ. Бид нар газар дээр нь яваад очиход тэр өргөх станцуудыг чинь мотор, цахилгаан хэрэгслүүдийг нь тоночихсон бид нар хамгаалж чадахгүй байна гээд зогсож байсан биз дээ? Бид нар энэ харуул хамгаалалтаа хянаад хүн тавьж чадахгүй байна хааяа нэг очихоор хамаг өргөх моторуудыг нь аваад тоночихсон байх юм гээд та өөрөө ярьж байсан шүү дээ. Тэгээд одоо ингээд яг энэ чуулганд үнэнээ зовлонгоо хэл л дээ. Одоо ингээд өөр тайлбар өгөөд зогсоод байх юм. Тэгээд ер нь цаашдаа наад бензин, нефть үйлдвэрлэж чадах юм уу чадахгүй юм уу?

**Б.Пүрэвдорж:** Алтанцэцэг захирал харилъя.

**Д.Алтанцэцэг:** Очирбат гишүүний асуултад хариулъя. Таныг очиход ярьж байсан асуудал бол бид төрөөс энэ үйлдвэрийн талбайгаас алслагдмал объектуудыг төрийн хамгаалалтад аваач ээ гэж бид нар хүсэлт гаргаад 23 оноос хойш Засгийн газартаа хандаж байсан. Хууль зүйн яам, Дотоодын цэргийн штабт хүртэл хандаж ирсэн.

Гэхдээ бид бол тухайн үед нэлээд өндөр өртөгтэй 3 жилийн хугацаанд 4.17 тэрбум төгрөгийн төсөвтэй төсөвт харуулын хамгаалалтын ажил хийнэ гэсэн учраас манай компани үүнийг бол цаашид камержуулж, ээлжээр харуул манаанд тавьж өөрсдийнхөө боломжоороо хамгаалаад явж байгаа. Тэр үед бол тоног төхөөрөмж алдагдаагүй кабель утас, өргөх насосын кабель утас энэ тэр алдагдаад тэнд бас бид нар ноцтой байдал үүслээ гээд ингээд Засгийн газартаа хандаж байсан үед тантай ярьж байсан юм. Одоо бол бид бол тэрийг өөрсдийнхөө хэмжээндээ 3 ээлжээр харуул манаа тавиад худгууд дээрээ өргөх, шахах станц дээрээ харуул манаа тавиад ажиллуул.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

**Б.Түвшин:** Та бүхэнд оройн мэндийг хүргэе ээ. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай гээд ийм хууль. Тэгэхдээ энэ ер нь гадаад зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх процессын тухай асуудал биш. Энэ бол ерөөсөө л энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсвийн зардлыг нэмэгдүүлье ээ л гэсэн

ийм л заалттай. Тэгээд энийг болохлоороо зардлыг зардал бишээр тооцъё л гэсэн ийм агуулга шүү дээ. Тэгээд эндээс нэг хэдэн асуултууд байгаад байгаа юм.

Энэ хууль техникийн бичилтийнхээ хувьд ингэсэн л байгаа юм л даа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээг энэ хуулийн тухай энэ хуулийн 2.1-д заасан гадаад зээлийн жилийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно. Тэгээд тэр нь хязгаарт хамаарахгүй, зардал тооцохгүй гэсэн үг.

Нөгөө талдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 чинь энэ ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай байна гээд заачихсан. Ингээд 2 өөр хууль зэрэгцээд гараад ирж байгаа 19.9-ийг ерөөсөө огт хөндөөгүй байгаад байгаа юм. Магадгүй хууль зүйн хувьд бол нь тусгайлан нарийвчлан зохицуулсан хууль нь өндөр чадвартай сүүлийнх нь баталж байгаа учраас гэж мөрдөж болох юм. Гэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль чинь өөрөө суурь хууль учраас энэ хууль чинь ингээд хоёулаа зэрэгцээд байж байх юм бол аль нь хүчинтэй байх юм бэ? Энэ хууль зүйн техникийн хувьд бол зөв үү гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаарт, Монгол Улсын гадаад зээл бодитоороо ингээд энэ экспортын орлого, валютын тогтвортой урсгалыг бий болгож байна уу манай Монгол Улсын тогтворт, гадаад өр бол жил болгон л нэмэгдэж байна. Ямар нэгэн тийм валютын тогтвортой байнгын урсгал хийж экспортыг нэмэгдүүлж байгаа биш зүгээр л санхүүгийн богино хугацааны төсвийн алдагдлыг нөхөөд байгаа харагдаад байгаа юм. Тэгэхлээр одоо энэ дээр ямар үр дүн гарсан бэ сүүлийн хэдэн жилд? Тодорхой статистик хэлээдхээч.

Миний зүгээр харж байгаагаар 25 оны 1 дүгээр улиралд жишээлбэл экспорт 2.8-аас 2.9 тэрбум доллар хүрч байгаа нь өмнөх жилээс буурчихсан. Бид нарын гадаад зээл өсөж байгаа. Зүгээр л төсвийн алдагдал нөхөөд байгаа юм биш үү л гэж би бол ингэж хараад байна.

3 дугаарт, гадаад өрийн удирдлага ер нь сайжирсан уу? Өрийн удирдлагын стратегийн зорилт хэдэн хувьтай хэрэгжиж байгаа вэ? Манай улсын гадаад өрийн ДНБ-д харьцах харьцаа бол 150 хувьтай. 150, 40.4 тэрбум доллар. Тэгээд энэ нь манай улсыг тийм өндөр эрсдэлтэй ангилалд оруулж байгаа гэж би харж байгаа. Тухайлбал, байгалийн баялагтаа суурилсан Чилийн гадаад өр гээд тэгэхэд 70-аас 80 хувьтай, Казакстан 60-аас 70 хувьтай байгаа.

Харин санхүүгийн хариуцлага муутай, санхүүгийн хямралд орж ирсэн өндөр өртэй улсын оронд Шри Ланкад жишээлбэл энэ 110-аас 120 хувь байгаа. Бид нар бол 150 орчим хувьтай байгаад байна. Тэгээд энэ байдлаасаа энэ гадаад өрийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь дорвитой бууруулах ямар алхмууд хийж байгаа вэ? Энэ нь олон улсын энэ санхүүжилтийн эрсдэлийг бууруулж байна уу? Нэр хүндэд нөлөөлж байна уу? Энэ цаашдаа ийм эрсдэлтэй ангиллаасаа бид нар буух уу гэдэг нэг ийм 3 дахь асуулт байна.

4 дэх асуулт, бид нар бол нэгдсэн төсөвтэй улс л даа. Тэгээд одоо энэ төсвийн гадуур дахиад нэг шинэ хууль гараад ирэхлээр 2 тайлантай болох юм

байна л даа. Тэгээд энэ нь бол бодит байдал дээрээ ингээд нэгдсэн төсөв задраад хэлбэр төдий болох юм биш үү? Энэ эрсдэлийг юу гэж харж байгаа вэ гэж байна.

5 дугаарт ер нь ер бол энэ Төсвийн тогтвортой байдлын хууль бол манай ингээд зардлыг хязгаарлаад урт хугацаандаа ингэж хөгжинө гэдгийг ингээд хязгаарлаад байж байгаа. Гэтэл энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг бид нар 2010 оноос.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж 1 минутаар тодруулъя.

**Б.Түвшин:** Тэгэхлээр энэ гадаад өрөө тогтвортой байдлын тухай хуулийг ингээд 10 оноос хойш 21 удаа өөрчлөлт оруулаад үүний үр дүнд бол бид нар ерөөсөө эдийн засгийн хувьд сайжрахгүй байгаад байгаа юм. Тэтгэвэртэй хүмүүс гарах насыг нь хойшлуулсан, тэтгэврээ нэмж чадаагүй, төгрөгийн инфляц, ханш өссөн, иргэдийн худалдан авах чадвар буурч, ядуурал буурсан. Тэгээд иймэрхүү байдал өсөөд байхад л бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа өөрчлөөд буцаагаад зардлаа нэмье гээд байгаа юм. Урсгал зардал чинь байна шүү дээ 7 их наяд байсан 2017 онд, 2020 онд 10 их наяд, 22 онд 14 их наяд, 23 онд 17 их наяд, 24 оноос 22, 23, 24 гээд жил болгон өсөж байгаа. Цалингаа шийдэж чадаагүй, эрүүл мэндийн салбарынхан маань гомдолтой. Боловсролын асуудлынхаа цалинг шийдээгүй, инфляц өсөөд байгаа. Үр ашиггүй зардал өөрөө ингээд бид нарыг улам ядууруулаад байгаа юм биш үү гэсэн нэг ийм асуулт байна. 6 дугаарт, тэр хяналт.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Сангийн сайд Загджавын Мэндсайхан хариулна.

**З.Мэндсайхан:** Түвшин гишүүний асуултад хариулъя. Энэ хуулиар бол ерөнхийдөө бол Төсвийн тогтвортой байдлын хуулийг огт хөндөөгүй, Төсвийн хууль, Өрийн удирдлагын хуулиудыг хөндөөгүй. Энэ бие даасан хууль явж байгаа. Гэхдээ энэ бусад хууль тогтоомжуудын адил үйлчилнэ. Ер нь гол нь бол бид нар Төсвийн тухай хуулиар тогтоосон дүрэм, Тогтвортой байдлын хуулиар тогтоосон дүрэм хязгаарт багтаад эдгээр төрийн нөгөө төслийнхөө шаардлагатай санхүүжилтийг нь гаргаж чадахгүй байгаа.

Тэгэхээр төсвийн ерөөсөө л нийт зардалд нэмж тооцох л зохицуулалтыг хийж өгч байна гэж ойлгох хэрэгтэй. Зүгээр өнөөдрийн байдлаар өрийн удирдлага бол хэр явж байна гэж бид нар бол өрийн удирдлагын менежмент хангалттай сайн явж байгаа гэж хэлж болно. Яагаад гэхээр бид нар ДНБ-ий 60 хүртэлх хувь хүртэл гадаад зээллэгийн өрийн удирдлагын хуулиараа зээл авах боломжтой. Өнөөдрийн байдлаар 40 аравны тэрбум буюу 39, 8 орчим хувьтай явж байгаа. Олон улсын валютын сангийн өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр өрийн дарамтыг хэмждэг уг үнэлгээгээр бол манай улс 2022 онд дунд хугацаанд өндөр эрсдэлтэй гэж байсан бол өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг бол баримтлан ажилласнаар 2025 оноос хэвийн эрсдэлтэй гэж үзэж байгаа. Энэ дээр нэмээд Тулгаа дарга хариулчих.

**Б.Пүрэвдорж:** Индрийн 4 дүгээр микрофон.

**С.Тулга:** Сангийн яамны санхүүгийн бодлогын газар Тулгаа. Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Улсын нийт өр 40 тэрбум доллар байгаа. Энийг

ДНБ-тэй харьцуулах юм бол 159.5 хувьтай. Үүнээс Засгийн газрын өр нь болохлоор 8.7 тэрбум буюу 21.6 хувийг нь эзэлж байгаа. Засгийн газрын өрийн хэмжээ бол ерөнхийдөө олон улсад энийг ДНБ-д эзлэх хэмжээгээр нь бол ерөнхийдөө өрийн ачааллыг тооцдог. 16 онд бол энэ номинал дүнгээрээ 93.1 хувь байсан. 22 онд 60 хувь байсан. Одоо бол ингээд 39.5 хувь дээр ирээд ерөнхийдөө бол олон улсын байгууллагуудын үнэлж байгаа бол манай улсын Засгийн газрын өр бол ингээд тогтворжчихсон байгаа.

Үүнтэй холбогдуулаад 24, 25 хувь гээд сүүлийн 2 жил дээр манай улсын зээлжих зэрэглэл дараалж ингэж нэмэгдсэн ийм байгаа.

Нийт өрийн хувьд бол энэ дээр мэдээж энэ дотор Засгийн газрын өр дээр нэмэх нь Төв банкны өр, арилжааны банкны өр, тэгээд хувийн хэвшлүүдийн өр байгаа. Засгийн газрын үүрэг энэ дээр ямар байх вэ гэхлээр Засгийн газрын өрөө яг энэ зохистой.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Түвшин гишүүн нэмж тодруулъя.

**Б.Түвшин:** Ер нь бол улсын нийт өр дотоодын нийт түүнд гэсэн харьцаагаар бас энэ улсын эрсдэлийг үнэлдэг ийм тогтолцоо бол байгаа. Энэ дээр бол бид нар Шри ланкаас илүү эрсдэлтэй байдалд орчихсон байгаа гэдгийг бол бас хэлэх нь зүйтэй байх.

Ер нь энэ том төсөл, мега төсөл явах юм уу үгүй юү гэдгийн цаана бид нар энийг эрсдэлийг нь даах юм уу үгүй юү гэдэг асуудлыг л ярих хэрэгтэй. Төсөл хугацаандаа ашиглалтад орно гэсэн баталгаа байхгүй, төслийн өртөг нэмэгдэхгүй гэсэн баталгаа байхгүй, өгөөж нь төлөвлөсөн хэмжээндээ хүрнэ гэсэн баталгаа байхгүй. Өнгөрсөн жилүүдэд хийсэн бүх төслүүд нь өртөг нь өсөөд, хугацаандаа ашиглалтад ордоггүй. Тэгээд энэ өрийг буцаагаад бид нар эрсдэлээ даахгүй болчих юм бол улс орон маань өөрөө эрсдэлд ороод татвар төлөгчдийн нуруун дээр маш том ачаа ирчих болчихоод байгаа юм. Түүнээс биш энэ төслүүдийг явуулахгүй гэсэн юм огт байхгүй.

Төслүүдээ явуулахын тулд урсгал зардлаа хасаад тэр орон зайн дээрээ төслүүдээ явуулахад бид нар эрсдэлгүй ээ боломжтой харьцаатай байна гэж байгаа. Зардлаа нэмэгдүү.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж хариулъя 4 номер.

**С.Тулга:** Нэмэлтээр мэдээлэл өгье. Тэгээд Засгийн газрын хувьд бол өрийг зохистой түвшинд барьж явах ёстой. Үүгээрээ яадаг вэ гэхлээр хувийн хэвшилтэй олон улсын санхүүгийн байгууллагаас хямдралтай арай өртөг багатай эх үүсвэр татах энэ боломжийг олгож өгнө. Хувийн хэвшил маань өөрөө ингээд эдийн засгаа аваад явах ийм тогтолцоотой байдаг.

Шри ланкын хувьд бол Шри ланк яагаад өрийн дарамтад орсон бэ гэхлээр татвараа хэт бууруулсан. Хэт бууруулангуут төсвийн орлого нь бага буурсан. Үүнтэй холбогдуулаад 21 онд КОВИД-ын шок орж ирсэн. КОВИД-ын шокоо эдийн засаг нь даагаагүйн улмаас буцаагаад татваруудаа нэмсэн. Татварын орлого нь

бол тасалдсан учраас ингээд зээл авахаас өөр аргагүй болсон ийм л туршлага байгаа.

**Б.Пүрэвдорж:** Шри ланк дээр нэг тодруулаад хэлчих. Түвшин гишүүн.

**Б.Түвшин:** Шри ланка дээр чинь бас нэг хамгийн гол яригддаг асуудал байна шүү дээ. Хамгийн том мега төсөл буюу тэр боомтоо Хятадын зээлээр авчхаад боомтынх нь эдийн засгийн үр өгөөж нь хүрэхгүй учраас боомтоо Хятадад 100 жилээр алдчихсан шүү дээ. Гадаадын хөрөнгө оруулалтаар татна гэдэг нэрийн дор гадаадын зээлийг аваад тэр төсөл нь үр ашиггүй болчих юм бол тэр төсөл чинь улс орныг эдийн засгийн хямралд оруулдаг, дээрээс нь улс орных нь эрсдэл болдог гэдгийг бол бас энд хэлэх хэрэгтэй байгаад байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулж байгаа зардлаа нэмдэг байсан бол одоо шинээр хууль санаачилдаг ийм аргатай болсон хэдүүлээ. Тэгээд энэний цаад талд нь мега төслүүдээ явуулна гээд байгаа боловч мега төслүүдийнхээ эрсдэлийг бид нар ерөөсөө огт тооцохгүй. Энэ нь эрсдэлийн тухай л яриад байгаа болохоос биш тэр мега төслүүдийн асуудал бол манай Монгол Улсад хэн нь ч гэсэн явуулъя гэж байгаа юм. Энэ хуулийн эрсдэл нь тэр 2 төсөл чинь жоохон гацахад л Монгол Улсын өр, санхүүгийн асуудал хүндэрнэ ээ гэдгийг бол ойлгож байгаа. Тэр эрсдэлийн тухай яриад байгаа гэдгийг та бүхэн бас ойлгоно байх гэж найд.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Сархадын Зулпхар гишүүн асуулт асууна.

**С.Зулпхар:** Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүдийн оройн амгаланг айлтгая. Гадаадаас зээл авчихдаг төсөл хэрэгжүүлнэ гээд. Тэгээд тэр зээлээ ашиглаж чаддаггүй ийм хачин чигтэй үзэгдэл бол ерөөсөө байж болохгүй ээ. Бид нэгэнтээ хөгжинө гээд томоохон зорилт тавьчихсан эдийн засгийн үр өгөөж, үр нөлөө авчрах жишээ нь төсөл хэрэгжүүлнэ гэхчигсэн бол тэрийг хугацаанд нь хэрэгжүүлээд үр дүнг нь үзэх ёстой. Энийг аль ч улс төрийн нам бол хариуцлагатай мэдэж байх ёстой. Манай нам бол социал демократ нам, ардчилсан нам бол либерал үзэл баримтлалтай нам. Бид эдийн засгаа хөгжүүлж байж үр дүнг нь үзнэ ээ гэж.

Тэрнээс гадна энэ хуулийн хүрээн дэх 2 төсөл бол өөрөө эрчим хүчний хараат бус байдал, бие даасан байдлыг хангахад чиглэсэн төсөл. Тэгэхлээр би 7 үндэслэл хэлэх гээд байна. Энэ хуулийг бид хамтдаа дэмжих ёстой гэж.

1 дүгээрт, энэ төсөл төслийг бид хэрэгжүүлснээр хугацаанд нь эрчим хүчний үнийн савлагаа, нийлүүлэлтийн эрсдэлийг багасгана. Та бүхэн харж байгаа шүү дээ энэ эрчим хүчний чинь үнэ савлах юм бол ямар байдал үүсдэгийг, нийлүүлэлт эрсдэлд орох юм бол ямар байдал үүсдэгийг энэ өнгөрсөн 2 сарын хугацааны олон улсын нөхцөл байдал бидэнд мөн гэрчлээд өглөө. Тэгэхээр 1 дүгээр үндэслэл нь энэ.

2 дугаар үндэслэл нь валют гадагшлах урсгалыг бид бууруулах зорилготой л энэ төслүүдийг хэрэгжүүлж байгаа шүү дээ. Тухайлбал, бид шатах, тослох материалд жилдээ 2 тэрбум ам.долларыг гадагш нь гаргаж байна. Цаашдаа бүүр нэмэгдэнэ. Гэхдээ энийг аль болох багасгах зорилготой.

Нөгөөтээгүүр бид гаднаас авч байгаа бас эрчим хүч байна. Манай баруун 3 аймгийн эрчим хүчний, цахилгааны эрчим хүчний хэрэглээний 80 хувь нь бол Оросын Холбооны Улсаас. Тэгэхээр бид Оросын Холбооны Улсад мөн төдий хэмжээний валют төлөөд сууж байгаа. Тэгэхээр энийг бид бол гадагшлуулахгүй байх зорилготой төсөл шүү гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа. Эрдэнэбүрэн усан цахилгаан станц.

3 дугаар асуудал, яг саяын импортыг орлох бид үйлдвэрлэл хийх юм бол эргээд энэ чинь төлбөрийнхөө тэнцлийг эергээр нь сайжруулдаг шүү дээ. Энийг та бүхэн мэдэж байгаа. Макро эдийн засгийн түвшинд бол хамгийн чухал бодлогуудын нэг. Тэгэхээр энэ талаас нь энэ асуудалд та бүхэн бас ойлгож санаж байгаа байх гэж бодож байна.

Нөгөөтээгүүр эрчим хүчний үнэ инфляцад нөлөөлдөг. Өнөөдөр бол дэлхийн улс орнууд энэ нефтийн жишээ нь хэрэглээтэй холбоотойгоор бол үндсэндээ бол айхтар эрсдэлд орчихсон, инфляц нь өсчихсөн ийм байдалтай байж байгаа. Бидэнд ч гэсэн энэ эрсдэл бол байгаа. Тэгэхлээр энийг давах үүднээс бид энийг чухалчилж байна.

5 дахь асуудал, үйлдвэрлэлээ хөгжүүлбэ, бизнесийг тогтвортой орчин бүрдүүлбэ гэж байгаа бол хүссэн ч, эс хүссэн ч эрчим хүчнийхээ бид бие даасан байдлыг хэрэглээг бүрэн хангасан энэ төслүүдийг дэмжих ёстой.

Тэгэхээр энэнтэй холбоотойгоор бол энэ төсөл өөрөө хүссэн, хүсээгүй бидний бол бодит стратеги шүү гэдгийг аль аль нь бол ойлгож байгаа байх гэж бодож байна.

6 дахь асуудал, үндэсний аюулгүй байдлын хувьд бол эрчим хүч бол хямралт нөхцөл байдлыг даван туулахад бидний хамгийн чухал хэрэглэгдэхүүн. Хямралт нөхцөл байдал. Ер нь дэлхийн улс орнуудад ойр ойрхон хямардаг болох юм шиг байна. Улс төрийн хямралууд гарах юм шиг байна. Хуучин бол 10 жилийн мөчлөгтэй байсан гэсэн чинь тийм биш болсон юм шиг байна л даа. Тэгэхлээр энийг даван туулахын тулд эдгээр төслүүд бидний энэ хямралт нөхцөл байдалд аюулгүй байдлаа хангах гол хөшүүрэг шүү гэж байгаа юм.

7 дахь асуудал, нийгмийн хөгжлийн бас маш чухал суурь нь бол эрчим хүч. Сургууль жишээ нь эмнэлгүүд байна. Бид харилцаа одоо гэж байгаа юм. Интернет, цахим харилцаа. Ундны усны найдвартай хэрэглээг бид эрчим хүчгүйгээр хангаж чадахгүй. Энэ үүднээс нь аваад үзэх юм бол энэ өөрөө их чухал гэдгийг та бүхэн мэдэж байгаа байх. Бидэнд гарааны түвшин ижилхэн байсан улсууд. Би Төв Азийн улсуудыг хэлж байгаа юм. Яг бидэнтэй ижилхэн байсан. Гаднын зээлээ аваад хэрэглээд томоохон бүтээн байгуулалт хийчихсэн. Өнөөдөр нэг улс чинь 300 тэрбум ам.долларын ДНБ-тэй болчихоод байж байна. Нөгөө улс нь 150 тэрбум ам.долларын ДНБ-тэй болчихоод байж байна. Бид 20 гаран тэрбум ам.доллартой л байж байна. Иргэд биднээс юу шаардаж байна.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** 1 минутаа нэмж тодруулъя.

**С.Зулпхар:** Иргэд биднээс юу шаардаж байна гэхээр зэрэг бид хөгжмөөр байна, хөгжсөн улсад амьдармаар байна л гэж байна. Тэгэхлээр энэ хөгжих эрхийг нь хангасан шийдвэрийг гаргах үүрэг нь бидэнд байгаа шүү Их Хурлын гишүүд ээ. Улс төрийн намын жишээ нь эрхэм төлөөллүүд ээ. Тийм учраас бид хамтдаа энэ бодлогын чухал шийдвэр, бүтээн байгуулалтын томоохон шийдвэр, стратегийн маш чухал шийдвэрийг хамтдаа жишээ нь нарийн хэлэлцэж байж. Гэхдээ дэмжих талд нь гаргах ёстой.

Нөгөөтээгүүр сая Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай холбоот бод бас зүйлийг бид ярьж байна. Бид нөхцөл байдлаа тохируулсан байдлаар хуулиа өөрчлөх эрх нь бидэнд байж байгаа. Төсвийн тогтвортой байдлын хуулийг гарцаа байхгүй өөрчлөх ёстой гэж үзэж байгаа бол сая Ариунзаяа гишүүн би санаачилъя гэж байна шүү дээ. Би бол дэмжээд энд бол санаачлаад явах бас ийм саналтай байна. Ийм учраас та бүхнийг энэхүү хуулийг дэмжиж, тэгээд хэлэлцэх эсэх асуудлыг дэмжиж өгөөч ээ гэсэн ийм та бүхэнд уриалга хүргэж байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ерөнхийдөө үг хэллээ тийм ээ. Энхтайваны Бат-Амгалан гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

**Б.Батбаатар:** Энэ бол яах вэ бид нар Монгол улсын Засгийн газар гадаад зээлийнхээ эрхээ нээчхээд тэрийгээ хэрэглэж байхгүй, хэрэглэж чадахгүй байгаатай л холбоотой асуудал гэж ойлгоод байгаа. Тэгээд аль хэдийн соёрхон баталчихсан тэгээд зардал гарч байдаг. Тэгэхээр энэ төслүүдийн нийт ашиглагдаагүй үлдэгдэл нь 13.8 их наяд төгрөг гээд, үүнээсээ 38 хувь 5.3 их наядын газрын тос болон Эрдэнэбүрэний усан цахилгаан станцын санхүүжилт гэсэн байна.

Тэгэхээр энэ 5.8 их наяд төгрөгийн энэ саналын 22 хувь болж байна гээд ингэхээр чинь 10 жилээр сунжрах эрсдэлийг хэн хариуцах вэ гэж. Жишээ нь 26 оны түвшинд жилд дунджаар 1.2 их наяд төгрөгөөр явбал энэ зөвхөн энэ 2 төслийг ашиглалтад оруулахад 10 гаруй жилийн хугацаа шаардагдах эрсдэлтэй гэж байна. Засгийн газар энэ хуулиа батлуулаагүй нөхцөлд үүнээс үүдэх нэмэлт өртөг, ханшийн эрсдэл, зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлтийг төгрөгөөр тооцсон уу? Улсын Их Хуралд энийгээ ил тавих уу?

Хоёрт нь энэ бол төсвийн сахилга батыг сулруулах уу, эсвэл төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх үү гэж? Гадаад зээлийнхээ ашиглалтын зардлаар нэмэгдэж болохоор тэр хуулийнхаа 2.1-д заачихсан байгаад байгаа. Тэгээд энэ чинь өөрөө шинэ төсөл нэмэхийг хориглосон заалт байгаа ч гэсэн гүйцэтгэлийн тайлан, энэ хөндлөнгийн аудитын шаардлага энэ асуудлуудаараа ямар байх юм бэ гэдгийг асууж байна.

Зөвхөн 2 төсөл л гэж. Тэгэхээр энэ 2 төсөл, шинэ төсөл нэмэхийг хориглохоор тусгаад оруулаад ирсэн. Гэхдээ энэ чинь нөгөө улс төрийн практиктай бид нар 1 удаагийн тусгай зохицуулалт нь дараа нь олон төслийн жишиг болоод явчихдаг. Өмнө нь ч гэсэн бас тэгж байсан асуудал. Тэгэхээр энэ төсвийн хязгаараас гадуур гаргахгүй байх тэр институцийн хамгаалалт нь яаж хийгдэж байгаа вэ? Шинэ төсөл нэмэгдэхгүйг нэмж тусахгүй гэсэн хориггоо зөрчсөн тохиолдолд ямар эрх зүйн үр дагавар үүсэх юм?

Газрын тосны үйлдвэр ашиглалтад орохгүй байх бодит өртөг нь хэд байх юм? Нийтдээ бид нар чинь 21-ээс 25 онд 6.2 тэрбум доллар гадагш нь зарцуулсан. 24 онд 2.5 сая тонн бүтээгдэхүүн импортлоод 1.9 бараг 2 тэрбум доллар зарцуулчихсан. Үйлдвэр ажиллах юм бол 1 тэрбум долларын борлуулалтын орлого олох боломжтой гэдэг чинь гадагш нь 1 тэрбум доллар явуулахгүй ээ л гэсэн. Хэрвээ энэ үйлдвэр чинь ашиглалтад орохгүй 1 жил болгоноор хойшлоод байвал бид нар энэ гадагшаа алдах валютынхаа урсгалыг яаж тооцсон юм? Төлбөрийнхөө тэнцэл болгон дээр тооцсон юм уу гэдэг асуудал.

Эрдэнэбүрэний усан цахилгаан станц чинь ганцхан эрчим хүчний төсөл биш. Бас баруун бүсийн тэр улс төр, эдийн засгийн тэнцвэрийн асуудлыг илэрхийлнэ ээ гэж би хувьдаа ойлгоод байгаа юм. Тэр тэнцвэрийнхээ асуудлыг бид нар яаж боломжоо, эрчим хүчнийхээ бүсийн хөгжлийнхөө тэнцвэрийг яаж хангаж байна вэ гэдэг дээрээ анхаарч бодсон зүйл байгаа юу? Улсын төсөвтөө бас дарамтгүй ээ гээд ингээд дүгнэчихсэн байгаа. Тэгэхээр энэ үнэхээр ашиглалтыг нэмэгдүүлэх нь тийм улсын төсөвт дарамтгүй гэж байгаа юм бол тэр өрийн үйлчилгээ, ханшийн эрсдэл, ирээдүйн төсвийн төлбөрийн хуваарь дээрээ яаж тооцоогоо хийгээд улсын төсөвт дарамтгүй ээ гэж ингэж дүгнэлт хийж оруулж ирж байгаа юм бэ? Ил тод байдлын хувьд бол харьцангуй тийм ерөнхийгөөр тавьчихсан байх. Ил тод байдлыгаа бид нар энэ гүйцэтгэл Улсын Их Хурал дээр ер нь ил тод бус байснаас болж өмнөх орж ирсэн хуулийн төсөл нь унасан шүү дээ. Хяналтгүй байна, хулгай явж байна, илүү дутуу хардлага байна.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Сангийн сайд Мэндсайхан хариулъя.

**З.Мэндсайхан:** Батбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нарын ашиглаагүй байгаа нийт авсан зээлийн ашиглаагүй байгаа дүн чинь 13.8 их наяд байгаа. Энэнээсээ 5.2 нь зөвхөн энэ 2 төсөл байгаа. Энэ 2 төслийг бид нар хугацаанд нь оруулах таны яриад байгаа нөгөө төсөвт өртөгт нэмэгдэх эрсдэл оруулахгүйн тулд хугацаанд нь буюу төлөвлөсөн санхүүжилтийг нь цаг тухайд нь өгөхийн тулд энэ хуулийн зохицуулалтыг хийж өгч байгаа юм.

Ил тод байдлыг бид нар Засгийн газрын хуулийн хэрэгжилтийн талаарх тайлан, энэ төслийнхөө хэрэгжилтийн талаарх тайланг Улсын Их Хуралд төсвийн гүйцэтгэлийн хамт хүргүүлж байя. Мөн төслийн хэрэгжилт, санхүүжилт, гадаад зээлийн ашиглалттай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу олон нийтэд нээлттэй мэдээлнэ ээ гээд ингээд энэ хуулийн төсөл дээрээ оруулаад өгчихсөн байгаа.

Энэ 2 төсөл маань хэрвээ энэ хууль батлагдахгүй бол 26-аас 31 онд зөвхөн хөрөнгө баталгаажуулсны төлбөрт бид нар 200, 2 орчим тэрбум төгрөгийг төлнө гэсэн ийм тооцоо гарч байгаа юм. Ашиглаж чадахгүй хүү, зээлийнхээ хүүгээр. Төсөвт бол тэртээ тэргүй энэ дарамт ирэхгүй зардал нь төсвийн хязгаараас гарлаа. Үлдэж байгаа тэр энэ жилийн батлагдсан гадаад зээл ашиглалтын 1.2-оос чинь үлдэж байгаа бид нар 72 зээл төслөө цааш нь санхүүжүүлээд л явчихна.

Хуулийн төсөл дээр нэмж хариулах зүйл энэ ажлын хэсэг дээрээс нэмээд хариулаад өгчих.

**С.Бямбацогт:** 18 цаг 18 минут болж байна. Тэгээд чуулганы хуралдаан Дэгийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу хуралдааны асуудал хэлэлцэж дуусаагүй бол цаг сунгана гэсэн байгаа. Өнөөдөртөө дуусгачих нь дээр байх тийм үү тэгээд маргааш бас маш олон асуудал байгаа Татварын олон хуулиуд. За тэлье тэгвэл цагаа сунгачихъя. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаа дуустал цагаа сунгалаа.

Одоо Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Батбаатар гишүүн тодруулах юм уу? Ажлын хэсгээс 4 дүгээр микрофон Сангийн яам.

**Ж.Дэлгэржаргал:** Батбаатар гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Хуулийн төслийн хувьд бол яг үндсэн яг гол зохицуулалт бол яг Улсын Их Хурал соёрхон баталсан олон улсын гэрээтэй төслүүдийг зөвхөн гүйцэтгэлээр нь бүрэн санхүүжүүлэх боломжийг олгож байгаа. Бусад бүртгэл, өрийн бүртгэлдээ бүртгэх, нягтлан бодох бүртгэл, тухайн жилд бид нар Төсвийн тухай хуулийн цаглаварт зааснаар бол 6 сард гүйцэтгэлийн тайлангаа өргөн барьдаг. Энэ дээр бас яг энэ хуй хуулиар хэрхэн гүйцэтгэл гарсан, ямар зардлууд гарсан тайланг бол төсвийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт өргөн барихаар хуульчилсан байгаа.

Нөгөө талдаа гадаад зээлийн санхүүжилт бол өөрөө эх үүсвэртэй зардал учраас буюу төсвийн орлогоо бид нар энэ төслүүдийг санхүүжүүлдэггүй учраас төсөв дээр бол дарамт үүсэхгүй. Бид нар бий болгочихсон байгаа эх үүсвэрүүдээ л яг ашиглах тухай асуудал байгаа. Нэмж мэдээлэл өгөхөд.

**С.Бямбацогт:** Батбаатар гишүүн тодруулъя.

**Б.Батбаатар:** Ганц нэг асуулт үлдчихлээ. Дараа нь яаралтай бичгээр өгчихвөл бас сайн байх гэж ингэж үзэж байна. Дээрээс нь энэ бид нар чинь зээл, санхүүжилт ингээд хэрэглэхээр гэрээ хийчхээд байдаг. Монгол Улс өөрөө 24 онд дундаас дээгүүр орлоготой улс орны тоонд шилжээд орчихсон. Тэгэхээр нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй эх үүсвэр хумигдаж эхэлж байна гэдэг асуудал үүсэж байгаа. Хэрвээ энэ эх үүсвэрээ ашиглахгүй байгаад байвал энэ зүйл дээр нөлөөлөл нь яаж гардаг юм бэ? Энэ талаараа бас Засгийн газар Улсын Их Хуралд нэлээн тооцоог нь гаргаж өгөхгүй бол өмнөх хуулийн төслөө хэлэлцэхгүй унасан тухай асуудлыг дөнгөж сая би хөндөөд орхисон.

Гэхдээ бид нар ингээд энэ хуулийг дэмжиж байгаа агуулгаар асуулт асууж байгаагаасаа гадна хяналттай байх тухай асуудлууд их чухал. Зүгээр дэмжинэ гэдэг чинь Засгийн газарт нэг ийм хоосон чек дурын тоогоо бичээрэй гээд өгч байгаа хэрэг биш шүү дээ. Та бүхэн тэр хяналтын нөхцөлтэйгөөр дэмжих ёстойгэдэг зүйлүүдээ.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Үг хэлчихлээ. Мэндсайхан сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Батбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл хумигдаж байна, эх үүсвэр хумигдаж байна гэж байна. Цаашдаа бид нар шинээр авах зээлүүд маань тэгээд л энэ арилжааны зээлийнхээ юугаар л явчихна манайд тавигдаж байгаа арилжааны хүүгийн ямар нөхцөлөөр тавигдах нь вэ нэгэнт нэгэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл

маань дундаас дээш орлоготой орон болсон учраас манайд энэ нөхцөл олдох нөхцөл байдал нь хумигдана гэдэгтэй бол санал нэг байгаа.

Тэгэхээр бид нар цаашдаа Хөгжлийн банк болон Хөгжлийн банкныхаа хууль эрх зүйн орчныг сайжруулаад, засаглалыг сайжруулах зарчмаар төсөв дарамт өгөхгүйгээр Хөгжлийн банкаараа явуулах тэр эрх зүйн боломжийг бүрдүүлэх чиглэлд нь бид нар техник туслалцаа аваад ажиллаж байгаа.

**С.Бямбацогт:** Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Алга байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуултаа асууя. Алга байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултаа асууя. Байна. Санал хураалтуудыг, өнөөдрийн санал хураалтуудыг маргааш өглөө “Баасан” гаргийн 10 цагаас нэгдсэн журмаар явуулъя. Санал хураалтуудыг хойшлуулж байна. Бусад асуудлуудаа өнөөдөртэй хэлэлцээд явъя. Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** Энэ гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай гээд энэ хууль бол 2 дахь удаагаа ингээд орж ирж байна. Өнгөрсөн жил бол нэр бүхий хэсэг гишүүдийн асуудлыг өргөн барина гэж байгаад ингээд тухайн үедээ бол бас асуудал нь ингээд гацсан. Би тухайн үед бас зарчмынхаа байр суурийг хэлж байсан. Энэ асуудлыг бол зарчмын хувьд дэмжихгүй ээ. Монгол Улсын төсвийг олон төсөвтэй болгох ийм буруу шийдлийг дэмжиж бол чадахгүй ээ гэдэг асуудлыг бол би хэлж байсан. Миний байр суурь ч гэсэн одоог хүртэл бол би бас хэвээрээ байгаа.

Яагаад гэвэл буруу зүйлийг бурууг нь буруу, зөв зүйлийг зөвийг нь дэмжээд явахаас өөр арга байхгүй. Энэ бол олон улсынхаа нягтлан бодох бүртгэл талаасаа ч гэсэн өөрөө бол буруу асуудал.

Гэхдээ би нэг талдаа авууштай зүйл нь бол хуучин бол сая өнгөрсөн жил гаруй хугацаанд 2 удаа бол үндсэндээ ингээд Сангийн яам Улсын Их Хурлын гишүүдээр энэ хуулийг зүтгүүлээд ингээд бүтэлгүйтээд бол эцсийн дүндээ өөрсдөө ингээд өргөн барьж орж ирж байгаа нь бол бас сайн асуудал гэж харж байгаа.

Би тэгэхээр нэгэнтээ энэ асуудлыг өөрсдөө санаачилж оруулж ирсэн бол энийгээ зөв болгох гарц гарах, гаргалгаа, шийдлийг нь бол ойрын хугацаанаас бол би хийгээрэй гэдэг саналыг хэлж байгаа шүү. Энэ бол ажил хэрэгч санал шийдэл шүү. Би энэ хуулийг сая Засгийн газар дөнгөж 7 хоногийн өмнө өргөн барихаас нь өмнө Монгол Улсын Ерөнхий сайд Учрал Ерөнхий сайдад, мөн Хэрэг эрхлэх газрын дарга Энхбаяр сайдад энэ асуудлыг зөв болгох 4 шийдлийг бол хэлсэн байгаа. Тэгэхээр Сангийн яам энийг мэдэхгүй биш би мэдэхийн сайнаар бол мэдэж байгаа байх гэж бол би бас харж байгаа юм.

1 дүгээрт бол би 4 санал зөв болгож оруулж ирэх нь юу юм бэ гэхээр энэ бол 1 дүгээрт өөрөө олон улсын байгууллагаас ч тэр олон улсынхаа нягтлан бодох бүртгэл талаасаа ч тэр энэ ерөөсөө төсвийнхөө зардлуудыг аккруэл суурь руу шилжүүлээч ээ, энийгээ юу гэдэг юм тодорхой магадгүй юу гэдэг юм барилга бүтээн байгуулалт нь ашиглалтад ороод үндсэн хөрөнгө болсных нь дараа энийгээ юу гэдэг юм үндсэн хөрөнгөөр бичигдээд цааш нь аваад явдаг энэ зохицуулалт руу шилжээч ээ гэдэг би саналыг бол 1 дүгээрт хэлсэн.

Хэрэв магадгүй тодорхой хугацаа шаардагдах гээд байгаа бол 2 дахь хувилбар нь бол төсвийн хөрөнгө оруулалтууд дотроосоо зөвхөн энэ гадаад зээлийнхээ хөрөнгө оруулалтыг аккруэл суурь руу шилжүүлчхээч. Энэ бол тоотой хэдхэн цөөхөн хөрөнгө оруулалт учраас энийг бол 7 хонохгүй юун дотор бол бүртгэлээрээ шилжүүлж байгаа. Тэгэхээр хууль өргөн барихгүйгээр энийг зөвхөн нягтлан бодох бүртгэлийнхээ системийг аккруэл суурь руу, аккруэл бэйс буюу суурь руу шилжүүлснээрээ бид нар бол энийг цэвэр бүрэн дүүрэн шилжих шийдэл байна гэдэг шийдлийг бол хэлсэн байгаа шүү. Энэ бол зөвхөн юу гэдэг юм бид нарын ч хэлээд байгаа асуудал биш энэ хувийн хэвшлийн компани байна уу, төрийн төсөв байна уу олон улсынхаа бүртгэлийн стандартаараа бүртгэлээ, зардлаа, хөрөнгөө зөв болгох шийдэл нь угаасаа энэ байгаад байгаа юм.

3 дахь шийдлийг нь би бас хэлсэн. Энэ угаасаа анх удаагаа бид нарт бас ийм асуудал орж ирсэн зүйл биш юм. Гадаадын зээл, тусламж ингэж дээд хязгаараа давсан зүйл биш юм. Хөрөнгө оруулалтууд юу гэдэг юм төсөвтөө багтахгүй болж ирсэн зүйл биш юм байгаа. Энэ сүүлийн 15 жилийн хугацаанд өмнөх үе үеийн Сангийн сайд нар, үе үеийн Засгийн газар, Улсын Их Хурал шийдэж ирсэн жишиг нь Тогтвортой байдлын тухай хуулийн тэр хэтрээд байгаа төсвийн алдагдал зээл хэтэрч, юу гэдэг юм тэр дүрэм зөрчигдөөд байгаа тэр заалтыгаа тодорхойгүй 1-2 жил, 3 жилээр бид нар энийгээ биелүүлж чадахгүй байна гэж тэр зөвхөн тэр заалтыг хойшлуулах, үйлчлэлийг нь ухраах хуулийг хийдэг байсан юм. Энэ бол өөрөө юу вэ гэхээр төсөв дотроо бүх зардал бүртгэлүүд нь байна. Ганцхан төсвийн тогтвортой байдлын тэр давж байгаа хэрэгжүүлж чадахгүй байгаа заалтынхаа хэрэгжүүлэх хугацааг нь 1, 2 жилээр ухраадаг байсан юм. Энэ бол угаасаа үе үед сая 2020 он хүртэл бол явж ирсэн жишиг байгаад байгаа юм.

Тэгэхээр үүгээрээ явах гарц гаргалгаа шийдэл бол 3 дахь нь байсан. Мэдээж юу гэдэг юм 4 дэх гаргалгаа нь бол ингээд яг хуучин өмнө гишүүдийн өргөн барьж байснаараа энэ хуулиа Засгийн газар өргөн барих асуудал байгаа. Тэгэхээр би бол хамгийн энэ 4 хувилбар дотроос хамгийн муу хувилбараар нь бол явлаа. Тэгэхдээ бол бид нар энэ асуудлыг зөв болгоод шийдэх ёстой. Зарчмын хувьд бол би угаасаа энэ миний зарчмын байр суурь учраас бол би энийг бол дэмжиж чадахгүй. Тэгээд та бүхэн маань энийг даруйхан ойрын хугацаанд зөв болгоод бүртгэлээ аккруэл суурь руу шилжүүлээд.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Нэмэлт асуулт. Асуултаа гүйцээ 1 минут.

**Г.Тэмүүлэн:** Тэгэхээр бол юу гэдэг юм тодорхой юу гэдэг юм энэ буруу систем рүү ч гэдэг юм уу ингээд юу гэдэг юм бүртгэл талаасаа цаашдаа хүндрэл учруулах энэ асуудал дээр бол буруу зүйл дээр бид нар бас үнэн мөнөө хэлээд, зөв гарц, гаргалгаа, шийдлүүдээ бол хамтдаа ингээд эрэлхийлээд явах нь бол би зөв байгаа гэж бол харж байгаа шүү. Тэрнээс юу гэдэг юм ямар нэг байдлаар энэ том төслүүдийг эсэргүүцэж байгаа хэн ч байхгүй байгаад байгаа юм. Тэрнээс юу гэдэг юм Монгол Улсад Монгол Улс газрын тосны боловсруулах үйлдвэртэй болох ёстой, цахилгаан эрчим хүчнийхээ юу гэдэг юм хараат бус байдлаасаа салах ёстой гэдэг асуудлыг дэмжиж байгаа хүн болгон бол байгаа.

Гол нь зорилго нь зөв байлаа гээд явж байгаа арга зам нь бол буруу байж болохгүй. Тэгэхээр бид нар бол цаашдаа энэ арга хэрэгсэл энэ зөв хуулийнхаа

хүрээнд энийгээ зөв залруулах асуудлуудаа бол ойрын хугацаанд шийдээд явах ёстой. Тэгэхээр магадгүй 2000 ирэх оны төсөв орж ирэхэд бол энэ алдаагаа залруулаад, засаад, бүртгэлээ шилжүүлээд ингээд явах алхмуудыг бол хийгээд яваарай л гэдэг би ажил хэрэгч саналыг бол бас хэлэх байна.

**С.Бямбацогт:** Мэндсайхан сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Тэмүүлэн гишүүний саналтай санал нэг байгаа. Яагаад гэхээр одоо манай зардлын бүртгэл бол мөнгөн суурьтай явж байгаа. Цаашдаа бид нар энийг зөв, зохистой болгохын тулд элэгдлээр нь бүрх бүртгэх буюу аккруэл суурь руу оруулах дээр бол санал нэг байгаа. Гол хугацаа нь бол нөгөө сая бид нар оруулж ирэхэд Төсвийн хуулиа бүхэлд нь өөрчлөх шаардлагатай байгаа учраас энэ асуудлыг бол бид нар энэ шинэчлэлийг эхлүүлэх цаг нь болсон гэдэгтэй бол санал нэг байна.

Ер нь бол нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь гэдэг бол ерөөсөө орлого, зарлага, мөнгө нь орж ирсэн эсвэл гарсан хугацаагаар нь биш үүссэн хугацаагаар нь бүртгэдэг арга. Тэгэхээр энэ дээр бол шинэчлэл хийхдээ бол санал нэг байна. Энэ дээр бол бас тантай хамтраад энэ асуудлыг шийдэх чиглэлд нь ажиллана гэж, санаачилгатай ажиллана гэдгийг хэлэх байна.

**С.Бямбацогт:** Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

**Ц.Баатархүү:** Ер нь бидний энэ сүүлийн 30 жилийн алдаа, оноог харахад энэ хариуцлагын тогтолцоо гэж чухал зүйлийг орхигдуулаад байгаа. Үе шаттай сайжруулна, дэмжинэ, хөгжүүлнэ, нэмэгдүүлнэ гэдэг үгнүүд бол Монголын хамгийн үнэ цэнгүй үг болж байна. Тэгэхээр ерөөсөө хариуцлагын тогтолцоог яг хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Жишээ нь, энэ 2 том бүтээн байгуулалтын ажлыг дэмжихээс өөр арга байдаггүй. Оруулж ирж байгаа хууль дээр нь хариуцлагын тогтолцоо байдаггүй. Засгийн газар Улсын Их Хуралд хариуцна гэдэг ганцхан өгүүлбэртэй. Тэгэхээр тодорхой 2 нөхцөлөөр энэ хуулийг бол дэмжих шаардлага үүсэж байгаа юм.

1 дүгээрт, хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг тодорхой болгомоор байгаа юм. Энэ бол 1 удаагийн хууль. 2030 он гэхэд энэ хууль хүчин төгөлдөр үйлчлээд дуусгавар болгоно гэдэг хугацааг зааж болох уу гэдэг асуулт байгаа.

2 дугаарт нь олон улсын аудитыг оруулна, жил болгон оруулна гэдэг энэ заалтыг энэ хуульд оруулмаар байгаа юм Улсын Их Хурлын гишүүд ээ. Тэгэхгүй бол нэг ийм ерөнхий хууль, тунхгийн хууль хэдүүлээ гаргаж болохгүй байна гэдэг ийм 2 асуултыг өргөн барьж байгаа Засгийн газраас асууя аа.

Төслийн удирдах нэгжээс их тодорхой зүйлийг асуумаар байгаа юм. 2025 оноос эхлээд зээлийн хүү гүйгээд эхэлсэн гэж ойлгож байгаа. 2025 онд бол анхны ТЭЗҮ-гээрээ бол ашиглалтад орох болов уу гэсэн төсөөлөлтэй байсан. 1 тэрбум долларыг зээлээд одоо бол ингээд энэ хууль батлагдсанаар 2.4 дахин нэмэгдээд, 2.4 тэрбум доллар буюу 8.4 их наядын зээл авах гэж байна гэж ойлгож болох уу? Зээлийн хүүд нь нийт төлөхөд нь 2 их наядыг төлөх юм байна. Ингээд энэ нефть барих, боловсруулах үйлдвэр 10 их наяд орчмоор зээлээ төлөөд эдийн засгийн

эргэлтэд орох буюу ашиглалтад орох юм байна гэж ойлгож болох уу? Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

Хамгийн сүүлд нь энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн 30-аас 40 хувийг хөрөнгийн зах зээл дээр гаргах энэ бодол санаа байгаа юм уу. Яагаад энэ иргэдийн оролцоо, иргэдийн хяналт, дотоодын аж ахуйн нэгжүүдийг энэ хөрөнгийн зах зээлээр дамжуулан засаглалыг сайжруулах чиглэл дээр ингэж алхам хийхгүй байгаа юм бэ гэдгийг асууя.

Эрдэнэбүрэний усан цахилгаан станц дээр сэргээгдэх эрчим хүчний зөв зүгтэй зөв төсөл учраас энэ төслийг ногоон бондоор санхүүжүүлэх энэ боломж байгаа юм уу? Ер нь бид нар энэ зээл гэдэг дээрээ энэ холимог санхүүжилтийн тогтолцоог татах боломж байна уу гэдгийг би бас түрүүчийн чуулган дээр асууж байсан. Энэ дээрээ та бүхнээсээ бас тодорхой хариултыг авъя. Энэ зээлийн хүү дээр бид нар бас будилаад тоогоо буруу хэлсэн байж магадгүй. Яг тодорхой та нар тоо хэлэхгүй байна. Ерөнхий ийм хариултыг энэ төслийн нэгж бол олон удаа хэлж байна.

Тийм учраас хууль дээр бол би 2 заалт оруулъя гэж байгаа. Энэ хууль бол 1 удаагийн хууль үйлчлээд дуусах ёстой. Тэр хугацаа нь хэзээ байх юм. Хоёрт бол энэ олон улсын аудитыг бол жил болгон оруулъя гэдэг ийм заалтуудыг оруулъя гэсэн асуулт байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Баатархүү гишүүний асуултад хариулъя. Эрдэнэбүрэний усан цахилгаан станцын төсөл бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тэрбум долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл. Хөнгөлөлттэй нөхцөлөөр авчихсан. Энэ зээлийнхээ дотоод зарцуулалт дотор нь нэг төсөл нь бол Эрдэнэбүрэний төсөл. Тэгэхээр энэ төсөл маань одоогийн байдлаар 30 хувийн гүйцэтгэл нь олгогдоод явж байгаа эхэлчихсэн төсөл.

Тэгэхээр бид энэ төслөө харин энэ цааш нь гацаахгүйгээр дуусгах зорилгоор энэ хуулийг оруулж ирсэн байгаа. Ер нь зүгээр яах вэ мэдээллийг өгөхөд Эрдэнэбүрэний төсөл бол 253.1 сая долларын төсөл, 2 хувийн хүүтэй. Хугацаа нь 20 жил. Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нь 7 жил. Газрын тос мөн ялгаа байхгүй 7 жил, үндсэн төлбөрөөсөө чөлөөлөгдөнө. Хугацаа 20 жил 1.7 их наядын өртөгтэй. Жилийн хүү нь 1.75 шүү дээ газрын тос бол. Ингээд явна.

Энэтхэгийн зээл бол зөвхөн энэ үйлдвэр барихад зориулагдана нефтийнхэд. Эрдэнэбүрэн бол эх үүсвэр нь Хятадынхаас ийм л 2 эх үүсвэр явж байгаа. Ер нь манай явж байгаа бүх зээлүүд холимог санхүүжилттэй явж байгаа. 5 хувь хүртэлх нь Монголын Засгийн газар өөрөө гаргаж байгаа. 95 хувийг нь санхүүжүүлэгч, зээл олгогч газраас санхүүжүүлээд ингээд явж байгаа төслүүд. Тэгэхээр бид нар таны зээлийн хүү дээр Тулгаа дарга хариулчих.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг 4 дүгээр микрофон Тулга дарга хариулъя.

**С.Тулга:** Гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд бол яг одоог хүртэл нийт 12.4 сая долларын зээлийн хүү төлсөн

байгаа. Зээлийн хүүг бол бид нар гадаад зээлийн ашиглалтын дүн дээр төлдөг. Нийт төслийн хугацаанд эргэн төлөлтийн хуваариас нь аваад үзэх юм бол Газрын тос боловсруулах үйлдвэр дээр нийт 454 сая ам.долларын зээлийн хүү төлөхөөр байгаа. Эрдэнэбүрэн дээр бол нийт 89.8 сая долларын зээлийн хүү төлөхөөр байгаа. Эрдэнэбүрэн дээр бол зээлийн хүү төлөгдөж эхлээгүй гэсэн үг. Ашиглалт гараагүй байгаа учраас.

Ногоон бондын хувьд бол өрийн удирдлагын стратегиар Засгийн газар бонд гаргахаар бол зөвхөн дахин санхүүжүүлэх зорилгоор гаргана. Шинэ эх үүсвэр бол татахгүй гэсэн ийм стратеги 26, 28 оны хувьд хэрэгжиж байгаа. Тэгэхлээр бол ер нь бол ногоон бонд бид нар бол засаг дахиж гаргахгүй ээ гэсэн үг. Одоо бонд гаргах юм бол өмнөх бондоо төлөх зорилгоор л бонд гаргаж байгаа гэсэн үг.

**С.Бямбацогт:** Тодруулъя Баатархүү гишүүн.

**Ц.Баатархүү:** Та бүхэн бичгээр бас асуултад ер нь хариулаарай. Ер нь Улсын Их Хурлын гишүүдийн асуултад энэ төслийн баг би бас энэ 3 удаа асууж байгаа юм. Гишүүд ч бас асуугаад байгаа юм. Их ерөнхий хариулах юм. Төслийн баг бол мэргэжлийн түвшинд мэргэшчихсэн, тоогоо мэддэг, баримттай, нотолгоотой ингээд хариулахгүй бол та бүхний энэ бөөрөнхий тойруулсан хариулт бол бид нарыг ингээд үл итгэх байдал руу аваачиж байна шүү. Энэ төсөл амжилттай явна, менежментийг нь хангалттай сайн удирдаж байна гэдэг тэр итгэлийг бууруулах хэмжээнд хариулж байна. Та бүхэн бол ерөөсөө энэ маш сайн баримт нотолгоо, тоотой болох хэрэгтэй. Их Хурлын гишүүдээсээ бага тоо баримт мэдэж байна. Их Хурлын гишүүд чинь энэ мэдээллийг нэлээн сайн татаж аваад бас харьцуулаад сууж байгаа шүү дээ тэгээд үнэн мөнөөр нь хариулахгүй ингээд бөөрөнхийлөөд битгий байгаач ээ гэдгийг дахин сануулъя. Амжилт хүсье.

**С.Бямбацогт:** Сангийн яам Мэндсайхан сайд сая Баатархүү гишүүн, Батбаатар гишүүд бас хариулт хангалтгүй байна мэдээлэл дутуу байна гэж хэлж байна. Энэ дээр бас дутуу мэдээллүүдээ гүйцээж бичгээр хариулт өгөөрэй.

Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг маргааш үдээс өмнөх чуулганаар хураана. Дараагийн асуудалдаа оръё.

18.36 цаг

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир танилцуулна. Танилцуулсны дараа явна, тэрний дараа явна. Таныг индэрт урьж байна.

**Д.Бум-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд хийж байна.

Уг төслийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир, Анар, Баярмаа, Золжаргал нарын гишүүд 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Сонгуулийн үндсэн зарчмын нэг болох бүх нийтийн байх, бүх нийтийн оролцоог бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага байсаар байгаа нь сонгуульд оролцож буй сонгогчдын ирц, оролцоо сонгуулиас сонгуулийн хооронд тогтмол буурч байгаа дүнгээс харагдаж байна.

Тухайлбал, 2021 онд 59.2 болж буурчээ. Сонгуулийн ирц, оролцоо буурч байгаа гол шалтгаан, нөхцөлийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос 2025 онд 21 аймаг, 330 сумын нийт 11700 сонгогчийг хамруулсан сонгогчийн зан төлөвийн судалгааны тайланд дурдсан үр дүнгээс үзвэл сонгуульд оролцоогүй шалтгааны 33.9 хувь нь санал авах өдөр байнгын оршин суугаа хаяг, газраасаа өөр газарт байсан. 7.7 хувь нь оюутан орон нутагт оршин суух хаягтай. 0.5 хувь нь гадаад улсад байсан зэрэг шалтгаантай байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 77 дугаар тогтоол гарч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гадаад улсад байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа боловч сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хаягаас өөр газарт байгаа иргэн, оюутан, суралцагчид, сонгуулийн санал авах өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх, санал өгөх боломжит хувилбарыг тодорхойлж, эрх зүйн орчныг бий болгох талаар санал боловсруулах үүрэг болгосон.

Хуулийн төслийг дээр дурдсан үндэслэл, шалтгаан Улсын Их Хурлын тогтоолд үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд дараах харилцаа г зохицуулахаар тусгалаа. Үүнд:

Нэгд нь гадаад улсад байгаа иргэд санал өгөхдөө урьдчилан бүртгүүлэхгүй бөгөөд сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал авах боломжийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Хоёрт, санал авах өдөр саналаа өгөх боломжгүй сонгогчийн саналыг урьдчилан авах төрөл, хэлбэрийг нэвтрүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Гуравд, санал авах өдөр тухайн сонгогчийн харьяа, хэсгийн хороо, хамаарах аймаг, нийслэлээс өөр нутаг дэвсгэрт байгаа сонгогчийн саналыг авах, түүнд

шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Мөн хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээнээс шалтгаалан дагалдан гарах хуулийн төсөл боловсруулах шаардлагатай. Тухайлбал, санал авах төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэхдээ сонгуулийн автоматжуулсан систем, түүнд хамаарах тоног төхөөрөмжийг судлах, тодорхойлох, баталгаажуулах зэрэг чиг үүргийг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн чиг үүрэгт нэмэлтээр тусгах зорилгоор Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдан гарах хуулийн төслийг боловсрууллаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урьж байна.

**А.Ариунзаяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир нарын 4 гишүүн 26 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 05 сарын 20-ны өдрийн хуралдаанаараа авч хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 77 дугаар тогтоолд гадаад улсад байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаягаас өөр газарт байгаа иргэн, оюутан, суралцагчид, сонгуулийн санал авах өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх, санал өгөх боломжит хувилбарыг тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар санал боловсруулахаар тусгасан.

Түүнчлэн сонгуульд оролцож буй сонгогчдын оролцоо сонгуулиас сонгуулийн хооронд тогтмол буурч байгаа тул сонгуулийн үндсэн зарчмын нэг болох бүх нийтийн оролцоог бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хөдөө орон нутагт ажиллаж байгаа иргэд хот суурин газарт сурч байгаа оюутнууд тухайн газартаа саналаа өгөхөд өөрийнх нь албан ёсны бүртгэлтэй хаяг дээрээс санал нь шууд бүртгэгдэх, улмаар орон нутаг, гадаадад ажиллахаар явж буй иргэд сонгуулийн албан ёсны санал хураалт болохоос өмнө урьдчилж санал өгөх боломжийг нээх, мөн гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэд 2 өдрийн дотор санал өгдөг байсныг 5 өдөр болгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим хуудаст байршуулан санал авсан байна. Байнгын

хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Гантөмөр иргэний бүртгэлийн байгууллага зөвхөн өөрийн хаяг дээрээ санал өгөхийг шаарддаг байсан бол энэ төслөөр хаяг хамаарахгүйгээр зохицуулсан нь 1 хүн 2 газар санал өгөх эрсдэл үүсгэх эсэх, намуудын зөвшилцөлгүйгээр энэ хуулийн төслийг санаачлах болсон үндэслэлийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Гантөмөр намын бүлгүүд төслийн талаар зөвшилцөх шаардлагатай тул хуулийн төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 47.6 хувь буюу олонх дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь чухал асуудал учраас зөвшилцөл дээр суурилж, намууд байр сууриа нэгтгэх шаардлагатай. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд сонгууль болохоос 1 жилийн дотор өөрчлөлт оруулахыг хориглосон зохицуулалттайг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар энэ хууль батлагдвал хэрэгжих нөхцөл боломж, техникийн бололцоо байгаа эсэх, улс төрийн намуудын зөвшилцлийг хангах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Гантөмөр гадаадад байгаа иргэдийн саналыг авах дэвшилттэй зохицуулалт хэдий ч үүсэх эрсдэл байгаа, бүртгэлгүй хүн санал өгөх тохиолдол гарч болзошгүй, гадаадад ажиллаж амьдардаг иргэдийн эрхийг хамгаалах нэрээр дотоодод байгаа иргэдийн сонгуулийн зохицуулалтыг өөрчилж болохгүй. Зөвхөн гадаадад байгаа иргэдийн асуудлыг тусад нь зохицуулах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 47.6 хувь, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 38.1 хувь дэмжсэн буюу олонх нь хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийг танилцуулъя. Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурлын даргаа Ардчилсан намын бүлгээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэх асуудал дээр 5 өдрийн завсарлага авах хүсэлтэй байгаа юм. Бүлэг дээрээ энэ асуудлаар

мэдээлэл авах шаардлага байна. Бас ойлголтын зөрүүнүүд нэлээн байх шиг байна. Хууль санаачлагчаас ирэх 1 дэх өдөр бас манай бүлэг дээр ирээд танилцуулгаа хийхийг бас хүсэж байна. 5 өдрийн завсарлага.

**С.Бямбацогт:** Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль бас нэлээн чухал хууль. Тэгэхээр бас сөрөг хүчний бүлэгтээ бас танилцуулж, байр суурь, ойлголтоо бас мэдээлэл өгөх зорилгоор завсарлах хүсэж байгаа юм байна. Тэгээд 5 хоногийн завсарлага өглөө. Дараагийн асуудалд оръё.

18.46 цаг

### **Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Таныг индэрт урьж байна

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын Үндсэн хуулийн цэцийн 25 оны 10 дугаар дүгнэлтийн тухай 25 оны 123 дугаар тогтоолыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 2 дугаар захирамжаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, гишүүдэд Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, А.Ганбаатар, С.Замира, С.Зулпхар, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаясгалан, Ц.Мөнхтуяа, О.Саранчулуун, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Б.Хэрлэн, Ө.Шижир нар ажилласан болно.

Хууль зүйн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотойгоор Эрүүгийн хуульд гүтгэх гэмт хэргийг шинээр оруулах тохиолдолд түүний субъектив шинжийг хэрхэн тодорхой маргаангүй тогтоох, хэвлэлийн эрх чөлөөнд нөлөөлөх

эрсдэл хэрэгжилтийн үр нөлөө болон гүтгэлгийн гэмт хэргийн гаралтын бодитоор бууруулах тооцоо, судалгаа байгаа эсэх, мөн нийтийн ашиг сонирхлын хүрээнд үзэл бодлоо илэрхийлсэн сэтгүүлчдийг эрүүгийн хариуцлагаас хэрхэн хамгаалж, мэдээллийн зорилго агуулгыг ямар шалгуураар ялган үнэлж, хэвлэлийн эрх чөлөөг хангах зохицуулалтыг хууль хэрэгжилтийн түвшинд яаж бодитойгоор хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Эрүүгийн хуульд гүтгэх гэмт хэргийн зохицуулалт байхгүйгээс иргэдийн нэр төр, алдар, нэр төр, гэр бүлд нь халдсан гомдлууд цагдаагийн байгууллагад шийдэгдэх боломжгүйгээр хуримтлагдаж байгаа, өнөөгийн нөхцөлд ийм төрлийн өргөдөл, гомдлын тоо хэмжээ, тэд нарыгаа хэрхэн шийдвэрлэж ирсэн байдал болон цаашид энэ асуудлыг шийдвэрлэхгүй орхигдуулбал гарах сөрөг үр дагаврын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг гүтгэх гэмт хэргийг Эрүүгийн хуулиар зохицуулдаг олон улсын жишиг, тэдгээрт хэлмэгдүүлэлт үүсэх эрсдэлийг хязгаарлах хатуу шалгуур, хяналтын механизм хэрхэн хэрэгждэг талаар, нийтийн албан тушаалтныг албан үүрэгтэй нь холбогдон шүүмжилж үзэл бодлоо илэрхийлснийг хэрхэн ялгаж тогтоох. Энэ талаар нэгдсэн ойлголт, нэр томьёо бий эсэх, мөн бусдын гэмт хэрэгт үйлдсэн гэж мэдээлэл тараахад хууль хяналтын байгууллагын албан хаагчид хамаарагдах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал цахим орчинд хиймэл ухаан ашиглан хүний нэр төрд халдах, гүтгэх гэмт хэрэгт хамааруулах шалгуур, түүнийг тухайн хүн хүний албан үүрэгтэй хэрхэн холбон үнэлэх, мөн хэвлэл мэдээллийн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг энэ төрлийн гэмт хэргээс тусгайлан чөлөөлөх зохицуулалт нэмэх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа эрүүгийн хуульд гүтгэх гэмт хэргийн зохицуулалт байх ёстой бөгөөд жирийн иргэдийн нэр төр, алдар хүндийг хамгаалах зорилгоор зөвхөн мэдсээр байж санаатайгаар худал мэдээлэл бэлтгэн тарааж, хохирол учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож, харин сэтгүүл зүйн үйл ажиллагаа, нийтийн албан тушаалтныг шүүмжлэх, мэдээллийг давтан түгээх зэрэг тохиолдлыг хариуцлагаас чөлөөлөхөөр тодорхой зохицуулах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат гүтгэх үйл ажиллагааг захиалгатайгаар тодорхой санхүүжилттэй хийгдэх асуудлыг хэрхэн илрүүлж, захиалагч болон санхүүжүүлэгчид хариуцлага тооцох, мөн ийм төрлийн зохион байгуулалттай асуудлыг хуульд хэрхэн тусгах талаар хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж, хариулт авсан болно.

Ажлын хэсгээс 2 хувилбар бүхий хуулийн төслийг боловсруулж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд хуулийн төслийн 1 дэх хувилбар буюу Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53.3 хувиар дэмжсэн бол, 2 дахь хувирал хувилбар болох гүтгэх гэмт хэргийг зохицуулалтыг тусгасан хуулийн төслийг дэмжигдээгүй болно.

Байнгын хорооны гишүүд эхний санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар гүтгэх гэмт хэргийн зохицуулалтыг шинээр боловсруулж, 2026 оны хаврын ээлжит чуулганы хуралдаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй талаар хуралдааны тэмдэглэл цохон тэмдэглэсэн болно.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу

хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Тэмүүжин гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Д.Энхтүвшин:** Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 84.3 дээр хууль тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй бол Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэж заасан байгаа.

Гэтэл одоо оруулж ирж байгаа, Байнгын хорооноос оруулж ирж байгаа хуулийн төслийг харахаар хүчингүй болгоно гэдэг нэмэлт, өөрчлөлт өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд нийцүүлж энэ зүйл, заалтыг нэмэлт, өөрчлөлт байдлаар оруулж ирэх ёстой ийм хуулийн заалт байхад хүчингүй болгоход энэ зүйл, заалтыг нь шууд хүчингүй болгосон ийм техник ашигласан байна л даа. Тэгэхээр энэ нь өөрөө хуулийн зөрчилд орох юм биш биз дээ гэдэг нэг асуудал байна. Энэ дээр Тэмүүжин гишүүн ажлын хэсэг хариулж өгөөч.

Ер нь бол энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн энэ заалт ч гэсэн өөрөө Үндсэн хуулийн бас 26.1 дээр байгаа хууль санаачлах эрхийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар эдлэх эрхтэй гэж заасан. Энэ дээр бол Байнгын хороо гэсэн тийм үг, үсэг Үндсэн хууль дээр байхгүй байгаа. Тэгэхээр ер нь цаашдаа бас энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн энэ зүйл, заалтыг бас эргэж хармаар харагдаад байгаа юм.

Өөр нэг асуудал нь болохоор энэ Үндсэн хуулийн цэц дээр холбоотой үндсэн асуудлын нэг нь бол хуулийн этгээдийн нэр хүндтэй холбоотой асуудал байгаа. Зөвхөн энэ бол иргэд, хувь хүн гэхээсээ илүү хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг тараасан энэ харилцааг энэ иргэний журмаар шийдэж болохоор ийм агуулгатай байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд жишээлбэл хэвлэл мэдээллээр энэ аж тухайн нэгжийн нэр хүндэд халдсан байна гэж бараг сонсогдсон юм байгаагүй. Тэрийг залруулга хийж байсан. Тэгэхээр энэ иргэний журмаар энэ харилцааг зохицуулах нь өөрөө бас учир дутагдалтай байгаа. Тэгэхээр Эрүүгийн энэ хуулиар зохицуулахгүй гэвэл энэ чиглэлээр ажлын хэсэг дээр хуулийн этгээдийн нэр хүндийг үр дүнтэй хамгаалах талаар хуулийн өөрчлөлтийн талаар ярилцсан уу?

Тэгээд Засгийн газар хэрвээ энэ гүтгэхтэй холбоотой зүйл, заалт оруулж ирэхээр бол хуулийн этгээдтэй холбоотой бас асуудлыг нь цуг оруулж ирээрэй. Энийг яаж шийдэх вэ гэдгийг тэгэхгүй бол зөвхөн хувь хүний нэр төр, алдар хүндтэй холбоотой хэсгээ аваад хуулийн этгээдтэй холбоотой асуудлыг нь зөвхөн иргэний журмаар гээд орхичихдог. Тэр нь өөрөө үр дүнтэй бол хамгаалах бас арга хэрэгсэл болж чадахгүй байгаа. Сүүлийн үед бас өрсөлдөгч нартайгаа зохион байгуулалттайгаар эрүүгийн шинжит маягтай ийм нэр хүндэд халддаг, худал мэдээлэл тараах иймэрхүү бас нөхцөл байдлууд бий болдог. Тэгэхээр энэ харилцааг бас орхигдуулах гээд байгаа тал харагдаад байгаа. Тэгээд энэ дээр ажлын хэсгийн ахлагч саналаа хэлнэ үү? Баярлалаа.

**С.Бямбацогт:** Байнгын хороо хариулах уу, ажлын хэсэг хариулах уу? Ажлын хэсэг Тэмүүжин гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

**Х.Тэмүүжин:** Хоёрт ярьсан асуудалтай бол санал нэг байна. Үндсэн хууль дээр Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй гэсэн заалттай. Бид бол 92 оны Үндсэн хуулиас хойш Улсын Их Хурлын энэ 34 жилийн туршлага дээрээ бол Байнгын хороогоос хууль санаачлах байдлаар тогтоолын төсөл санаачлах байдлаар ингээд яваад ирсэн практик байгаа юм байна лээ. Тэгээд ер нь бол Үндсэн хуульд заасан хууль санаачлах эрх Байнгын хороонд байх уу үгүй юү гэдэг маргаан бол гарч магадгүй ер нь бол. Цаашдаа энэ асуудлаа нэг мөр жигдлэх байх. Ер нь гишүүд ажлын хэсэгт орсон гишүүд нэрээрээ санаачлаад явахад бол асуудал байхгүй.

1 дэх асуудал дээр бол Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй холбогдуулаад хуулийг хүчингүй болгож болно эс үгүй бол хуулийн зохицуулалтыг тодорхой болгож болно. Бас холбогдох хууль тогтоомжуудад бас нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аль ч үйл ажиллагааг нь бол бид бол Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлттэй холбогдуулаад, Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулаад холбогдуулаад тэр Үндсэн хуульд нийцээгүй байна гэдэг утга санаанд нийцүүлэхийн тулд хууль тогтоомжийг бүхэлд нь бол харах, сайжруулах бол хууль тогтоогчийн өөрийн бүрэн эрх. Тийм учраас бол бидний үйл ажиллагаа аль ч хэлбэрээр нь явж болно. Нээлттэй.

3 дахь асуудал дээр бол ажлын хэсэг бол энэ асуудлыг бас нэлээн дэлгэрэнгүй ярилцсан. Засгийн газар тэр дундаа Хууль зүйн яамнаас санал оруулж ирэхдээ энэ хуулийн этгээд гэдгийг нь хасчихвал яасан юм гэдэг саналыг байнга олон дахин давтаж ярьж байна лээ. Ер нь бол нэр төр, алдар хүндтэй холбоотой энэ асуудал зөвхөн хувь хүний асуудал биш. Хувь хүмүүс эвлэлдэн нэгдээд, эс үгүй бол хувь хүмүүс нийлээд хуулийн этгээд байгуулаад тэрүүгээрээ үйл ажиллагаа явуулж байх ч гэсэн энэ өөрөө бизнесийн алдар хүндтэй холбоотой асуудал нь яах аргагүй хуулиар хамгаалагдах ёстой харилцаа бол мөн.

Тэр дундаа эдийн засгийн том хохирол амсдаг, зах зээл дээрээсээ зүй бусаар шахагдаж гардаг хувийн өмч өөрөө эрсдэлд ордог, зарим талаараа хуулийн этгээд гэдэг бол зөвхөн аж ахуйн нэгж ерөөсөө биш. Төрийн бус байгууллагууд. Жишээ нь, Чимэд сан гээд хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ чинь Чимэд багшийн нэр төр дээр оршин тогтнож байгаа л үйл ажиллагаа шүү дээ. Тийм учраас энэ нөгөө нэр төрийн хамгаалалт гэдэг бол

зөвхөн хувь хүн дээр байдаг зүйл ерөөсөө биш. Энэ бас хуулийн этгээд дээр байдаг зүйл шүү гэдгийг бол бид бол ойлгох ёстой. Энэ чиглэлийн хууль тогтоомжийн боловсруулалтаа бол хийх ёстой.

Гэхдээ нэг зүйлийг болгоомжлох ёстой. Сая худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэргийг бичихдээ хуулийн этгээд гэдэг гэдгийг үгийг ашигласнаас болоод энэ үгийн ард төр орж ирээд жоохон самууруулсан. Тийм учраас Эрүүгийн хууль дээр энэ нэр төр, алдар хүндтэй холбоотой хамгаалалтын хуулийн этгээд гэдэг нэрийг төр ашиглах боломжгүй гэдэг зохицуулалтыг нь бас хийж өгч байж, төрийн байгууллага иргэнээсээ илүү нэр хүндтэй, алдар хүндтэй байх илэрхийлэгддэг энэ гажуудлыг бид нар бол хязгаарлах ёстой. Энэ гажуудлаас болоод бас маш.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Байнгын хорооны даргаас энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 84.3, 84.5-тай холбоотой асуулт асууя. Тэгээд энэ дээр болохоор Үндсэн хууль дээр заагаагүй субъект хууль санаачлах эрхтэй байгаа энэ 84.3-аар биш ээ 84.5-аар, мөн 84.3 дээр болохоор энэ хууль тогтоомж Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлээд хууль, тогтоол Улсын Их Хурлаас энэ Байнгын хорооноос оруулж ирэхдээ нэмэлт, өөрчлөлт гэдэг л зөвхөн агуулгаар биччихсэн байна. Тэгэхээр ер нь Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд бас яг энэ зүйл, заалтуудыг энэ хуулиудын хоорондын зөрчил үүсэж байна гэж бодож байна. Энийг яаж сайжруулах талаар бас таны санаа бодлыг сонсьё.

**С.Бямбацогт:** Цогтбаатар дарга хариулъя Хууль зүйн байнгын хороо.

**Д.Цогтбаатар:** Энэ чухал асуудал. Яах аргагүй хууль дээр бол тодорхой заагаад өгчихсөн байгаа хэн хууль санаачлах эрхтэй. Тэгэхлээр саяын аль ч хувилбараараа орж ирж байгаа 2 төсөл бол хоёулаа Байнгын хорооноос орж ирж байгаа юм шиг нөхцөл байдал үүсэж байна шүү дээ. Аль нь ч наадах чинь эргээд асуудал дагуулж болзошгүй. Гэхдээ энэ дээр сая хэлснээр нэг ийм асуудал байгаа. Угаасаа Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гараад энэ зайлшгүй явах процесс өөрөө яваад эхэлж байгаа байхгүй юу. Тэгээд тэрнийхээ дагуу ажлын хэсэг байгуулагдаад энэ юу орж ирж байгаа, хуулийн төслүүд орж ирж байгаа. Энэ дээр нөгөө ажлын хэсэгт орсон гишүүд яг энэ дээрээ өөрсдөө бас оролцоод явж байгаа шүү дээ.

Тэгэхлээр ер нь бол яг ард нь үг, үсэг гэхгүй агуулгаар нь ярих юм бол гишүүд санаачилж бол орж ирж байгаа шүү дээ. Түүнээс бол энийг хэн нэг гишүүн биш харин хүн тэн дотор орчихсон ажлын хэсэгт эд нар явж байсан бол нэг асуудал. Тэгэхэд энэ бол яг цэвэр гишүүд л оруулж ирж байгаа.

**С.Бямбацогт:** Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асуух уу? Тийм байх тээ?

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нөгөө Үндсэн хуулийн цэцээс гаргасан шийдвэрийн дагуу бид нар энэ Эрүүгийн тухай хуулийн 13,14 гээд хэлэлцээд явж байгаа. Хууль зүйн байнгын хороон дээр үг хэлэх гэсэн боловч нөгөө шатууд нь өнгөрчихсөн байсан. Яг өнөөдрийн байдлаар жишээлэхэд 461-д

бид нар нэг сэтгүүлчийг ямар гэмт хэрэгт холбогдуулж шалгаж байгааг нь бол мэдэхгүй байна.

Гэхдээ өлсгөлөн зарлуулаад энэ сошиалд байгаа мэдээллээр бол 2, 3 хоночхож байгаа юм. Тэгээд одоо бид нар энд хэвлэлийн эрх чөлөө, ардчилал яриад байгаа юм. 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль дээр 4 дүгээр зүйл дээр нь байсан байх аа. 4 дүгээр зүйл дээр төрийн байгууллагын хэвлэлийн, төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох гээд. Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно гэж байгаа байхгүй юу хуулиараа.

Гэтэл одоо яам болгон, сайд болгон, бараг сайдынх нь зөвлөх болгон бүгдээрээ нэг ийм камер барьсан, микрофон барьсан хүмүүстэй. Их Хурлын дарга бас энийг бас анхааруулаад бүгдэд нь Засгийн газрыг Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилдог юм бол энэ дээр бас нэг хуулийг дагаж мөрд, хуулийг хянахад ийм байна гэдэг нэг ийм чиглэлийг өгмөөр юм шиг надад бол санагдаад байгаа юм. Яам болгон л сайд болгон дэргэдээ хэвлэлийн бараг агентлагтай. Бүгдээрээ контент бэлддэг. Тэр нь үнэн, худлаа эсэхийг нь хэн ч мэдэхгүй. Тэр яам нь зөв ажиллаад байгаа юм уу, нийгэмд зөв мэдээлэл өгөөд байгаа юм уу хэн ч мэдэхгүй. Буруу ажиллаад байгаа юм уу, үнэн ажиллаад байгаа юм уу гэдгийг нь хэн ч шүүж чаддаггүй. Тэгэхээр энэ талаас нь бас харах ёстой юм шиг байгаа юм.

Тэгэхээр миний асуулт бол сэтгүүлчид бол ер нь бол эрх мэдэлтэнтэй л үзэж байгаа юм. Иргэн Дорж, Дондог, Дулмаатай бол ямар ч сэтгүүлч үзэхгүй. Зүгээр иргэн Дорж, Дондог, Дулмаагийн амьдрал ямар байна гэдгийг эрх барьж байгаа эрх мэдэлтнүүдэд хүргэж өгч байгаа хүн чинь өөрөө сэтгүүлч. Тэгээд сэтгүүлчид тэр дотор зүгээр миний харж байгаагаар бол тэр дотор ямар нэгэн нууц мэдээлэл хадгалаад байх ч шаардлагагүй, аваад байх ч шаардлагагүй. Зүгээр нийгэмд байгаа тэр асуудлыг эрх мэдэлтний өмнөөс аваачиж өгснийхөө төлөө жишээлэхэд сэтгүүлч Өнөрцэцэг бол бүүр ял авсан шүү дээ. Нууцыг хадгалах, нууцыг өөр дээрээ юу гэдэг юм байлгах ч гэдэг юм уу тэр үүрэг нь бол өөрт нь байхгүй хүн ял авч байна. Өнөөдөр дахиад нэг сэтгүүлч тэнд хуурай өлсгөлөн зарлаж байна. Тэгэхээр бид нар энэ 98 онд баталсан тэр Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиараа төр өөрөө хэвлэл мэдээлэлтэй байх, тэр хориотой байх тэр хуулийг бид нар хэрэгжүүлж хянаж чадахгүй байгааг энэ Улсын Их Хурлын дарга анхаараасай.

Тэгээд ер нь бол энэ сэтгүүлчид эрх мэдэлтэнтэй үзээд эрүүгийн ял авдаг байдал чинь хэр зохимжтой байх юм бэ? Магадгүй энэ ажлын хэсэг Тэмүүжин гишүүн Улсын Их Хурлаас магадгүй энэ чиглэл Засгийн газарт өгөхдөө энэ дээр протоколоор ч юм уу нэмж оруулж болдог бол энийг бас зөв талаас нь харж үзэж оруулж ирээсэй гэдэг ийм байр суурьтай. Тэгээд энэ дээр бас хууль энэ нөгөө Үндсэн хуулийн цэц дээр очиж ажлын хэсэгт ажилласан Тэмүүжин гишүүнээс энэ тал дээр нэг байр сууриа илэрхийлээч ээ л гэж хэлэх гэсэн юм.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн ахлагч Тэмүүжин гишүүн хариулъя.

**Х.Тэмүүжин:** Энэ ажлын хэсгийг байгуулаад хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Тэгээд сонирхлын бүлэг гэдэг юм уу эрх ашиг нь хөндөгдөж болох, болзошгүй хамгийн том бүлэг нь бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон

сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулж байгаа энэ мэргэжилтнүүдийн хувьд бол гомдол, санал бол маш ихээр гаргасан.

Ямар байдлаар гомдол санал ихээр гаргасан бэ гэхээр ер нь бол Эрүүгийн хуульд байгаа худал мэдээлэл тараах гэдэг энэ гэмт хэрэг чинь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бол маш ихээр хумилаа. Дээр нь энэ гэмт хэрэг Эрүүгийн хуульд заасан энэ зүйл, заалтыг ашиглаад сэтгүүлчдийг айлгах, сэтгүүлчдийн дуу хоолойг боомилох, албан тушаалтан эрх мэдэлтэнтэй зөрчилдвөл зөрүүлээд ийм хариуцлага тооцож болдог юм шүү гэж мануухай болгож өлгөж бусдад нь үзүүлэх ийм үйл явц бол хэрээс хэтэрлээ. Тийм учраас энэ айдсын эффект өгөөд байгаа энэ Эрүүгийн хуулийн зохицуулалтаа үгүй хийгээч ээ гэдэг энэ алга болгооч ээ Үндсэн хуулийн цэц ийм байр сууриар энийг чинь Үндсэн хуульд нийцээгүй байна шүү дээ гэж дүгнэлээ шүү гэдэг ийм байр суурийг бол маш ихээр гаргасан.

Үнэхээр бид нар шүүх болон бусад байгууллагуудаас статистик тоо авсан. Тэгсэн чинь их сонин дүр зураг гарсан. Шүүхээр шийдэгдсэн өөрөөр хэлбэл, худал мэдээлэл тараасан гэдэг энэ гэмт хэргээр зүйлчлэгдээд шүүхээр шийдэгдсэн хэрэг дотор сэтгүүлчид бол ерөөсөө 2, 3-хан юм байна лээ. Бусад нь бол иргэд.

Гэхдээ цагдаагийн байгууллагад шалгагдсан үйлдлээр нь харах юм бол цагдаагийн байгууллага буюу шүүхэд аваачихгүйгээр наана нь цээрлүүлж айлган сүрдүүлдэг үйл явц бол хавтгай юм байна лээ. Өнөөдөр Эрүүгийн хуулиас худал мэдээлэл тараах гэдэг энэ зүйл түдгэлзээд хуулийн байгууллага ийм зүйл, заалтыг ашиглах боломжгүй байгаа боловч 461 дээр сэтгүүлчийг аваачаад хийчихсэн, өлсгөлөн зарлах хэмжээнд нь аваачаад ажиллаж байна гэдэг бол энэ өөрөө ямар аюултай үзэгдэл энэ хуулийн байгууллагууд дотор нэргэсэн байгаа вэ гэдгийн бас тод үзүүлэлт болох байх. Ганц Эрүүгийн хуулиар биш энэ завхралын хамгийн том сээжм бол процесс дээр байгаа.

Хэрэг шалгаж байгаа процесс маань социализмаасаа бид нар салаагүй байгааг илэрхийлж байна. Хүн нь байвал хэрэг нь олдоно гэдэг зарчим одоо хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа юм байна. Онилсон мөрдлөг буюу ямар нэгэн байдлаар чамайг айлган сүрдүүлээд л амьдралаар чинь тоглож болдог юм гэдгээ харуулж чадах хэмжээний хуулийн байгууллагын үйл ажиллагаа одоо хүртэл явж байгаа юм байна. Вишинскийн онол өөрөөр хэлбэл. Хамгийн сайн нотлох баримт бол хэрэгтэн өөрөө хэргээ илчлэх гэдэг энэ зарчмаар эрүү шүүлт явуулдаг энэ коммунист, фашист мөрдөн шалгах үйл ажиллагаа Монголын хуулийн байгууллагын үйл ажиллагаанаас огт салаагүй юм байна. Салаагүй байгаа учраас саяхан бас сэтгүүлчид эсэргүүцлээ илэрхийлэхдээ энэ Эрүүгийн хуулийнхаа гүтгэх гэдэг заалтыг буцааж оруулж ирэх гэж байгаа бол процессынхоо шинэчлэлийг цуг явуулаач ээ.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

**Да.Цогтбаатар:** Түрүүн Гантөмөр гишүүн бас саналаа илэрхийлсэн. Баянхонгор аймгийн барилгын цэргийн 339 дүгээр ангид цэргийн амь эрсэдсэн. Энэхүү байдал дээр бас Улсын Их Хурал эмгэнэл илэрхийлээд, холбогдох хүмүүсээс нь хариуцлагын асуудал яригдаад сэтгүүлч Мядагдам яг энийг газар дээрээс нь судлаад бас ажиллаж байгаа. Тэгээд сэтгүүлч Мядагдамд бас талархал илэрхийлье. Гомдол, санал нь бол өнөөдрийг болтол тасраагүй байгаа.

Бямбацогт дарга би дахиад минутаа авах уу? Энэ чинь тал нь өнгөрчихлөө шүү дээ. Энэ 2 мэтгэлцсээр байтал. Үгүй ээ тэгээд та 2 ярьсаар байтал миний анхаарал бас сарниад байна шүү дээ. Дахиад минутаа эхнээс нь авчих уу? Тийм, минутаа авах гэхээр миний үг багтахгүй 8 секунд нь тийм. Ер нь бол.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Тодруулаад асуучихъя. Асуултаа гүйцээгээд асуучихъя.

**Да.Цогтбаатар:** Тэгээд ер нь бол гомдол, санал өнөөдрийг болтол тасраагүй байгаа учраас одоо энэ шаардлагатай байгаа бол Засгийн газарт саналаа оруулж ирэхдээ сэтгүүлч нарын эрх ашгийг хамгаалах, сэтгүүлч нар нэг ийм хувийн байдал гаргаж яваагүй байх юм. Эд нар бол нийгэмд болохгүй байгаа, бүтэхгүй байгаа асуудлыг эсвэл эрх мэдэлтэн дээр хэт их эрх мэдэл төвлөрөөд энд хулгай гарч байна, энд луйвар гарч байна, эсвэл энд нийгэмд хор уршигтай асуудал явагдаж байна гэдгийг л илэрхийлж байгаа юм. Нэг илэрхийлэл нь энэ Мядагбадам сэтгүүлч ээ л гэдгийг хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр энэ сэтгүүлч нарын эрх ашгийг хамгаалах албан ёсных нь байгууллагатай юу гэдэг юм Сэтгүүлчийн эвлэл гэж байдаг бол тэр эвлэлтэй хамтраад, саналыг нь тусгаад тэгээд энэ нөгөө хуулийнхаа саналыг Засгийн газартай сэтгүүлч нарын байгууллага хамтраад оруулж ирэх ёстой шүү гэдэг энэ байр суурийг магадгүй би бол гишүүнийхээ өмнөөс, гэхдээ манай Улсын Их Хурлын дарга бол бас энэ дээр нэмэлт тайлбарыг хэлэх байх ийм байр суурь илэрхийлж байгаа шүү гэдгийг л хэлэх гэсэн юм.

**С.Бямбацогт:** Даваагийн Цогтбаатар гишүүн үг хэллээ. Сая тэр ярьж байгаа асуудлууд дээр бид нар анхаарах ёстой. Улсын Их Хурлын тухай хуульд бид нар Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо гэж бас хүний эрхийг дээдэлнэ ээ гэж оруулж байгаа. Гэхдээ нэг хүний эрх нөгөө хүний эрхийг эрхээр хязгаарлагдах ёс. Үнэхээр хэвлэл мэдээллийн байгууллагууд нийтийн албан тушаалтныг шүүмжилж байгаа алдаа дутагдлыг нь олон нийтэд мэдээлж байгаа. Үүнээсээ болж хариуцлага хүлээхгүй байх ёстой. Хариуцлага хүлээхгүй байх.

Харин гүтгэж байгаа, худлаа мэдээлэл тарааж байгаа ийм асуудлууд дээр бол хариуцлага хүлээдэг байх ёстой. Өнөөдөр улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал дээр Монгол улсын хилийг 56км нааш нь татчихсан байна, хилийн баганыг нааш нь татчихсан байна гэдэг худлаа мэдээлэл тараагдаад энэ улс орон даяараа юу болчхов? Хятад улс бараг газар нутгаа өгчихсөн байна гэж худлаа мэдээлэл явсан шүү дээ. Юу болж бас бужигналаа. Тэр нь шал худлаа мэдээлэл байсан. Худлаа мэдээлэл гүтгэдэг. Одоо бас хэдэн жилийн өмнө та бүхэн мэдэж байгаа. Жирийн төрийн албан хаагчийг ДОХ-той гэж гүтгээд түүнээсээ болоод тэр хүн амьд явах аргагүй болоод амиа хорлож байсан гэх мэтийн иймэрхүү бас асуудлууд дээр ялгаж салгах ёстой.

Тэгээд нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагдах ёстой. Жирийн иргэдийг гүтгэдэг, гутаадаг, улс орны тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар худлаа мэдээлэл тараадаг иймэрхүү асуудлууд дээр бид бас илүү бас хариуцлага тооцдог байх ёстой. Тэгээд энийг бас нэг ялгаж салгах ёстой. тэгээд яагаад Байнгын хороон дээр энэ ялгаж салгах асуудал нь байхгүй болчхов уу энийг бас цаашдаа бид анхаарах ёстой байх аа.

Баянхонгор аймагт бас цэргийн амь нас эрсэдсэн асуудал дээр Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ өмнөөс эмгэнэл илэрхийлье. Аав, ээжийн хүү бас ялгаа юу байх вэ? Эх орноо хамгаална, эр цэргийн албанд хаагаад бас эр бие би жагсаад ирнэ ээ гээд цэргийн албан дээр мордсон. Тэр анги дээр бас цэргийн сахилга бат, дэг журам, хяналт муу байснаас болж энэ үйл явц болсон байх. Гэхдээ хэргийн газар дээр бас хууль хяналтын байгууллагууд мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаа юм байна лээ. Энэ талаар бас Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Батлут сайд бас мэдэгдэл гаргасан. Эмгэнэл илэрхийлсэн байна лээ.

Тийм болохоор хууль хяналтын байгууллагууд буруутай этгээдүүдийг тогтоож хуулийн дагуу хариуцлага тооцох ёстой байх. Тооцох ёстой. Эх орноо хамгаалаад ирье, эр цэргийн албаа хаагаад ир гэж бодохоор үр хүүхдээ явуулдаг болохоос амь насаа алдчих вий гэж ийм асуудал байж болохгүй л дээ. Тийм болохоор иймэрхүү зүйлүүд дээр бид нар хатуу хариуцлага тооцох ёстой. Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, манай Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо анхааралдаа авч, энд хүний эрх зөрчсөн асуудал байвал яагаад энэ энэ салбарт хүний эрх зөрчсөн энэ дэглэлт, цэрэг дэглэлт гэдэг юм уу ийм асуудал явж байна бас шаардлагатай бол бас хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулна.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя.

**Р.Эрдэнэбүрэн:** Өнөөдөр хэтэрхий олон асуулт асуучихлаа. Асуулт давхацлаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ц.Даваасүрэн:** Оройн мэнд. Тэгэхээр энэ Цэц гэдэг байгууллага бол үнэхээр Монголын төрийг самарч байна л даа. Ингээд хүн гүтгэх бол ялгүй гээд ингэчихсэн. Тэгэхээр би энэ гүтгэхийг бусад улс орнууд яадаг юм гээд энэ манай Их Хурлын судалгааны хүрээлэнгээр хийлгэсэн байхгүй юу. Гүтгэхэд ял өгдөггүй орон гарын 5 хуруунд багтаж байгаа байхгүй юу. Ял өгдөггүй орон. Монгол, Болгар, Румын. Америк бол өндөр торгуультай. Бүгд ялтай. Европын нөгөө ардчилсан орнууд гүтгэвэл бүгд ялтай. Тэгээд энэ дээрээс бид нар нэг юм бодох хэрэгтэй. Яагаад Монгол ялгүй юм? Ялгүй орнууд яаж байна уу гэж. Болгарыг та нар хар 4 жил 7 удаа сонгууль хийж байна шүү дээ. Яагаад тэгж байна үнэн, худлыг ард түмэн ялгахаа больчихсон байхгүй юу. Зөв, бурууг ялгахаа больчихсон байхгүй юу. Бид яг тийм болж байна шүү дээ. Ямар ч лидер байхгүй. Аль хүн нь сайн хүн юм мэдэхгүй. Бүгдийгээ гүтгээд алчихна. Хийгээгүй хэрэгтний төлөө хэрэгтэн болно. Үгүй ээ энэ бүгдийг бид нар үзэж байна шүү дээ. Би ч гэсэн үзэж байна шүү дээ. Тэгээд аваачаад хууль хяналтын байгууллагад өгнө. Үзэл бодлоо илэрхийлсэн гээд байна.

Үндсэн хуулийн 19.3-д хүн эрхээ эдлэхдээ, тэр эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрхийг хүндэлнэ гээд байж байгаа шүү дээ. Энэ заалтыг Цэц яасан юм мэдэхгүй. Хэрвээ нотлох баримт байдаг юм бол гаргаад л тавих хэрэгтэй шүү дээ. Үгүй ээ гаргаад тавьчихсан бол би өнөөдөр 5 сонгогдохгүй шүү дээ. Янз бүрийн юманд холбоод л гүтгэнэ. Надыг танихгүй улсууд тийм л гэж бодно шүү дээ.

Нутгийнхан мэдэж байгаа учраас сонгоод байгаа. Тэгээд энэ бол аймшигтай зүйл байхгүй юу. Хэдхэн орон юм байна. Банк ч дампууруулж мэднэ, үймээн самуун ч тэгж байж мэднэ, хүний аминд ч хүрч мэднэ. Гүтгэл гэдэг бол аюултай ноцтой зүйл. Францыг та нар хар л даа. Францын Ерөнхийлөгч Макроны авгайг хүйсээ сольсон гээд тэгсэн 10 хүн яаж байна вэ 4 сараас 8 сарын ял авч л байна шүү дээ. Трампыг гүтгэхчээр ВВС яаж байна вэ? Тэрбум доллар нэхэмжилж байна шүү дээ. Америк бол аягүй өндрөөр нэхэмжилдэг юм байна лээ.

Тэгэхээр та нар минь адаглаад ял эдлүүлдэггүй юм гэхэд нэг маш өндөр торгуультай болгох хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ байж болохгүй. Үгүй ээ хийгээгүйнхээ үүргийн төлөө яагаад гэмт хэрэгтэн болоод явж байх ёстой юм. Тийм учраас бид нар энэ дээр бол ямар нэг тийм шийтгэлийн асуудалгүйгээр ингэж орхиж болохгүй. Гүтгэхгүй бол хэн ч яллахгүй шүү дээ. Нотлох баримтаа гаргаад ир л дээ. Тэгвэл хэн ч яллаж чадахгүй шүү дээ. Ер нь энэ манай сэтгүүл зүй ч гэсэн тийм болох хэрэгтэй. Яагаад мөрдөн байцаах сэтгүүл зүй байгаа юм. Яагаад гэвэл нотлох баримт олж авч чадаж байна шүү дээ. Тэгээд дараа нь гаргаад тавьчихаж чадаж байна шүү дээ. Үгүй ээ ийм болох хэрэгтэй сэтгүүл зүйб Цагдаа ч тийм болох хэрэгтэй. Түрүүний Тэмүүлэнгийн.

Америкт Европын орнуудад гүйцэтгэх ажил дээр хүний гэм буруутайг нотолж байж барьж хорьдог. Хүн амины хэрэгтэй хүн ч байсан тэр хүн алжээ гэдгийг нотолж байж хорьдог байхгүй юу. Манай зүгээр чөлөөтэй мэдээллээр хорьчихож байгаа байхгүй юу. Нэг сайт дээр юм гарчихвал хорьчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь жирийн иргэн ч хэлмэгдэж байгаа энд. Зөвхөн улс төрч биш. Тэр сэтгүүл ч хэлмэгдэж байгаа. Яагаад гэвэл мэдээллээр зүгээр л хүнийг яаж ч болно. Эрүүгийн хэрэг үүсгэж болно.

Тэгэхээр энэ юмнуудаа бид нар ингэж өөрчилж явах ёстой болохоос биш бусдыг гүтгэ ээ, энэ бол эрх чөлөө гээд ингэж болохгүй. Эрх чөлөөгөө эдлэхдээ Үндсэн хуулийн 19.3-аар бусдын эрхийг хүндэлнэ ээ гэж байж байгаа. Тэгээд ийм маягаар явахгүй бол энэ болохгүй. Тэгэхээр энэ.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Байнгын хороо санаачилж болохгүй гэж байна. Ажлын хэсэг хариульъя.

**Х.Тэмүүжин:** Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарахдаа дотроо хэд хэдэн нөхцөлтэй гарсан байна лээ.

1 дүгээрт, худал мэдээлэл тараах гэдэг энэ гэмт хэрэг чинь тодорхойгүй зохицуулалттайгаасаа болоод иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж байгаа юм байна. Энэ зохицуулалтаа тодорхой болго гэсэн агуулгатай.

Хоёрт нь ингэж Эрүүгийн хууль дээр хэрвээ гэмт хэрэг гэж бичиж байгаа бол хорих ялыг хэрэглэж болохгүй шүү гэж ийм байдалтайгаа тайлбартайгаа гарсан байна лээ. Тэгээд ажлын хэсэг бол ер нь бол худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэргийг хуульчлахдаа бол манайх яах аргагүй хууль тогтоомжийн алдаа гаргасан юм байна. 2, 3-н төрлийн гэмт хэргийг холиод тэгээд биччихсэн учраас хаашаа л бол хаашаа татаж сунгаж болоод хүнийг хэлмэгдүүлж болдог тийм маягийн зохицуулалт болчихжээ.

Худал мэдээлэл тараах гэдэг нь бол тусдаа гэмт хэрэг. Сүүлийн 20-оод жил шинэ төрлийн гэмт хэрэг гэж үзэж байгаа. Үндэсний аюулгүй байдалтай, эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой тэр чиглэлийн гэмт хэрэг хувь хүний эсрэг чиглэдэггүй гэмт хэрэг гэж үзэж байгаа. Гүтгэх гэмт хэрэг нь болохоор хувь хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой хувь хүн руу чиглэдэг гэмт хэрэг гэж үзэж байгаа. Тэгээд энэ 2 гэмт хэргийг холиод бичихсэн учраас зөрчил дагуулсан юм байна лээ. Хууль зүйн, байнгын хороо санаачлах боломжтой байсан. Бид бол 2 төслийн хувилбар бэлдсэн ажлын хэсэг.

Нэг нь бол Үндсэн хуульд нийцээгүй байна гэдэг зүйл, заалтыг шууд хүчингүй болгох. Нөгөөдөх нь Үндсэн хуульд нийцээгүй заалтыг хүчингүй болгохынх нь сацуу хувь хүний эрх чөлөөний хэсэг дээр гүтгэх гэмт хэргийг бичих ийм 2 хувилбараар бичсэн. Тэгээд Байнгын хороон дээр нэг нь дэмжигдээд Улсын Их Хурал руу орж ирсэн. Улсын Их Хурлаас болон Байнгын хорооноос бол Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх ёстой. байх. Яах аргагүй 10-аад жилийн өмнө бол гүтгэх гэмт хэргийг гүтгэх гэдэг үйлдлийг Эрүүгийн хуулиараа зохицуулах бол зохимжгүй байна гэдэг зөвлөмжийг олон улсын байгууллагууд байнга өгдөг байсан бол сүүлийн жилүүдэд бол энэ төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулиараа шийдэхгүй бол бас хор хөнөөл нь бол илүү аюултай нөхцөл байдал руу шилжиж байна гэдэг зөвлөмжийг өгдөг болчихсон юм байна лээ.

Дээр нь мэдээж хэрэг энэ эрүүгийн хуулиараа гэмт хэрэг болгон шийдэж байгаа улс орнууд бол түгээмэл байгаа. Герман бол сүүлийн бараг хэдэн жил ч юм дээ энэ энэ гэмт хэргийг Эрүүгийн хууль дээрээ байгаа боловч хэрэглэхгүй байсан. Гэхдээ хэрэглэхээс өөр аргагүй нөхцөл байдал руу очиж байна гэж үзэж байна лээ. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр нөгөө хиймэл ухаантай холбоотой. Хүнийг байгаагүй газар нь байсан болгож, хийгээгүй бол хийсэн болгож, хэлээгүй үгийг нь хэлсэн болгож хийдэг ийм технологи гараад ирсэнтэй холбоотойгоор гүтгэх гэдэг энэ үйлдэл бол ер нь бүүр аюултай нөхцөл байдал руу очлоо гэдгээ бол үнэлж байна лээ. Тийм учраас Эрүүгийн хуулиар энэ төрлийнхөө зохицуулалтыг хийхээс өөр аргагүй байна гэдэг байр суурь руу улс орнууд шилжсэн байна лээ.

Тэгээд бид бол ажлын хэсэг дээрээ энэ төрлийн гэмт хэргийг гүтгэхийг бол бичихдээ түрүүний болгоомжилж байсан албан тушаалтныг шүүмжилсэн шүүмжлэлийг гүтгэх болгож хувирах вэ гэдгээс бол тайлбарыг бол хийсэн.

**С.Бямбацогт:** Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

**Ц.Даваасүрэн:** Жирийн иргэн ч бай, албан тушаалтан ч бай Үндсэн хуулиараа хамгаалагдсан байхгүй юу эрх нь. Хэнийг ч гүтгэж болохгүй. Тэр бусад улс орнууд чинь ерөөсөө өөрсдөө бүгдээрээ Эрүүгийн хууль дээрээ ялтай байгаа байхгүй юу. Би хэллээ шүү дээ хэдхэн орон ялгүй ээ гэж. Та нар ChatGPT-тэй ороод л үз. Тодорхой. Тийм учраас ямар нэг хэмжээний шийтгэл байхгүй бол энэ болохгүй. Одоо энийг бол ингээд мэргэшээд бүүр ашиглаж эхэлнэ. Юу ч үүсгэж болно. Үгүй ээ иргэний дайны нөхцөл байдал руу ч орж болно шүү энэ бол. Хүний аминд хүрнэ. Түрүүн чи жишээ хэлнэ шүү дээ 90-ээд оны сүүлд. Хүний аминд хүрч байж 111-ээр баривчилдаг болсон байхгүй юу. Үгүй ээ энэ бусад улс орнууд гүтгэх юм байхгүй байгаад байхад Монголд яахаараа ингээд хүнийг гэмт хэрэгтэй холбож гүтгэж болдог юм бэ? Хуучин хуульд байсан юм. Ноцтой гэмт хэрэгт, онц ноцтой гэмт хэрэгт бол 2-3 жилийн ялтай байсан байхгүй юу. Одоо хүн алаад булчихсан

гэхэд ямар ч ял авахгүй байна шүү дээ. Энэ чинь болохгүй шүү дээ. Яаж болох юм бэ?

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Өнөөдөр манай ардчилсан парламент өдөржингөө л үг хэлэх эрхийг хааж боох, 30 хоногоор саатуулах, барих л юм ярилаа. Эхлээд Улсын Их Хурлын гишүүдийнхээ үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг халдах талаар өдөржингөө яриад одоо сэтгүүлчдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг яаж барьж хорих вэ гэдгээ ярьж эхэллээ.

Энэ чинь ийм байдаг юм аа Даваасүрэн гишүүн ээ манай энэ сэтгүүл зүйн салбар гүтгэх эрх чөлөө өгөөдөх, Эрүүгийн хуулиас бүүр байхгүй болгоодох гээгүй. Гүтгэхгүй байх эрх чөлөөг өгөөч ээ гэж гуйгаад, намайг залуу байхаас хойш гуйгаад би өнөөдөр энд ингээд энэ суудал энэ хууль, эрх зүйн орчныг зохицуулж өгч чадахгүй байгаа байхгүй юу. Ард түмний үнэнийг мэдэх эрх энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний ард байдаг. Энэ хамгийн энэ ардчиллын хамгийн нандин хэл. Энэний яг эсрэг талд нь эрх баригчдын бүхнийг нуух, эрх мэдлээ хэтрүүлэх тэр сэрэл сэрэхүй байж байдаг юм. Хүн гүтгэсэн бол тэр хүн ямар нэгэн байдлаар буруудах ёстой. Энийг огт буруудахгүй ямар ч ял авахгүй гэж хэлээгүй шүү дээ. Хамгийн гол нь энэ дээр яг үнэнийг эрэлхийлдэг, мэргэжлийн сэтгүүл зүй, мэргэжлийн редакцуудын эрх ашиг хөндөгдөөд байдаг юм.

Та нар 2008 онд санаж байгаа биз дээ. Онц байдал зарласан 4 хоногт ганцхан үндэсний телевизээс өөр ямар ч хэвлэл мэдээлэл байгаагүй шүү дээ. Тэгэхэд ямар байсан? Монголын ёс зүйтэй мэргэжлийн сэтгүүлчид ЖДҮ хулгайг чинь илрүүлж өгсөн. Боловсролын зээлийн сангийн чинь хулгайг илрүүлж өгч байсан. Дэлхий дээр эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбоо оффшор данс гэдэг юмыг дэлхий дээр дэлбэлж өгч байсан. Энийг сэтгүүл зүй, энийг үнэнийг мэдэх эрх гэдэг юм. Битгий энэ дотор зүгээр троллуудын энэ эрх мэдэлтнүүдийн хөлсөлж авдаг, гүтгэдэг юмыг манай салбартай битгий холбож ойлгож ийм ташаа байгаарай. Таны хэлээд байгаа тэр өндөр ялтай гүтгэсэн зүйл ангиуд ямар улсад хэрэгждэг вэ гэвэл тэд үнэнийг мэдэх эрхтэй, сурвалжлах эрхтэй байдаг юм. Өнөөдөр нийтийн албан тушаал хашиж байгаа эрх мэдэлтэн, улс төрч болсон хүмүүст ерөөсөө нууц гэж байх ёсгүй. Асуусан мэдээлэл болгоныг өгч байх ёстой. Хувийн нууц ч гэж байх ёсгүй. Тэгсэн газар гүтгэх эрх чөлөө хаагддаг байхгүй юу. Хүн гүтгэх боломжгүй болдог юм. Тэр үед бид нар энэ тухай ярьж болно. Тэгээгүй өнөөдөр зүгээр өөртөө дургүй санагдсан сэтгүүлчийг барьж хорьдог энэ цаг үед бид нар энэ хуулийг гарцаагүй энэ Үндсэн хуулийн цэцийнхээ дүгнэлтийн талд зогсоод 13.14-ийг байхгүй болгоод харин Засгийн газар нь тэр асуудлаа оруулж ирэх эрхийг нь нээлттэй үлдээх ёстой байхгүй юу даа.

Өөрт тохиолдсон жишээгээ ярья. Би нэг том улс төрчийн оффшор дансыг хэд хэдэн газар байдаг хөрөнгөтэй нь дэлгэсэн. Намайг тухайн үедээ хүн гүтгэж байна гэсэн. 8 жилийн дараа дэлхий нийт дэлхийн 6 орон дээр тэр хүний хөрөнгийг царцаасан. Өнөөдөр Америкийн Нэгдсэн Улсруу орох эрхгүй тэр хүн. Тэгээд яах юм 8 жилийн өмнө би ял авах ёстой байсан уу? Манай Өдрийн сонинд бас Соёлын гавьяат зүтгэлтэн Дашцэрэн гэж хүн байсан. Одоо талийгаач болчихсон. Энэ хүн

гаалийн хулгайг илрүүлж байсан. 5 жилийн дараа гаалийн хулгай илрээд, хүн нь, гаалийн дарга нь шоронд орж байсан ийм түүхтэй.

Тэгэхээр хэсэг бусаг троллууд, хэсэг бусаг ёс зүйгүй хүмүүс улс төрчдийн захиалгаар явдаг хүмүүсийн ард Монголын сэтгүүл зүйг булшлахыг бид нар өнөөдөр энэ ардчилсан парламент дотор ярихыг зөвшөөрч болохгүй. Ялгаж салга. Үгүй ээ мэдээлэх, сурвалжлах эрхийг нь нээгээд өг л дөө. Бүх юм нь хаалттай байгаа шүү дээ. Бүх мэдээлэл нь хаалттай. Та хэрвээ Улсын Их Хурлын гишүүн бол танд хувийн нууц гэж байх ёсгүй. Харин жирийн иргэн хувийн нууцтай байх ёс.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Мөнхбаясгалан гишүүн тодруулж асуултаа асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Хэрвээ та нийтийн албан, тушаалтан улс төрч болж байгаа бол тийм эрхгүй байх ёстой шүү дээ. Тэрийгээ татгалзах ёстой. шүү дээ. Тэгж байж та зөв мэдээллийг ард түмэнд өгөх ёстой. Өнөөдөр яадаг та нар мэдээлэл өгдөггүй, бүх юмаа нууц гэдэг. Дуртай дээр нь нууцын тэмдэг дардаг. Тийм учраас энд чинь ард түмний мэдэх эрх зөрчигдөөд байгаа юм. Бид нар хүн гүтгэх эрх чөлөө хүсээгүй юм. Чөлөөтэй ажиллах, үнэнийг ард түмэнд мэдээлэх эрхийг хүсээд байгаа юм. Үгүй ээ харин тэгээд энийгээ хий л дээ. Юун түрүүнд барьж хорихоо битгий эн тэргүүнд тавиад бай. Засгийн газарт асуудлыг нь нээлттэй тавиад Засгийн газар тэр хуулиа бариад ороод ирэг. Одоо бол бид нар, одоо бол бид нар 13.14-өө л хүчингүй болгочихъё. Биш ээ Даваасүрэн гишүүн та буруу ойлгоод байна. Та хүний ялгаж байгаа, ялгахгүйг та яаж мэдэж байгаа юм? Монголын ард түмэн үнэн, худлыг ялгахгүй байна гэж яаж хэлж чадаж байгаа юм? Би бол ард түмэнд итгэдэг.

**С.Бямбацогт:** Үгүй ээ үнэн, худлыг, зөв, бурууг, хар, цагааныг, ус тосыг ялгах л ёстой л доо. Тийм ялгах ёстой. Тийм нийтийн албан тушаалтны алдаа, дутагдлыг асуудлыг шүүмжлэх, мэдээлэх, нийтлэх бол нээлттэй байх ёстой. Түүний төлөө бол тэр хэвлэж, мэдээлж нийтэлж байгаа хүмүүс хариуцлага хүлээхгүй байх ёстой.

Нөгөө талдаа хүнийг гүтгэж гутааж, нэр төр, алдар хүндийг нь доромжилж байгаа улсууд дээр хариуцлага байх ёстой. Энийгээ л ялгая гээд байгаа шүү дээ. Ялгахгүй хоёуланг нь яриад л байгаа шүү дээ. Одоо болноо гишүүд ээ. Энийгээ ялгаж салгах ёстой шүү. Одоо Их Хурлын гишүүдийг ч гэсэн хуулиа битгий зөрч өө, бие биеэ битгий гүтгэ ээ, битгий бие биеийнхээ нэр хүнд, алдар хүндийг гутаа, бас төрийнхөө нэр хүндийг бодоо гэдэг л асуудал ярьж байгаа шүү дээ. Хэрвээ ингээд хуралдаа суу, ажлаа хий, санал хураалтдаа оролц, оролцохгүй бол ёс зүйн хариуцлага хүлээнэ шүү гээд ингээд ярихаар амыг нь хаах гэлээ, барих гэлээ гэж ярьдаг чинь жоохон хэтэрхий л бас мушгиж байна шүү дээ Мөнхбаясгалан гишүүн ээ. Бас ингэж мушгиж туйлширч болохгүй шүү та бас.

Хуралдаан даргалагч биш Ёс зүйн дэд хороо урьд нь Ерөнхийлөгчийн оруулж ирсэн хууль байж байгаа шүү дээ. Хуралдааныг 30-аас дээш хувьд нь суухгүй бол эгүүлэн татна гээд. Бид нар 50-аас дээш хувьд нь суухгүй бол ёс зүйн асуудал ярьга гэж байгаа. Энийгээ бас ялгаад салгаад бас нэг жоохон мушгиж бас хэтрүүлж, гуйвуулж ярих хэрэггүй шүү бас.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Г.Ганбаатар:** Хэвлэл мэдээллийн салбарынхан ч нэг талаасаа иргэд, олон нийтийн мэдэх эрх, нөгөө талдаа, нөгөө талаасаа энэ төрийн байгууллага өндөр албан тушаалтнуудын үйл ажиллагаа нь ил тод байна уу гэдэг ийм л ашиг сонирхлын зөрчил дээр л ажилладаг л салбар л даа. Энэ хууль орж ирсэнтэй холбоотойгоор би бас нэлээн судалсан. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хуулиудыг судалж үзсэн. Жишээ нь, Герман улсад худал мэдээлэл тараах, хүн гүтгэх асуудлыг бүүр маш нарийн ялгаад заачихсан байдаг юм билээ.

Ялангуяа доромжлох, нотлогдоогүй мэдээлэл тараах, санаатай гүтгэх, худал хэрэгт буруутгах гээд бүүр ингээд өөр өөр түвшинд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг л юм билээ л дээ. Манай энэ одоо оруулж ирж байгаа, ажлын хэсгээс оруулж ирж байгаа хуулийн төслийн энэ зохицуулалтыг харахаар худал мэдээлэл тараах, гүтгэх хоёрыг яг бүүр маш тодорхой зааж оруулж ирсэн юм уу? Нөгөө талдаа энэ манай оронд ялангуяа Ром, Германы эрх зүйн бүлд хамаарах энэ манайтай төстэй хууль, эрх зүйн орчинтой энэ бусад улсад яг ямар байгааг судалж үзсэн үү гэдэг асуулт ажлын хэсгээс асуух хэрэгтэй байна.

**С.Бямбацогт:** Тэмүүжин гишүүн ажлын хэсэг хариулъя.

**Х.Тэмүүжин:** Бид бол энэ чиглэлийн гэмт хэргүүдтэй холбоотой судалгаануудыг бол нэлээн нарийвчилж хийсэн. Гэхдээ одоо чуулган дээр оруулж ирж байгаа бол бид ямар нэгэн гэмт хэрэгтэй холбоотой хуулийн төслийн санал оруулж ирээгүй. Зөвхөн Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт дурдагдсан Эрүүгийн хуулийн зохих заалтыг хүчингүй болгох зохицуулалт бол оруулж ирж байгаа.

Харин Засгийн газарт үүрэг, чиглэл өгөхдөө энэ энийг анхаараарай гэдэг байдлаар нэлээн дэлгэрэнгүй бичиж байгаа. Тухайлбал, дараах тохиолдолд гүтгэх гэмт хэрэг гэж үзэхгүй ээ гэж хууль тогтоогчийн тайлбар байдлаар ...тантик тайлбар гэж хэлдэг. Нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг хөндөж, үзэл бодлоо илэрхийлэх бол энэ бол гүтгэх гэмт хэрэг биш шүү. Нийтдээ албан тушаал эрхэлж байгаа, эс үгүй бол эрхэлж байсан хүнийг албан тушаал, үйл ажиллагаатай нь холбогдуулан шүүмжилсэн бол энийг гүтгэх гэмт хэрэгт хамаатуулж бас бичиж болохгүй шүү.

Олон нийтэд ил тод болсон эх сурвалж, эс үгүй бол үнэн бодит баримтад тулгуурласан, эс үгүй бол мэдээллийг нягталж шалгасны үндсэн дээр тухайн үедээ үнэн гэж үзэх хангалттай бодит үндэслэлтэй байсан бол энийг гүтгэх гэж бас тооцож болохгүй шүү. Үйл баримтын шинжтэй мэдээлэлд үндэслэн илэрхийлсэн үнэн, худлыг тогтоох боломжгүй үнэлэлт дүгнэлт, эс үгүй бол уг мэдээллийн тоо утга, бодит байдлаас зөрүүтэй боловч тухайн мэдээллийн үндсэн агуулга, утга санааг өөрчлөх хэмжээнд хүрээгүй бол гүтгэсэн гэж үзэж, эс үгүй бол худал мэдээлэл гэж үзэж болохгүй шүү. Нийгмийн сүлжээ цахим хуудсанд бусдын нийтэлсэн, байршуулсан мэдээллийн агуулгыг өөрчлөхгүйгээр дахин түгээсэн, эс үгүй бол уг мэдээллийн талбартаа тайлбартай нийлэхдээ энэ зүйлд заасан зорилго, сэдлээр хувиргаж, эсвэл баталж илэрхийлснээс бусад өөрийн хувийн байр суурь, үзэл бодлоо илэрхийлсэн, түгээснийг гүтгэх гэмт хэрэгт тооцож болохгүй шүү.

Бусдын гэмт хэрэгт үйлдсэн гэж мэдээллийг олон нийтэд тараасан этгээд нь тухайн гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэж шалгаж байгаа Эрүүгийн хэргийн гэрч болсон бол бас гүтгэсэн гэж энэ зүйл, заалтаар татаж болохгүй шүү гэх мэтчилэн ийм нарийвчилсан тайлбаруудыг хууль тогтоогч хийж өгч байж сая энэ гүтгэх гэмт хэргийн ард хүн хэлмэгдүүлэх, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хязгаарлах, ямар нэгэн байдлаар өөр эх сурвалжийн мэдээллийг зүгээр түгээснийхээ төлөө энэ гэмт хэрэгт татагдаж холбогддог гэх мэтчилэн энэ гажуудаад байгаа энэ хуулийн байгууллага дотор хууль буруу хэрэглээтэй болоод байгаа үйл явдлыг бол зогсоох юм байна гэж харж байгаа. Гэхдээ Засгийн газар энэ зүйлүүдийг анзаарч, анхаарч хуулийн төслөө боловсруулж оруулж ирээрэй гэж хэлж байгаа.

Ер нь бол яг энэ гүтгэх, худал мэдээлэл тараах, гэмт хэрэгт холбогдуулж гүтгэх, үнэн байсан ч гэсэн хувийн нууцтай холбоотой мэдээллийг бусдын нэр төрийг гутаах зорилготойгоор тараах гэх мэтчилэн энэ үйлдлүүд бусад улс оронд бол тус тусдаа гэмт хэрэг байдаг юм байна лээ гэдгийг бол бид бол маш тодорхой илэрхийлж байгаа. 2015 оны Эрүүгийн хуулиар ч гэсэн зарим төрлийн гэмт хэргийг нь гүтгэхээс салгаж бас хуульчилсан байгаа.

**С.Бямбацогт:** Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**Г.Ганбаатар:** Тодруулж асуух ч юу байх вэ ер нь би бас өөрөө цагтаа нэг сэтгүүлч нөхөрт бас бас гүтгүүлээд хэлмэгдэж л явсан хүн л дээ. 10-аад жилийн өмнө л дөө. Тэгээд яах вэ тухайн үедээ би хэвлэл мэдээллийн ёс зүйн зөвлөл ч билүү мэдээллийн Хэвлэл мэдээллийн зөвлөл ч билүү тэрэнд нь хандаад бас нэлээн тэднийхэн нь бас нэлээн сүрхий хариуцлага тооцоод тэр хүн чинь надаас сүүлдээ уучлал гуйгаад л юм хум л болж байсан. Зүгээр яах вэ цаашдаа ингээд хэвлэл мэдээллийн чинь 4 дэх засаглал гээд байдаг. Тэгээд шууд Эрүүгийн хуулиар явах нь хэр зохимжтой юм бол оо? Яг ингээд хэвлэл мэдээллийнх нь худал мэдээлэл тараасан хэвлэл мэдээллийн байгууллага юм уу, редакц нь байх юм бол өөрсдөө хариуцлагаа хүлээдэг. Хувь хүн, хувь сэтгүүлч байх юм бол тэр дотоод зохицуулалт тэр Хэвлэл мэдээллийн зөвлөлд нь хандаад, эсвэл Иргэний хуулиар ч юм уу ингээд явчхаж болдоггүй юм уу? Ер нь сэтгүүлчид Эрүүгийн хуулиар хандахаасаа илүү өөрийнх нь тэр дотоод зохицуулалт, хэвлэл мэдээллийн байгууллага чинь сэтгүүлчдийн холбоо, зөвлөл гээд байдаг биз дээ энэ чинь? Нэг дотоод бас нэг тийм аудит, хяналт тэр.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Гүйцээгээд яачих уу? Болсон уу? Тэгвэл Дамдины Цогтбаатар гишүүн. Ганбаатар гишүүн.

**Г.Ганбаатар:** Тэгээд ингээд сэтгүүлчид Эрүүгийн хуулиар хандахаасаа илүүтэй ингээд өөрийнхөө тэр дотоод механизмыгаа сайн ажиллуулдаг байвал энэ хэвлэл мэдээллийн хараат бус байдал чинь арай хангагдах юм биш үү? Хэрвээ энийгээ ингээд Эрүүгийн хууль руу ингээд оруулаад явчих юм бол энэ чинь нөгөө манай улс ч гэсэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөгөөрөө олон байр ухраад байгаа ч юм уу үүнтэй холбоотой юм биш үү гэсэн ийм саналыг хэлэх байна. Баярлалаа

**С.Бямбацогт:** Хариулах уу? Тэмүүжин гишүүн хариулъя.

**Х.Тэмүүжин:** Ажлын хэсэг дээр бас энэ тухай нэлээн дэлгэрэнгүйгээр яригдсан. 1992 оны Үндсэн хуулиар Монгол Улсад өөрөө удирдах ёс гэж өөрийн засаглал, өөрийн зохион байгуулалтын зарчмыг бол хуульчилсан. Энэ өөрөө удирдах ёсны байгууллагууд нутгийн удирдлагын хэлбэр дээр байж болно. Төрийн бус байгууллагууд өөрөө удирдах зохион байгуулалтыг хийж байгаа. Иргэний нийгмийн институцүүд өөр төрийн удирдах зохион байгуулалтыг хийж байгаа. Дээр нь ардчилсан чөлөөт улсад бас нэг маш чухал нэг ойлголт байдаг бол энэ өөрийн зохицуулалт гэдэг нэг ойлголт байдаг. Заавал бүх харилцаа төрийн зохицуулалттай байх албагүй. Энэ өөрийн зохицуулалт гэдгийг ярьдаг хамгийн жишиг болсон 4, 5 салбар байдаг. Хуульчдын өөрийн зохицуулалт байна, сэтгүүлчдийн өөрийн зохицуулалт байна, багш, эмч нарын өөрийн зохицуулалт байна.

Тэгээд энэ сэтгүүлчдийн өөрийн зохицуулалтыг заавал төрийн зохицуулалтгүйгээр асуудлаа шийдэх чадвартай байх тухай яриаг бол бид бол ярилцсан. Сэтгүүлчид мэргэжлийн өөрийн зохиц.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Дамдины Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

**Д.Цогтбаатар:** Би асуулт асуухгүй ээ үг хэлнэ. Энд нэг ийм юм байгаа юм. Ер нь бол сэтгүүлчидтэй би бол яг энэ асуудлыг яригдаж байхад мэдээж сэтгүүлчид орж ирж уулзсан. Тэгээд нэг юмыг маш тодорхой хэлсэн. Ийм гүтгэх, хуулийн зохицуулалтгүй, худал мэдээлэл тараах хуулийн зохицуулалтгүй орон гэж байж болохгүй. Сэтгүүлчдээсээ айгаад энийг аваад хаячихсан тийм улс ерөөсөө байж болохгүй. Ийм хууль орж ирнэ ээ гэдгийг бүүр эхнээсээ маш тодорхой хэлсэн. Сэтгүүлчид ч нэг юмыг маш тодорхой ойлгож байгаа.

Юу гэвэл бид нар хүн гүтгэх гээгүй ээ. Биднийг хүн гүтгэвэл тэрийг юу чөлөөлөөд өгөөч ээ гэж тэд ерөөсөө гуйгаагүй байхгүй юу. Эд нарын яриад байгаа юм нь юу гэхлээр үгүй ээ энэ асуудлыг шалгаж байгаа нь энэ гээд түрүүн Тэмүүжин гишүүн яг ярьж байна лээ процессыг нь жишээлбэл хууль дээрээ аягүй тодорхой юм ярьж байгаа юм. Энэ юмнуудаа та нар оруул аа. Гэхдээ процессын хууль дээрээ та нар өөрчлөлт оруулахгүй бол бид нарыг шалгаж байгаа нэрээр аль хэдийн шийтгээд хаячихдаг. Сүүлд нь бид нар гүтгээгүй байсан ч аль хэдийн бид хохирчихсон байх гээд байна. Ийм л юм ярьж байгаа юм.

Тэгээд сэтгүүлчидтэй яг энэ дээр нь ойлголцоод энэ бол заавал орж ирнэ шүү. Энэ хууль бол зайлшгүй манай улсад байх ёстой хууль гээд. Тэр бусад орны жишээнүүд яриад л байна. Герман, Грек, Итали гээд л Япон гээд орнуудад энэ гүтгэх чинь гэмт хэрэг байхгүй юу. Бүүр тодорхой зүйл, ангитай. Германд бол тэр ... гээд эс үгүй бол энэ бол яг гүтгэх гэмт хэрэг, эс үгүй бол ... гэдэг нь бол доромжлох гэм энэ тэр гээд тэгээд энэ бол бүүр яг эрүүгийн хэргүүд байхгүй юу.

Тэгэхлээр энэ дээр бол бид нар энэ хууль бол орж ирнэ. Тэгэхдээ засаг руу яагаад явуулж байгаа гэхлээр ажлын хэсгээс орж ирж байгаа юм тэр процессын хууль орж ирээгүй. Тэгэхлээр энийг нь оруулахаас өөр үггүй 1 дүгээрт.

2 дугаарт, манайхан нэг юмыг энд бодоорой. Энэ Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжээд эхэлчихсэн байгаа. Улсын Их Хурлын тухай хуульд ч гэсэн заачихсан байж байгаа. Энэ Эрүүгийн хуулийн асуудлыг бол зөвхөн Засгийн газар

санаачилна гээд заачихсан байж байгаа байхгүй юу. Хууль тогтоомжийн тухай хууль дээр бол энэ Эрүүгийн тухай аливаа хууль орж ирж байгаа бол энэ үзэл баримтлалынх нь төслийг бол зөвхөн энэ асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн энэ үзэл баримтлалыг нь батална гэж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ үйлчилж байгаа хуулиудаа бид нар юу зөрж явчих гээд байгаа байхгүй юу. Түрүүн тэр Энхтүвшин гишүүн ярьж байна лээ. Энэ үйлчилж байгаа хуулиа зөрчих гээд байгаа юм уу гэхэд таны тэр зөрчиж болзошгүй болзошгүй гүй гэж байгаа хууль дээр чинь нэмээд би энэ хуулиудыг хэлчихмээр байгаа юм.

Тийм учраас Засгийн газар харин болгоомжлоод энэ дээр айгаад юм уу оруулж ирэхгүй байж болохгүй ээ. Би Их Хурлын даргыг ч гэсэн энэ дээр та энд бидэнтэй нэгдээд манай Байнгын хороо ч гэсэн энэ заавал оруулж ирээрэй гэж байгаа. Оруулж ирэхгүй байж болохгүй. Гэхдээ энэ дээрээ маш тодорхой байхгүй бол нээрээ эрх мэдэлтнүүд энийг харагдахгүй өөр замаар нөгөө сэтгүүлчдийг хашраах, гэсгээх ийм боломжийг л үлдээхгүй байх ёстой.

Тэгэхлээр тэр үгээ хэлэх эрх чөлөө, шүүмжлэх гэдэг чинь бол үгээ хэлэх эрх чөлөөний асуудал. Гүтгэх гэдэг бол сэтгүүлч ч хэн ч гүтгэж болохгүй. Монгол улсад ямарч иргэн үндэслэлгүйгээр өөр нөгөө иргэнээ гүтгэж болохгүй. Тийм учраас нөгөө иргэний эрхээр нөгөө хүний эрх чинь хязгаарлагдана гэдэг энэ агуулгыг бол тал талдаа ойлголцоод Засгийн газар руу энэ юмаа явуулъя. Тэгээд оруулж ирдэг газар нь оруулж ирэх ёстой гэж ярьж байгаа юм.

Тэгээд өшөө энэ дээр яагаад яг хүчингүй болгох юун дээр бас гишүүд дэмжсэн болов уу. Яагаад гэвэл гишүүд бол саналаа өгөөд л энийг дэмжсэн шүү дээ. Тэн дээр юу вэ гэхлээр хоёр саналд хоёуланд нь хуулийг бол хүчин төгөлдөр, хүчингүй болгоё гэдэг санал орж ирсэн хоёуланд нь. Тэгээд тэр санал нь дэмжигдээд л дараагийнх нь бол Засгаас заавал орж ирэх ёстой. Энийг бол харин шахаж ажиллах ёстой. Хаврын.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Тэгэхээр Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч нар Засгийн газраас орж ирэх ёстой. Тийм учраас энэ бол алга болоогүй. Гүтгэх гэмт хэрэгт хариуцлага тооцох ёстой. Худлаа мэдээлэл тараах гэмт хэрэгт хариуцлага тооцох ёстой. Харин нийтийн албан тушаалтныг шүүмжлэх, алдаа дутагдлыг нь нийтлэх, хэвлэх бол хариуцлага тооцохгүй байх ёстой гээд ялгачихсан. Энийгээ ялгаж салгасан хуулиа Засгийн газар оруулж ирэх ёстой гэж хэлээд байна шүү дээ тийм ээ.

Тийм болохоор Байнгын хороо энэ асуудлаа Засгийн газарт чиглэл өгсөн тогтоол байх юм уу, одоо эцсийн хэлэлцүүлгүүд энийгээ тодорхой хугацаат оруулж ирээд бас юугаа оруулж ирээрэй. Тэмдэглэлээр үүрэг өгье. Энийг Хууль зүйн байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг дээр бас анхаараарай гэдгийг бас энд чиглэл болгоё.

Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултаа асууя.

**П.Наранбаяр:** Энэ асуудал дээр баярлалаа. Тэгэхээр энэ асуудал дээр бас энэ сэтгүүлчидтэй уулзаж үзсэн, ярилцаж үзсэн. Өнөөдөр бас Тэнгэр телевизийн хэлэлцүүлэгт бол оролцсон. Тэгээд бас дефакто хэлэлцүүлэг энэ тэр гээд оролцоод ингээд явж байхад нэг ажиглагдаж байгаа зүйл бол энэ сэтгүүлчид бол

энэ гүтгэх, худал мэдээлэл тараах гэдэг энэ 2020 онд нэмэлтээр оруулсан энэ дээр бол маш их тийм шүүмжлэлтэй, айдастай.

Энэ ямар учиртай вэ гэхээр жишээлэх юм бол би нэг жишээ хэлье л дээ. Тухайлбал, нэлээд хэдэн жилийн өмнө Архангай аймгийн Засаг даргыг ажлаа аваад удаагүй байхдаа 15 удаа гадаадад аялчихсан байна, явчихсан байна гэсэн ийм юм бичсэн сэтгүүлчид хэрэг үүсгэчихсэн. Юу гэсэн бэ гэхээрээ үгүй ээ яг тооцоод үзсэн 13 удаа явсан байна. Чи 2 удаа нэмж бичсэн байна. Намайг гүтгэлээ гээд тэгээд л шийтгээд хаячихсан.

Тэгээд ингээд харахаар яг энэ хууль гармагцаа 20, 21 онуудад бол 32 сэтгүүлч хэвлэл мэдээллийн ажилтан, албан хаагчдын эрүүгийн гэмт хэрэгтэн болчихсон байгаа байхгүй юу. Энэ чинь манай нөгөө үг хэлэх, өөрийгөө илэрхийлэх тэр эрх чөлөөг л боомилсон ийм л юм болчихсон байсан гэдэг нь л харагдаад байгаа юм. Хэрвээ түрүүн Тэмүүжин гишүүн хэлж байна, Цогтбаатар гишүүн ч хэлээд байна энэ процедурыг нь нарийн болгох ёстой гээд. Энэ чадахаар бол сайн л байна.

Энэ дээр бас нэг зүйл яахад бид заавал энэ ингээд энэ чинь 30-хан жил болж байгаа ардчилал шүү дээ. 30 гаруй жил л болж байгаа хэвлэлийн эрх чөлөө шүү дээ. Энэ үед заавал ингэж Эрүүгийн хууль руу татаад байх ер нь ямар хэрэг байна гэж. Өөрөөр хэлэх юм бол энэ чинь нэр төр алдар, хүнд бол хүний хувийн эдийн бус баялаг гэдгийг Иргэний хууль ч гэсэн заачихсан байгаа шүү дээ. Иргэний хуулиараа тэр өндөр торгууль руу нь, өндөр торгууль биш өндөр тэр тэр хүнээс нь миний нэр хүнд рүү халдлаа гээд ингээд хоорондоо шүүхдэлцэх энэ Иргэний хуулиараа бүрэн шийдээд явах юм нь эрх чөлөө нь байж байгаа шүү дээ. Энийг яагаад энэ цаад тал энэ тал руу нь илүү оруулж ирж Иргэний хууль талаас нь илүү ярихгүй байна хүмүүс ээ. Ингэхгүй бол бид ингээд л торгуулаад л яагаад л янз бүрийн эрүүгийн ийм юм руу оруулаад байвал энэ хэдэн сэтгүүлчид чинь тэгээд сүүлдээ бүр дуугарахаа ч болиод ингээд эхэлнэ.

Тэгэхээр зэрэг энэ асуудал дээр бас миний зүгээс бол юу гэж хараад байна вэ гэхээрээ зэрэг энийгээ бид бас яг одоо Иргэний хуулийн энэ заалтуудыг л амилуулж шүүхэд нь шууд тэр хүний хэргийг нь үүсгүүлээд ингээд хоорондоо ингээд мэтгэлцээд явах боломжийг л олгох боломж энийг л хийх хэрэгтэй байна шүү дээ.

Би бол хүн гүтгэх, худал мэдээлэл тараахыг бол ерөөсөө хүлээн зөвшөөрөхгүй. Хувь хүний хувьд ч хүлээн зөвшөөрөхгүй. Ийм нөхцөл байдал дунд ингээд бие биеийгээ гүтгээд ингээд тэгээд гүтгүүлсэн хүн нь хохироод явж байдаг гэвэл зөвшөөрөхгүй. Энийг бол ёстой Иргэний хуулиар яс үзэлцэх хэрэгтэй. Иргэний хуулиараа л энэ нэг хүнийг тэгж байгаад эхлэх юм бол тэр өндөр хэмжээний хохирлоо, нэр төрөө сэргээлгэх, тэр эдийн бус баялгаа сэргээлгэх ийм юм руугаа ороод ирвэл манай нийгэм илүү л баялаг болно шүү дээ.

Тэрнээс биш ингээд энэ заалт Үндсэн хуулийн цэцийн энэ заалтыг ингээд заавал Эрүүгийн хууль дээр нь үлдээх ёстой энээ тэрээ гээд яагаад байх явдалгүй. United States буюу Америк ч гэсэндээ энэ Эрүүгийн хууль дээр энэ байдаггүй ч гэсэн Иргэний хуулийнхаа зарчмаар бол маш өндөр ийм эд баялгийнх нь юу гэдэг юм нэр төрийг нь сэргээлгэх энэ зардлыг гаргуулж л байна шүү дээ.

Тэгэхээр энэ утгаараа ингээд явж болоогүй юм уу? Ийм учраас энэ Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг бол энэ Улсын Их Хурал шууд хүлээгээд авчих л хэрэгтэй гэж үзэж байна.

Процедурын асуудал бол нарийн ширийн юмнууд ярина биз. Миний бодлоор бол энэ бол бид бас ухралт хийж болохгүй ээ. 20 он шигээ ухралт хийж болохгүй. Бас энэ хэвлэл мэдээллийнхээ эрх чөлөөг бас хангах тал дээр бид бодох ёстой гэж бодож байна. Тэгэхдээ би дахин хэлье. Хувь хүний энэ нэр төр гэдэг бол эдийн бус баялагт тооцогдоно. Энэ Иргэний хуулиараа яваг гэж бодож байна.

**Б.Пүрэвдорж:** Хэн хариулах вэ? Цогтбаатар дарга эхлээд хариулчихъя. Эхлээд Тэмүүжин гишүүн хариулчихъя.

**Х.Тэмүүжин:** Өнөөдөр Улсын Их Хуралд оруулж ирсэн хувилбар бол Эрүүгийн хуульд байгаа тэр зүйл, заалтыг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулаад Үндсэн хуультай нийцээгүй гэдэг заалтаа л хүчингүй болгох л хувилбар нь орж ирсэн. Тийм учраас таны ярьж байгаа хувилбар одоо энэ санал хураалтаар баталгаажих гэж байна гэсэн үг.

Энэ санал хураалттай холбогдуулаад Засгийн газарт бол тодорхой үүрэг, чиглэл өгч байна. Яагаад гэвэл бид тодорхой тоо баримт ярихаас өөр арга байхгүй. Шүүхээр шийдэгдсэн хэргийн чинь бараг 80, 90 хувь нь иргэд хоорондын маргаан байна. Гүтгэснээс холбоод гэр бүл салсан байна, ажлаасаа халагдсан байна, эд хөрөнгөөрөө хохирсон байна, аж ахуйн нэгжээ дампууруулсан байна. Энэ сэтгүүлчтэй огт холбоогүй үйл ажиллагаанууд байна. Иргэдийн эрх, өмч, амьдрал өөрөө энэ үйл явдлын чинь ард сүйрч байна.

Тийм учраас Үндсэн хуульд заагдсан нэр төр халдашгүй байх, иргэн эрхээ эдлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах гэдэг Үндсэн хуулийн энэ заалтыг ут амьдрал дээр баталгаатай хэрэгжүүлье гэх юм бол ялт ч үгүй ямар нэгэн байдлаар хариуцлагын тогтолцоо ажиллах ёстой юм байна гэдэг л ийм зүйл яригдаж байгаа юм.

Энэ дээрээ Засгийн газар өөрөө бодлогоо бод оо, асуудлаа шийд ээ. Энэ бол Засгийн газрын үүрэг байна. Ер нь бол түрүүн Цогтбаатар гишүүн ч ярилаа Эрүүгийн хуулийг санаачлах гэж Эрүүгийн хуулийн санаачлах гэхээс илүү нөгөө ялын бодлого. Эрүүгийн хууль дээр байгаа хамгийн гол тулгуур бол ялын бодлого бол Засгийн газрын чиг үүрэг шүү. Улсын Их Хурлын гишүүд ялын бодлогыг дээш, доош татах хууль санаачилж болохгүй ээ гэдэг энэ зарчимтай бол бид бас санал нэгтэй байгаа.

Тийм учраас Засгийн газар энэ хүрээн дээрээ судалгаагаар нарийн хий, хэлэлцүүлгээ сайн өрнүүл, олон нийтдээ бас ойлголтоо сайн өг, тэгээд хуулиа оруулж ир. Орж ирж байгаа хууль дээр чинь бид нар нэг л цензур тавина шүү. Энэ нь юу вэ гэхээр Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлтийг хүлээн авч байсантай холбогдуулаад оруулж ирж байгаа хууль чинь иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж болохгүй шүү. Сэтгүүл зүйн чөлөөт байдлыг үгүй хийж болохгүй шүү. Сэтгүүлчдийг албан тушаалтнууд эрүүгийн хуулийг ашиглах байдлаар цээрлүүлдэг, айлган сүрдүүлдэг, шүүмж дуу хоолойг нь боомилдог, бусдад нь

үзүүлэн болгож та нар ингээд үзээрэй гэж энэ сүрдүүлэг хийдэг үйл явдлыг өөгшүүлэх юм уу, түүнийг хэрэгжүүлэх гэж байгаа бол энэ хуулийг чинь бид нар хэмжих хэмжүүрээрээ тодорхой барьж байгаад хатуухан шиг шүүн хэлэлцэнэ шүү л гэж хууль тогтоогчийн зүгээс үзэж байна л гэдэг энэ байр суурийг илэрхийлж байгаа юм.

Цогтбаатар гишүүн, дарга, Байнгын хорооны дарга Цогтбаатар нэмэлт тайлбар өгье.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Энэ Тэмүүжин гишүүн яг сая хэлэх гэснийг хэлчихлээ. Энэ нөгөө иргэд хоорондын гол нь яг шүүх дээр очсон юун дээр бол сэтгүүлчид аягүй цөөхөн. Иргэд хоорондоо гүтгээд байгаа энэ тэгээд зохицуулалтгүй үлдчих гээд байгаа байхгүй юу. Нэг.

Хоёрт, энэ дээр нэг зүйлийг харин бид нар мартаггүй байх ёстой. Энэ бол энэ улс 37 он гэдэг үзэгдлийг үзээд туулаад гарсан шүү дээ. Энэ чинь бол ёстой харин гүтгээд тэрний дагуу хэчнээн хүн амь үрэгдсэн. Тэгэхлээр тэгж хүнийг бүр яллаад, цээрлүүлээд, амийг нь үрэгдүүлэх хүртэл тийм хэмжээнд гүтгэж байгаа хүмүүс зүгээр торгууль авах ч юм уу, ял эдлэхгүй ч юм уу тийм юм гэж бол ёстой байж болохгүй. Тэгэхээр тэр утгаараа бид нар энэ түүхэн дурсамжаа бас санах хэрэгтэй.

Нөгөө талаасаа Америкт байдаггүй юм шиг яриад байна. Америк 50 Эрүүгийн хуультай орон гэсэн үг шүү. Тэр.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсэг юм уу? Лодойсамбуу гишүүн нэмэлт тайлбар өгье.

**Ч.Лодойсамбуу:** 1937 оны тэр сорчилж хядсан хядлагыг гүтгэлэгтэй холбож бас болохгүй байх аа. Ер нь бол Наранбаяр гишүүнтэй бол санал нэг байна. Санал нэг байна. Ер нь одоо Эрүүгийн хуулиар шийднэ гэдэг нь юу гэж байгаа юм гэхээр энд нэг иргэн гомдол гаргаад намайг гүтгэчихлээ гэнгүүт төр нь хүлээж авангуутаа шалгаж үзээд тийм байна шүү дээ гээд нөгөө хүнийг торгоод, эс үгүй бол яллаад өнгөрчхөж байгаа юм.

Нөгөө гүтгүүлээд хохирчхож байгаа тал нь байхгүй. Хохирлоо яаж барагдуулах вэ гэхээр байхгүй. Иргэний шүүхээрээ яваач ээ гэхээр манай хуульч нар, Хууль зүйн сайд, энэ өмнөх Хууль зүйн сайд энэ тэр байсан хүмүүс юу гэдэг вэ гэхээр Иргэний шүүхэд хандахаар хаяг нь олддоггүй юм, процесс нь хэцүү. Наадах чинь эрүүгээрээ явахгүй бол хариуцагч нь олдохгүй ингээд зовоод байдаг юм. Тэрийг шийдэх гэж л уг нь Хууль зүйн яам гэж байгаа. Тэгэхээр тэрийгээ оруулж ирээд яв гэдэг энэ Наранбаяр докторын, Наранбаяр гишүүнтэй бол санал нэг байгаа. Ер нь бол эцэст нь хэлэхэд хүнийг гүтгэх эрх гэж энэ хаана ч байхгүй.

**Б.Пүрэвдорж:** Цогтбаатар дарга нэмж тайлбар өгье.

**Д.Цогтбаатар:** Би ажлын хэсэгт байхгүй шүү дээ. Би байхгүй байхгүй юу. Энэ дээр байна шүү дээ 37-ны гүтгэлэгтэй холбохгүй гэж болохгүй шүү. Нээрээ наадах чинь гэрчийн мэдүүлэг авч байна гээд л хүмүүсээр нөгөөдөх нь энэ тэгсэн, энэ миний хамсаатан байсан гээд л гүтгэчихэж байгаа байхгүй юу. Үгүй ээ яг үнэн.

Тэр дотор чинь өшөө санаатайгаар өөрсдөө гүтгээд явсан ч зөндөө хүмүүс байж байгаа юм. Тэр цагаатгах комиссын материалуудтай танилцаад үзээрэй. Тэр дотор чинь аягүй их тийм юм явчихсан байгаа байхгүй юу. Тийм.

**Б.Пүрэвдорж:** Би бас үг хэлэх ёстой байсан. Би нэг үгээ хэлчихье. Тэгэхээр Цогтбаатар даргаа би нэг энэ статистик хэлээд өгье. Та 2 түр зуур юугаа үзчих, дараа нь яачих. Цогтбаатар даргаа би нэг таны үеийн статистик яриадахъя.

Тэгэхээр энэ гишүүд ээ, ийм байгаа юм 2002-оос 2000 та нэмж уучлаарай нэмж тодруулъя. Наранбаяр гишүүн.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ цөөхөн минут үлдсэн. Тэгэхээр энэ дээр тодруулга хэлье. Ер нь бол 1937 оны тэр том тэр хэлмэгдүүлэлтийн үе төр нь хүнээ гүтгэж байсан. Бие биеэр нь шууд өөрийгөө илчлэх юм хийлгээд л. Энэ бол хуучин Зөвлөлт холбоот улсын Сталины дэглэмийн л нэг аймаар юм. Тэр бидний цус маханд ийм юмыг дахин давтаж болохгүй гэсэн юм бий. Тэгэхээрээ төрийн энэ оролцоо юмыг л аль болохоор хязгаарлаж, иргэд хоорондын л энэ бие биеэ нэр төрөө хадгалах, нэр төрөө эрхэмлэх энэ ухаан руу л бид явах ёстой л гэж би дахин дахин хэлээд байгаа нь энэ юм байгаа юм.

Тэгээд сая бас энэ ажлын хэсгийн гишүүд болоод Байнгын хорооны дарга бас ингээд энэ дээр тайлбар маш сайн хэлсэнд талархал илэрхийлье. Ер нь бол энэ парламентын үед бид хүний эрхийг дээдэлсэн, хүний эрхийг баталгаажуулсан, хэвлэлийнхээ эрх чөлөөг илүү баталгаажуулсан энэ зүг рүү л явахгүй бол Монгол Улс бол энэ асуудлаараа байнга хойшоогоо яваад байгаа шүү гэдэг дээр л санаа зовж байгааг хэлээд байгаа юм. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Тэмүүжин гишүүн тайлбарлая.

**Х.Тэмүүжин:** Үнэхээр ажлын хэсэг дээр энэ тухай бас нэлээн сайн ярьсан. Иргэн иргэнээ гүтгэх, эс үгүй бол сэтгүүлч хэн нэгнийг, албан тушаалтныг гүтгэх гэдгээсээ гадна одоо Монгол Улсад бас их хавтгайгүй болчихсон нэг үзэгдэл бол албан тушаалтнууд гүтгэдэг болчихсон. Албан тушаалтнууд эрх мэдлээ ашиглаад хуулийн байгууллагууд эрх мэдлээ ашиглаад иргэнийг гүтгэдэг болчихсон. Хэвлэлээр гутаадаг болчихсон. Тэгээд энэнтэй холбоотой асуудлыг бол Эрүүгийн хууль дээрээ бас зөвхөн энэ гүтгэх гэдэг биш энэ хуурамч нотлох баримт бүрдүүлэх, мөрдөн шалгах үйл ажиллагааг хууль бусаар явуулах, хэргийг хууль бусаар хэрэг тохож нээх гэх мэтчилэн энэ асуудал дээр бол тусад нь бас зохицуулалт үнэхээр шаардлагатай юм байна гэдгийг харсан.

Иргэний журмаар энэ гүтгэхдээ гэдэг юм уу, нэр төртэй холбоотой асуудлыг шийдэхэд түрүүн Лодойсамбуу гишүүний ярьсан нөгөө хариуцагчийг олдоггүй ээ гэдэг. Тахарын албаа буцааж сэргээн байгуулах хэрэгтэй шүү дээ. Тахарын алба чинь иргэний шүүхийн хариуцагчийг хамгийн сайн олдог байгууллага байсан юм.

**Б.Пүрэвдорж:** Гишүүдэд бас нэг ийм тодорхой мэдээлэл өгөхөд 2002 оноос 2017 оны хооронд Эрүүгийн хуульд гүтгэх гэмт хэргийг 111 дүгээр зүйл ангиар шийдвэрлээд түүнд нийтдээ 116 хүнийг 15 жилийн туршид 116 хүнийг яллаж байсан байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн сэтгүүлч биш иргэн бүгдээрээ ороод.

2020-2025 оны хооронд гүтгэх гэдгийг чинь 2017 онд сэтгүүлч нар эсэргүүцээд тэгээд тэрийг арай өөр маягаар шийдэж байсан. Би энийг дараа нь ярина.

Тэгээд 2020 онд Эрүүгийн хуульд худал мэдээлэл тараах гэдгээр оруулаад 2025 оны хооронд 5-хан жилийн дотор 500 гаруй хүнийг энэ зүйл ангиар ялсан байгаа. Тэгэхээр нэг хуулиар нь гүтгэхээр чинь 15 жилийн туршид 116 хүн яллаж байхад сүүлд худал мэдээлэл тараахаар чинь 500 хүнийг яллачихсан байна шүү дээ. Тэгэхээр ер нь бол энэ хэвлэн нийтлэх эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх энэ эрх чөлөө яаж их буурсныг энэ статистик тооноос харж болно.

Тэгэхээр би сая ярилаа тийм ээ 2002-2017 гээд тэгээд 2020-2025 оны статистик ярилаа шүү дээ. Дунд нь 3 жил хаашаа алга болчихсон юм бэ гэдгийг би та нарт хэлж өгье.

2017 онд сэтгүүлч нар эсэргүүцээд гүтгэх гэмт хэргийг юунаас авч хаянгуут, Эрүүгийн хуулиасаа авч хаячхаад яасан бэ гэх дээр Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1 рүү үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр хүндэд халдах гэж оруулаад тэгээд Зөрчлийн хуулийн 5.9.1-ээр торгодог. Эхлээд 50-аар, дараа нь 100-гаар тэгээд баривчилдаг. Яг энэ энэ зөрчлийн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн энэ нэр хүндэд халдах гэдэг энэ заалтаар 1000 гаруй хүмүүсийг прокурорын зөвшөөрөл, шүүхийн шийдвэргүйгээр энэ цагдаагийн байгууллагуудаар энэ хүмүүсийг бүгдийг нь торгосон.

Тийм учраас энэ хуулийг өргөн барьж энэ нэг тэр Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас энэ 31.1-ийг авч хаях заалт энэ хуулийг өргөн бариад тэгээд энэ хууль 24 онд Цогтбаатар дарга Энхбаяр сайд байж байхдаа оруулсан. Тэгэхдээ 25 он, 24 онд хасагдсан байх. Ингээд хасагдсан гэдгийг хэлье.

Сая бол өнгөрсөн 7 хоногт Мөнхбаясгалан гишүүн байгаагүй байх. Энэний түрүүчийн 7 хоногт Байнгын хороон дээр яг энэ яг энэ асуудал орж ирсэн. Тэгээд энэ Цогтбаатар дарга байхгүй энэ мэргэжлийн бас яг энэ асуудлаар сайн мэргэшсэн хүн удирдаагүй учраас энэ дээр ямар зүйл, заалтаар нь буцаасан юм бэ гэхээр ажлын хэсгээс ийм заалт оруулж ирсэн юм. Нийтийн албан тушаалтан тушаалтан шүүмжлүүлсэн асуудал дээрээ тайлбар өгөх үүрэгтэй ч сэтгүүлч шүүмжилсээр байх юм бол гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ ээ гэж ийм заалт оруулж ирсэн.

Тэгэхээр нэг сэтгүүлч хүн нь хэн нэгнийг шүүмжилдэг. Тэгэнгүүт Монгол хүн болсон л хойно нөгөө өөрийгөө өмгөөлнө шүү дээ тийм ээ өөрийгөө өмгөөлж тайлбар өгнө. Тэгэнгүүт өөрийгөө өмгөөлөөд тайлбар өгөнгүүт нөгөө сэтгүүлч чинь дахиад шүүмжлэнгүүт нөгөө хүнд чинь хэрэг үүсгэхдээ байгаа байхгүй юу даа.

Ийм заалт оруулж ирсэн учраас үүгээр нь би өнгөрсөн 7 хоногт буцаасан. Харин энэ 7 хоногт Цогтбаатар дарга яг мэргэжлийн хүний хувьд бол Байнгын хороогоо яагаад энэ яг энэ Засгийн газраас яг энэ гүйцэтгэх салбараас нь санал авна гэдэг чинь хамгийн зөв гэдгийг хэлье.

Ингээд энэ асуудлаар асуулт асууж дууслаа. Энэний дараач үг хэлэх хүмүүс байгаа юм уу? Үг хэлэх хүмүүс байхгүй юм байна. Санал хураалтыг дараа нь нэгтгэж явуулна. 8 дугаар асуудал. Дараагийн асуудалдаа оръё.

19.59 цаг

**Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

**О.Саранчулуун:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын гишүүдээс 2025 оны 06 дугаар сарын 24 Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара олон улсын гэр бүл олширч буй өнөөгийн нөхцөлд Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж хүүхэд төрүүлсэн гадаад улсын эхчүүдийг урамшуулах эрх зүйн зохицуулалтыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл “Эхийн алдар” одон олгох эрх нь хүүхэд амьд төрж, улсын бүртгэлд бүртгэгдэн төрсний гэрчилгээ авсны дараа үүсэх ёстойг онцлон хүүхдээ бусдад үрчлүүлсний дараа одон олгох болон урамшууллын эрх давхар үүсэх эрсдэлийг судлах хууль, хууль, журмын түвшинд хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хүүхэд төрсний дараах эндэгдэл, төрөлхийн гажиг, амьдрах чадваргүй төрөлт зэрэг нөхцөлд “Эхийн алдар” одон олгох шалгуурыг хэрхэн тооцох. Мөн хуулийн өөрчлөлтийн улмаас халамжийн хүрээ хэт тэлж, улсын төсөвт нэмэлт, дарамт үүсэх эрсдэлийг судалсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа “Эхийн алдар” одон олгох үйл ажиллагааны эрх зүйн болон захиргааны зохицуулалт тодорхой бус байгаагаас үүдэн хүүхдийн эндэгдэл, гэрийн төрөлт, үрчлэлт, төрөлтийн дараах зэрэг олон нөхцөлд маргаан үүсэх эрсдэлтэйг анхааруулж, үрчлэлтийн насны хязгаарыг бүрэн халах нь төсөв, нийгмийн бодлогын хувьд тооцоолоогүй үр дагавар дагуулах эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсэгт тусгасан “тэр үед 3 хүртэлх насанд нь” гэснийг төслөөс хасах тухай зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёолол Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг.

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсэг. Адьяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Юрагийн Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Би шалгаадахъя. Батбаатар өөрийнхөө нэрийг л өгсөн байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууна.

**Р.Эрдэнэбүрэн:** Энэ хуулийн төсөл мэдээж ингээд эцсийн хэлэлцээр батлагдчих байх, асуудал байхгүй байх. Би зүгээр энэ бид нар нэг ийм юм бодох цаг болчихсон юм биш үү л гэж л хэлэх гээд асуух гээд байгаа юм. Энэ сүүлийн 20, 30 жил бол ямар үйл явц болсон бэ гэхлээр хөдөөгийнхөн, ялангуяа ер нь айлууд бол Монголчууд бол охидуудаа сургуульд сургасан. Эрчүүд, эрэгтэй хүүхдүүд яах вэ болно гэж мал дээрээ авч үлдээд тэгээд ингээд охидуудаа дандаа бүгдийг нь дээд боловсролтой болгосон. Одоо энэ ер нь бол сүүлийн 20, 30 жил бол их, дээд сургуулийн анги дүүргэлтийн бараг 90 хувь нь охидууд, эмэгтэйчүүд байсан. Тэгээд. Энэний үр дүнд ямар байдал бий болчхоод байгаа вэ гэхлээр орон нутагт бол эмэгтэйчүүд байхгүй болсон. Тэгээд одоо хэдэн эрэгтэй, эрчүүдтэй. Хэдэн залуучууд мал маллаж байгаа. Одоо бид нар ямар юм руу явж байна вэ гэхлээр нөгөө мал маллаж байгаа хэдэн залуучуудыгаа орон нутагт нь байлгахын тулд хаврын морин уралдааныг дэмжих хэмжээндээ ирж байгаа. Мориор нь тэндээ авч үлдэх гээд байна шүү дээ. Морь уяулж.

Гэтэл эмэгтэйчүүд юу болж байгаа вэ гэхлээр одоо энэ боловсролтой болчихсон эмэгтэйчүүд бол энэ одон ч юм уу, энэ жоохон хүүхэд гаргадаг энэ урамшууллаас болоод хүүхэдтэй болох тухай, хүн ам өсөх тухай тийм зүйл бол байхгүй болсон. Тэгээд мэдээж энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ

бид нар энэ Их Хурал ер нь цаашдаа энэ Нийгмийн хамгааллын яам энэ эрчүүдийг боловсролтой болгох, тэгш байлгах, энэ юм руу тэдний эрүүл мэндийг хамгаалах дээшлүүлэх энэ дээр ер нь ямар анхаарал хандуулах гэж байна, юу хийх гэж байна гэдэг асуулт асуух гэсэн юм. Эрчүүдтэй холбоотой.

**Б.Пүрэвдорж:** Хэн хариулах вэ? Төрийн нарийн бичгийн дарга индрийн 4 дүгээр микрофон. Нэрээ хэлээд, албан тушаалаа.

**А.Даваажаргал:** Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн нарийн бичгийн дарга Даваажаргал. Өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар бид Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн анхдагч хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар оруулаад Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэгдсэн байгаа.

Энэ хуулийн үндсэн концепц бол хүн ам зүйн хөгжилтэй холбоотой бүхий л зохицуулалтуудыг бид хангахыг хичээсэн. Таны хэлж байгаа хүн амын өсөлт удааширч байгаа, дээрээс нь эрчүүдийн бас энэ боловсролын асуудал орхигдож байгаа асуудал дээр энэ хууль дээр бол тодорхой заалтуудыг оруулж тусгахыг хичээсэн.

Ер нь бол хүн амын тооны харьцаа бас сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж байгаа. Мөн насны бүтэц өөрчлөгдөж байгаа. Тэгэхээр эдгээр асуудлуудыг зохицуулах нь бол яг цаг үеийн тулгамдсан асуудал байгаа учраас энэ хуулийг анхдагч хуулийн төсөл байдлаар оруулж ирсэн байгаа. Тэгээд энэ хуулиар бол бид нар ирэх 7 хоногоос өргөн барихаар төлөвлөөд явж байна. Хуулийн төсөл танилцуулагдаад эхлэхээр ер нь бол саяын эрэгтэйчүүдийн, тэр тусмаа залуучуудын, хөдөө мал дээр байгаа залуучуудын нийгмийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр зохицуулалтуудыг оруулж ирэхийг хичээсэн байгаа.

**Б.Пүрэвдорж:** Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн. Ажлын хэсгийн дарга Саранчулуун хариулна.

**О.Саранчулуун:** Би таны хэлж байгаа асуулттай санал нэг байна. Монгол Улс хүн ам зүйн бодлогынхоо төвд нь төрөлтийг дэмжих агуулгыг нэлээн түлхүү тусгачихсан. 1990-2000 оны хувьд бол шилжилтийн үед яг энэ чиглэлээр нэлээн анхаараагүй сул гэх юм уу, харин 2000-2010 оны хувьд бол халамжийн бодлогоор дамжсан дэмжлэг түлхүү яваад. Ер нь одоо ч гэсэн халамжийн хэв загвараар хүн ам зүйн бодлого нэлээн төвтэй явсан юм байна лээ. Тэгэхээр эндээс судлаачид ямар дүгнэлтийг хийж байгаа вэ гэхээр мөнгө бол дангаараа өнөөдөр хүн ам зүйн бодлогыг тодорхойлдог, нөлөөлдөг гол хүчин зүйл биш 1 дүгээрт.

2 дугаарт, хүн ам зүйн бодлого дотор өнөөдөр бид нар ажил, амьдралын тэнцвэрийн асуудлыг хангах ёстой. Хүүхэд асаргааны үйлчилгээг сайжруулах хэрэгтэй.

3 дугаарт нь бодлого өөрөө халамж төвтэй биш амьдралын мөчлөг төвтэй байх ёстой гэдгийг бид нар хүн ам зүйн хэлэлцүүлэг хийж байх үед бас ярьж байсан. Тэгэхээр энийг одоо яамнаас орж ирэх хууль, тогтоолд бас.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Ренчинбямбын Сэддорж гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Батмөнхийн Батцэцэг гишүүн алга байна. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

**М.Нарантуяа-Нара:** Оройн мэнд хүргэе. Танхимд байгаа 15 гишүүддээ үдшийн мэнд хүргэе ээ. Тэгэхээр энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ялангуяа эх хүн хүүхэд төрүүлж, өсгөж хүмүүжүүлэх бойжуулах энэ үйлс бол зөвхөн нэг гэр бүлийн асуудал биш. Улс орны хүн амын өсөлт, үндэсний аюулгүй байдал, цаашлаад нийгмийн хөгжил, ирээдүйн үнэт баялагтай бол шууд холбоотой. Тэгэхээр энэ хуулийн төслөөр “Алдарт эх”-ийн одонгоор шагнагдах нөхцөлийг өмнөх хуулийн төсөлд заасан байсан хуульд байсан 1 нас хүртэлх гэсэн энэ зүйл, заалтыг авч байгаа нь бол үнэхээр сайшаалтай.

Энэ дундаа өнгөрсөн хугацаанд энэ хууль нөгөө нөхөж хэрэгждэггүй ээ, эргэж хэрэгждэггүй гэдэг юм байдаг юм шүү дээ. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд хүүхдээ алдаад насаараа шаналж байгаа ээжүүдэд энэ урамшуулал, энэ алдаршууллаас хоцорсон ээжүүдэд энэ нөхөж хүртэх үү, эс үгүй бол яг хэрэгжсэн цагаасаа авхуулаад энэнээс цаашаа хэрэгжээд явах юм уу? Өнгөрсөн хугацаанд хүүхдээ алдчихаад шаналж байгаа ээжүүдэд нөхөж олгох уу гэдэг асуулт байна. Мөн түүнчлэн энэ дэлхий ертөнц нээлттэй болж байна. Хэдийгээр глобал гэл гэр бүлүүд олон болж байна. Тэгээд манай Монгол улсын хувьд бол хэдийгээр олон биш ч гэсэн цөөн тооны гадаад иргэн Монгол улсын иргэнтэй гэр бүл болоод, Монгол улсад амьдраад, Монгол улсад ажил хөдөлмөр эрхлээд тэгээд Монгол улсын энэ хүнд хэцүү нийгэм, цаг үеийн нөхцөл байдалд олон хүүхэд төрүүлээд өсгөж хүмүүжүүлж байгаа хүүхдүүдийн асуудлыг, хүүхдүүд төрүүлээд ажиллаж, амьдарч байгаа ээжүүдийн гадаад иргэн, ээжүүдийн асуудлыг бас бид нар бас харах шаардлагатай болсон байна гэж би харж байна.

Ер нь бол яг үнэнийг хэлэхэд түрүүн Эрдэнэбүрэн гишүүн хэллээ ээжүүд бол ингээд “Алдарт эхийн” одонгийн төлөө төрөөд байгаа юм биш ээ энэ ямар нэгэн зөвхөн урамшуулал болон одонгоор ээжүүдийн төрөх хүчин зүйлийг хангана гэж үзэж болохгүй. Одоо ингээд сүүлийн үед ер нь бол төрөлт маш эрч хүчтэйгээр буурч байна. Залуу гэр бүлийн ачаалал маш их нэмэгдэж байна. Олон хүүхэдтэй эхчүүдийг зөвхөн одон урамшууллаар урамшуулах биш нийгмийн хамгаалал, хүүхэд асрах үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, мөн түүнчлэн орон сууцын дэмжлэгтэй уялдуулсан цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ тал дээр ялангуяа олон хүүхэдтэй айл гэдэг бол гарцаагүй ипотекийн зээлд бол зайлшгүй очер дараагүйгээр орох ийм шаардлагатай байгаа. Тэгээд энэ дээр бас яам ямар арга хэмжээ авч байна гэдэг асуултыг бас асуучихъя. Боломж байвал хариулна биз. Тэгээд энэ хуулийн төслийг бол дэмжихээс өөр аргагүй.

Харин бид нар цааш цаашдаа хэдийгээр цөөнх байгаа ч гэсэн цөөнх байгаа энэ Монгол Улсын хүн амын өсөлт хөгжилтөд хувь нэмрээ оруулаад байгаа гадаад улсын иргэн, тэр дундаа Монгол улсад Монгол хүний адилаар амьдраад байгаа гадаад иргэдийн асуудлыг бас гадаад ээжүүдийн шүү асуудлыг бас авч хэлэлцэх шаардлагатай байна гэж бодож байна. Тэгээд энэ 2 асуултаар.

**Б.Пүрэвдорж:** Үүрийнтуяа. Хууль санаачлагч Үүрийнтуяа гишүүн хариулна.

**Д.Үүрийнтуяа:** Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

1 дүгээрт, өнгөрсөн хугацаанд хууль нөхөж үйлчлэх эсэх гэдэг дээр 2024 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар энэ хуульд өөрчлөлт оруулаад 1-ээс дээш насандаа нас барсан хүүхдүүдийг одонгийн хүүхдийн тоонд оруулдаг өөрчлөлтийг оруулахад өнгөрсөн цаг хугацаанд хүүхдээ алдсан ээжүүд бүгд хамрагдсан. Энэ хууль 2027 оны 01 сарын 01-нээс хэрэгжихээр орсон байгаа. 2027 оны 01 сарын 01-нээс хойш өмнө нь хүүхдээ төрүүлээд 0-1 насандаа алдсан ээжүүд материалаа бүрдүүлж өгөх ёстой юм байгаа юм. Зөвхөн 27 оны 01 сарын 01-нээс хойш төрөөд эндсэн хүүхэд орно гэсэн заалт байхгүй.

Тийм учраас энэ 27 мянган ээж 2 дугаар одон, 10154 ээж 1 дүгээр одон авна гэдэг бол өнгөрсөн цаг хугацаанд хүүхдээ алдсан ээжүүдийн тоо. Үндсэндээ ихэнх нь бас олон хүүхэд төрүүлж байх, 8, 9 хүүхэд төрүүлж байх үед хүүхдээ алдсан, хүүхдийн эхийн, нярайн эндэгдэл өндөр байх үеийн энд өртсөн бас эмэгтэйчүүд, эндсэн хүүхдүүдийн тоо нэлээн орж байгаа гэдгийг нэмж хэлье. Энэ хууль батлагдсаны дараа 24 онд орсон өөрчлөлтийн дагуу Ерөнхийлөгчийн зарлигаар журам гарах ёстой. Энэ журмаар хэрхэн яаж олгох талаар зохицуулалтын нарийвчилсан заалтууд орж ирнэ ээ гэж ойлгох хэрэгтэй.

2 дахь асуудал гадаад ээжүүдэд олгох эсэх гэж. Гадаад иргэнтэй гэрлэсэн Монгол Улсын иргэншилтэй болчихсон ээжүүд өнгөрсөн жил бас авсан санагдах юм. Бас хэвлэл мэдээллээр гарч байсан Орос эмэгтэй Монгол эрэгтэй хүнтэй гэрлэсэн. 4 хүүхэд төрүүлсэн Орос эмэгтэй одон авч байсан.

Тэгэхээр энэ бол хориглогдсон зүйл, заалт байхгүй. Монгол улсын иргэншил авчихсан байгаа үед энэ боломж нь нээлттэй гэж харагдаж байгаа.

3 дахь зүйл дээр тантай би санал нэг байна. Мэдээж яамнаас энэ дээр тодорхой бодлогын асуудлуудыг хэлэх байх. Түрүүн Эрдэнэбүрэн гишүүн ч гэсэн асуултдаа хэлнэ лээ. Бид нар ер нь ээжүүд одон авахын төлөө гэдэг юм уу, эсвэл 1 хүүхдийн 50 мянган төгрөг, сарын 50 мянган төгрөг харж байгаад 50 мянган төгрөг авахын төлөө хүүхэд гаргаад байгаа юм ерөөсөө байхгүй л дээ.

Энэ хуулийн үндсэн зорилго нь ээжүүдийн хөдөлмөрийг ялгахгүй байх, хүний эрхийн, хүүхдийн эрхийн зөрчил гаргахгүй байх үндсэн концепц агуулж байгаа юм. Монгол улс Монгол улсын төр иргэнийхээ нөхөн сэргээх ёстой эрхийг сэргээхийн тулд төрийн түшээдийн хувьд энэ хуулийг санаачилж оруулж ирж байгаа юм. Яг хүн ам зүйн бодлогоор хүн амын өсөлтийг хангахын тулд цогц бодлого хэрэгтэй гэдэгтэй санал нэг байгаа.

Өнөөдөр манай төрөлтийн нийлбэр коэффициент 2025 онд 2 болчихсон. Өөрөөр хэлбэл, Монгол эмэгтэй амьдралынхаа туршид 2 хүүхэд төрүүлж байна л гэсэн үг. Бид нарыг төрж байх үед бидний ээжүүд 1980-аад оны үед 1 Монгол эмэгтэйд 6 хүүхэд төрүүлдэг байсан байгаа юм. Гэхдээ яагаад 2 хүүхэд төрүүлээд байна вэ гэдэг дээр үнэхээр цөөн хүүхэдтэй болох бодлоготой байгаа юм уу гээд залуучуудын хүсэлт, санал асуулгаар бол бид нар дунджаар 4 хүүхэдтэй болмоор байна. Гэхдээ өнөөдөр байгаа амьдралын нөхцөл байдал, ажил орлого, эрүүл мэнд, боловсролын салбарын хүртээмжийг харахаар 2-оос илүү хүүхэдтэй болох боломжгүй байна гэдэг хариултыг өгч байгаа. Тэгэхээр суурь асуудлаа засах ёстой гэдэгтэй.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

**М.Нарантуяа-Нара:** Баярлалаа. Бодит иргэдийн ялангуяа залуучуудын залуу гэр бүлүүдийн хувьд бол одоо надад хандаж байгаа юугаар бол? Ер нь энэ одонг, “Алдарт эх”-ийн одонг 2 дугаар одонг нь 3 хүүхэд, 1 дүгээр одонг нь 5 хүүхэдтэй байж болдоггүй юм уу гэсэн ийм асуудлыг их хөндөж байгаа. Энэ у уг нь бол бид нар ингээд нээрээ 3, 5-аар тогтчих юм бол 4 болохоор яах аргагүй бас хүнд байгаад байгаа байхгүй юу. Ялт ч үгүй хүүхэд нэмэгдэнэ гэдэг чинь нөгөө хүнс нэмэгдэнэ гэж байгаа шүү дээ. Гэтэл энийг чинь дагаад тэр чигээрээ санхүү, эдийн засгийн бодит маш том ачаалал ирж.

Тэгэхээр уг нь бол бид нар бас цааш цаашдаа хараад ингээд яах юм бол үнэхээр хүн ам зүйн бодлогод өсөлтийг авчрах, хүн амаа тэлэх бодлого хэрэгжүүлэе гэж бодож байвал 3 болоход айл өрх бүхэн 3 хүүхэдтэй болоход хүн ам дараа дараагийн жилүүдэд хэдэн хувиар өсөх боломжтой вэ гэдэг энэ тооцооллыг хийж байгаад бид нар бас дахин харах бас боломжтой болов уу гэж бодож байна. Тэгээд ямар ч л байсан хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Үүрийнтуяа гишүүн хариулъя.

**Д.Үүрийнтуяа:** Энэ хууль маань 1957 оны хууль л даа Монголын анхны хуулиудын л нэг. Өөрчлөлт их цөөхөн орсон. 2011 онд энэ 6 хүүхэд, 8 хүүхэд байсан тоог 4, 6 болгож 1, 2 дугаар одонгийн хүүхдийн тоог бууруулсан. Гэхдээ энэнээс хойш бас олон жил өнгөрсөн байна. Магадгүй төрөлт буурч байгаа энэ цаг хугацаанд олон хүүхэд гэж хэдэн хүүхэд байх юм бэ гэдэг дээр бид нар бас үндэслэл, тооцоотой судалгаа хийж энийг авч үзэх ёстой асуудлын нэг бол мөнөөс мөн.

Ялангуяа одон гэхээсээ илүү олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих бодлого дээр бол энэ хүүхдийн тоог харж үзэх ёстой болчихоод байгаа юм. Саяхан уул нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас барьж байгаа энэ гэр бүлийг дэмжих хуулийн төсөл дээр олон хүүхэдтэй гэр бүлд татварын хөнгөлөлт олгох асуудал байсан. Харамсалтай нь энэ хасагдсан гэдэг зүйл явж байна лээ. Уг нь ийм л бид нар цогц бодлогоор мөнгөн хэлбэрээр гэхээс илүү хөшүүргээр бид нар олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих ёстой. Энэ дээр бол санал нэг байна.

**Б.Пүрэвдорж:** Саранчулуун гишүүн нэмж хариулъя.

**О.Саранчулуун:** Би яах вэ хүн амын дэмжих бодлого гэдгийг зөвхөн одонгоор битгий хараасай гэдгийг би хүмүүст бас хэлмээр байгаа. Монгол улс хүн амын бодлогынхоо хэв загварыг халамжийн парадигмаас нь гаргах хэрэгтэй л гэдгийг энэ хэлэлцүүлгээс бас хараасай гэдэг утгаар энэ ажлын хэсэгт бас ажиллаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар хаашаа чиглэ чиглэх ёстой вэ гэж эрдэмтэд, судлаачид үзэж байна вэ гэхээр амьдралын мөчлөгт суурилсан үндэсний бодлого хэрэгтэй байна гэж байгаа юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр хэрвээ бид нар хүн амаа өсгөө гэвэл хүмүүс дараах асуултад хариу олж байж хүүхэдтэй болдог байгаа байхгүй юу. Би хэзээ гэрлэх юм, байртай билүү, орлоготой билүү, жирэмсэлбэл ажлаа алдах уу, хүүхдээ хэн харах вэ гээд энэ

асуудлууд дээр бид нар 1 удаагийн урамшууллаар биш 20-30 жилийн амьдралын замнал дэмжсэн ийм бодлого хэрэгтэй гэдгийг энэ Гэр бүлийн яамнаас боловсруулж байгаа бүх хууль, эрх зүйн баримт бичиг тусгах хэрэгтэй байгаа. Бид бид нар зөвхөн одонгийн асуудлыг ярихаас гадна энийг багцаар нь харахын тулд бид нар хэлэлцүүлэг хийж, олон талын яриануудыг өрнүүлсэн юм.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. Зарчмын зөрүүтэй 1 саналтай юм байна. Дээрээс нь хуулийн төслийг дэмжих эсэх талаар санал хураалтыг нэгтгэн явуулна хойшлуулж байна.

20.20 цаг

**9 дүгээр асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Д.Энхтүвшин:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 005 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т заасны дагуу Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 12, 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, санал дүгнэлт гарган Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд танилцуулсныг нэгтгэн дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг 2027-гоос 29 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөдөө аж ахуйн салбарын бодлого, мөн зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Замира гадаадын банкны салбарыг Монгол улсад байгуулах, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, Астана-Улаанбаатар чиглэлийн нислэгийн маршрутад Баян-Өлгий аймгийг багтаах асуудлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт болон эдийн засгийн бодит үр дүнг хэрхэн төсөөлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатайг онцолж, өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнийн өсөлт ялангуяа махны үнийг тогтворжуулах арга хэмжээ. Мөн газрын тосны

бүтээгдэхүүний экспортоос улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын төсөөллийн талаар.

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл боловсрол болон эрүүл мэндийн салбараас бусад салбарын төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг бууруулах асуудлаар тооцоолол хийгдсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн төсөвт өртөг болон нүүрсний тэнцвэржүүлсэн үнийн тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал Үдийн хоол хөтөлбөрт дунд болон ахлах ангийн сурагчдыг хамруулах зардлын санхүүжилтийг төсөвт тусгасан эсэх, мөн хөрөнгө оруулагчдыг татах боломжтой шинэ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Боловсролыг сайжруулах асуудлын хүрээнд салбарын чанар, хүртээмжийг тэлэх, багш нарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, бэлтгэх, давтан сургах, хомсдолыг арилгахад чиглэсэн бодлого, төлөвлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын хуулийн төслүүд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдсан эсэх талаар.

Төсвийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Төсвийн тогтвортой байдлын тухай болон Гадаад зээлийн ашиглалтын тухай хуулийн төслийн талаар тодруулж, төсвийн бодит нөхцөл байдлын өнөөгийн хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулан тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэх, инфляцын өсөлт төлөвлөснөөс давах эрсдэлтэй нөхцөл байдал үүсэх үед тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, төсвийн эх үүсвэрийг хэрхэн нэмэгдүүлэх, бүрдүүлэх, төлөвлөх, бүрдүүлэхээр төлөвлөсөн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Оюу толгой төслийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төвлөрүүлэлт, Ирээдүйн өв санд төвлөрч буй уул уурхайн орлогын тодорхой хэсгийг тэтгэврийн нэмэгдэлд хуваарилах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт, цалин тэтгэврийг нэмэгдүүлэхэд зарцуулах 3 их наяд төгрөгөөр барилга, байгууламж барихаар төлөвлөж байгаа нь бодлого оновчтой эсэх, үр ашиг багатай, хөрөнгө оруулалтыг танаж иргэдийн бодит орлогыг дэмжих чиглэлд зарцуулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Жавхлан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 208 хуулийн 1080 заалтаар салбар бүрийн төсвийн зарцуулалтыг зохицуулсан нь төсвийн уян хатан байдлыг хязгаарлаж байгаа тул эдгээр хуулийн давхардал, үр ашиггүй зардлыг дахин нягталж, төсвийн шинэчлэл хийхээр бодлого төлөвлөсөн эсэх талаар.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг аймаг, сумдын цогцос хадгалах байрны нөхцөлийг сайжруулах болон хар тамхи донтолттой тэмцэх үйл ажиллагаа явуулах төсвийг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй талаар дурдаж, Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хилийн хамтарсан шалган баталгаажуулалтын ажлын явц, Засгийн газраас Улсын Их Хуралд бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр өргөн мэдүүлэхээр боловсруулсан хуулийн төслүүд, зөрчлийн мэдээллийн системийг ашиглалтад оруулах ажлын хэрэгжилтийн үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал Хууль зүйн байнгын хорооноос хянасан шүүхийн байгууллагуудын төсвийг бууруулахгүйгээр улсын

төсвийн төсөлд тусгахад анхаарах. Мөн Хүүхэд, гэр бүлийн шүүхийн төсөв, Ази, номхон далайн хүний эрхийн сургалт, судалгааны төв байгуулахад шаардагдах төсвийг тусгах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг Хууль зүйн салбарын байгууллагуудын урсгал зардал нэмэгдэж байгаа эсэх, Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын хуулийн төслүүдийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсвийн үзүүлэлтэд нөлөөлөх тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Цагдаагийн мөрдөн байцаагчдын цалинг нэмэгдүүлэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд хууль зүйн салбарын байгууллагуудын төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын саналыг төсвийн төсөөлөлтэй хэрхэн уялдуулж байгаа талаар, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг нийгмийн даатгалын орлогын төсөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний өр, зээлийн хэрэгжилт болон аймаг, орон нутаг дахь улсын эмнэлгийн урсгал зардлыг нэмж тусгах боломжтой эсэх, мөн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч байгаа хувийн эмнэлгүүдэд иргэдээс давхар өндөр төлбөр авч буцаан олголтыг бүрэн олгохгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Баясгалан инфляцын тооцоолол болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож байгаа нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, зорилт, бүлэгт чиглэсэн бодлогод тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара Засгийн газар болон иргэн бүрд ноогдож буй өрийн хэмжээ, ДНБ-ий өсөлттэй уялдуулан өрийн хэмжээ өөрчлөгдөж байгаа эсэх, мөн ахмадын тэтгэвэр, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон цалинтай ээжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх талаар төсөвт тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн хүн амын өсөлт, гэр бүл салалт, мөн залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон залуу гэр бүлийг дэмжих талаар төсөв, арга хэмжээ тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа ахмадын тэтгэврийг энд индексжүүлэх, тэтгэврийн зөрүүг арилгахад чиглэсэн арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр хувийн тэтгэврийн сангийн асуудал, дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Галбадрах боловсролын салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт 1 хүнд ноогдох ДНБ-ийг өсгөх боломж, эдийн засгийн хүндрэлтэй энэ үед эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, импортыг орлуулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун инфляцыг бууруулах арга хэмжээ болон нэмэгдсэн өртгийн албан татварын бодлогын хэрэгжилтийн талаар, татварын тогтолцоог үе шаттайгаар олон улсын стандартад нийцүүлэх нь эдийн засгийн чадавхад нийцэж байгаа эсэх талаар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан байна. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 сарын 19-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39, 64 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үеэр Улсын Их Хурлын гишүүн Жавхлан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн төсвийн алдагдлын хэдэн хувийг орон нутгийн төсвийн алдагдал эзэлж байгаа, Засгийн газрын өрийн хэмжээний ДНБ-д эзлэх хувь, хэмжээг 45 хувиас 50 хувьд хүргэж төвлөрч, төлөвлөсөн үндэслэл, шалтгаан болон Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь, хэмжээгээ 45 хувь байгааг

өөрчлөхгүйгээр гадаад зээлийн ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар нэгдсэн төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлэх нь эдийн засгийн бодлоготой нийцэж байгаа эсэх, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн төсөөллийн бодитой тооцоолсон эсэх, төсвийн алдагдлын хэмжээ нэмэгдэж байгаа суурь шалтгаан болон цаашид төсвийн алдагдал өөрчлөгдөх эсэх, хэрэглээний үнийн индексийн түвшнийг тооцоолж байгаа одоогийн аргачлал нь бодитой эсэх, уг аргачлал оновчтой болох боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Гантөмөр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалтай баталж, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг хүчингүй болгож байгаа нь зөв эсэх, Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг дахин өргөн мэдүүлж байгаа үндэслэлийн талаар, Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрээний усан цахилгаан станц барих төслүүдийн хэрэгжилтийн.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж минут өгье. Та жоохон хурдан унш.

**Д.Энхтүвшин:** Хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх ДНБ-ий бодит өсөлтийг нэмэгдүүлэх, хэрэглээний үнийн өсөлтийн түвшин нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ, суурь зарлагын дээд хэмжээ болон Засгийн газрын өрийн нийт хэмжээг тус тус бууруулах талаар зарчмын зөрүүтэй санал гаргасан бөгөөд уг саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 6.5 хувь буюу олонх нь дэмжээгүй болно.

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт болон гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Энхтүвшин гишүүнд баярлалаа. ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Содномдоржийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Равсалын Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн

бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Зияханы Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны салбар дундын бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга.

Гишүүдэд танилцуулга хийж байгаа албан тушаалтнууд үнэн, зөв мэдээлэл өгөх, худал мэдээлэл өгөхгүй байхыг хориглох ийм Их Хурлын тухай хуульд заалт байдаг. Энийг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох ийм заалтуудтай. Тэгээд та бүхнийг үнэн, зөв мэдээллийг өгөхийг хүсье.

Одоо Төсвийн болон Эдийн засгийн Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Мөнхтулга гишүүнээр тасаллаа. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Д.Энхтүвшин:**Төсвийн хүрээний мэдэгдлээс иргэдэд хамгийн ойрхон үзүүлэлт бол хэрэглээний үнийн өсөлтийн үзүүлэлт байгаа. Тэгэхээр юу статистикийн тоо гарсан байна лээ л дээ. Энэ инфляцад ер нь бол мөнгөний нийлүүлэлт бас тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. 2025 оны 05 сарын 15-ны байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 25.3 хувиар өссөн ийм үзүүлэлт байна.

4 сарын байдлаар инфляц 10.1 хувьтай гэсэн ийм үзүүлэлтүүд байна. Тэгэхээр яах вэ энэтэй холбоотой Монголбанкнаас хүн байвал энэ мөнгөний нийлүүлэлт болон инфляцын корреляци ямар байгаа юм? Энэ мөнгөний нийлүүлэлтийн бодлогын “lag” буюу хоцрогдол нь ямаршуу үзүүлэлттэй байгаа талаар мэдээлэл өгөөч.

Нөгөө талаас энэ төсвийн болон мөнгөний бодлогын энэ уулзвар энэ асуудал дээр бас чухал үүрэг рольтой газар бол энэ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл байгаа юм. Энэ байгууллагын үйл ажиллагаа ерөөсөө сонсогдохгүй байгаа. Төсвийн тогтвортой байдал бол энэ төсвийн сахилга баттай холбоотой асуудал дээр нэлээн тодорхой байр сууриудаа илэрхийлээд явдаг. Энэ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл ажиллаж байгаа юу? Энэ байгууллага яг юу хийж байгаа вэ? Энэ энэ бодлогын уулзварууд дээр тодорхой хэмжээний арга хэмжээ, бодлогын мэтгэлцээн ийм юм ерөөсөө харагдахгүй байна. Энэ талаар мэдээлэл өгөөч.

**Б.Пүрэвдорж:** Та хариулах уу? Тогтвортой байдлын зөвлөлөөс хэн хариулах вэ? Тогтвортой байдал төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуусан юм уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Дэлгэрсайхан Индрийн 3 дугаар микрофон.

**Ж.Дэлгэрсайхан:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь Энхтүвшин гишүүний асуулт бол мөнгөний бодлоготой холбоотой Монголбанк, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуусан асуулт. Манайх бол ерөнхийдөө төсвийн бодлогын тэлэлтэд инфляцад нөлөө үзүүлдэг гэсэн ийм дүгнэлтийг, дүгнэлтүүддээ хийж байгаа. Төсвийн бодлого тэлээд явж байгаа нь төсвийн бодлого тодорхой 1 их наяд төгрөгөөр тэлэхэд инфляцад тийм нөлөө үзүүлдэг ээ гэсэн Монголбанкны судалгаа бол байдаг.

Тийм учраас бид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх энэ явцдаа төсвийн бодлого болон мөнгөний нийлүүлэлтийг ер нь цаашдаа инфляцад яаж нөлөөлөх вэ, эдийн засагт яаж нөлөөлөх вэ гэдэг нөлөөллийн судалгааг бол зайлшгүй хийх шаардлагатай гэдэг ийм байр суурьтай байгаа. Сүүлийн үеийн мэдээллээс харахад бол мөнгөний нийлүүлэлтийн өсөлт бол нэлээд хурдтай харьцангуй өсөлт багатай байж байгаад нэлээд хурдтай өссөн ийм өсөлт ажиглагдаж байгаа. Тийм учраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр эдгээр үзүүлэлтийг харгалзан үзэх ёстой гэдэгтэй бол бидний зүгээс санал нэг байдаг. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр хариулна.

**Ж.Энхбаяр:** Энэ гадаад болон дотоод шалтгаантай үнийн өсөлт нэлээн өндөр инфляц 1 дүгээр улиралд 2 оронтой тоо 10 хувь даваад явж байгаа. Үүн дотроо хүнсний багцын үнэ нэлээн өндөр гарсан. Гурил 9 хувь, мах 37 хувь. Энийг гадаад шалтгаан буюу дизель түлшний үнэ 36 хувиар өссөн нь инфляцыг өсгөхөд нэлээн гол суурь шалтгаан болж байгаа.

Нөгөө талаар манай экспорт их өндөр байгаа. Ноднингийн мөнгөн үеэс 2.2 тэрбумаар илүү гарч байна. Биет хэмжээ ч нэмэгдэж байна. Үнийн дүн ч нэмэгдэж байна. Энэ нь өөрөө бас мөнгөний нийлүүлэлт өндөр байгаад бас шууд нөлөөлж байгаа нэг ийм нөлөөлөлт байна. Улсын Их Хурлын гол арга хэрэгсэл бол энэ төсвийн хүрээний мэдэгдлийг баталж байгаа асуудал. Төсвийн хүрээний мэдэгдлээр бид нар энэ төсвийн тэлэлтийг хязгаарлаж, энэ эдийн засгийн бодлогодоо нийцүүлж байгаа гол арга хэмжээ. Яагаад гэвэл төсвийн зарлага ингэж.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төсвийн зарлага нэмэгдэнэ гэдэг маань өөрөө мөнгөний нийлүүлэлтийг шууд өдөөдөг, инфляцыг бас өсөхөд бас суурь шалтгаануудын нэг. Төсвийн зарлага сүүлийн 10 жилийн ингээд бид нар судалгаа хийж үзсэн ер нь жилдээ 15-18 хувиар ингэж сүүлийн 10 жил өсөж ирсэн юм байна. Одоо Эдийн засгийн яамны барьж байгаа бодлого бол 27 оны хувьд бол өсөлтийг 10 хувь, 28

онд 6 хувь, 29 онд 4.6 хувь өсөхөөр тасралтгүй багасгаж, бууруулж, төсвийн зарлагыг бол хязгаарлах ийм бодлогыг явуулж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууна.

**П.Батчимэг:** Чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг яг ямар дарааллаар яаж оруулаад байгааг ерөөсөө ойлгохоо больчихлоо. Хурлын дарга байсан бол би бас асуух асуулт байна л даа. Хурлын дарга маань хаачсан юм бол дэд даргаа?

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсэг хуралдуулж байгаа.

**П.Батчимэг:** Ингээд ер нь сүүлийн үед энэ орж ирж байгаа чуулганаар хэлэлцэх асуудлуудын эрэмбэ, дараалал ерөөсөө маш ийм ойлгомжгүй болчихсон. Өнөөдөр бид нар яг үнэндээ өглөөний бараг 10 цагаас эхлээд л 10 цаг хэлэлцлээ шүү дээ Их Хурлын тухай хууль тэгээд Дэгийн тухай хууль. Хэлэлцсээр байж байгаад ингээд хамгийн бид нарын гол амин чухал асуудал өнөөдөр энэ нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл. Энэ эдийн засгийн хамгийн гол асуудлаа хэлэлцэх байтал энэ асуудлуудыгаа бүүр хамгийн сүүлд тавиад ирц өнөөдөр хуралдааны танхимд 13, 4 гишүүн байна. Энэ гишүүддээ баярлалаа.

Тэгээд ийм асуудлуудыг ингэж дарааллыг ингэж тогтоодог нь ер нь ямар учиртай юм бол оо? Хурлын даргын дэргэд байгаа энэ зөвлөл ер нь цаашид энэ яг энэ байдлаар ингэж явах юм бол асуудалд хандах юм бол энэ чуулганы хуралдааны бид ингэж хуралдаж суух ер нь хэрэг байна уу үгүй юү? Гадаа амьдрал маш хэцүү, тэгээд маш олон шийдэх асуудлууд байсаар байтал өнөөдөр энэ ирэх 3 жилийн энэ төсөв, энэ эдийн засгийн асуудал, энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллийн тухай өнөөдөр бүүр олноороо суугаад гишүүд өглөө эрт тархи толгой бүх юм нь сэргэг ирц өндөр байж байхад асуудалтай яахгүйгээр шууд дэг ингээд Их Хурлын тухай хууль ийм асуудлууддаа гол анхаарал тавиад өнөөдрийн хамаг цаг бараад хаячихсан. Энд би үнэхээр бас харамсаж байна. Одоо яг үндсэн цагаа, асуултынхаа цагийг авъя дарга. Асуудлынхаа үндсэн цагаа авъя.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол үндсэндээ ирэх 3 жил 2027, 2028, 2029 онд бидний мөрдөх улсын нэгдсэн төсвийг Их Хурлаас хуульчлан баталсан энэ хууль. Тэгэхээр энэ ирэх жилүүдийн улсын төсвийг боловсруулах, батлах, тэгээд энэ батлагдсан төсөвтөө нэмэлт, өөрчлөлт оруулахдаа яг энэ хуулийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж ажиллах ёстой. Тэгэхээр Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг зөв баталж байж ирэх жилүүдийнхээ улсын төсвийг зөв, алдагдалгүй баталж байх энэ суурь үндэс нь тавигдана.

Төсвийн тогтвортой байдлын хуулийн 9.1.1-д Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батална гээд энэ бүүр тодорхой заачихсан. Тэгвэл энэ хуулийн 6.1.3 дээр нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байна гэсэн. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс л би энэ асуултыг асуух гээд байгаа юм. Зарлагаа та бүхэн хараадах даа. Орлого, зарлагаа хараад яагаад энэ зарлагуудыг ингээд хэтрүүлээд

тавиад өгчихсөн юм бол? Засгийн газар бол яг зарлагад орлогыг ингээд нийцүүлээд оруулаад ирчихсэн. Тэгтэл яг таамаг өгч байгаа энэ төсвийн таамаглал өгч байгаа Тогтвортой байдлын зөвлөл өөрөө юугаа хэтрүүлээд оруулаад ирчихсэн байх юм. Энэ дээр одоо яагаад ингэж хэтрүүлсэн тал дээр нэг хариулт өгөөч ээ.

Ер нь Засгийн газарт өгч байгаа тэр төсөөллийн таамаг дээрээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нэг тийм их харьцангуй нийцтэй боллоо энэ тэр гээд ингээд нэг ийм налсан, нялуурсан ийм юу өгчихсөн байх юм. Зөвлөгөө, зөвлөмж өгчихсөн байх юм. Тэгэхээр та энэ хэтрүүлж тавьсан л юун дээрээ надад.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Индрийн 3 дугаар микрофон.

**Ж.Дэлгэрсайхан:** Батчимэг гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хуулийн дагуу макро эдийн засгийн таамаглал, төсөөллийг боловсруулж, Эдийн засаг хөгжлийн яам руу явуулдаг. Энэ хүрээндээ бид нар тооцоолол хийхдээ 2, 3 үндсэн хүчин зүйлийг харгалзан үздэг юм.

1 дүгээрт, гадаад эдийн засгийн орчны нөхцөл байдал.

2 дугаарт, Монгол Улсын эдийн засгийн орчны нөхцөл байдал, цаашдын хандлага, эрсдэлүүдийг бид хардаг.

3 дугаарт нь загваруудад үндэслэн макро эдийн засгийн төлөв байдлыг таамагладаг ийм 3 үндсэн зүйлийн нэгдлийг бид тайлагнаж холбогдох талууд руу явуулдаг юм. Тэгэхээр энэ дээр таны хэлж байгаа зүйл дээр бид макро эдийн засгийн загварын тооцоолол бид нар дигнар болон кайм гэж 2 загварыг ашигладаг. Өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал дээр суурилсан тодорхой хязгаарлалтууд байгаа гэдгээ бол бид дүг өөрсийнхөө энэ баримт дээр 106 хуудас баримт байгаа энэ дээрээ дурдсан. Тэгээд бид нарын энэ дээр гол нь голлох саяын таны хэлээд байгаа 2 хүснэгтийг бид Эдийн засаг, хөгжлийн яам руу хүргүүлсэн юм.

1 дүгээрт нь макро эдийн засгийн үзсэн үзүүлэлтийн төлөв байдлын таамаглал нь бол тухайн үед бол татварын өөрчлөлт яригдаж байсан учраас татварын нөлөөлөлгүй болон нөлөөлөлтэй ийм 2 хүснэгтийг хүргүүлсэн. Энэ загвараа бол бид тайлбарлахдаа загвар бол бидэнд төлөвийг харуулж байгаа юм. Яг өмнөх нөхцөл байдлаар эдийн засаг цаашаа үргэлжилсэн тохиолдолд өнөөгийн бидний эцсийн бүтээгдэхүүний гол үнүүдийн таамаглал дээр суурилоод явахад нэг нөхцөл байдал ийм харагдахаар байна шүү гэдэг ийм зүйлийг харуулж байгаа.

Ер нь бол Монгол Улсын төсвийн болон эдийн засгийн нөхцөл байдал динамикаараа ийм өссөн байдлаар цаашаа явах нь ээ гээд энэ дээрээ нэмээд бид нар та манай дүгнэлтийн тэр хүснэгтийн доод хэсгийг харвал бид нар нэмээд энэний хүрээнд тодорхой зөвлөмжийг хүргүүлж байна гэсэн ийм зөвлөмжийг өгсөн юм. Тэгээд энэ зөвлөмжүүдээ бол бид энэ төсвийн тэлсэн бодлого хэрэгжүүлэхгүй байх, ДНБ-д эзлэх хувийг бууруулах, алдагдлыг бууруулах энэ байдлаар төсвөө төлөвлөөч ээ гэсэн ийм зүйлийг хэлж байгаа. Таны дараагийн

асуултад бол бид нар харьцангуй нийцтэй болоод байгаа гэдэг нь бол бид нар энэ түүхэн өөрчлөлтийг харж дүгнэдэг.

Өмнөх жилүүдэд бол манай хоёрын тоонууд нэлээд ялгаатай байсан ийм үе бол бий. Одоо бол Эдийн засаг, хөгжлийн яамны оруулаад ирсэн тоонууд нь эдийн засгийн өсөлтийн таамаглалууд дээр манай болон олон улсын байгууллагуудтай холбоотой энэ таамаглалуудтай нэлээд нийцтэй болоод байгааг бид нар тэгж харьцангуй ойртож ирж байна гэдэг байдлаар хэлж байгаа.

Үүнээс гадна бас материал бүрдүүлэлтийн хувьд хуулийн шаардлага дээр бол ахиц дэвшлүүд гарч байгааг бол бид дурдаж байгаа. Гэхдээ эцэст нь бол бид нар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг батлахдаа эрсдэлүүдийг тооцох, дунд хугацааны төсвийн хүрээний хууль, эрх зүйн орчныг баримтлах, дээрээс нь манай гол дүгнэлт бол энэ удаад төсвийн хүрээний мэдэгдлийн хууль, эрх зүйн чадамжийг сайжруулах чиглэл рүү.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Пүрэвийн Батчимэг гишүүн нэмж тодруулъя.

**П.Батчимэг:** Эдийн засгийн ер нь суурь асуудлуудаа шийдэж чадаагүй, одоогоороо энэ инфляцын өсөлт 2 оронтой тэгээд төсөөлөл нь болохоор ер нь их өөдрөгөөр төсөөлчихсэн. Энд гол энэ төсөөллүүд жишээ нь эдийн засгийн өсөлтийг 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6, хувь 29 онд 6.3 хувьд хүрнэ ээ гээд ийм хүлээлттэй том төсөөллийг тавиад өгчихсэн.

Инфляцаа 27 онд 7 хувь байхаар, 28 онд 6, 29 онд 5 хувьд хүрэхээр ингээд төсөөлөөд өгчихсэн байгаа юм. Тэгэхээр үнэхээр энд яг хүрч ажиллах энэ ирэх 3 жилд энэ төсөөлөл хэр магадлалын хувьд бодитой байж чадах юм? Эдийн. Засгийн хөгжлийн сайдаас асууя.

**Б.Пүрэвдорж:** Жадамбын Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Эдийн засгийн өсөлт 5.8, өнгөрсөн онд бид 6.8-аар гарсан. Бидний бас баталсан төсөөллөөс давж биелсэн. 5.8 гэдэг маань хэр өндөр юм бэ? Ер нь Монгол Улсын потенциал түвшин. Манай аж үйлдвэрлэлийн, экспортын уул уурхайн гээд худалдаа үйлчилгээний гол чадавхаа ингээд дүгнээд үзэхэд 6 орчим хувь дээр байгаа. Тэгэхээр энэ бол манай бодит чадавхад тулгуурласан гэсэн үг.

Олон улсын байгууллагууд Азийн хөгжлийн банк бол Монгол Улс 6 хувь өссөн гэж тооцсон. Бид бол 5.8. Дэлхийн банк бол 5.5 гэсэн бид нар 5.8. Олон улсын валютын сан 5.3 гэсэн бид нар 5.8 гэж. Яагаад ингэж тооцоолж байна вэ гэвэл өөдрөг байгаа. Өөдрөг байж байж улс орноо урагшлуулдаг, эдийн засгаа өсгөх ёстой. Тэгэхийн тулд хөгжлийн ийм төсөл хөтөлбөрүүд хэрэгжих боломж.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж 1 минут тодруулъя.

**Ж.Энхбаяр:** Хэд хэдэн гол зүйлүүд байгаа юм. Ер нь нүүрс олборлолт нэмэгдэнэ, экспорт нэмэгдэнэ, хил дамнасан төмөр замын холболттой ажлууд ашиглалтад орно. Боомтуудын гарц, ухаалаг худалдаанд учирч байгаа саад тотгоруудыг үндсэндээ арилгаад цэгцлээд дуусаж байна. Оюу толгой дахь зэсийн

баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдэж байна. Төмөр хүдрийн олборлолт, тээвэрлэлт нэмэгдэнэ. Зэсийн үнэ түүхэндээ их өндөр түвшинд гараад ирлээ. Тэгээд ган, зэс, нүүрс, пиролиз боловсруулах үйлдвэрүүд буюу боловсруулах салбарын үйлдвэрүүд нэлээн явна. Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын хөтөлбөрүүд үргэлжилнэ. Энийг гадаад, дотоодын зээлээр үргэлжлүүлэн дэмжиж явуулна.

Ингээд Баян, Бөөрөлжүүт, Сэлэнгэ, Тавантолгой гэх мэт цахилгааны станцууд, Эрдэнэбүрэний усан цахилгаан станцуудын барилга, бүтээн байгуулалтын ажлууд ид өрнөж байна. Энэ ажлууд үндсэндээ ашиглалтад ороод ирнэ буюу эдийн засаг бол нэлээн боломжийн өсөж эхэлнэ.

Ингээд дээрээс нь гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүдийн саналууд орж ирж байна.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Асуулт дээр нь дахиад. Пүрэвийн Батчимэг гишүүн нэмж тодруулъя.

**П.Батчимэг:** Таны өөдрөг төсөөллийг бол сонслоо. Энэ хүнсний, Евроазийн эдийн засгийн холбоо гээд худалдааны хэлэлцээр хийгээд л баахан гэрээ байгуулаад явчихсан. Тэр 367 нэр төрлийн бараа тарифын хөнгөлөлт яг эдэлж, үнийн чөлөөлөлт нь байгаа юм уу? Ингэснээрээ энэ хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэж байна уу?

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ингээд түрүүн тэгээд дуусгаадахъя. Эрчим хүчний томоохон төслүүд гадаадын томоохон хөрөнгө оруулалтууд нь нэлээн идэвхэжнэ. Тийм болохоор бид нар өөдрөг байгаа. Харин ч их даруу байгаа. Суурь түвшин дээрээ л байна гэсэн үг.

Нөгөө талаар Евроазийн эдийн засаг холбоотой хэлсэн гэрээ түүнийг гишүүн орнуудын парламент эцэслэн баталсан. 7 сарын аравдаар албан ёсоор гэрээ хэрэгжиж эхэлнэ. Маргааш бид нар хамтын Евроазийн эдийн засгийн холбоотой хамтын ажиллагааныхаа гэрээ бичиг, газрын зураглалаа гаргана гэсэн үг. Үйл ажиллагаагаа хэрхэн хөгжүүлэх вэ. 40 гаруй техникийн зохицуулалтууд байгаа. Гааль, хорио цээр, стандарт, мал эмнэлэг, ургамал хамгаалал гээд энэ төрийн байгууллага хооронд хамтын үйл ажиллагаа яаж уялдуулах вэ? Гаалийн тоо, бүртгэл үүсгэх, тэр барааны ангилалтаа цэгцлэхээс нэлээн олон ажлууд байгаа. Энэ мэнийгээ бид нар засгийн байгууллагууд энэ дээр ажлаа хийж байна. Хувийн хэвшлүүд, бас үйлдвэрүүд бэлтгэл ажлаа хангаж байна. 15-55 хувийн тарифын чөлөөлөлт орж ирнэ.

**Б.Пүрэвдорж:** Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Би нэг энэ техникийн чанартай асуулт асууя гэж бодож байна. Энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төсөөлөл боловсруулахад бол нэлээн гол гол макро хувьсагчтай хүчин зүйлсийг бол харгалзаж үзэж байгаа. Тэгээд тэр дотор ялангуяа инфляц байна л даа. Та хэд инфляцыг бол ерөнхийдөө 6 дээр нэмэх, -2 хувьд энэ түвшиндээ байна гэж бодоод

байдаг. Гэтэл 10 гарчихсан. Дээрээс нь ирэх 2 жилд инфляц бол өшөө өснө гээд Олон улсын валютын сан, Дэлхийн банк хэлээд байдаг. Бид нар чинь өөрсдөө дотооддоо үйлдвэрлэдэггүй, дандаа гаднаас импортолдог. Импортоор дамжиж инфляц нэмэгдэнэ. Бид нар экспортолж байгаа барааныхаа үнэд нөлөөлж чаддаггүй. Тэгээд ингээд инфляц чинь бол өөрөө ингээд компаниудын ашигт ажиллагааг бууруулна, зардлыг нь нэмнэ, ашигт ажиллагааг нь бууруулна. Ингэхээр татвар буурна гээд ийм ийм олон хүчин зүйлс байгаа байхгүй юу.

Тэгэхээр асуух гээд байгаа асуулт маань юу вэ гэхээр хэрвээ инфляц гэдэг хувьсагчийг жишээлбэл та бүхний төсөөлж байгаагаас 2-3 хувь нэгжээр өндөр байлаа гэж бодоход та бүхэн энэ дунд хугацааны төсвийн мэдэгдэл, төсвийн төсөөллөө хамгийн богинодоо, эсвэл хамгийн уртдаа буюу хамгийн ихдээ ямар хугацаанд өөрчилж чаддаг вэ? Өөрөөр хэлбэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засгийн хөгжлийн яам ингээд хамтарч ажиллаад, яамнууд хамтарч ажиллаад эдгээр мэдээллийг шинэчлэх ажлыг ямар хугацаанд хийж чаддаг юм бэ? Энэ талаар мэдээлэл өгөөч.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Мэдээж бид нар инфляцыг 7 оронтой тоонд барина гэсэн зорилттой байгаа юм. Ирэх онд шүү дээ 27 онд. Одоо гадаад орчны нөлөөтэй холбоотойгоор, шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор дэлхий нийтээрээ ялангуяа хөгжиж байгаа орнууд бол төсвийн нэлээн ачаалал авч байна. Тэгээд хариу арга хэмжээнүүдийг төлөвлөөд хэрэгжүүлж байна. Монгол Улс, Засгийн газар бол бид тогтвортой нийлүүлэлтийн асуудлаа нэлээн шийдэж нөөцийн хэмжээг нэлээн бий болголоо. Нөөцийн сав, агуулахын барилга ажлууд нэлээн эрчимтэй явагдаж байна. Үнэ дээр бид нар бас тодорхой үнийн тогтворжуулах гэрээ хэлэлцээрүүдийг нэлээн хойд хөрштэйгөө амжилттай хийсэн.

Тэгэхээр энэ өсөлтийн гол шалтгаан бол мах, төмс, хүнсний ногоо, гурил гэсэн бид дотооддоо хийгээд бүрэн зохицуулаад байсан энэ бараануудаас шалтгаалсан шалтгаанууд их өндөр байгаа. Энэ бол гаднаас хамааралгүй бид өөрсдөө шийдэх асуудал. Зохион байгуулалтын, мал, мах бэлтгэлийн, ногоо, хүнсний ногооны тарилтыг идэвхжүүлэх, энэ жилийн улаан буудай, үр тарианы тарилтыг идэвхжүүлэх ийм бодлогын арга хэмжээнүүдийг нэлээн авсан. Ялангуяа тариалалт хамгийн их шаардагдаж зардал болдог шатахууныг бол бид өнгөрсөн өвлийн хямдруулсан үнээр хямд үнээр тооцож, нийлүүлэлт хийсэн. Бордоо, ургамал хамгааллын бодисын нийлүүлэлтийг мөн ингэж хийгдсэн. Тэгэхээр харьцангуй одоо намар гэхэд ургацаа хураагаад энэ шалтгаалсан хүнсний инфляцууд нэлээн багасах байх.

Дээрээс нь Евроазийн орнуудтай хийсэн гэрээний хүрээнд бас Монгол Улсад тарьдаггүй, ургадаггүй, нэлээн олон төрлийн үйлдвэрлэдэггүй хүнсний болон бусад төрлийн бараа нэлээн орж ирнэ. Энэ маань бас нийлүүлэлтийн инфляцыг нэлээн бууруулахад их нөлөөллөө. Яагаад гэвэл энэ чинь 15-55 хувийн татварын босготой байсан зах зээл шүү дээ. Энийг тэглээд ирэхээр манай талд бас ялангуяа хөдөө аж ахуйн гаралтай хөнгөн үйлдвэрлэл дээр бол нэлээн том боломж гарна. 180 сая хүний зах зээл. Бид өмнө 3.5 сая хүний зах зээл дотоод хэрэглээндээ ажиллаж байсан бол одоо 180 сая хүний зах зээлд Монголын үйлдвэрүүд, аж ахуйн нэгжүүд өрсөлдөнө гэсэн үг. Тэр зах зээл хөнгөлөлттэй

нөхцөлөөр гарах бололцоо бүрдэж байгаа. Энэ мэтийн давуу талаа тооцоод бид нар юмнуудаа тооцно.

Инфляцын шок буюу энэ ойрх дорнодоос бол огцом хурцдаад бүүр дайны байдалд юу гэдэг юм мөргөлдөөн, сөргөлдөөний байдал ингээд хүндрээд эхлэх юм бол бид нар яаж нөлөөлөх вэ гэдэг тооцоонуудыг бүх хувилбараар хийгдээд байнга ажиглаж явж байна. Одоогийн байдлаар бол яг энэ шатахуун тогтсон үнэ дээрээ тогтох ийм төлөв байдалтай байна.

Төсвийн хүрээний мэдэгдлийг хийхийн тулд заавал олон нийтээр мэргэжлийн байгууллагууд хийж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэйгөө хамтарч, мэдээ тоонуудаа солилцож, статистик Монголбанк, Сангийн яам гээд олон байгууллагууд оролцож байж энэ тоо энэ дүн гардаг. Ийм болохоор бид нар хамтран сайн нэлээн ажилласан болохоор ерөнхий үзүүлэлтүүд, тоонууд их, ажил ижил төстэй, их зөрүү их багатай орж ирж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Соронзонболд гишүүн тодруулъя.

**Л.Соронзонболд:** Тодорхой асуугаад байгаа нь хамгийн богинодоо ямар хугацаа зарцуулах вэ, хамгийн ихдээ ямар хугацаа зарцуулах вэ л гэж асуусан шүү дээ. Тэгээд 14 хонох гээд байгаа юм уу, сар хонох гээд байгаа юм уу, 3 сар болох гээд байгаа юм уу тэрийгээ л хэлчих гээд байхгүй юу.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Дагаж байгаа хууль дотор бас энэ тодотгол хийх хугацааг бид нар чөлөөлж байгаа. Төсвийг бол хуучин хуулиараа үлдээнэ. Тодотголыг бол онцгой нөхцөл байдал үүссэн төсвийн тусгай шаардлага үүссэн нөхцөлд бол маш богино хугацаанд хариу арга хэмжээг аваад Засгийн газар тодотголоо өргөн бариад Их Хурал хурдан шийдэх бололцоотой болъё гэдэг ийм хуулийн төсөл энэ төсвийн хүрээний мэдэгдлийг дагуулаад өргөн барьсан 2 хуулийн 1 нь байгаа. Энийг дэмжигдэнэ гэж найдаж байна. Хэрвээ энэ хууль дэмждэг юм бол бид илүү засаг хурдтай хариу арга хэмжээг авах боломж бүрдэнэ.

Одоо хуулиар чинь бол батлагдсаны дараа 3 сар хөдлөхгүй гэдэг нэг ийм хатуу зохицуулалт яваад байгаа юм. Гэтэл гадаад орчны энэ огцом өөрчлөлтүүд, сөргөөр үйлчлүүлж эхэлбэл бид яаралтай арга хэмжээ авах ийм хуулийнхаа гарцыг нээе ээ гэсэн ийм хуулийн төсөл дагаж өргөн барьсан байгаа. Энэ хууль батлагдвал илүү хурдтай шуурхай ажиллах бололцоо бүрэн бүрдэнэ.

**Б.Пүрэвдорж:** Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууна.

**П.Мөнхтулга:** Монгол улс маань 30 гараад их наядын төсөв 1 жилдээ зарцуулж байна. Үүний 10-хан хувиар нь шинэ хөрөнгө оруулалтууд тавьж байна. Иргэд юу хүсээд байгаа вэ гэхээр хувийн хэвшлийнхэн маань дэд бүтэц тавиад өгөөч ээ, арьс ширний үйлдвэр хийхэд цэвэрлэх байгууламжийг нь төр барих үүрэгтэй, эрчим хүчээр хангах үүрэгтэй, сум, орон нутагт зам хүсэн хүлээж байна. Ингээд харахлаар уул нь төсөв маань нэмэгдээд байгаа одоогоос 8 жилийн өмнөхийг харах юм бол 4 дахин нэмэгдчихсэн байдаг. Гэтэл хөрөнгө оруулалт, цалин тэтгэвэр маань 4 дахин нэмэгдэхгүй байгаад байгаа.

Тэгэхээр энэний гол шалтгаан бол урсгал зардал дээрээ бид нар дэндүү үрэлгэн яваад байна. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 226800 төрийн албан хаагч байна. Төрийн өмчит хувьцаат компани дээр дахиад 40-50 мянган хүн байна. Энэ бүх хүмүүс чинь нийлээд хөдөлмөрийн зах зээлийнхээ 40 гаруй хувийг эзэлчжээ байгаа. Төр баялаг бүтээхгүй байна. Төрийн өмчит компаниуд ашигтай ажиллахгүй байна. Хувийн хэвшлийн хөдөлмөрийн зах зээлээсээ 40 хувийг нь булаачхаад хувийн хэвшлийнхнээсээ нийгмийн даатгалын сангаа бүрдүүл гээд ажилтан, ажил олгогч хоёроос нь хоёулангаас нь бүрдүүлээд тэтгэврээ нэмж чадахгүй байна. Тэтгэвэрт 1.4 их наядын татаас өгч байна. Тэтгэл өнөөдөр ахмадууд маань үнийн өсөлтөө барахгүй байна. 690 мянган төгрөг авч байна. 8 жилийн өмнө 500 мянган төгрөг байсан.

Тэгэхээр бид нар энэ төсвийн хүрээний 2 дугаар хэлэлцүүлэг явж байна. Бид нарт боломж байгаа. Засгийн газарт боломж байгаа. Эрс өөрчлөлт хийх реформын шинж чанартай энэ сонгуулиуд дөхчихсөн байна. 27 он, 28 он хоёулаа сонгуультай жил. Төсөв тэлнэ. Тэгэхээр энэ дээр яг цаг мөч нь энэ дээр реформын шинж чанартай өөрчлөлтөө хийгээд нэг өмнө нь явж ирснээсээ арай өөр явмаар байгаа юм. Гаргалгаа нь бол энэ цахимжуулалт чинь E-Mongolia-гаар 1280 төрийн үйлчилгээг цахимжуулчхаж. Энэний ард орон тоо цөөрөх л ёстой. Тэтгэл эсрэгээрээ нэмэгдээд л байна.

1280 үйлчилгээг хүн үзүүлдэг байсан бол цахим систем өөрөө үзүүлдэг болчихлоо. Яагаад энэ төрийн албан хаагчдын орон тоо хөдөлмөрийн зах зээл дээрээс буухгүй байгаа юм бэ? Хувийн хэвшлүүд чинь ажилтан хайгаад аргаа барсандаа бүүр гадаадаас оруулж ирж байна. Тэтгэл өнөөдөр төрийн албанд яг ямар ажил хийгээд байгаа юм? Энэ дээр аттестатчилал нэг шигшээ юм явуулж болохгүй юу? Энэ урсгал зардлын үргүй энэ ачааллаасаа Засгийн газар салж болохгүй юм уу? Энэнийхээ зөрөөн дээрээс бид нар тэтгэврээ ядаж энэ баялаг бүтээгч энэ хөдөлмөрийн зах зээлээ энэ баялаг бүтээгч нарт чөлөөлөөд өгөх юм бол Нийгмийн даатгалын сан чинь арвижаад л ирнэ шүү дээ.

Төрийн өмчийн хувьцаат компани дээр байгаа энэ олон хүмүүс яг төсөвт энэ 40 мянган хүн ажиллаад энэ олон төрийн өмчит компаниуд төсөвт ямар нэмэр үзүүлж байна. Өнгөрсөн бид нар энэ парламент 5 гаруй төсөв баталлаа тодотголтойгоо нийлээд. Төрийн өмчит компаниудаас төсөвт тэдэн төгрөг төвлөрүүлчихлээ гээд дорвитой мэдээ ерөөсөө сонсохгүй байна. Өөрсдийнхөө олсон ашгаараа урамшуулаад дуусчхаад байна. Цалингаа өөрсдөө 10, 20 саяар нь өөрсдөө тодорхойлоод байна. Тэгэхээр энэ болгон гажуудлаа засчих юм бол бид нар тэтгэвэр нэмэх, Нийгмийн даатгалын сангаа арвижуулах энэ боломжууд байгаа юм биш үү. Эдийн засаг, хөгжлийн сайд яг энэ дээр та нэг дорвитой реформын шинж чанартай ийм зүйл хийгээч ээ% Засгийн газарт л цаглавар, боломж нь байна. Энэ дээрээ хариулт авъя.

**Б.Пүрэвдорж:** Мөнхтулга гишүүн маш чухал асуулт асууж байна. Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төсөв юунд зарцуулагдаад байна? Нийгмийн даатгал, халамж, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө, цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал энэ бол урсгал зардал. Энэ маань улсын төсвийн чинь 80 хувь нь энэ эзлээд байгаа

байхгүй юу. Маш олон хуулиар. 200 гаруй хуулиар зардлыг хуульчилсан. Бидний хамгийн том сул тал уул уурхайн хэлбэлздэг орлогоос тогтворгүй орлогыг тогтвортой үйлчилдэг зардал болгочихсонд л асуудал байгаа байхгүй юу даа. Энэ зардал бол буухгүй, хүүхдийн мөнгө буухгүй, цалин, тэтгэвэр буухгүй, энэ халамж буухгүй. Орлого маань саваад байгаа юм. Яг өнөөгийн нөхцөл байдал юу болж байна вэ гэвэл сүүлийн эрүүл мэнд, боловсролын салбарын цалингийн нэмэгдлээр үндсэндээ Монгол Улс 27 онд шинэ хөрөнгө оруулалт хийх боломжгүй болж байгаа. Зөвхөн урсгал хийгдэж байгаа хөрөнгө оруулалтуудаа үргэлжлүүлэх бололцоотой. Бидэнд 3.6 их наядын урсгал санхүүжилт шаардлагатай бол бидэнд байгаа бололцоо 2.2 их наядыг л санхүүжүүлнэ.

Тэгэхээр юу хэрэгтэй гэвэл хүн ам өсөөд байдаг, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг Монгол Улсын 330 сумд хүргэх шаардлага хэвээрээ байгаад байдаг. Энийгээ дагаад цэцэрлэг, сургууль баригдаж байна, орон тоо нэмэгдэж байна. Яг цэвэр төрийн албаны тухайд бол төрийн алба тасралтгүй багасаж байгаа. 20 мянгаар багассан ийм тоо гарсан. Төрийн алба мэргэшсэн яг төрийн жинхэнэ албан хаагчдын тоо 20 мянгаар багассан. Засгийн газраас бол төрийн албанд энэ орон гарсан орон тоонд шинээр томилгоо хийгдэхгүй байгаа. Хэмнэлтийн горимд явж байгаа.

Ингэхээр одоо яах вэ? Бид үндсэндээ өнгөрсөн хугацаанд олсон орлогоо зардалдаа, нийгмийн хамгаалал талдаа илүү түлхүү зарцуулчихжээ. Ингээд манай эдийн засгийн потенциал маань дээд хэмжээнд тулаад ирж байна. Одоо бидэнд шинэ хөрөнгө оруулалт хэрэгтэй. Шинэ Эрдэнэт хэрэгтэй, шинэ Оюу толгой хэрэгтэй, Шинэ Тавантолгой хэрэгтэй. Шинэ цахилгаан станц, шинэ төмөр зам барих хэрэгтэй. Тэгэхийн тулд яах вэ? Энэ хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах, энэ эдийн засаг, худалдаа хувийн хэвшилд тээг болоод байгаа бүхий л тэр асуудлыг чөлөөлдөг. Учралын Засгийн газрыг чөлөөлөлтийн Засгийн газар гэж нэрлэж байгаа. Бид энэ эрх зүйн хүрээнд, бизнесийн орчны хүрээнд дандаа чөлөөлөлтөө хийнэ.

Ирэх 7 хоногт бид бас Их Хуралд бизнесийн эрх чөлөө, хөрөнгө оруулалтын энэ зөвшөөрлийн хуулиуд энэ эдийн засгийг дэмжих энэ багц хуулиудыг оруулж ирж хэлэлцүүлнэ. Бид хандлагаа өөрчлөхгүй бол хөрөнгө оруулалтыг дэмжиж урамшуулахгүй бол бизнесийн халдашгүй байдал, өмчийн халдашгүй байдлыг хангахгүй бол болохоо байсан. Үндсэндээ байгаад суурилагдсан хүчин чадал, бүхий түвшиндээ дээд түвшиндээ хүрсэн. Төмөр зам дээд түвшиндээ хүрсэн. Эрчим хүч дээд түвшиндээ хүрсэн Эрдэнэтийн үйлдвэр дээд түвшиндээ хүрсэн. Тавантолгойн нүүрс дээд.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** 1 минут нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төмөр зам маань дээд түвшиндээ хүрч, ачаа тээврээ хийсэн. Нүүрсний салбар дээд түвшиндээ хүрсэн. Одоо олох орлого маань энэ төсвийн хүрээнд заагдсан энэ орлогын түвшинд л гарна. Илүү гарахгүй. Илүү гарахын тулд яах вэ гэвэл бидэнд шинэ ажлууд хэрэгтэй. Бид шинээр нөөц нь тогтоогдсон орд газруудаа, алтны орд газруудаа эргэлтэд оруулмаар байгаа юм. Тэгэхийн тулд Ашигт малтмалын хуулиа өөрчилье. Энэ гадаадын хөрөнгө оруулалтаар үүссэн бөөн гомдлууд байна. Шийдэгдээгүй асуудал. Энийгээ шийдвэрлэе. Татварын

маргаанууд байна. Энийг шийдвэрлэе. Арбитрын маргаан байна. Энийг шийдвэрлэе.

Тэгэхээр энэ эрх зүйн орчныг энэ 7 хоногт оруулж ирнэ. Өнгөрсөн Засгийн газраар хурлаар хэлэлцэж дагасан 115 хуулийг өөрчилж байгаа юм. 115 хуулиар эдийн засгийн эрх чөлөөг, хөрөнгийн халдашгүй байдлыг хамгаална. Одоо харамсмаар зүйлүүд их байна шүү дээ. Томоохон томоохон нөөцүүд байна. Бэлэн болсон ордууд байна. Ашиглуулдаггүй. Олон.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

**Д.Ганмаа:** 10-аад гишүүд байна. Энэ дээр ийм асуулт асууя. Энэ Монголын энэ дундаж наслалт нь эрэгтэйчүүдийнх 76 биш ээ, эмэгтэйчүүдийнх нь 76, эрчүүдийнх 67 гээд 9.2 жилийн зөрүүтэй. Тэндээсээ ялангуяа их санаа зовж байгаа асуудлууд бол харьцангуй залуугаасаа эрчүүд амь насаа алдах эрсдэлүүд маш өндөр байгаа. Гол шалтгаануудыг нь мэдээж та тодорхойлдог. Зүрх судасны өвчин, халдвар, хавдар, архи, тамхидалттай холбоотой асуудлууд, даралт ихсэх, замын осол, тээврийн осол гэх мэтчилэн.

Эдгээр тохиолдлууд бусад улс оронд ч гэсэн энд тохиолдож байсан. Жишээлбэл хамгийн түрүүнд эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд анхаарч стратегийн бүүр эрүүл мэндийн тийм интервенц хийсэн улс нь Ирланд Улс юм байна лээ. Одоо Австралид жишээлбэл энэ бас явагдаж байдаг. Тэгснээр эрэгтэй, эмэгтэйчүүдийн насны зөрүүгээсээ гадна залуу эрчүүдийг цаг бусаар алдах энийг бууруулсан тийм системтэй үйл ажиллагаа хийсэн.

Тэгэхлээр манай Монгол Улс ялангуяа дараа 2010, уучлаарай 27 онд эрүүл мэндийг дэмжих жилтэй холбоотой яг энэ эрчүүдийнхээ амь нас, эрүүл мэндэд зориулсан ийм стратегийн төлөвлөлт боловсруулсан, хийсэн, гаргасан, бодсон юм Эдийн засгийн яамнаас, Эрүүл мэндийн яамнаас, Гэр бүл, хөдөлмөр төлөвлөлтийн яамнаас, ер нь Засгийн газраас юу байна гэдгийг асуумаар байна. Энэ бол зөвхөн эрүүл мэндийнх гэхээсээ илүүтэй ерөөсөө бүүр Засгийн газрын бодлогын асуудал байгаагаар.

Тэгснээрээ энэ дундаж наслалтыг бууруулахаасаа гадна жишээлбэл эрүүл мэнд дээр гэхэд чинь тусгайлан бүүр ийм эрүүл мэндийн даатгалын багц гаргамаар байхгүй юу. Эрчүүдэд зориулсан. Даралт бууруулах, холестерол бууруулах, чихрийн шижинг бууруулах, элэгний үйлчилгээг сайжруулах, архи, тамхийг бууруулах, депрешт гээд юу гэдэг билээ амиа хорлох эдгээрийг бууруулах ийм target-д ийм асуудлуудыг тэгээд бүүр 25-аас 64 нас гээд насыг нь бүүр зааж өгөөд.

Магадгүй эрчүүд хамгийн их ажилладаг газар энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайн хүргэх. Яагаад гэхээр эрчүүд өвдөхөөрөө дандаа бүүр эцсийн шат руу юм уу, бүүр сүүл рүүгээ л эмнэлэг, тусламжийг хайж явдаг юм байна. Эдгээр ийм асуудлууд байгаа юм. Тэгээд одоо бид нар ингээд хайхаар зэрэг хавсралт 2 дээр уул нь байна л даа. Хөтөлбөр хэрэгжүүлнэ гээд. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн арга хэмжээ гээд. Арга хэмжээний хэрэгжилттэй нь 66.2 хувиас 70 хувь руу нэмнэ гэсэн боловч энийг саяын миний нэрлэсэн шиг яг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж чадаж байгаа юу?

Жишээлбэл, суурь түвшин нь ийм байхад дараа жил яах юм? Жилийн дараа юм уу, 2 жилийн дараа магадгүй эрэгтэй, эмэгтэйчүүдийн насны зөрүүг 0.5 насаар бууруулна ч гэдэг юм уу. Эсвэл эрт илрүүлэгт эрчүүдээ илүү оруулна. Эрүүл мэндийн даатгалаас багцыг тусгайлан бий болгоно ч гэдэг юм уу тийм тооцоолж болох шалгуур үзүүлэлтээр оруулаад тэр нь шинжлэх ухаанд суурилсан яг үнэхээр өөрчлөх боломжтой тийм юмнууд оруулж ирж байна уу, оруулж ирэх гэж байгаа юу гэдгийг нэг хариулж өгнө үү. Зүгээр нийт тэдэн хүнийг тэгж хамруулсан гээд л яваад баймааргүй байна. Тийм нэртэй гоё гоё олон хөтөлбөрүүд байгаа. Одоо хүртэл яг бодит үр дүн нь хүрчихсэн юм байхгүй. Үр ашгийн тооцоолол огт байхгүйгээр гоё нэр өгөөд л тэгээд баахан компани ажлууд өрнүүлээд яваад байдаг.

Тэгэхлээр энэ нарийн хэвчилсэн байдлаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн арга хэмжээ гэж яг юуг хэлж байгаа юм, ямар шалгуур үзүүртэй юм, суурь түвшин нь юу юм, юу болгочихсон байх юм бэ гэдгийг хариулж өгнө үү.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Учрал Ерөнхий сайд нь Засгийн газар гол бодлогоо хүний хөгжил гэж үзэж байгаа. Тийм болохоор эрүүл мэнд, боловсролын салбарыг тэргүүлэх салбар гэж зарлаж, энд тавигдах хөрөнгө оруулалтуудыг хамгийн өндөр тавьж байгаа. Эрүүл мэнд боловсролын салбарын хөрөнгө оруулалт бол 2-3 дахин өссөн. Энд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын цалин хөлсний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Хамгийн өндөр нэмэгдлийг өгсөн. Тийм ч учраас бас өнөөдөр бас бусад салбарт хөрөнгө оруулалт хийх боломж хязгаарлагдаж байгаа.

Нөгөө талаар хүн ам маань өсөж байгаа. Монгол Улсын хүн ам тасралтгүй өсөж байна. Бид 3.5 сая болсон. Хүн амын насжилт нэмэгдэж байгаа. Бид нар 90 онд чинь дунджаар 58, 56, 58 насалдаг байсан. Одоо 72, 3 дундаж нас гарчхаад 15, 6 жилээр дундаж нас уртасчхаад байна шүү дээ. Энэний цаана чинь амьдралын чанарын өөрчлөлт, эрүүл мэндийн үйлчилгээ, иддэг, уудаг, амьдрах орчин гээд маш олон зүйл.

Дээрээс нь эрүүл мэндийн боловсрол их сайжирч байгаа л ийм шинж. Тэгэхээр хүн ам маань өсөлт хадгалагдсан хэвээр байна. Насжилт нэмэгдэж байна. Улам цаашдаа улам л энэ чиглэлийн арга хэмжээнүүд цаашдаа хийх ёстой. Яагаад гэвэл Монгол хүн боловсролтой байх ёстой. Эрүүл байх ёстой. Тэгж байж хөгжлийн суурь хангагдах учиртай. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд гээд ийм хөгжлийн бодлого дээр бас ийм бодлогын арга хэмжээнүүд төлөвлөгдөөд тодорхой эх үүсвэртэй ингээд зорилт болоод бас явж байгаа. Тэгээд эрчүүдийн төлөө санаа тавьсан Ганмаа гишүүндээ их баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ганмаа гишүүн нэмж тодруулъя.

**Д.Ганмаа:** Яг тусгайлан хавсралт 2 дээр байгаа эрэгтэйчүүдийн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх гэдэг дээр ямар арга хэмжээ төлөвлөсөн юм, шалгуур үзүүлэлт нь юу юм, ямар болгоно гээд төлөвлөж байгаа юм гэдэг дээр хариулах ажлын хэсгээс энэ тэр байна уу?

**Б.Пүрэвдорж:** Яг энэ, Энхбаяр сайд хариулчихъя даа. Яг ажлын хэсэг дээр яг энэ чиглэл дээр байхгүй байгаа.

**Ж.Энхбаяр:** Энэ дээр маргааш 2027 оны хөгжлийн төлөвлөгөө орно. Тэр үед бүх салбарууд ирнэ. Одоо төсвийн хүрээний мэдэгдэл буюу макро эдийн засгийн асуудал ярьж байгаа болохоор энэ талын улсууд ирсэнгүй. Маргааш таны хариултыг уламжлаад, маргааш танд хэлэлцүүлгийн үеэр хариулахаар бэлдэж ирье, ирүүлье ээ.

**Б.Пүрэвдорж:** Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна. Үг хэлж болно шүү бас.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Би энэ нөгөө төсвийн хүрээний мэдэгдлийн файл дээр харахлаар энэ дээр байна л даа. Хэлэлцүүлэг хийсэн гэж байгаа юм. Иргэдийн оролцоог хангах, иргэдийн санал санаачилгыг төсөвт тусгах зорилгоор 26 оны 03 дугаар сарын 30-ны өдөр олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн юм байна гэж байна. Цахим хэлэлцүүлэг хийгээд бас 1030 гаруй хариулт, санал хүлээж авсан гэж байна.

Энэ дээр ирсэн энэ саналууд нь хэлэлцүүлэгт орж байгаа хүмүүсийнхээ хүртээмжийг ер нь хэр хангасан бэ гэдгийг нэг тодруулчихъя. Яагаад гэвэл 2 энэ бараг хэд дэх удаагийн төсөв бид нар ярьж байна гэхээр үргэлж нэг алдаатай зүйл нь юу вэ гэхлээр хэлэлцүүлэгт оролцуулж байгаа хүмүүсийг оролцуулах жишээлбэл нийгмийн нөгөө бүлгүүд байна шүү дээ, орон нутагт байгаа хүмүүс зэргийг хэр хамруулсан асуудал дээрээс нь хэлэлцүүлгүүд нь өөрсдөө хэр хүртээмжтэй байдаг вэ гэдгийг бид нар ер нь харахаар юм билээ.

Улсын Их Хурал дээр хуу хууль өргөн барихад бол гишүүд d.parliament дээр байршуулаад Засгийн газар ер нь хууль бол аягүй харьцангуй ил тод юм байна. Хуулийн төсөлд боловсруулж байгаа явц, одоо ингэлээ гээд бүх процесс нь d.parliament-аар харагддаг. Мэдээлж болдог.

Засгийн газрын боловсруулж байгаа тогтоол, тушаал, баримт бичиг эд нар чинь ерөөсөө ингээд иргэдэд ил тод тавьж санал авдаг процесс нь аягүй сонин хаалттай байгаад байгаа байхгүй юу. Ил тод биш, хүртээмжтэй биш. Тэгэхээр энэ хамгийн чухал улсын төсөв ирэх жил яг энэ улс юу хийх вэ? Энэ дотор ямар мөнгө байгаа вэ дээрээ үүний ил тод байдлыг би тодруулах гээд байгаа юм. Тэгээд өнгөрсөн жилээс ингээд ирсэн ялгаатай байна уу, үгүй юү өнгөрсөн жил хэлэлцүүлэг хийлээ, санал нь ирлээ гэдгийг ингээд харахаар их тийм ахицтай дээрдсэн зүйл харагдахгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр өмнөх жилүүдийн төсвийн хүрээний мэдэгдлээс энэ удаагийн энэ олон нийтийн саналыг авсан хэлэлцүүлэг чинь хэр хүртээмжтэй болсон юм бэ, хэр багтаамжийн хувьд олон хүмүүсийг хамруулсан юм бэ, хэр иргэдийг хамруулж чадсан юм бэ гэдгийг би тодруулж яг энэ хэлэлцүүлэгтэй холбоотой асуултыг процессыг нь тодруулж авмаар байна. Тэгээд дараа нь тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Манай яам дэргэдээ Хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалах төв гээд ийм төв байдаг. Үүгээрээ дамжуулан энэ хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Олон улсын байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, валютын сан.

Нөгөө талаас Монголын томоохон аж ахуйн нэгжүүд, экспортлогч, импортлогч, гол бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил дээр анхаарч байгаа ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдээр ажиллана. Гадаадын хөрөнгө оруулалтын гол гол улсуудыг урьж ярилцана. Хамгийн гол нь энэ бол цэвэр мэргэжлийн түвшний хэлэлцүүлэг болдог. Энд бол их сургуулийн профессорууд, эрдэмтэд, Монголбанк, аудит, тэгээд санхүүгийн ер нь гол мэргэжлийн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд мэргэжлийн улсуудын хэлэлцүүлэг, мэргэжлийн мэтгэлцээн болдог. Зөв төсөөлж байна уу, орлогоо зөв төсөөлж байна уу, зарлагаа зөв төсөөлж байна уу, эдийн засгийн өсөлтөө яаж гаргаж байна, гол эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нөлөөллүүд нь юу юм, ямар төсөл, хөтөлбөрүүдээс ингэж тооцоо гарч байгаа тухай нэлээн мэргэжлийн нэлээн халуун ярианууд болдог.

Тэгэхээрээ бас харьцангуй тийм нийтийг хамарсан бүх нийтийн хэлэлцүүлэг болдоггүй. Болох ч боломжгүй. Энэ бол цэвэр мэргэжлийн хүрээнд эдийн засагч нарын хүрээнд явагддаг. Ийм хэлэлцүүлэг байдаг. Тэгээд тэрийг бол бид нар сайн хийсэн болохоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөл манай хоёрын тоонууд маш олон зүйлээрээ давхцаад бодлогын хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн саналууд нэгдээд байгаа байдал маань энэ хэлэлцүүлэг сайн хийсний үр дүнд ингэж гарч ирж байгаа.

Өмнө чинь энд 2 тал болчихоод хоорондоо мэтгэлцээд эхэлдэг байсан бол харьцангуй тэр асуудал багасчихсан байгаа биз дээ гэдэг чинь бид нар хэлэлцүүлгээ, бэлтгэл ажлаа хий сайн хийсний л шинж гэж би үзэж байна.

**Б.Пүрэвдорж:** Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Би энэ Төсвийн хүрээний мэдэгдлийн номоос хараад ярьж байгаа шүү. Эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын ирүүлсэн санал дээр жишээлбэл, шинжлэх ухаанд чиглэх хөрөнгө оруулалтыг нэмэх гээд тэгж байгаа юм. Тэгэнгүүт саналыг тусгасан тайлбар нь болохоор саналыг хүлээн авч, анхаарч ажиллана. Иргэний нийгмийн байгууллагын санал байна л даа. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах гэдэг санал энэ дээр оруулсан байгаа. Саналыг тусгасан эсэх тайлбар нь болохоор саналыг хүлээн авч, боловсруулахад анхаарч ажиллана. Орон нутаг болон хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжээч гэхээр саналыг хүлээн авч, анхаарч ажиллана. Ийм хэлэлцүүлэг хийчхээд тэгээд энийгээ хэлэлцүүлэг гэж нэрлэх юм уу? Би ер нь энэ цаашдаа хэлээд байгаа шүү дээ хэлэлцүүлэг хүртээмжтэй биш байгаа шүү гэж хэлээд байгаа. Тэгээд ийм хэлэлцүүлэг хийхээр энийг хэлэлцүүлэг гэж тооцох юм уу тооцохгүй юм уу гэдэг энэ санал энэ дээр л эргэлзээд байна л даа. Ингээд саналыг хүлээн авна гэдэг чинь хэлэлцүүлгийн хариу юм уу? Тэгээд энэ дээр нь байгаа, байхгүй нь мэдэгдэхгүй байгаа байхгүй юу. Энэ дээр нь тусгагдсан үгүй нь мэдэгдэхгүй байна шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төсвийн хүрээний мэдэгдэл маань өөрөө ингээд төсөл, хөтөлбөр нь ярих, задлах бололцоо байхгүй шүү дээ. Бүх төсвийн захирагч нараас бүх саналаа авна, бүх орон нутгаас саналаа авна, бүх салбаруудын саналыг дүгнээд ингээд ерөнхийдөө энэ 9 эдийн засгийн энэ үзүүлэлтээр л энэ хуулийн төсөл орж өргөн баригдана. Тэгэхээрээ бид нар энэ болгоныг анхаарна гэдэг маань энэ зардал, нийт зарлага дотроо оруулна аа, анхаарна аа, хөгжлийн бодлогодоо тусгана гэж байгаа юм.

Тийм болохоор энэ төсвийн хүрээгээ бид нар баталчхаад үүнийг дагуулаад хөгжлийн бодлого орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ батлагдсан төсвийн хүрээнд нөгөө хөгжлийн бодлогод туссан зорилтууд чинь наагдаад ороод ирнэ. Энийгээ бид нар маргааш, нөгөөдөр хэлэлцээд дуусгахаараа тэгээд намар төсөв орог өргөн барихад энэ төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд, энэ орлого, зарлагын хүрээнд төсөв хөгжлийн бодлогод туссан энэ зорилтууд төсөвт ингэж тусаж гарч ирнэ ээ гэдэг маань намар гарч ирнэ.

Тэгэхээр наад туссан санаанууд чинь бүгд намар болохоор яг салбар салбараар тоондоо хуваагдана, зардал нь яг тодорхой болж байгаа орж ирнэ шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Та бүхэнд оройн мэнд хүргэе. Тэгээд сүүлийн үед энэ Улсын Их Хурал дээр ёс зүй, гишүүдийн оролцоо маш их яригдаж байгаа. Бид нар 2027, 2028, 29 гээд ирээдүй цаг дээр ярих ёстой. Энэ дээр бол бид нар Улсын Их Хурлын гишүүд маш сайн ирцтэй байх ёстой. Гэтэл манай эрх эрх баригч намаас асуулт асуух гэж байгаа 4, 5 гишүүн байна. Төсвийн байнгын хорооны дарга байна. Эдийн засгийн хөгжлийн яамны сайд нь байна. Сангийн яамны сайд алга. Хэрэгтэй ёстой өнөө, маргаашгүй Их Хурлын чуулган дээр асуултад хариулахад бэлэн байдалд байна гэсэн Сангийн яамны дэд сайд маань ч алга. Тэгээд би бол одоо ирээдүй цагийг ярих гэхээр одоо цаг дээр чинь алдаа гарчхаад байгааг л ярих гэсэн юм.

Сангийн яамнаас би уг нь энд Сангийн яамны сайд, эсвэл дэд сайдаас нь, болохгүй бол Төсвийн байнгын хорооны даргаас асууя. Боловсролын яамны энэ төсөв дотор багш, ажилчдын цалинг үндсэн цалингийн 50 хувиар нэмнэ гэсэн хамтын ажиллагааны хэлэлцээр байгаа юм. Гэтэл манай Энх-Амгалан сайд нэмэгдэл цалинг нь ч гэсэн 50 хувиар нэмэгдүүлнэ гэж хэлээд 600 гаруй тэрбум төгрөгийн асуудал гаргаж ирээд тавьчихсан. Одоо энэ асуудал чинь явах юм бол 1.1 их наяд төгрөгийн асуудал яригдана. Төсөв өөрөө тодотгол хийхэд Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Төсөв батлах, төсвийн тодотгол хийхэд Улсын Их Хурлын бүрэн эрх. Гэтэл тэнд нэг яамны сайд нь дангаараа дур мэдээд 300 гаруй тэрбум төгрөгөөр үндсэн цалин, бусад цалин, бүгдийг нь нэмж байгаад улсын төсөв дээр 1.1 их наяд төгрөгийн асуудал аваад ирж байгаа юм.

Хариуцлага ярина гэх юм бол төсвийн тухай хуулийн 70.3, 70.4 дээр боловсролын яамны буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн ажлын хариуцлагын асуудал шууд яригдах ёстой. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны асуудал өнөөдөртөө бол цөөнхөөс тавигдсан дарга хариуцаж байгаа буюу би хариуцаж байгаа юм.

Тэгээд бид нар өнөөдөр 1.1 их наядынхаа асуудлыг ярихгүйгээр одоо байгаа асуудлаа шийдэж чадаагүй байгаа. Одоо магадгүй энэ 5, 6 сард хичээллээд сургууль, цэцэрлэг амрахад амралтын мөнгийг нь өгч явуулаад 9 сараас эхлээд багш нартаа өгөх, багш, ажилчдадаа өгөх цалин байхгүй. Одоо бид нар тодотгол батлаагүй байгаа үе. 2025 оны 10, 11 дүгээр сард бид нар төсөв батлахад тодотголыг нь яриагүй шүү дээ. Батлахад 620 орчим тэрбум төгрөгийн асуудал сох дутаж байгаа юм. Энэ асуудлыг яахаараа нэг яамны сайд дангаараа асуудлыг шийдээд яваад байдаг юм. Пүрэвдорж дарга энэ дээр бас анхаарал хандуулаад протоколд оруулмаар байгаа юм. Нэг яамны нэг сайд дангаараа 600 гаруй тэрбум төгрөгийн нэмэгдэл, нийт дүнгээрээ 1.1 их их наяд төгрөгийн асуудлыг шийдээд байж болохгүй. Тодотгол орж ирээгүй байгаа. Одоо бид нар 2025 оны 11 сард баталсан Төсвийн тухай хуулиар явж байгаа юм. Эдийн засгийн хөгжлийн яам бол хамаагүй байх. Энэ дээр Сангийн яам, Боловсролын яам хариулах, ёстой. Эдийн засаг, хөгжлийн яам магадгүй ирээдүй цагийнхаа төсөөллийг оруулж ирж байгаа байж болно.

Гэтэл Боловсролын яаман дээр чинь нэгхэн яаман дээр Улсын Их Хурлаас баталж өгсөн төсвөөс хамааралгүйгээр 600 тэрбум төгрөгийн нэмэгдэл буюу нийтдээ 1.1 их наяд төгрөгийн асуудлыг яриад сууж байгаа. Энэ хариуцлагыг бид нар хэзээ ярих ёстой вэ гэдгийг асуумаар байгаа юм.

Яах вэ 05 сарын 19-нд би энэ Зарлагын хяналтын дэд хорооны нэрийн өмнөөс Сангийн яам руу хөтөлбөр, арга хэмжээ, зориулалт, эдийн засгийн ангиллаар Сангийн яамнаас баталсан 1-12 сарын хооронд хэрэгжих ёстой санхүүжилтийн хуваарийг авъя гээд явуулсан байгаа. Энэ дээр ямар нэгэн тайлбар одоогоор бол бас ирээгүй байгаа. Тэгэхдээ энэ Сангийн яаманд хамаагүй байж магадгүй.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ нэлээн маргаантай асуудал үүссэн. Гэхдээ энэ асуудлыг нэг мөр болоод шийдвэрлэсэн. Боловсролын салбарын 1772 байгууллага Монгол Улсад байна. Нийт 91499 багш, ажилчид, нөгөө 220 мянган төрийн албан хаагчдын 91 мянган чинь багш нар байхгүй юу. Эдний цалингийн сүлжээг нь нэг сүлжээтэй болгосон. 05 сарын 01-нээс 50 хувь нэмэгдсэн байгаа. Үүнээсээ нэмэгдэл цалингаа тооцуулж авдаг боломж бүрдүүлсэн. Ингээд энэ салбар тойрсон асуудлууд ингээд дууссан байгаа.

Нийтдээ энэ цалингийн зардлын 50 хувь 11 сараас 26 хувь нэмэгдүүлэх ийм хуулийг Их Хурал баталсан. Нийтдээ 822 тэрбум төгрөгийн нэмэлт үүсэж байгаа. Энэ яам нэмэх биш Засгийн газраас эрүүл мэнд, боловсролын салбарын цалинг, нэмэлтийг өргөн бариагүй. Улсын Их Хурал дээр төсөв өргөн барьснаас хойш хэлэлцүүлгийн явцад нэмэгдсэн зардал шүү дээ. Энэтэй холбоотой Сангийн яам нэмээд тайлан өгөөдхөөч.

**Б.Пүрэвдорж:** Сангийн яамнаас тайлбар өгчих.

**З.Мэндсайхан:** Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Боловсролын салбарын цалин өнгөрсөн оны төсөв хэлэлцэж байх үед 3 талт хэлэлцээр хийгээд

төсөв Засгийн газар өргөн барьсны дараа цалин нэмэх асуудал үүссэн. Ингээд Их Хурал дээрээс 618 тэрбумыг багш нарын үндсэн цалин, эрүүл мэндийн салбарын ялангуяа багш нарын цалинг үндсэн цалинг 50 хувиар нэмэхээр ингээд шийдвэр гаргасан.

Засгийн газар төсөв батлагдсаны дараа энэ батлагдсан төсвийнхөө хүрээнд энэ асуудлаа шийдвэрлэхийг Боловсролын сайдад үүрэг болгосон. Боловсролын сайд энийг хэрэгжүүлэхдээ багш, ажиллагсдын цалинг нэмчихсэн. Ингээд багш ажиллагсдын цалинг нэмэгдээд төсөв нь хүрэхгүй болохоор хуучин үндсэн цалингаас нь нэмэлт урамшууллыг нь бодоод ингээд боловсролын салбар 2 цалингийн системтэй болчихсон байсан. Манай Засгийн газар энэ асуудлыг шийдвэрлээд үндсэн цалин дээрээс нь тэр нэм.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж хариулья.

**3.Мэндсайхан:** Шинэ үндсэн нэмэгдсэн үндсэн цалин дээрээс нь нэмэлт тэр багш нарын урамшууллыг нь тооцоод явдаг энэ 2 систем рүү шилжүүлж 2 цалингийн шатлалыг нь байхгүй болгосон. Энэ хэрэгжилт дээрээ багш, ажиллагсад гэж нэмэгдсэн учраас 677 тэрбумын нэмэлт санхүүжилтийн асуудал үүссэн. Ингээд Засгийн газар шийдвэр гаргахдаа Боловсролын сайдын батлагдсан төсвийнх нь хүрээнд энэ асуудлыг нь шийдвэрлээд явж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Цогтбаатар гишүүн нэмж тодруулья.

**Да.Цогтбаатар:** Үгүй ээ энэ Сангийн сайд бол зөв хариулж байна. Одоо бид нар тодотгол хийх хүртэл бол тэр 618 тэрбум төгрөгийн асуудлыг шийдсэн. Тодотголын чинь асуудал өнөөдрийг хүртэл орж ирээгүй байгаа буюу Боловсролын сайд өөрөө дангаараа 1.1 их наяд төгрөгийн асуудлыг тодотголгүйгээр шийдээд байгаа учраас хариуцлагыг нь хэн хүлээх юм бэ л гэдэг юм яриад байгаа юм. Тодотгол хийгдээгүй байгаа одоогийн байдлаар. Яг зүгээр Сангийн сайдын саяын тайлбараар багш, ажилчдын үндсэн цалингийн нэмэгдэл 50 хувийг 618 тэрбум гээд Улсын Их Хурлаас Төсвийн тухай хууль батлахдаа шийдээд өгчихсөн буюу шинэ боловсролын сайд Энх-Амгалан сайд гарч ирээд 1.1 их наядыг буюу намар хүртэл бүх цалингийнхаа санг дуусгачхаад байгаа юм.

Гэтэл бид нар тодотгол баталж өгөөгүй байгаа. Тэгээд ингэж дураараа нэг сайд хандаж болохгүй ээ л гэдгийг хэлээд байгаа юм. Тодотгол чинь батлагдахгүй бол яах юм?

**Б.Пүрэвдорж:** Сангийн сайд хариулья.

**3.Мэндсайхан:** Засгийн газрын тогтоол төсвийн ерөнхийлөн захирагч нь батлагдсан төсөвтөө багтаа гэсэн заалттай. Тэгэхээр Боловсролын сайд хөрөнгө оруулалт болон бусад зардлаа одоогоос эхлээд танаад, хэмнээд явж байгаа батлагдсан төсөвтөө хамааруулаад.

Тодотгол хийх төсвийн тусгай шаардлагууд бол үүсээгүй байна. Гэхдээ бид нар сая төсвийн хүрээг өргөн барихдаа төсвийн хүрээнд энэ төсвийн тогтвортой байдлын 7.5 буюу төсвийн хүрээ батлагдсанаас хойш 3 сарын дотор тодотгол хийж болохгүй ээ гэдэг энэ заалтыг өөрчлөхөөр нэмэлт энэ төсвийн хүрээг

дагуулаад өргөн барьчихсан явж байгаа. Батлагдаагүй байгаа. Энэ батлагдахгүй байлаа гэхэд бид нар 8 сард тодотголоо хийнэ шүү дээ. Үгүй ээ Улсын Их Хурал харин мэднэ. Улсын Их Хурал хэрвээ батлах юм бол бид нарт 06 сарын 01-нээс эхлээд 06 сарын 01-нээс эхлээд тодотгол хийх боломж нь бүрдэнэ. Төсвийн хүрээ чинь өөрөө.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Хамгийн гол нь төсвийн тодотгол хийгдээгүй байж байхад батлаагүй төсвөөр тэнд үйл ажил, нэг сайд дураараа аашлаад байна гэдэг зүйлийг яриад байна шүү дээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

**Ө.Шижир:** Хэдэн юм асууна. Эхнийх нь 1 дүгээрт төр хэзээ хувийн хэвшилтэйгээ өрсөлдөхөө болих вэ гэдэг асуудал байна. Одоо энэ 2029 он хүртэл төсөөлж байгаа төсөөлөл дээр чинь ийм үг, өгүүлбэр алга. Өнөөдрийг хүртэл ДНБ-ий чинь 74-ийг төр үйлдвэрлэж байна. ДНБ-ий чинь 90 тэрбум гэж бодох юм бол улсын өмчийн зарлага чинь 35 их наяд буюу нийт ДНБ чинь гуравны нэгийг эзэлж байна. Өдрөөс өдөрт төрийн өмчит компаниуд нэмэгдэж байна. Тэгээд төрийн өмчит компаниудынхаа үр ашгийг, төрийн өмчит компанийнхаа ашиг орлогыг, төрийн өмчит компаниудынхаа компаниудынхаа үйл ажиллагааны зардлыг, эсвэл ашиг, алдагдлыг нь энэ төсөөллүүдээр яаж бодсон юм бэ? Тусдаа нэг ийм аж ахуйн нэгжүүд байгаад байх юм уу гэдэг.

Саяхан Нийслэл тусдаа вант улс байсныг бид нар харлаа шүү дээ. 10-хан сантиметр замыг 70 сая төгрөгөөр барина гэж Туулын хурдны зам оруулж ирж байгаа байхгүй юу. 10-хан сантиметр шүү дээ. Бид нар ингэтлээ мөнгөтэй болчихсон улс юм уу? Эсвэл ингээд төсөл эрэмбээ төслийнхөө эрэмбийг ялгаж чадахаа больчихсон юм уу?

Эдийн засгийн өсөлт ДНБ чинь хэзээ бодит амьдрал дээр иргэдийнхээ гар дээр орлого олж очих юм бэ? Хэзээ худалдан авах чадвар сайжрах юм, хэзээ иргэдийн амьдрал ахуй сайжрах юм? Нөөцийн мах гээд сая засаг баахан улс төр хийж байх шиг байна. Нөөцийн мах гэдэг бол үнэндээ бага, дунд орлоготой иргэдэд зориулсан хавар махны үнэ нэмэхээр тодорхой түвшинд зарахаар хийж байгаа буюу тийм бага, дунд орлого, эмзэг бүлгийнхэнд зориулсан төрийн бодлого биз дээ Энхбаяр сайд аа? Та өөрөө Хөдөө аж ахуйн сайдаар зөндөө олон жил ажилласан. Тэгтэл одоо энэ Монгол Улсын иргэд чинь бүгдээрээ эмзэг бүлгийнх болчихлоо. Өнөөдөр Засгийн газар махны очерт иргэдийгээ хооронд нь зодолдуулж байна, уралцуулж байна, муудалцуулж байна. Мах чинь магнаг боллоо. Энэ сүүлийн хэдэн жилийн бодлогын чинь буруу үр дүн л гэсэн үг. Хэзээ иргэдийн амьдрал дээр бодит орлого болж очих юм бэ? Бид нар дандаа ийм сайхан юм яриад хэдэн жил суух юм. Энэ үр дүнгээрээ байгаад байх юм уу? Тэгээд аягүй сайхан бодлого яриад байна. Экспортод гаргаж байгаа мах чинь 4 доллар буюу 15 мянга. Махаа хямдруулаад зарж байгаа, иргэддээ зарж байгаа гээд байгаа мах чинь бас 15 мянга. Экспортод гарч байгаа мах иргэддээ худалдаалж байгаа мах 2 чинь үнийн дүн нь яагаад адилхан байгаа юм? Ийм төрийн бодлого гэж байдаг юм уу? Нэг.

Сарын өмнө намайг чуулган дээр махны үнэ 30 мянга болчихлоо гэж ярьж байснаас хойш өнөөдөр махны үнэ чинь 30 хувь болчихлоо. Макро, микро эдийн засгийн бодит үзүүлэлт тоонууд чинь иргэд дээрээ буухгүй байна. Худалдан авагч эд нар сайжрахгүй байна. Өдрөөс өдөрт ядуураад байна. Бид нар хэрвээ

ядуурлынхаа шугамыг багахан өөрчлөхөд л нийт иргэдийн чинь бараг 70 хувь ядуурлын шугам руу очлоо. Хэмжих нэгжээ, агуулгаа өөрчлөөд бид нар тэрийгээ өөрсдийгөө магтаад байж болохгүй.

2026 бол ямар нэгэн сонгуульгүй цор ганц жил. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуультай. 2028 оны Их Хурлын болон орон нутгийн сонгуультай. Ядаж энэ нэг сонгуулийн жилийг ашиглаад улс төрийн шийдвэрүүдээ гаргаж болдоггүй юм уу? Хэдий болтол бид нар ийм канондсон олон цаас гаргах гэсэн юм.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Төсвийн тогтвортой байдлын хууль гээд 23 дахь удаагаа, 22 дахь удаагаа өөрчлөгдлөө. Үгүй ээ ийм тогтвортой байдал гэж байдаг юм уу? Нэг бол нэрийг нь солих хэрэгтэй шүү дээ. Энэ яагаад ингээд 22, 23 дахь удаагаа өөрчлөгдөөд байна вэ гэхээр буруу тооцоод байна гэсэн үг. Буруу тооцоод байгаа учраас аргагүйн эрхэнд энэ хуульд өөрчлөлт оруулаад байна гэсэн үг. Одоо бид нар чинь алт, зэс, нүүрс гээд хэдхэн юм зардаг. Орлогоо хэтэрхий өөдрөгөөр төсөөлчихдөг, зардлаа түрүүлээд гаргачихдаг, оны эцэстээ мөнгөгүй болчихдог. Тэгээд цаашид бид нар ер нь улсын төсвийг чинь 75, бараг 76 орчим хувийг урсгал зардал эзэлж байна шүү дээ. 2028, 2027, 2029 онд улсын төсвийн хэдэн хувийг урсгал зардал эзлэх юм бэ та нарын тооцоогоор? Тэгээд тодруулчихъя.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Тантай санал нийлэх зүйл байна, нийлэхгүй ч зүйл байна. Ер нь өрхийн орлого тасралтгүй өсөж ирж байгаа. Өнөөдөр бид амьдарч байгаа энэ орчноо л харах, хэрэглэж байгаа хэрэглээгээ л хар. Өрхийн орлого, амьдралын чанарт гарч байгаа өсөлтийг ерөөсөө үгүйсгэж болохгүй.

Хамгийн эхний үзүүлэлт дундаж нас чинь 15, 6 жилээр уртасчхаад байна шүү дээ. Тэрний цаана чинь ямар их амьдралын чанарын өөрчлөлт, эрүүл мэнд, хоол хүнс, амьдрах орчныг өөрчилж явж байгаа билээ. Материаллаг ахуйн талаар бол бид сүүлийн энэ 20 жил маш их ахиц гаргасан ийм улс орны тоонд орж байгаа шүү дээ. Дундаж орлоготой орон болчихлоо шүү дээ.

Гадаадын зээл, тусламжаас салаад бид нар зөвхөн хөрөнгө оруулалтын, эдийн засгийн, зээл хамтын ажиллагааг хөгжүүлдэг орон болж хувирч байна. Өрхийн орлого бол өнгөрсөн жил 5 хувь гарсан. Хөдөөд 10 хувийн өрхийн орлого нэмэгдсэн, Улаанбаатарт 2 хувь байгаа.

Хөдөө талдаа энэ чиглүүлсэн зорилт хөтөлбөрүүд, энэ экспортыг дэмжсэн бодлогын үр дүнд хөдөөгийн орлого нэлээн сайжраад орон нутагт байгаа төрийн албан хаагчдын нөгөө нэмэгдлүүд 20-40 хувийн нэмэгдлүүд үйлчлээд ирсэн. Тэрэнтэй холбоотойгоор ер нь хөдөө орон нутаг талдаа илүү орлоготой. Төв суурин газар хүнд байгаа.

Мах гэхэд бол жилдээ 8-9 мянган тонн махыг нөөцлөөд нийслэл Улаанбаатар хотын 4, 5 сарын яг ийм хаврын тарчиг үед зохицуулалт хийдэг л ажил байхгүй юу даа. Тэр ажлаа л Нийслэл хийгээгүй л асуудал. Гэтэл энийг бол экспорттой хольж болохгүй. Экспорт чинь бараг 100-аад мянган тонн, 350 сая долларын мах экспорт нь гарч байна шүү дээ. Тэр чинь бүгд хөдөөдөө малчны

орлого болж очиж байгаа. Үйлдвэр, аж ахуйн нэгждээ очиж байна шүү дээ. Тийм, адууны мах чинь бараг 70 хувь нь, сарлагийн мах, ямааны мах гээд ер нь нэлээн явж байна. Энийг бол ер нь яг энэнтэй битгий зүйрлэж сааруулах зүйл битгий яриасай гэж бодож байна. Бид чинь 30 жил махаа гаргая гэж мөрөөдсөн ард түмэн шүү дээ.

Сүүлийн 3 жил нэг бид нар 300 сая долларыг гаргадаг болоод, уул уурхайн бүтээгдэхүүн 5 бүтээгдэхүүний хажуугаар ноос ноолуур хоёр чинь 300-аас дээш сая доллар орж ирж энэ эдийн засгийн бүтцэд чинь бас их нэлээн өөрчлөлт орж ирж байна. Төрийн өмчийн компаниудыг 25 хувь цөөлөх бодлого засгаас барьж байгаа. Тасралтгүй цөөлж байгаа, нэгтгэж байгаа. Сая Эрдэс Монголыг татан буулгасныг мэднэ тээ. Одоо бүх компаниуд нэгдэх ажлууд тасралтгүй явагдаж байна. Төрийн байгууллагуудын бүх чиг үүргийн шинжилгээ хийгдээд дуусаж байна.

Одоо төсвийн тодотгол, эсвэл намар төсөвтэй хамт энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнээс авхуулаад олон зүйлийг бид нар оруулж ирнэ. Энэ давхардсан чиг үүргүүд, ажлын уялдаагүй байдлууд, шаардлагагүй бүтцүүдийг нэлээн зоригтой цэгцэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Шижир гишүүн нэмж тодруулъя.

**Ө.Шижир:** Энхбаяр сайд аа хөдөө аж ахуйн сайд хэдүүлээ нэг яг захуудаар яваад, гэр хорооллын иргэдтэй уулзаад, хөдөө орон нутагт байгаа иргэдтэй яг ямар нэгэн камергүй, зурагтгүй, хэвлэлгүй явж үзэх юм уу? Та хэдийн амьдрал бол сайхан байгаа байх л даа. Монгол Ардын намын сайд нар бол хэзээ ч энэ эдийн засгийн өсөлт, инфляц, бууралт, эдийн засгийн уналтыг бодохгүй шүү дээ. Бүгдээрээ амьдраад сайхан амьдраад байгаа юм чинь. Үгүй ээ яг бодит амьдрал чинь би танд Энхбаяр сайд нэг юм хэлье та эдийн засгийн өсөлт гэж ярьж байна, инфляц гэж ярьж байна. Гэтэл төсвийн зарлага чинь эдийн засгийн өсөлт инфляц хоёроосоо 3 дахин өндөр байгаад байна шүү дээ. 10 хувь иргэдийн амьдрал, орлого өслөө гэж байна. Бараа, бүтээгдэхүүнүүд чинь 20-200 хувь өслөө шүү дээ. Энд нь 10 хувь орлого нэмэгдэж байгаа бол энд нь 200 хувь зардал нь нэмэгдээд байна шүү дээ. Тэгээд орлого, зарлагын зөрүүгээр ч хүн амьдардаг юм шүү дээ.

Тийм учраас зээлээс зээлийн хооронд амьдраад байна шүү дээ. Төрийн байгууллагыг татан буулгаж байна гэж байна. Төрийн буруутай гаргасан шийдвэрийн хохирлыг хэн төлөх юм жишээ нь Эрдэнэс?

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Хөдөө орон нутагт явахын тухайд бол би яг 2 жил орон нутагт ажиллаж, амьдарсан хүн. Их Хурлын шийдвэр гаргаад Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг орон нутагт шилжүүлсэн тэнд ажилласан. Орон нутагт байнга ажиллаж энэ Засгийн газрын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Үр дүн бол эдийн засгийн тоон дээр хангалттай гарсан.

Төрийн өмч янз янз байна. Мэдээж шаардлагагүй төсөл, хөтөлбөрүүд нэлээн байна. Тэрийг цэгцэлнэ, нэгтгэнэ, цөөлнө, энэ явна. Нөгөө талаар Монгол Улсын эдийн засгийг нуруундаа үүрч яваа Тавантолгой, Эрдэнэт гээд,

Монросцветмет гээд гол төсвийн орлогыг бүрдүүлж чадаж байгаа төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг бас үгүйсгэж болохгүй шүү дээ. Эд нар чинь л энэ төсвийн тогтвортой байдлыг, энэ эдийн засгийн өсөлтийг хангаж чадаж байна. Инфляц чинь өөрөө 430 бараа, хүн 430.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** 430 хэрэглээний барааны дунджаар инфляц тооцогдож байгаа шүү дээ. Мэдээж хүнсний багц энэ дотор 90-ээд төрлийн нэр төрлийн бүтээгдэхүүн байгаа. Үүн дотроосоо мах, ногоо, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт өндөр гарчихлаа. Энэ бол мэдээж зохион байгуулалтын алдаа ч гарсан.

Дээрээс нь цаг уурын асуудал ч гарсан. Өнгөрсөн зун бол яг төвийн бүсэд ган болж, төмс, хүнсний ногоо бол дотоодоосоо бид нар чинь 100 хувь хангаж байсан байхгүй юу. Энийгээ буцаагаад ухарчихлаа л даа, алдчихлаа. Их Хурал улаан буудай гурил тойрсон 2 удаагийн хуулийн өөрчлөлт нааш нь цааш нь болж бужигнуулсан. Энийгээ дагаад улаан буудайн тариалалтыг эрс багасгачихсан. Үр дагаврыг бид нар өнөөдөр инфляц болоод л амсаж байна. 1 хувийн инфляцын өсөлт цалингийн зардал, тэтгэврийн зардал дээр 30 тэрбум төгрөгийн нэмэлт зардал үүсгэж байгаа шүү дээ. Одоо инфляц 10 хувь гэдэг чинь тэтгэвэр дээр бид нар 300 тэрбумын нэмэгдэл төсөв батлахаас аргагүй байдал үүсэж байгаа юм.

Тэгэхээр энэ гарч байгаа Их Хурлаас гарч байгаа шийдвэрүүд л их зөв байх ёстой. Гол нь зөв.

**Б.Пүрэвдорж:** Надад 2 асуулт байна. Тодруулах юм уу? Шижир гишүүн тодруулъя.

**Ө.Шижир:** Харин тийм Энхбаяр сайд та ингээд түрүүн ярихдаа иргэдийн орлого 10 хувиар бодит өслөө гэж байна шүү дээ, гэж ярьж байна шүү дээ. Энэ талд нь худалдан авах чадварыг нь 20-200 унагаачхаад байгаа байхгүй юу даа. Бэлэн бараа, бүтээгдэхүүнүүд чинь өсөөд байна шүү дээ. 2024 он, 2026 оны цагаан сарын үеэр миний хийсэн судалгаа байгаа. Хамгийн багадаа 8 хувь өссөн. Цагаан сарын дараа дахиад өссөн. Тэгээд эндээ орлогыг нь 10 мянган төгрөг нэмчхээд зарлагыг нь 100 мянга болгоод байна шүү дээ. Тэгэхээр энэ иргэд чинь яаж амьдрах юм бэ гэж байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт ингээд та хэд маань ингээд ярихаараа иргэдийн амьдрал сайхан болж байна, ахуй амьдрал сайжирч байна гараад хар л даа гэж байна. Үгүй ээ гараад хар л даа харин. Тийм сайхан болоод байгаа амьдрал байгаа юм уу? Тийм байвал энэ нийгмийн амьдралын нийгмийн бухимдал ийм өндөр байх уу? Маханд ингэж очерлох уу? Хоорондоо зодолдох уу махны төлөө жишээ нь яг бодитойгоор? Тэгээд миний нэг юм хэлээд байгаа юм. Тэр нөөц экспортод гаргаж байгаа мах нөөцийн мах бол чинь адилхан үнэтэй байна шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Тийм 20, 200 хувийн өсөлт байхгүй шүү дээ. Хамгийн дээд өссөн нь махан дээр 37 хувийн өсөлт гарчхаад байна бодит. Энэ маань инфляцыг гурав аравны, инфляцын өнөөдрийн 10.1 хувийн 3.7 хувь нь махны үнийн өсөлт

шууд шалтгаан нөгөө бүрдүүлж байна. Энэ бол харьцангуй бид нарын дотоодоосоо хангах бололцоотой л ийм боломжтой бараа. Бид энэ дээрээ бодлогын хувьд алдаа, мах бэлтгэл дээр алдаа гарчихлаа шүү дээ. Энэ маань энэ 3, 4, 5 сарын махны үнийг хэт хөөрөгдөж, иргэдийг бухимдуулсан асуудал байна. Эндээ Засгийн газар шийдвэр гаргаж зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. Хууль хяналтын байгууллага ч гэсэн энэний үр дагаврын талаар шалгах ажлыг үүрэг аваад ажиллаж байна шүү дээ. Энэ шийдэгдэх бололцоотой ажил байхгүй юу. Одоо ингээд мал ногоонд цадаад махны, шинэ махны нийлүүлэлт нэмэгдээд эхэллээ. Тасралтгүй махны үнэ чинь бага өдөр өдрөөр л ингээд.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Муу муухайгаар нь дуудаад байх хэрэггүй л дээ энэ чинь. Монгол Улс чинь урагшилж байна, хөгжиж байна, бас хөгжил дэвшил рүүгээ бас итгэлтэй тэмүүлэх ёстой. шүү дээ. Тэрнээс улс орноо гэж үгүйсгэх, ард түмнээ үгүйсгэх, муу муухай гэж ерөөсөө хэт ингэж битгий туйлшраач ээ. Алдаа оноо гарсан бол тодорхой асуудал дээр энэ дээр ийм асуудал гарлаа энийгээ ингэж шийдье ээ гэж. Тэгээд ерөнхийлсөн ийм баримжаагүй тоо ярьж, туйлшруулж иргэдийг мэдээллээр төөрөгдүүлэх нь өөрөө илүү их сөрөг үр дагавартай шүү дээ. Тийм. Энэ инфляцыг бид нар бага болгоно гэж зорилт тавиад засаг өөрийгөө дайчлаад ажиллаж байна шүү дээ. Энэ их зөв байхгүй юу. Тэрнээс инфляц өндөр байна гэж тавих шиг амархан. Тэгж болохгүй шүү дээ.

2 дугаарт, эдийн засгаа өсгөө гээд зорилт тавьж байна. Энийг чинь хийхийн төлөө л засаг ажиллана шүү дээ энэ чинь. Засаг Их Хурлынхаа өмнө амлалт авч, зорилтоо оруулж ирж байна шүү дээ. Орлогоо нэмэгдүүлнэ ээ, эдийн засгаа өсгөнө өө, инфляцаа нам барина. Энэ бол бүх Засгийн газрын хийдэг л гол үүрэг байхгүй юу даа.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр би бас 2, 3 асуулт байна. 2020 онд энэ төсвийн хүрээний мэдэгдлийг 4 удаа өөрчилж байсан юм. Өөрөөр хэлбэл 2020 оны 4 сард тодотгол орсон. Тэрүүгээрээ төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилсөн. Дахиад 5 сард уулаасаа 21 оныхоо төсвийн төсөөллийг гаргаж төсвийн хүрээний хуулиа хийсэн. Тэгээд 8 сард дахин тодотгол хийсэн. Тэр дээрээ бас дахиад өөрчилсөн. Тэгээд 10 сард 11 сард төсвийн 10 сард төсвийн хууль орж ирэхэд 21 оны төсөв орж ирэхэд дахиж өөрчилсөн. Ингээд 4 удаа өөрчилсөн дураараа өөрчилсөн энэ жил дахиад 3 өөрчлөх нь л дээ.

Яагаад гэвэл 6 сард төсвийн хүрээний юу төсвийн тодотгол хийвэл төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчилнө. Дахиад 27 оныхоо төсвийг хэлэлцэж эхлэхдээ дахиад л өөрчлөөд ороод ирнэ. Тэгээд 3 удаа өөрчлөх юм байна. Энэ төлөвлөлтгүй байснаас болж энэ улс орны эдийн засаг бас нэлээн хүнд нөхцөл байдал руу орж байгаа юм. Жишээ нь саяын инфляц ярьж байна шүү дээ. Одоо бол яг 10.1 хувийн инфляцтай байгаа. Тэгэхдээ хүнсний инфляц 19.7 байгаа шүү дээ.19.7.

19.7 гэдэг чинь энэ КОВИД-ын үед 18 хувьтай байсан байхгүй. Ерөөсөө ложистикийн хямрал болоод тэрнээс болж хүнсний үнэ өссөн. Тийм хүнд үед 18 хувиар өсөж байсан. Гэтэл дайн байлдаан байхгүй, ямарваа нэгэн асуудал

байхгүй өнөөдөр ингээд 19.9 хувиар хүнсний инфляцаа өсгөнө гэдэг бол энэ Засгийн газар маш тийм хариуцлагагүй ажиллаж байна гэсэн үг.

Тэгээд энэ дээр би дахиад нэмээд нэг зүйл хэлэхэд би 2021 онд Тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийг өргөн барьсан. Өөрөөр хэлбэл, 20-оос 24 оны хооронд би энэ ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх талаар олон ажлууд хийсэн. Тэрний нэг нь бол тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийг 21 онд өргөн бариад 3 жил зүтгэж байж 24 онд батлуулсан. Тэрнээс өмнө яасан бэ гэх дээр 16 оноос 24 он хүртэл ерөөсөө 3-хан удаа ахмадууд энэ тэтгэврийг нэмсэн байхгүй юу. Тэр нь 20 оны сонгуулийн өмнө, 21 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө, 23 онд ингээд сонгуулиудын өмнө нэмсэн.

Тэгэхээр энэ Тэтгэврийг индексжүүлэх тухай энэ өргөн барьсан хуулиар маань одоо сүүлийн 2 жил дараалан инфляцын дагуу тэтгэвэр нэмэгдэж байгаа. Хэрвээ энд тэтгэвэр яг энэ үнэн тэр инфляцын дагуу нэмэгдсэн бол өнөөдрийн байдлаар ахмадууд хамгийн багадаа сая 100 мянган төгрөгийн тэтгэвэр авах ёстой байсан. Гэвч инфляцаа буруу боддог.

Одоо ингээд 10.1-ээр өнөөдөр энэ өнгөрсөн сард 7.3 байсан уу даа. Тийм байсан. Одоо ингээд 10.1 болчихлоо шүү дээ. Тэгээд яг энэ 12 сард очиход инфляцыгаа нөгөө ахмадын тэтгэврийг бага бодохын тулд инфляцаа багасгасан гэдэг ийм сагсанд хамгийн бага өсөлттэй тэр бараануудаа 420-оос хамгийн бага өсөлттэй өөрөөр жишээлбэл энэ инфляц энэ 420 нэр төрлийн бараанд Шижир гишүүн ээ юу ордог вэ гэх дээр буудалд хонох үнийн өртөг ордог байхгүй юу даа. Жишээ нь ийм ийм зүйлүүд ордог. Жишээ нь энэ тэрнээсээ хамгийн бага бараануудыг нь сагсандаа оруулж байгаад тэгээд инфляц бага байна гээд ахмадын тэтгэврүүдийг ба инфляцын дагуу бага нэмдэг ийм асуудал байдаг шүү.

Тийм учраас яг энэ оны эцсийн энэ мэдээж төсвийн хүрээний мэдэгдэл дээр инфляцыг хэдэн хувь байхаар тооцоолж байгаа юм, тэрүүгээрээ тэрний дагуу хэдэн хувиар инфляц тооцож, ахмадын тэтгэврийг нэмэх гэж байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:**Тэтгэвэртэй холбоотой тэтгэвэр бол инфляцтай уялдаж нэмэгдэнэ гэж хуульчилсан. Нөлөөлөл нь инфляц 1 хувь өсвөл тэтгэвэр 30 тэрбумаар нэмэгдэнэ. Инфляц 10 хувиар жилийн эцсээр гүйцтэлтэй гарвал 27 онд инфляц биш ээ тэтгэвэр 300 тэрбумаар нэмэгдэнэ ээ л гэсэн ийм л тооцоо.

2 дугаарт инфляцыг Засгийн газар гаргахгүй байгаа шүү дээ. Статистикийн хороо хараат бусаар Улсын Их Хурлын харьяа байгууллага статистикийг олон улсын аргачлалын дагуу хүний үндсэн хэрэглээний 3, 430-н сагс бараан дотор тооцоод гаргаж байгаа шүү дээ.

Мэдээж махны үнэ өндөр байгааг учир шалтгааныг бүгд мэдэж байгаа. Тэгээд энийгээ засаад, залруулаад ойрын үед энэ тогтворжих дотоодоосоо тогтворжуулах бололцоотой. Төмс, хүнсний ногоо, улаан буудай, гурил, махыг бол дотогшоо тогтворжуулах бололцоотой.

Нөгөө талд мал, махны үнэ өссөн. Малчны орлогын асуудал бол гарч байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Их Хурал дээр хэрэгжсэн олон бодлогууд өөрөө инфляц болж орж ирээд байгаад л асуудал байна шүү дээ. Одоо хар та сая төлөлтийн алдаа, төсвийн хүрээний өөрчлөлтийг дурдлаа. Би өнөөдөр гэхэд л бас энэ Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороотой нэлээн хэрүүл хийгээд л гарч ирж байгаа бид нар. Ноднин 151 Засгийн газраас өргөн барьснаас гадуур 151 төсөл хөтөлбөрийг 3.2 их наядаар оруулж ирсэн.

Сая 206 санал бас 3 их наядын хууль зөрчиж, эх үүсвэргүй, техник эдийн засаг үндэслэлгүй, үр ашгийн тооцоололгүй ийм зүйлүүдийг Их Хурлын гишүүд дур мэдэн энэ бодлогыг өөрчилж байна шүү дээ. Тэрний үр дагавар, хэрэгжилтийн алдаа гарч байна. Төсвийн бодлого, хөгжлийн бодлого чинь буруу болж байна. Тэгэхээр энэ асуудлыг хэлж байгаад тэр Дэгийн хуульдаа өөрчлөлт оруулж жоохон цэгцлэхгүй бол энэ дур зоргын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх гэдгээр хаацайлж хуулийг уландаа гишгэж байгаа байдал сүүлийн үед хавтгайрч. Арай ч ийм байдаггүй юм. Энэ бол Их Хурлын бүрэн эрх гэж. Хуулийг давсан бүрэн эрх гэж байхгүй шүү дээ.

Үндсэн хуульд заасан байгаа шүү дээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Өөрчлөхийг хориглоно гэж. Тэрийг ч тоохгүй байна. Бүүр сумын асуудал руу орсон. Сумын доторх дэд бүтцийн асуудал, засвар үйлчилгээний асуудал, сумын эмнэлгийн тоног төхөөрөмжийг Монгол улсын хөгжлийн бодлого руугаа их замбараагүй оруулж байгаа байдал бол арай дэндэж байна шүү дээ. Тэгээд ийм ийм шалтгаанаас ч болоод энэ төлөвлөгөөнүүд чинь, өөрчлөлтүүд чинь байнга л үүсээд байна шүү дээ. Тэгэхээр бид бол энэ Дэгийн хуулиа нэлээн сайжруулах, чамбайруулах шаардлага хаа хаанаа л байна.

Тэгэхээр инфляц бол өнөөдөр өндөр гарч байгаа боловч дунд хугацаандаа намар ургац гаргаад, мал, мах, төл авалт гээд олон хүчин, цаг уурын байдал гээд олон хүчин шалтгаанаас бол бид нар 7 хувь дээрээ бид нар инфляцаа бариад орно л гэсэн ийм зорилготой, тэмүүлэлтэй. Энэний төлөө л ажиллаж байна. Энэ дээрээ бас Монгол.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Тэгээд жишээ нь сагсан дотор 420 нэр төрлийн бараа байгаа юм. Жишээ нь буудлын үнэ бол өвөл уначихдаг байхгүй юу. Тэгэнгүүт сагс руугаа оруулчихна. Инфляцаа багасгахын тулд. Тэгэнгүүт юу байдаг юм намар болоод жуулчлал зун болоод эхлэхээр, нөгөө жуулчлал эхлэхээр буудлын үнэ өсөхөөр нөгөө 420-иосоо нөгөөдхөө гаргачихна. Тэгээд махны үнэ ч тухайн үед нэлээн буурна. Тэгээд ингээд л яг оны эцэс рүү төсөв хэлэлцэх үед инфляцаа тооцохдоо тэгээд л өөртөө ямар ашигтай, ямар, яаж л энэ ахмадуудын тэтгэврийг, хүмүүсийн цалинг нэмэгдүүлэхгүй байх талаар л арга хэмжээ авч таараад байдаг юм л даа.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэллээ. Би үг хэлсэн. Үгүй ээ би. Зарчмын зөрүүтэй 1 саналтай энэ санал хураалтыг маргааш явуулна. Хэлэлцэх асуудалд дараагийн асуудалдаа орёе.

**Хэлэлцэх асуудал 10. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ренчиндоржийн Батболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Р.Батболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлдэг байх нь зүйтэй талаар дурдаж, нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг хүчингүй болгож байгаа үндэслэл, тооцооллын талаар, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татвартай холбоотой хуулийн төслүүд батлагдсанаар төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа 2026 оны төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ инфляцтай уялдуулан тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх боломжтой байсан бөгөөд улсын төсөвт 2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг нэмж баталсан талаар дурдаж, үүнтэй холбоотойгоор мөнгөний бодлогын орон зай байгаа эсэх, мөн зээлийн хүүгийн түвшин болон эдийн засгийн бусад үзүүлэлтэд хэрхэн өөрчлөгдсөн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан төсөвт тодотгол хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх бодлогыг хэвээр хадгалан харин хуулийн хүчин төгөлдөр мөрдөх хугацааг хойшлуулах боломжтой эсэх, мөн Засгийн газрын өрийн хэмжээний ДНБ-д эзлэх хувийг 45 хувьд барих боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Засгийн газраас төсвийн

тодотголыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх эсэх, төсвийн тодотголын төслийг дагалдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дахин өргөн мэдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Боловсролын яамны алдаатай бодлогын нөлөөгөөр төсөвт ачаалал үүсэж байгааг дурдаж, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өмч хувьчлалын асуудлыг Улсын Их Хуралд дахин өргөн мэдүүлэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Иргэдийн цалин 1 хүнд ноогдох бодит орлогыг өсгөж, урсгал зардлын өсөлтийг бууруулах, аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд чиглэсэн хөгжлийн бодлого болон алдагдалгүй төсвийг баталдаг болох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт нь бага орлоготой иргэдийг дэмжихэд чиглэсэн бодлого болохыг дурдаж, төсвийн урсгал зардал, ялангуяа үр ашиггүй зардлуудыг бууруулах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн төсвийн тодотгол хийх нь зүйтэй, мөн Засгийн газрын өрийг нэмэгдүүлэх, өрийн дарамтад орохгүй байх, зээлийг авсан эсэхэд хяналт тавьдаг байх нь зүйтэй талаар? Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төсвийн тодотгол хийхийг дэмжиж байгаагаа илэрхийлж, төсвийн тодотгол хийхэд холбогдох хуульд заасан тодорхой нөхцөлүүд бүрдсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж, хэлэлцүүлэх талаар зарчмын зөрүүтэй санал гаргасан бөгөөд уг саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 45.5 буюу хувь буюу олонх дэмжээгүй болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг энэ хуулийн 15.3-д заасан нөхцөл, шаардлага хангасан албан татвар төлөгчийн тухайн улиралд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэл хувийг буцаан олгох бөгөөд иргэний дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтад төлсөн албан татварыг 100 хүртэл хувийг буцааж олгох, өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалт хэрэгжүүлэх хугацаа, тайлагнах журмыг Засгийн газар батална гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргаж, уг саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 33.3 хувь нь буюу олонх дэмжээгүй болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг” гэснийг “мэдэгдлийг” гэж өөрчилсүгэй гэсэн агуулгатай 1 дүгээр зүйлийг нэмэх талаар зарчмын зөрүүтэй санал гаргаж, уг саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 44.1 хувь буюу олонх дэмжээгүй болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 7.5 дахь хэсгийн түүний нэмэлт, өөрчлөлтийг төсвийн тодотголын гэснийг тус тус хассугай гэснийг 7.5 дахь хэсгийн төсөл, төсвийн тодотголын гэснийг хассугай гэж өөрчилж, мөн зүйлийн 2 гэж өөрчлөх талаар, мөн зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх талаар зарчмын зөрүүтэй санал гаргаж, уг саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 41.2 хувь буюу олонх нь дэмжээгүй болно.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт болон гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга. Чимэдсүрэн би нэг өнгөрсөн 7 хоногт танд үүрэг өгсөн. Тэрийгээ яаж байгаа биз дээ? Тайлангаа тавиарай. Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Ажлын хэсгийнхэн гишүүдэд үнэн, зөв мэдээлэл өгөх ёстой. Гишүүд асуулт. Улсын Их Хурлын гишүүд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Пүрэвийн Батчимэг гишүүн алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн алга байна. Гонгорын Дамдинням гишүүн алга байна. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн алга байна. Батжаргалын Заяабал

гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Д.Энхтүвшин:** Өглөөний 10 цагаас хойш 12 цаг хуралдаж байна. Тэгээд нэг их бас асуулт байхгүй. Нэг зүйлээр нэг л юм зүгээр тодруулж асууя. НӨАТ-ын 5, 6 сарын өмнө баталсан НӨАТ-ын хуулиа жишээлбэл ингээд буцаагаад хүчингүй болгож байна. Энэ хуулиа татаж байна. Тэгэхээр яах вэ нөхцөл байдал өөрчлөгдсөн гэж жишээ нь 8 эрсдэл макро орчинд нөлөөлсөн гэж энэ дээр бичсэн байгаа. Гэхдээ эд нарын тусгалууд нь ерөөсөө энэ хуулийн төслүүд дээр тусгагдаагүй байсан.

Тэгэхээр асуух гээд байгаа юм нь гэхээр энэ ингээд уул нь улс төрчид бол бас ингээд яаж ч найгаж болно . Гэхдээ яг ингээд болохгүй юмыг болохгүй гэж хэлдэг энэ институцийн чадамжууд байхгүй бол Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам энэ бол жишээлбэл үнэхээр яг энэ төсвийн ийм нөхцөл байдал ийм болох нь тэгээд НӨАТ дээр бол жишээлбэл энэ буцаан олголт дээр энэ гарч ирж байгаа энэ зардлыг даахааргүй байна гэдэг нөхцөл байдал ойлгомжтой л байсан. Өмнө нь ч гэсэн анх хэлж 2024 он тэр төсөв ярьж байхад ч гэсэн он гараад төсөв хүндэрнэ гэдэг нь ойлгомжтой л байсан. Тэгээд тэр үед нөгөө институцүүд нь яамнууд, мэргэжлийн яамнууд нь асуудлаа мэдэж байгаа мөртөө яг энэ улс төрчдөд нь, сайд нар нь хэлэхээр тэгээд яг тэрэнд нь тааруулаад ингээд нөхцөл байдлыг нь өөрчлөөд байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу.

Одоо жишээлбэл, Занданшатар Ерөнхий сайдыг байхад бол НӨАТ-ын асуудлыг бол оруулж ирээд ингээд шийдчихэж болно. Учрал Ерөнхий сайдын хувьд бол дахиад болчхож болно. Тэгэхээр нөхцөл байдлууд нь ерөөсөө өөрчлөх хэмжээнд болоогүй байхад зүгээр ингээд сайд дагаж ч юм уу, үзэмжийн шинжтэй иймэрхүү өөрчлөлтүүд хиймээргүй байна. Тэгэхээр зүгээр энэ 2 яамдаас сайдууд нь биш зүгээр яг энэ хамгийн удаан ажилласан Эдийн засаг болон Сангийн яамнаас яг ийм зовлон байдаг юм уу? Яг сайд нар яг энэ болохгүй ээ гэж хэлээд байхад сайд нар болго гээд шахахаар та нарын хувьд бол бие даасан энэ мэргэжлийн байр сууриа илэрхийлэх тэр тоо, судалгаагаа гаргаад одоо болохгүй байна аа, чадахгүй байна аа гэж хэлэхгүй байх тийм эр зориг ч юм уу, мэргэжлийн тийм ёс зүй байдаг уу? Хэрвээ тийм байдал илэрхийлбэл ажил албатай чинь ярина гэдэг тийм нөхцөл байдаг юм уу? Тэрийг нэг ойлгох хэрэгтэй байна. Энэ ийм л асуулт.

**Б.Пүрэвдорж:** Энхбаяр сайд хариулья.

**Ж.Энхбаяр:** Энэ төрийн албан хаагчид, мэргэжлийн яамнууд, энэ мэргэжлийн энэ дүн шинжилгээний байгууллагууд бүх ажлаа яг хийгээд л олон улсын аргачлалын дагуу эдийн засгийн төлөв байдал, тэнхээт тамирыг чинь гаргаад л ирж байгаа байхгүй юу даа. Жишээлбэл, одоо яг энэ жишээ их сонин. Энэ бид нарын ярьж байгаа сэдэв. Энэ НӨАТ-ын буцаан олголтыг, Энхтүвшин дараа нь хариулна. НӨАТ-ын буцаан олголт ингээд энэ хууль хэрэгжихэд бид нар 1.8-2.5 их наядыг төсвийн орлого багасаж байсан юм. Таныг бол төсвийн орон зайгаар бол шийдэх юм байна гээд Занданшатар Ерөнхий сайд үед хэрэгжүүлсэн, өргөн барьсан байхгүй юу засгийн бодлого болгож.

Гэтэл яг хэлэлцээд явж байтал багш, эмч нарын цалин гээд 2 их наядыг нэмээд хаяж байгаа байхгүй юу. Нөгөө НӨАТ-аас суллаж байсан мөнгийг чинь цалингийн нэмэгдлээр шинэ эх үүсвэр гаргаад өгч байгаа юм. Нэмэгдэл ачаалал. Тэгэнгүүт энийг чинь аль алиныг нь зэрэг хэрэгжүүлэх бололцоогүй болчхож байгаа байхгүй юу. Одоо бид нарын өмнө юу тулчихсан гэвэл нэг бол НӨАТ-ынхаа хуулийг үйлчлэлийг нь хойшлуулъя, буцаая.

Тэгээд багш нарын, эмч нарынхаа цалинг 27-нд үргэлжлүүлэн нэмдгээрээ нэмээд явъя. НӨАТ-аа ч буцаагаад, цалингаа ч нэмэх юм бол хөрөнгө оруулалт байхгүй. Монгол Улсад 1 ч хөрөнгө оруулалт байхгүй. Одоо бол шинэ хөрөнгө оруулалтгүй болчихсон байгаа. Одоо шилжиж байгаа 3.6 их наядын хөрөнгө оруулалтаас бидэнд 2.2 их наядын санхүүжих орон зай байгаа. Энийгээ ч алдана гэсэн үг. Ингээд бид нар зөвхөн НӨАТ-ын буцаан олголтыг өгчхөөд цалингаа 2 их наядар нэмчихсэн. Ингээд Монгол Улс бүх олдсон орлогоо цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө өгөөд дуусна гэсэн үг. Хөгжлийн бөгөөд бусад хөрөнгө оруулалт, бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх бололцоогүй ээ гэсэн үг. Энэ бол ингээд ийм 3 сонголт үүсэж байна шүү дээ одоо.

Тэгэхээр энэ Засгийн газрын чинь тооцоолоод, орон зайгаа тооцоолоод, өргөн барихад энэ тусдаа ажлын хэсэг гаргаж байгаад энэ зардлыг, урсгал зардлыг хэт ачаалж байгаа байдал бол арай нөгөө мэргэжлийн байгууллагууд чинь ажиллаад бүхэл бүтэн институцээс ажиллаад судалгаа гаргаад ирж байгаа зүйлийг нэг гишүүн санал гаргаад л зуу зуугаар нь тэрбум нэмээд л, төсөв тооцоогүй, эх үүсвэргүй зардлуудыг нэмж байгаа байдал чинь л ийм байдалд хүргэлээ шүү дээ одоо.

Тэгэхээр энэ бол, бид нар энэ оруулж ирж байгаа хууль маань юу вэ гэвэл нөхцөл байдал ийм болчихлоо шүү, сонголт хийгээч ээ гэж байгаа юм. Цалин дээрээ нэмэх юм уу, НӨАТ-аа буцаах юм уу? Хуулийг нь авч хэрэгжүүлэх юм бол хөрөнгө оруулалт чинь зогсох нь ээ. Ийм эрсдэлүүд үүсэж байна шүү гэдгийг Их Хурлын гишүүд маань анхаараач ээ гэж ийм сануулга гэдэг юм уу ийм маягаар л оруулж ирж байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл энэ дандаа Их Хурал дээр нэмэгдсэн зардлууд байхгүй юу. Тэрнээс мэргэжлийн байгууллага ажлаа яг хийгээд л бүх тооцоог гаргаад л өгч байгаа.

**Б.Пүрэвдорж:** Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Уул нь Пүрэвдорж дарга 3 минутдаа багтааж асуу, дуусгаарай гэсэн чинь тэгээд хариултаа авч чадсангүй. Энэ бол яах вэ 1 удаа болж байгаа асуудал биш л дээ яг. Институцийн чадамжийн асуудал л би асуугаад байна. Тэгэхээр энэ миний мэдэж байгаагаар бол яг энэ мэргэжилтнүүд нь асуудлуудаа мэдээд байгаа байхгүй юу. Он гараад ийм нөхцөл байдал, ингэнэ тэгнэ гээд байгаа.

Тэгэнгүүт тэрэнтэй холбоотой яах вэ би институцийн чадамж, энэ Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яамны одоо энд байгаа хүмүүсээс хамгийн удаан ажиллаж байгаа 2 хүний хувьд бол яг энэ мэргэжлийн байр сууриа илэрхийлэхэд ямар нэгэн асуудал үүсдэг үү, эсвэл сайдтайгаа асууд зөрөөд, асуудал үүсээд

гарвал ямар нэгэн байдлаар жишээлбэл ажил албатай нь ярьдаг ч гэдэг юм уу иймэрхүү нөхцөл байдал үүсдэг тэр талаар л би яах вэ энэ институцүүд нь чадамжтай байгаасай. Монгол Улсын хувьд бол Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам 2 хамгийн чухал институцүүд байхгүй юу. Тэгээд эд нар өөрсдөө байр сууриудаа хэлдэг байхгүй бол болохгүй байгаад байна л даа.

**Б.Пүрэвдорж:** Сангийн яамнаас хариулъя. Санжаадорж нь арай дээр дээ.

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Яг НӨАТ-ын хувьд бол одоо яг мэргэжлийн байгууллагын хувьд бол манай дээр бас судалгааны газар байдаг. Эндээс бол юу гэж яриад байна гэхлээр бид нар татвар дээр бол илүү бодлогын хувьд бол тогтмол гэж хэлье дээ. НӨАТ, хувь хүн гэх мэт ийм татваруудаа бол аль болох бага оролдох хэрэгтэй байгаад байгаа юм.

Яагаад гэхлээр нөгөө талдаа бид нар уул уурхайгаас дэндүү хамааралтай учраас уул уурхайн орлого маань савлаад байгаа учраас эцсийн сүүлдээ бид нар зарлагаа санхүүжүүлэх буюу түрүүний ярьсан нөгөө цалин хөлсөө санхүүжүүлэх дээр ирэх юм бол энэ тогтмол орлого чинь бид нарыг аврах асуудал болчихоод байгаа юм. Нэг дэх нь.

Хоёр дахь нь бол одоогийн яг судалгаагаар бол юу гэж ярьж гаргаж ирээд байна гэхлээр НӨАТ бол одоогийн яг энэ инфляц өндөр үе дээр бол бид нарын нөгөө нэг яг өрхийн орлогоор нь бол бид нарын зорилтот түвшин рүүгээ чиглэсэн бодлого дээр очиж чадахгүй байгаад байгаа юм. Яагаад гэхлээр тэр хүмүүсийн маань хэрэглээ өөрөө НӨАТ-гүй бараа, бүтээгдэхүүн хэрэглээд байгаа байхгүй юу. Нөгөө талдаа засгаас бол бол татварын бол цогц бодлого яг энэ.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Чимэдсүрэн дарга яг энэ та хариулчих. Энэ чинь 400 сая төгрөг болгочихвол нөгөө зарим хэсэг нь НӨАТ төлөхгүй, бичилт энэ тэр нь яаж явах юм? Зарим нь хэсэг нь НӨАТ төлөөд явна. Энэ дээрээ ямар асуудал гарах юм бэ? Босгыг 400 сая болгож байгаа шүү дээ.

**Ч.Чимэдсүрэн:** Сангийн яам, Татварын бодлогын газар Чимэдсүрэн тэгэхээр НӨАТ-ын буцаалт бол 20 хувь байгаа. Тэгээд үүнийг ингээд 50 хувь болгож нэмэгдүүлэх юм бол нөгөө хэрэглэгчийн цөөнх буюу арай өндөр хэрэглээтэй хэсэгтэй буцаан очих дүн маань бол илүү өндөр байгаад байгаа юм. Тэгэхээр одоогийн нийгэм, эдийн засгийн яг ийм цаг үед бол бид нар хэрэглээг дэмжсэн татварын бодлого гэхээсээ илүү иргэдийнхээ орлогыг хамгаалсан хөдөлмөрийг хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжсэн бодлого нь бол энэ цаг үед бол оновчтой байгаа юм. б

Бас нэг шалтгаан бол энэ заалт орох үед бол дараа дараагийнх нь ингээд НӨАТ-тай холбоотой дараагийн үргэлжилсэн бодлогууд нь бас орох, тухайн үед өргөн барьсан хууль дээр орсон татварын нэмэлт, өөрчлөлтүүд, шинэчлэлтэй холбоотой заалтууд ингээд бас явагдах ёстой байсан. Тэгтэл одоо цаг хугацаа, эдийн засаг, энэ нөхцөл байдал ийм өөрчлөгдсөн учраас бол ийм Татварын хуулийн нэмэлт өөрчлөлтөөр.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн. Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Тийм, гол нь сая өнөөдрийн яриад байгаа нөхцөл байдал чинь 5 сарын өмнө яг л адилхан байсан байхгүй юу. Тэгээд тэр үед хүлээн зөвшөөрөхгүй байх ёстой байхад жишээлбэл тэр өөрчлөлтийг оруулж ирж, Улсын Их Хурлаар батлуулчихаад тэгээд одоо илүү зөв тал руугаа болж байгаа юм шиг тэгж л харагдаад байна л даа. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Яг зөв хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

**Л.Соронзонболд:** Энэ дагаж ирсэн хуулийн төсөл дээр энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д оруулах гэж байгаа энэ өөрчлөлт бол хийсэн ч, хийгээгүй ч ялгаагүй юм шиг ойлгогдоод байгаа байхгүй юу. Яагаад тэгж хэлж байна вэ гэхээр энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гээд. Тэгээд тэрэнд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт энэ хоёр чинь хоёулаа л ялгаагүй л дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд л өөрчлөлт оруулж байгаа байхгүй юу.

Дараа нь төсвийн төсөл байна. Тэгээд төсвийн төсөл болон төсвийн тодотгол гэж байгаа юм. Тэгтэл чинь төсвийн төсөл чинь, төсвийн тодотголын төсөл ч гэсэн ялгаагүй л төсвийн төсөл байхгүй юу. Тэгэхээр ялгаагүй л 3 сарын дотор ямар нэгэн өөрчлөлт оруулж болохгүй ээ л гэж би ойлгоод байгаа юм. Энийгээ нэг тайлбарлаач.

**Б.Пүрэвдорж:** Хэн хариулах вэ? Батхүү дарга хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Эдийн засаг, хөгжлийн яамны Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дээр бол төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх асуудал, бас батлагдсан хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах асуудал. Энэ нь төсөв болон төсвийн тодотгол хийхэд зэрэгцүүлээд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилдөггүй байх л тийм зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ удаагийн оруулж ирсэн дээр бол үндсэн төсвийг 9 сард өргөн мэдүүлээд 11 сард батлахдаа төсвийн хүрээг дагуулж хөдөлгөж болохгүй. Тодотгол хийхдээ бол шаардлагатай бол төсвийн хүрээгээ хөдөлгөж болдог ийм л зохицуулалтыг оруулахаар тусгасан ийм хуулийн зохицуулалт байгаа.

Тэгэхээр энэ 3 сарын төсөв болон төсвийн тодотгол батлагдахаас өмнө 3 сарын дотор төсвийн хүрээг өөрчилж болохгүй гэдэг энэ зохицуулалт өнгөрсөн жилээс эхэлж мөрдөгдөж эхэлсэн. Гэтэл өнгөрсөн жилээс мөрдөгдөж эхэлснээсээ эхлээд л одоо эд эдийн засаг дээр болж байгаа энэ огцом эрсдэлүүдээс үүдээд тодотголыг хийхэд төсвийн хүрээгээ дагуулаад хөдөлгөх яг тийм практик шаардлагууд бол үүсээд байгаа гэсэн үг. Үндсэн төсөв дээр бол хүрээгээ хөдөлгөхгүй, тодотгол хийхэд хөдөлгөдөг больё л гэсэн ийм хуулийн зохицуулалт байгаа.

**Б.Пүрэвдорж:** Нэмж Энхбаяр гишүүн хариулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ биднээс үл хамаарсан гадаад аюулгүй байдлын орчинд гарч байгаа том өөрчлөлтүүд, эдийн засгийн гэнэтийн өөрчлөлтийн нөлөөнд Засгийн газар шуурхай арга хэмжээ авах, энэ орлого, зарлагынхаа тэнцвэрт

байдалд үүссэн эрсдэлийг цаг тух тухайд нь шуурхай зохион байгуулах, зохицуулах, төсвийн удирдлагаа үр нөлөөтэй удирдахын тулд л энэ хуулийг оруулж ирж байгаа юм л даа.

Тэгэхгүй бол 3 сар гээд цоожилчихоор нөхцөл байдал яаж эргээ билээ. Үнэ ханш, инфляцтай шатахууны үнийн өсөлт яаж хөдлөө билээ, энэ Ойрх Дорнодын асуудал яаж хүндрээ билээ. Тэгээд саяын тэр багш, эмч нарын цалингийн илүү дутуу салбар дотор нь шингээж байгаа, энэ гүйлгэж байгаа байдал, эх үүсвэр дутах ч уу, илүүдэх ч үү? Энэ болгонд 9 сард өргөн бариад 11 сар батлах гээд явахад тодотгол үнэхээр оройтчихно л доо.

Тэгэхээр ямар ч байсан бид бол экспорт маань тун идэвхтэй идэвхжээд биет хэмжээ, үнийн дүн нэмэгдээд бас болом харьцангуй гайгүй л яваад байна. Харьцангуй маш бага шоктой яваа улс орны тоонд Монгол улс орж байгаа шүү дээ.

**Б.Пүрэвдорж:** Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

**Л.Соронзонболд:** Би нөхцөл байдлыг бол маш сайн ойлгож байгаа. Зүгээр яах вэ гол нь энэ 7.5 дээрээ оруулж байгаа энэ нэмэлт, өөрчлөлтийг гэдэг хэсгийг хасаж байгаа, төсвийн тодотгол гэдгийг хасаж байгаа чинь өөрөө яг ингээд утга, агуулгын хувьд арай жоохон буруу л ороод ирчихсэн юм шиг санагдаад байгаа байхгүй юу.

Төсвийн тодотгол гэдэг чинь өөрөө төсвийн төсөл л байх. Төсвийн тодотголын төсөл гэдэг чинь ялгаагүй л төсөв баталж байгаатай адилхан шүү дээ. Төсвийн төсөл байхгүй юу. Тийм учраас ялгаагүй л 3 сарын дотор та нар оруулж ирэх боломжгүй л гэж би ойлгоод байгаа юм. Тийм учраас энийг анхнаасаа би та бүхэнд хэлж байсан. Энэ бол арай ч утга, агуулгын хувьд арай өөр найруулж орж ирэх ёстой байсан байх л гэж үг хэл үг хэлж байгаа шүү. Санал хэлээд байгаа юм.

**Б.Пүрэвдорж:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Маргааш өглөө санал хураалтыг явуулна. Энэ чинь өөр дахиад байхгүй байх аа. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

22.17 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

